



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

1

Хуралдааны товч тэмдэглэл:

2-8

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

9-126

1.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

9-47

2.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

47-63

3.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газрын 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

63-126

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит
чуулганы 06 дугаар сарын 23-ны өдөр /Даваа гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 95 гишүүн хүрэлцэн ирж, 75.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд нээснийг мэдэгдэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Х.Баттулга, П.Батчимэг, Ж.Ганбаатар, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Х.Жангабыл, Г.Лувсанжамц, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Ц.Туваан;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, Л.Гантөмөр, Н.Наранбаатар, С.Одонтуяа;

Тасалсан: Н.Алтанхуяг, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Ж.Батсуурь-06 минут, Х.Булгантуяа-04 минут, З.Мэндсайхан-14 минут, Ч.Номин-28 минут, Э.Одбаяр-14 минут, Б.Пунсалмаа-15 минут, О.Саранчулуун-02 минут, Ж.Чинбүрэн-05 минут, Ж.Энхбаяр-12 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсныг танилцуулав.

Нэг.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, референт Б.Төрбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, М.Нарантуяа-Нара, О.Цогтгэрэл, М.Ганхүлэг, Г.Ганбаатар, М.Бадамсүрэн, Ц.Мөнхтуяа, Ж.Золжаргал, Н.Батсүмбэрэл, Ж.Алдаржавхлан, П.Сайнзориг, Э.Одбаяр нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Боловсролын сайд П.Наранбаяр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, С.Цэнгүүн, О.Амгаланбаатар нар үг хэлэв.

Хуралдаан техникийн саатлын улмаас 18 цаг 03 минутаас 18 цаг 22 минутад завсарлав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	61
Татгалзсан	42
Бүгд	103

59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	61
Татгалзсан	42
Бүгд	103

59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	61
Татгалзсан	42
Бүгд	103

59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	62
Татгалзсан	41
Бүгд	103

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	64
Татгалзсан	39
Бүгд	103

62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	64
Татгалзсан	39
Бүгд	103

62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	62
Татгалзсан	41
Бүгд	103

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 66

Татгалзсан 37

Бүгд 103

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын болон Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Рэгдэл, М.Ганхүлэг, Д.Пүрэвдаваа, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 65

Татгалзсан 37

Бүгд 102

63.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газрын 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн

аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар, А.Энхбат, Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан, Татварын ерөнхий газрын дэд дарга А.Энхболд, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, дэд дарга Г.Энхтайван, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын дарга Б.Цогтбадрах, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, С.Эрдэнэбат, Д.Батбаяр, Д.Үүрийнтуяа, Ж.Батжаргал, Ж.Баярмаа, Л.Соронзонболд, Д.Энхтуяа, Б.Мөнхсоёл, М.Мандхай, Б.Пунсалмаа, Ц.Сандаг-Очир, Л.Эхнасан, О.Саранчулуун, Да.Цогтбаатар, Б.Бейсен, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогтбадрах, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын

дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 19 цаг 30 минутаас 23 цаг 00 минутад хуралдааныг даргалав.

Уг асуудлыг 23 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, референт Б.Нарантуяа, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 58 минут үргэлжилж, 126 гишүүнээс 108 гишүүн хүрэлцэн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр 23 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр,
Даваа гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 02 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ирц 95 гишүүн буюу 75.4 хувьтай байгаа тул 2025 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатар 6 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн байна аа.

Хоёрдугаарт, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөлд хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороонд хороог тогтоож хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсан.

За хэлэлцэх асуудалдаа оръё.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна аа. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танилцуулна аа. Ерөнхий сайдад мэдээлэл өгье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Занданшатар: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн нэгд Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлж байна аа.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газар нь улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэж, хүний хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, төрийн оролцоог багасгах, инновац, шинэ технологи, хиймэл оюун ухаанд суурилан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шат дамжлагыг бууруулж, үйл ажиллагаанд тавих хяналт, ил тод байдлыг сайжруулж, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зэрэг зорилт арга хэмжээг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлуулсан.

Энэ хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны тогтвортой байдал, залгамж чанар, шуурхай, тасралтгүй байх зарчимд үндэслэн Засгийн газрын бодлогын тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалах зорилгоор Засгийн газрын бүтцийг зарчмын хувьд хэвээр үлдээж, бүрэлдэхүүний хувьд Ерөнхий сайд Засгийн газрын 19 гишүүнтэй ажиллах нь зүйтэй гэж үзсэн. Улсын Их Хурлаас 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах буюу тус хуулийн 1 дүгээр зүйлд заасан Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд 20 минут Үндэсний хорооны даргатай холбоотой хэсгийг тус тус хүчингүй болгож, эдгээр 3 сайд, үндэсний хороо, 4 хороодыг татан буулгаж байгаа юмаа.

Үүний хүрээнд бид тусгай чиг үүрэг бүхий сайдын институцийг бусад бодлогын яамдад зохистойгоор хуваарилж, төрийн бүтцийг цомхон, зохистой, уялдаа холбоотой, хариуцлагатай болгохыг зорьж байна. Энэ нь зөвхөн хэмнэх алхам биш харин бодлого, хэрэгжилт, хариуцлага, гүйцэтгэлийн хяналтыг нэг цонхонд төвлөрүүлж, институт хоорондын давхардлыг арилгах стратегийн өөрчлөлт юмаа.

Өнөөдөр ард иргэдэд цалин, тэтгэвэр, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, орон сууцжуулах зэрэг олон тулгамдсан асуудал байна аа. Сүүлийн үеийн олон нийтийн судалгаагаар 10 иргэн тутмын 4 нь амьдрал муудсан, 5 нь өөрчлөгдөөгүй гэж

хариулсан байна. Энэ бол бодлогын үр дүнг иргэд мэдрэхгүй байгааг харуулсан анхааруулга гэж үзэж байна.

Иймд манай Засгийн газар судалгаанд үндэслэсэн бодлогыг хэрэгжүүлж, ард иргэдийнхээ өмнө тулгамдаад байгаа асуудлуудыг зөв эрэмбэлж, иргэдийн амьдрах орчин нөхцөлийг иргэддээ ээлтэй болгохын тулд иргэдийнхээ санал бодлыг сонсож хамтдаа шийдэл гарцаа гаргаж ажиллана аа. Олон улсын харилцаа геополитикийн хурцадмал нөхцөл байдал хэвээр үргэлжилж байгаа энэ цаг үед худалдааны тарифын зөрчилдөөн, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн уналтаас үүдэлтэй эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах улс орны хөгжлийн өмнө тулгамдсан томоохон сорилт бэрхшээлийг харилцан ойлголцолд тулгуурлан зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэх, үндэсний эв нэгдлийг хангаж ажиллах зайлшгүй шаардлага тулгарч байна аа.

Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан ийм учраас Үндэсний баялгийн сангийн асуудал, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах нэгдсэн бодлого, төрийн бүтээмж, нээлттэй засаглалын түншлэлийн асуудал, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын, хууль тогтоомж Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудлыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын, хилийн бүс дэх тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, хилийн боомтын хөгжлийн бодлого төлөвлөлт, хилийн боомтын болон стратегийн орд газрыг холбосон дэд бүтцийн бүтээн байгуулалт, шинэчлэлийн асуудлыг Сангийн сайдын, хотын хэт төвлөрлийг сааруулж, нийгмийн үйлчилгээг 20 минутын дотор авах хүнд ээлтэй шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэх бодлого зохицуулалт, авто замын түгжрэлийг бууруулах асуудлыг Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудалд тус тус хамааруулахаар заалаа.

Түүнчлэн дээрх өөрчлөлтүүдтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчид өөрчлөлт оруулахаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна гэж заасны дагуу дэвшүүлсэн бодлого зорилтоо хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ ээ. Энэ өөрчлөлтөөр шинэ Засгийн газрын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс суурь бүрдэхээс гадна давхардсан чиг үүргийг арилгаж, бодлогын хэрэгжилт сайдын шууд хариуцлагад хамаарах, үр ашиггүй бүтэц, зардлыг багасгах, төрийн хариуцлага, гүйцэтгэлийн хяналт сайжрах боломжтой болно гэж үзэж байна аа.

Хуулийн төсөл батлагдсанаар дараах зорилтуудыг хэрэгжүүлэхийг зорино. Энэ бол ард иргэддээ ойрхон, ээлтэй, тэднийгээ сонсож ажлаа хийдэг, хэрэгжүүлдэг төр байх. Монгол хүний хөгжил бол төрийн бодлогын цөмд байх, хөдөлмөр эрхлэлт орлогын шинэ боломжийг сайжруулах, хот хөдөөд тэгш хөгжих үндэс бүсчилсэн хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх, цомхон, чадварлаг, зохистой төрийг төрийн бүтээмжийг сайжруулах, татварын шинэчлэлийг хэрэгжүүлэх, Засгийн газар ил тод байж, эргэлтийн оролцоог хангах зэрэг зорилтуудыг хэрэгжүүлж, үндэсний

сөрөн тэсвэрлэх чадварыг бүх түвшинд дээшлүүлэхийг зорьж байна аа. Энэ зорилгоор бүсчилсэн хөгжил, ногоон шилжилт, мега төсөл, цахим шилжилт зэрэг тогтвортой хөгжлийн суурь бүтээн байгуулалтуудыг эрэмбэлэн зорилт шаардлагад нь нийцүүлэн ард иргэдийн хүсэл зорилгод нь нийцүүлэн эрэмбэлж, дэс дараатай хэрэгжүүлэх энэ зорилтыг дэвшүүлж байна.

Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй холбогдуулан Засгийн газрын зарим гишүүний эрхлэх асуудлын хүрээний нийтлэлийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулан өргөн мэдүүлсэн болно.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ.

Цаг үеийн байдалтай холбогдуулан эдгээр хуулийн төслүүдийг нэн яаралтай горимоор хэлэлцүүлж өгч байгаад талархал илэрхийлэхийн зэрэгцээ үр бүтээлтэй шуурхай баталж өгнө гэдэгт итгэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслүүдийн талаарх ТББХ-ны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна аа. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдаас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хуулийн төсөлд Улсын Их Хурлаас 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай оруулах буюу тус хуулийн 1 дүгээр зүйлд заасан Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот, Үндэсний хорооны даргатай холбоотой хэсгийг тус тус хүчингүй болгохоор тусгасан байна аа.

Үүнтэй холбогдуулан Засгийн газрын зарим гишүүдийн эрхлэх асуудалд өөрчлөлт оруулахаар тусгажээ. Байнгын хорооны хуралдаанаар хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаяр төсөл нь өмнөх Засгийн газрын бодлогын уламжлалыг хадгалж байгаа эсэх, Засгийн газрын хяналт

хэрэгжүүлэх газрыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд ажиллуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрыг Эдийн засаг хөгжлийн сайдад шилжүүлсэн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа төрийн албаны удирдах албан тушаалтнуудын тоог цөөлөх, төрийн албаны реформ, ажиллах хүчний дутагдалтай салбарын талаар мөн Засгийн газрын 14 мега төсөл үргэлжлэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир буруу бүтэц давхардсан чиг үүргийн улмаас улсад учирсан хохирол хариуцлагын талаар хууль санаачлагчаас асуулт асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар төрийн албан хаагчдыг 9 хувиар бууруулах үндэслэл, шаардлагаа тодорхой болгож, энгийн төрийн албан хаагчид руу бус давхардсан чиг үүрэг бүхий удирдах албан тушаалтанд чиглүүлэх талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 75 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 75 хувийн саналаар, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 75 хувийн саналаар, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 75 хувийн саналаар, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 68.8 хувийн саналаар, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 81 хувийн саналаар, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 81.3 хувийн саналаар, Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай хуулийн Улсын Их Хурлын тогтоолын төслийг 81.3 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийг танилцуулъя. Гомбожавын Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд, Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Болдын Жавхлан Сангийн сайд, Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх

зүйн газрын дарга, Бат-Эрдэнийн Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын референт, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Нийт 24 гишүүн асуулт асуухаар нэр урьдчилж ирж байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэх дээр нэг дөрөв, тавхан хоногийн дотор дахиад бүтцээ оруулж ирж байна л даа. Түрүүн одоо бүтцээ оруулж ирэхгүй уул нь бүтцээ оруулж ирж байж дараа нь бүрэлдэхүүнээ томилох ёстой. Тэрнийгээ яаж тойрсон юм бэ гэх дээр хуучин Засгийн газрын бүтцээр явж байгаа гэж тойроод тэгсэн мөртөө яг нөгөө нэг хууль хэлэлцүүлэх явцад болох дээр Ерөнхий сайдын мэдэлд биш Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд аваачаад ингээд яг бүтцийн шинжтэй юм зүйлүүд хийсэн л дээ. Тэгээд одоо Үндсэн хуулийн цэцэд өгөөд бас та нар тэгээд аргалаад гарах байх л даа.

Тэгэх дээр ер нь бол энэ одоо энэ хууль бүтэц оруулж ирж байгаагийн гол үндсэн шалтгаан нь бол төсвийн тодотголыг хийхдээ ард иргэдийн саналыг авахгүйгээр өөрөөр хэлбэл иргэд мэдэх эрхгүйгээр тэр төслийг хийж байгаад харамсаж байгаа. Гол одоо өөрчлөлт нь энэ л байгаа юм. Та нар мэдэх шаардлагагүй ээ, бид нар бол та нарын төлсөн татварыг дураараа зарцуулна гэдэг энэ л концепцын үүдэн дээр энэ одоо хууль орж ирж байгаа. Тийм учраас энэ дээр бол АН-ынхан одоо эсэргүүцэх ёстой. Яг энэ заалт дээр нь. Мэдээж бүтэц бүрэлдэхүүний асуудал бол тодорхой явж таарах байх.

Тэгэх дээр Их Хурлын Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.9 дээр хэрэв Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хуулийг оруулж ирэх юм бол үзэл баримтлалын хувьд тусад нь хэлэлцэнэ гэж байгаа юм. Заавал үзэл баримтлалаас тусдаа бичиг баримт шаардаж шаардах шаардлагагүй. Тэгэхдээ тусад нь хэлэлцэнэ гэж байгаа юм. Тэгэх дээр энэ тусад нь хэлэлцэхдээ тэр нөгөө нэг дагуулж одоо Төсвийн тухай хуулийг оруулж ирэх тухай асуудал энэ хууль дээр чинь байхгүй байхгүй юу даа. Ер нь бол энэ нэг удаагийн өөрөөр хэлбэл Засгийн газрын Занданшатар даргын Ерөнхий сайдын нэг удаагийн энэ Засгийн газрын бүтцийг батлах бүрэлдэхүүнийг батлах энэ хуулийн дагуу суурь хуулиуд орж ирж тэр нь өөрчлөгдөж ерөөсөө болохгүй байхгүй юу даа. Энэ бол асар том одоо хуулийн хулгайнуудад орно. Ингэж одоо ард иргэдийн мэдэх эрхийг хааж ерөөсөө болохгүй. Тийм учраас энэ хууль дээр би эсрэг байгаагаа илэрхийлье.

Хоёрдугаарт нь өнгөрсөн бүтэн сайн өдөр энэний түрүүчийн бүтэн сайн өдөр би Лхагвасүрэн Ерөнхийлөгч, Монгол банкны ерөнхийлөгч Лхагвасүрэн болон Хаан банкны гүйцэтгэх захирал Мөнхтуяа нартай уулзсан. Тэд нар бол надад хэлэхдээ хуучнаараа тэтгэврийн зээл явахаар болсон гэж хэлээд, нэг дэх өдөр өнөөдөр

хэвлэлийн хурал хийнэ гэж амласан. Гэвч хэвлэлийн хурал өнөөдрийг хүртэл хийгээгүй байна.

Дахиад анхааруулъя. Дөрөв дэх өдөр хүртэл хийхгүй чуулганы хуралдаан хийхгүй болбол 4 дэх өдөр би ард иргэддээ энэ одоо 5 дахь өдрөөс эхлэн жагсаал зохион байгуулна гэж уриална аа. Манай ахмадууд бүгдээрээ гараад ирнэ. Тэртээ тэргүй 100 хувийн төлөлтөө тэр зээлийг хаах ямар шаардлага байгаа юм бэ? Тэр ахмадууд өнгөрөөд өглөө гэхэд ард нь батлан даагч хүүхдүүд нь бүгдээрээ төлдөг шүү дээ. Ямар ч одоо юу гардаггүй шүү дээ. Одоо зээлийн эрсдэл гардаггүй шүү дээ. Тэгээд ахмадууд хэдэн төгрөг аваад зээлээ төлөх нь та нарт ер нь ямар хамаатай юм.

Тийм учраас энэ Лхагвасүрэн ерөнхийлөгч тэр томоохон зээл өгдөг 2 Төрийн банк, Хаан банкны зээл өгдөг тэр захирлуудтайгаа хамт гарч, ард иргэдэд зөв мэдээлэл өгч, доошоо тэр дүрэм журмаа хурдан шуурхай хүргэх тэр ажлаа хийгээрэй. Шаардаж байна шүү.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүний УИХ-ын дэд даргын асуултад хариулъя. Пүрэвдорж гишүүн бол хуулиа сайн мэддэг, туршлагатай парламентч хүн. Яг төсвийн тодотголыг өнгөрсөн онд хэлэлцэж байхад, төсөв баталж байхад яг энэ хууль чинь мөрдөгдөөгүй ээ. Тэр үед та энэ асуултыг тавьж байгаад засаж байсан бол болох байсан. Өнөөдөр 7 хоног, 14 хоног битгий хэл өдөр хоногоор дэлхийн эдийн засаг өөрчлөгдөж, геополитикийн нөхцөл байдал хурцдаж байна аа. Одоо би анх томилогдож байх үед нүүрсний үнэ түүнээс шалтгаалсан түүхий эдийн үнээс шалтгаалсан төсвийн орлогын бүрдэлт 2.3 их наядаар тасрах байсан бол одоо өнөөдөр 3.3 их наяд болоод 7 хоногийн дотор 1 их наядаар орлого буурч байгаа дүнтэй байна.

Тэгээд ийм өөрчлөлтийн энэ эрин үед органик хуульд процессын хуулийг заагаад тэрнийгээ дагаж мөрдөх, тэгээд энэ гадаад, дотоод давагдашгүй хүчин зүйл олон өөрчлөлтүүдийг өөрчлөөд л Улсын Их Хурал батлаад явах бүрэн бололцоотойг уул нь сайн мэдэж байгаа. Тийм учраас Их Хурлын дэд дарга маань найз маань бас одоо улс төржих гэж байгааг ойлгож байна. Түрүүн болохоор Байнгын хороон дээр дэмжээд үг хэлээд байсныг чинь санаж байна. Баяр хүргээд байсан тийм учраас нэг л үгээрээ байгаач ээ гэж хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе ээ. Тэгээд энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний ялангуяа энэ хэмнэлтийг хэмнэлтийн горим таналт одоо хүний нөөцийн юу салбар бүхнээс нэг 20 хувь орчим, тэгээд давхардсан чиг үүргийг арилгах энэ хэмнэлтийг бол бас тодорхой хэмжээгээр ойлгож дэмжиж болно. Гэхдээ нөгөө талаараа энэ ер нь төрийн ажилд ер нь хариуцлагын зарчим гэж байна уу? Одоо ингээд салбар яамдууд, шинэ одоо салбар яам маань шинэ сайдтай боллоо. Тэгээд өмнөх нөгөө бодлогын салбар яамны бодлого хэрэгжилт, хэрэгжилт, гүйцэтгэлийг одоо яаж үнэлж хүлээлцэж, өгөлцөж авалцаад байдаг вэ гэдэг энэ асуудал байж байна.

Нөгөө талаар та энэ одоо 20 бүх салбараас 20 хувь ингэж одоо хүний нөөцийг танана гэж байгаа нь төрийн албан хаагчдыг танана аа гэж байгаа нь энэ хийг ямар үндэслэлээр ингэж тогтоож байгаа вэ? Жишээлбэл Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүн хүч дутмагшилтай байдаг, хүүхэд хамгааллын салбар бүүр хүн хүч хүрэлцдэггүй, нийгмийн ажилтан хүрэлцдэггүй гээд ингээд ам нээх болгондоо ийм юмыг ярьдаг байсан өмнөх сайд нь. Боловсролын яаманд багшийн одоо хүний нөөц ямар дутмагшилтай байгаа билээ бүгд маш сайн мэдэж байгаа. Тэгэхээр ийм зүйлүүдээ та яаж үнэлж дүгнээд бүх салбар бүрээс ингэж одоо танах ёстой гэж бодсон байгаа юм. Нөгөөтэйгүүр энэ төрийн албан хаагчид гэдэг чинь нэг ийм ёстой нөгөө 2 хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага гэдэг шиг иргэд талаасаа нэг төрийн албаны хэдэн хулгайчууд гэж хэлэгдээд байдаг, хүнд сурталтай, их зантай гээд байдаг. Нөгөө талаас төр засаг өөрөө хүссэн үедээ, хэрэгтэй үедээ томилж болдог, хэрэгцээгүй үедээ халж, зольж сольж болдог ийм одоо ажилтан, албан хаагч нар өөрөөр хэлбэл одоо нийт энэ дүнгээрээ 14 мянга орчим төрийн албан хаагчдыг ингээд хална гээд ингэж байгаа юм.

Гэтэл энэ хүмүүсийн арын амьдрал яах вэ? Цалингийн зээлтэй хүмүүс яах вэ? Яг үнэндээ энэ 14 мянган төрийн албан хаагч бол хамгийн энэ төр засгаас татлаа түлхээсгүй яг л эгэл жирийн ажил амьдралаа хийгээд явдаг байсан тэр хүмүүс л халагдана. Би тэрийг бүр маш сайн мэдэж байна. Тэгээд нөгөө татлаастай түлхээстэй хэдэн нөхдүүд нь үлдээд үргэлжлээд явдаг ийм л юман дээрээ үлдэнэ шүү дээ. Тэгэхээр энийг яаж та хангах гэж байна аа?

Дээрээс нь одоо жишээлбэл Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд шинэ сайд Аубакир сайд өөрөө ярилцлага өгсөн байсан. Давхардсан чиг үүргийг арилгана аа энийг ойлгоорой. Нөхцөл байдал ийм байна аа гээд. Тэгэхээр энэ давхардсан чиг үүрэгт бүхий ажлын байрыг бий болгоод ажиллуулаад байсан өмнөх сайд нар хариуцлага хүлээх юм уу. Ер нь зарим одоо энэ Засгийн газрын тал хувь сайд нар өмнө нь бүтэн жилийн хугацаанд энэ засгийг удирдаж авч явж байсан. Тэгээд одоо жилийн дараа энэ чиг үүрэг давхардлыг мэдэж байгаа юм уу. Нөгөөтэйгүүр энэ шинэ одоо ялангуяа яам авсан сайд нар өмнөх энэ салбар яамандаа төрийн аудитыг оруулах хэрэгтэй байх гэж бодож байна. Одоо жишээлбэл 2024 оны төсвийн гүйцэтгэл дээр манай нам дөнгөж сая одоо энэ Батбаатар дарга энэ ажлаа аваад дөрөв, тавхан хонож байгаа хүн төсвийн гүйцэтгэлийг ярина гээд явж байгаа байхгүй юу.

Тэр хүн чинь 2024 онд юу болсон юм, яасан ийснийг нь мэдэхгүй. Тэгээд одоо нэг ийм юм болсон гэдэг юмаар бид нар тайлбар өгөөд сууж байна гэдэг өөрөө буруу. Тэгэхээр зэрэг тэр 2024 онд төсвийн ерөнхийлөн захирагч байсан хүн тэр ажлыг, тэр төсвийг хэрхэн захиран зарцуулсан, хэрхэн үр дүн, хэдэн хувьтай явж байгаа вэ гэдгийг энд тайлагнах ёстой болохоос биш дөнгөж ажлаа аваад 4, 5-хан хонож байгаа хүмүүс энийг тайлагнаад суух нь хэр нийцэлтэй вэ гэж би гайхаж байна. Тэгээд одоо хамгийн гол нь одоо энэ удахгүй ингээд халагдаж солигдох энэ 14 мянган хүн чинь бас л Монгол Улсын иргэд байгаа шүү дээ тийм биз дээ. Эсвэл тусгай хүмүүс юм уу? Тэгэхээр энэ тал дээр та яг ямар дүгнэлт энэ...

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя аа. Төрийн албан хаагчдын талаар таны үнэлэмж бас зарим талаар санал нийлж

байна аа. Төрийн албаныхан бол мерит зарчмаар ажлаа хийж байгаа дийлэнх олонхыг ганц нэгхэн одоо нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино гэж авлигач, ард түмэндээ үйлчилдэггүй нүүрчилдэг ийм хүмүүсээс болоод төрийн албаны нэр хүндийг их унагаажээ. Одоо энгийн ард түмний дунд төрийн албан хаагч гэхээр, төрийн хүн гэхээр бүгдийг нь л одоо авлигач, хулгайч шиг хардаг ийм төрд итгэх итгэлийг сулруулдаг ийм болж. Ийм учраас төрийн албаны цогц шинэчлэл хийхээр зорьж байгаа.

Төрийн албаны зөвлөл Засгийн газрын Хэрэг эрхлэх дээр ажлын хэсэг байгуулж байгаа. Төрийн албаны аттестатчилал явуулахаар зорьж байгаа. Яг төрийн албан хаагчид энэ аттестатчилалд дуртай байдаг юм. Энийг ард иргэдийн санал асуулгаар тэдэнд үйлчилж байгаа байдлаар нь, тэднээс авлигал хээл хахууль нэхээд зовоож байна уу, аль эсвэл яг ард түмэндээ үйлчилж чадаж байна уу гэдгээр нь бас ангилж салгаж, цөөхөн хувьд нь бас одоо энэ албаны аттестатчилал явуулж өгөөч ээ гэж Төрийн албаны зөвлөл ч, төрийн албан хаагч ч хүсэж байгаа.

Тэгэхдээ энэ төрийн албыг цомхотгох энэ санаачилгыг чинь та баталчихсан шүү дээ. Төрийн албыг 9 хувиар цомхотго оо гээд ингээд Их Хурлаас баталчихсан шүү дээ. Энийг чинь одоо бид нар энэ жил хэрэгжүүлэхгүй бол ирэх жилийн тэр 9 хувиар цомхотгох чинь 6 сарын тэтгэмж энэ тэр гээд ирэх жилийн төсөвт дарамт үзүүлэх учраас одоо хэрэгжүүлж байж ирэх жилийнхээ төсвийн орон зайг нээхгүй болбол бид нар ийм төсвийн хайчинд орчихсон байгаа.

Ийм учраас энэ сул орон тоог байгаа орон тоог царцаах, давхардлыг арилгах, жишээлбэл би төрийн та зөндөө ярьж байснаа одоо тэр эрчим хүчний 4, 5 тавцанг бий болгочихсон. Энэ чинь хувийн хэвшлийнхэнд хамгийн их дарамт үзүүлж байдаг. Нэг газар очоод л ахиад л бичиг нэг их олон шат дамжлага. Энэ шат дамжлагыг цөөрүүлж энэ татвар төлөгчдийн мөнгийг бид бас зөв зарцуулах ёстой. Давхцалгүй, давхардалгүй, ард иргэддээ чирэгдэл багатай, төрийн албаны дунд, доод шатанд хүнд суртал, чирэгдэл ихтэй байна гэж яриад байгаа. Тийм учраас 14400 төрийн албан хаагчийг хална гэж буруу ойлгоод байгаа.

Ийм учраас энэ олон шат дамжлага үүсгээд байдаг дарга нарын тоог цомхотгох үүргийг яамдад өгсөн байгаа. Би ганцхан яамны жишээ л дурдаад байгаа. Жишээлбэл Эдийн засгийн хөгжлийн яам 28 газар, хэлтсийн даргатай. Энэ нэг 10 гаруй газар хэлтэстэй ажиллаад байх бүрэн бололцоотой гэж үзээд бүх газарт, бүх яамдад би анхны хурлаараа яамдын орон тоо, бүтцийг оновчтой, давхардалгүй, чирэгдэлгүй болгох ийм чиглэл өгч, стандарт баталсан байгаа. Стандартжуулж байгаа. 6 мянга орчим орон тоо батлагдсан ч ажилд хүн аваагүй байгааг эхний ээлжид цомхотгоё гэж байгаа. Гэх мэтчилэн төрийн албан хаагчдаас дарга нараас нь дарамт шахалт үзүүлээд байдаг, төрийн албаны шаардлага хангахгүй одоо нөгөө цүнх барьчихсан энэ тэр гээд шүүмжлээд байдаг дарга нараас чинь одоо бас эхэлж байгаа юм. 260 орчим дарга нарыг эхний ээлжид асуудлыг нь шийдэж байгаа, ярьж байгаа.

Д.Амарбаясгалан: Нарантуяа-Нара гишүүн тодруулж асууя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр энэ хуулийг бол батлалцсан. Гэхдээ хамгийн гол нь та салбар яамдуудаа энэ нөгөө гарцаагүй чиг үүрэг давхацсан одоо ажлуудыг бол цомхотгож болж байна аа. Тэгвэл еще хүний нөөц нэмэгдэлтэй байгаа энэ

зүйлүүдээ бас яаж үнэлж дүгнэж байна аа гэдэг асуултыг тавиад байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг зарим одоо салбар яаманд чинь бүүр хүний нөөц асар дутмагшилтай, хүн хүч нь хүрэлцэхгүй байгаа учраас энэ нөгөө төсөвтөө суулгасан, энэ нөгөө хөгжлийн хөтөлбөртөө суулгасан ажил үүргээ хийж чадахгүйгээс болоод бид нарыг энд ингээд өдөр болгон энд болсон болоогүй хурал хийгээд, ажил яваад байгаа ч юм шиг, явахгүй ч байгаа юм шиг байхад жишээлбэл монгол хүүхдүүдийн эрх яаж хамгаалагдаж байна аа гэдэг асуудлууд бас хөндөгдөж байгаа.

Тэгэхээр зэрэг миний гол хэлэх гээд байгаа санаа бол таныг энэ бусад энэ салбар мэргэжлийн яамдууддаа үнэхээрийн гарцаагүй байгаа хэрэгтэй шаардлагатай ажлыг. Тэгээд дээрээс нь та аттестатчилал ярьж байна. Энэ нэг талаараа зөв. Гэхдээ нөгөө талаар төрөөс ямар...

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн бас зөв санал хэлж байна. Энэ дээр бас санаачилгаар хамтраад ажиллаарай. Тэгэхдээ 1 зүйлийг би тодруулаад хэлэхэд энэ давхардал чирэгдэл чинь өөрөө хүнд суртал учруулж байгаа юмаа. 36 сарын тэтгэмж олгох ёстой. Тэгэхдээ хувийн хэвшилд одоо хүний нөөц жинхэнэ дутагдаж байгаа газар хувийн хэвшил байна. Хамгийн том ажил олгогч бол Засгийн газар болсон. Хувийн хэвшил биш.

Тэгэхээр энэ хувийн хэвшлийн ажиллах нөхцөл бололцоогоо ч нэг талаас хангах ёстой. Тэрэн дээр орон зай гаргаж өгөх ёстой, төрийн албаа ч, татвар төлөгчдийн мөнгийг ч цомхон, чадварлаг үр ашигтай болгох ёстой. Ингэж байж нийт тэнцвэрээ олж байж одоо олон жил ажиллаж байгаа туршлагатай, мэдлэг чадвартай, шударга төрийн албан хаагчдаа дэмждэг тогтолцоо бий болно. Харин төрийн албаны нэр хүндийг унагаад байдаг, авлига хээл хахууль нэхээд чирэгдүүлээд байдаг энэ төрийнхөө нэр хүндийг өсгөх хэрэгтэй байна аа гэдэг зорилгоор л төрийн албаны аттестатчилал бодлого чинь хэрэгжих юмаа гэдгийг онцолж байгаа юм. Бүх чиг үүргийг төрөөс хийх тохиромжгүй. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх хуультай.

Д.Амарбаясгалан: Нарантуяа-Нара гишүүн дахин тодруулж асууя.

М.Нарантуяа-Нара: Гол нь Ерөнхий сайд аа, энийг энэ би түрүүн хариуцлагын зарчим ярьсан дээрээ сая цаг амжсангүй. Одоо ингээд өмнө нь энэ чиг үүргийн давхардлыг бий болгоод ажиллуулаад байсан энэ сайд нартаа ямар хариуцлага тогтох юм бэ? Хэрэгтэй болохоороо нээчихдэг, хэн нэгэнд зориулаад агентлаг, газар, хэлтэс нээгээд ингээд орон тоо хүний нөөцийг юу яагаад төсвийн мөнгө ч цалингаар урсаад байдаг энэ байдлыг бий болгосон хүмүүстээ тэгвэл өмнөх хүмүүстээ хариуцлага тооцохгүйгээр дараа дараа яах вэ. Жишээлбэл энэ төр засаг ч гэсэн өөрийн гэсэн цаг хугацаатай. Тэгэхээр энэний дараа дахиад энэ буруу байсан байна аа гээд нээх энэ эрсдэлээс сэргийлэхийн тулд бид нар хариуцлагын механизмыг ярих ёстой байна гэж бодож байна. Та энэ тал дээр юу гэж бодож байна?

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн ээ, би бас дахин хариулаад байна л даа. Энэ сайд нар чинь өөрсдөө ингээд орон тоо бүтэц бий болгочихсон юм биш ээ. Энэ хуулийг нь та баталчихсан, та бүхэн баталчихсан. Тэгэхээр тэр бүхэнд хариуцлага тооцох чинь одоо энэ хуулиар л өөрчлөлт оруулж засаж байгаа болохоос биш тэр үндэсний хороод, одоо татан буулгаж байгаа 11 хороо, 9 сангийн асуудал маань дандаа хуультай, тогтоомжтой, зохион байгуулалттай учраас өнөөдөр оруулж ирээд хуульд өөрчлөлт оруулж байна. Энэ бол хамтын гаргасан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлээд явж байсан тэр сайд нарыг буруутгах нь би бол харин тэр хуулийн хэрэгжилтэд алдаа гаргасан бол, завхрал гаргасан бол, дутагдал гаргасан бол, зөрчил гаргасан болбол хариуцлага тооцох үүргийг өгч Ерөнхий сайдын албан даалгавар сахилга хариуцлагыг сайжруулах талаарх албан даалгавар анхны хурлаараа бүх сайд нарт өгөгдсөн байгаа. Урдах ажлаа үнэлж, дүгнэх сангийн зөрчлүүдийг ил тод болгох, нээлттэй, ил тод болгох, аудит хяналт шалгалт хийх бүх үүрэг, бүх сайдад оногдсон байгаа гэдгийг би онцолж байна.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Засгийн газар Ерөнхий сайд томилогдоод сайд нар бүрдээд арай 7 хоноогүй байх шиг байна. Энэ цөөхөн хоногийн дотор Засгийн газар одоо бүгдээрээ л төр ер нь аймаар данхар болчихсон байна, төрийн үр ашгийг ярья. Төрийн өмчит компаниа цэгцэлье гээд их асар их хариуцлагатай зүйлсүүдийг өнгөрсөн цөөхөн хоногийн дотор ярьдаг болчихлоо. Үнэхээр та бүхэнд бас баяр хүргэе, амжилт хүсье. Өнгөрсөн хугацаанд яг энэний эсрэг сарын өмнө, 2 сарын өмнөөс л яг энэний эсрэг зүйлийг өмнөх төсөв төсвийн тодотголудын үеэр тас эсрэг зүйл ярьдаг байсан ингээд богино хугацаанд өөрчлөгдөж байгаад нь одоо амжилт хүсье ээ.

Эдийн засгийн хүндрэл хаалга тогших биш бүр ингээд ороод ирчихсэн бодитойгоор. Тэр иргэд бизнес дээр аль хэдийнэ мэдэгдээд эхэлчихсэн. Тэгэхээр муу зүйлд ч гэсэн бас сайн талууд байдаг юм гэнэ лээ. Одоо энийг ашиглаад хэчнээн хэдийгээр хүндрэлтэй асуудал гарах ч гэсэн энийг ашиглаад тэр эдийн засгаа зөв зүйтэй болгох энэ олон олон зүйл алхмуудыг хийхийг одоо бүрэн дүүрэн дэмжиж ажиллана аа. Харин энэний хүрээнд аль болох тийм иргэдээс биш анхан шатны албан хаагчдаасаа илүү тэр дарга цэрэг нэрээсээ, тэр бизнесүүдээсээ биш болж өгвөл тэр төрийн өмчөөсөө эхэлж тэр хасалт таналт олон зүйлүүдээ хийх бодлогоо барих нь одоо их зүйтэй.

Энэ асуудлаасаа гадна өөр Ерөнхий сайдаас өөр нэг зүйл асуух гэсэн юм. Ер нь Ерөнхий сайдын болоод Засгийн газрын эрхлэх асуудлын хүрээнд төрийн болоод албаны нууц, төрийн нууцтай холбоотой асуудлууд байдаг аа. Та ер нь энэ төрийн нууцтай холбоотой асуудлууд дээр ямар бодлого барьж ажиллах вэ? Өнгөрсөн хугацааны улс даяараа шуугьсан нөгөө их айхтар олон оффтек гэрээнүүд чинь зарим нь одоог хүртэл нууц хэвээрээ л байгаа шүү дээ. Энэ нууцуудын чинь цаана л эдийн засгийн хүндрэлийн олон олон зүйлүүд л нуугдсаар л байгаа шүү дээ. Энэ дээрээ та нэгдүгээрт нь ямар бодлого чиглэл баримтлах юм.

Хоёрдугаарт нь ер нь энэ төрийн нууцтай холбоотой төрийн нууцыг ил болгох асуудал дахиад Засгийн газар, Ерөнхий сайдад байдаг эрх үүрэг нь. Энэ Зориг агсны хэрэг гэдэг хэрэг дээр та ер нь та болоод танай Засгийн газар энийг ил болгох,

шаардлагатай зүйлсийг нь олон нийтэд нээлттэй тавих зүйлсийг одоо хийвэл яасан юм бэ? Зориг агсны хэрэг гэдэг өөрөө сүүл сүүлдээ одоо бүүр домгийн шинжтэй болоод гучаад жил болчихсон, улс төрийн арга хэрэгсэл. Сонгуульд ялчихвал энийг илрүүлэх гэж байна гэж хэлдэг. Одоо илэрчихсэн бараг маргааш нөгөөдөр зарлах гэж байна гэж хэлдэг, сонгуулийн арга хэрэгсэл болдог. Саяхны сонгуулийн л арга хэрэгсэл болоод л баахан кино ший болоод л явж байсан. Энэ одоо нэг ийм тодорхойгүй байдал нууц зүйл чинь өөрөө дараа дараагийн ард иргэдийн бухимдал, ард иргэдийн тэр бие биеийнхээ тархи толгой угаадаг, эсэн бусаар ашигладаг энэ зүйлийн л нэг хэрэг болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр одоо энэ гучаад жил болж байгаа энэ хэрэг дээр та ер нь ямар бодол саналтай байдаг юм? Энэ чинь өөрөө дахиад энэ 3, 4 шатны, 3 шатны Дээд шүүхээр шийдэгдсэн гэж үзэж болох хүмүүс хүртэл одоо айл өрхийн телевизээр гараад, шударга ёс яриад сууж байдаг. Энэнд чинь дахиад л төрийн үнэлэмж, шүүхийн үнэлэмж олон олон зүйл чинь энийг дагаж бас унаад байна шүү дээ. Тэгэхлээр яг энэ асуудал өөрөө Засгийн газрын эрх хэмжээний асуудалд байдаг болохоор энэ дээр та нэг бас нэг тодорхой байр суурь илэрхийлээч. Энэ болбол үнэхээр мэдээж тэр гүйцэтгэх ажлын мөрдөн байцаалтын гээд олон зүйл ярьж болох байх л даа. Тэгэхдээ л энэ чинь одоо хугацаа дамжаа хэмжээ, улс төрийн тэр нэг байр суурь, элдэв янзын зүйлд ашигладаг зүйл нь одоо хэрээс хэтэрлээ шүү дээ. Одоо энийг нэг таслан зогсоовол ер нь яасан юм.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн маш чухал асуулт асуулаа. Энэ асуултыг бол нарийн тодорхой судлаад танд хариуг нь өгөх нь зүйтэй гэж бодож байна. Ер нь мэдээж төр юм чинь нууцтай байх ёстой, тэр хуулиа дагаж мөрддөг байх ёстой. Гэхдээ онцын шаардлагагүй асуудал бол Засгийн газрын хуралдаанаар нууцаас гаргаж болдог. Хэрвээ тийм тодорхой асуудлууд байх юм болбол тэр нууц Монгол төрийн аюулгүй байдал нууцлалд үл хамаарах бол тэрнийг нууцлалаас гаргаж, олон нийтэд ил тод мэдээлэх болно. Энэ ил тод байдал гэдэг бол хяналтын хамгийн сайн хэлбэр. Хэвтээ хариуцлагын тогтолцоо гэж ардчилсан нийгмийн чухал хэлбэр.

Энийг бид төгөлдөршүүлэхийн төлөө тантай хамтарч ажиллаж энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль, олон санаачилгуудыг хэрэгжүүлж байсан. Энэ бол хэрэгжих бололцоотой. Зориг агсны хэргийн талаар ч гэсэн би хэргийн материалтай уншиж танилцаагүй мөртөө би бас энэчээнээс цээж мэдэн ярих бололцоо алга байна. Тийм учраас энэ асуудлаар манай Хууль зүй, дотоод хэргийн сайд Мөнхбаатар танд бас хариулт өгнө. Судлаад хариу...

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя. Алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Өдрийн мэндийг хүргэе ээ. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнтэй холбогдолтой, бас гишүүдийн дунд яваад байгаа бас нийт олон нийтэд бас яваад байгаа асуудлыг яг албан ёсоор бас нэг тайлбар өгчих нь бас зөв байх аа гэж бодож байгаа. Үндсэн хуулийн зөрчлийн асуудал байх уу, дарааллын хувьд бас зөв үү, буруу юу гэдэг дээр бас одоо гишүүд болон олон нийт бас жоохон эргэлзээтэй байгаад байна аа. Хэдийгээр Ерөнхий сайдын маань бас бүрэн эрхийн

асуудал боловчиг хуулийг бас одоо ингээд хэсэгчлэн биелүүлэх байдлаар асуудалд бас хандах нь зөв үү, буруу юу гэдэг дээр л эргэлзээд байгаа юмаа.

Тэгэхээр энэ одоо бас тодорхой асуудал дээр зарим сайдуудаа томилоод, заримыг нь үлдээж байгаад ингээд дарааллын хувьд бас буруу явж байгаа энэ байдалдаа албан ёсны бас нэгдсэн тайлбар өгөөд ингээд явах нь зөв өө. Цаашдаа бас хууль тогтоох энэ байгууллагын хувьд бол тодорхой асуудлууд дээрээ бас тодорхой хариултуудаа өгөөд ингээд шийдлээ гаргаад явах нь зөв өө гэсэн эхний асуулт байгаа юмаа.

Хоёр дахь нь Үндэсний хороодын асуудлууд дээр бол бид бүхэн гал унтраадаг гэхээсээ илүүтэй яг гарч байгаа асуудал дээрээ төвлөрөөд ялангуяа энэ боомтын асуудал, эрчим хүчний асуудал, мөн дээрээс нь энэ түгжрэлийн асуудал гээд тухайлсан асуудлуудаа илүү бас өөр түвшинд гаргаж ирье ээ. Яамдууд хоорондын одоо бас энэ дундын энэ асуудлуудыг бас нэгдсэн байдлаар зохион байгуулалт хийгээд явъя аа гэсэн энэ агуулга, мөн чанар дээр бол энэ одоо үндэсний хороодууд энэ асуудал хариуцсан сайдууд бол гарч ирсэн. Тэгэхээр түгжрэл болон энэ хот төлөвлөлтийн асуудал, боомтын асуудлуудыг бид бүхэн бас Засгийн газрын олон асуудлын нэг хэсэг болгоод ингээд хуучин шигээ бас ингээд асуудлыг эрэмбэлдэг биш нэг арай өөр хэлбэр лүү бас орчих уу? Энэ асуудлуудын ач холбогдлыг бууруулахгүй байх тал дээр цаашдаа бас яах нь зөв бэ гэдэг дээр хоёр дахь асуултаа бас асууя.

Гурав дахь нь бол хөдөө аж ахуйн салбартай холбогдолтой асуулт байгаа юмаа. Хөдөө аж ахуйн салбарын экспортын бүтээгдэхүүнийг илүү нэмэгдүүлэх чиглэл дээр яг аль одоо бас Засгийн газрын энэ бүрэлдэхүүн хариуцаж явах вэ? Эдийн засаг, хөгжлийн яам уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх гэдэг энэ чиглэл дээрээ голчлоод явах уу, эсвэл Хөдөө аж ахуйн яам хариуцах уу? гадаад улсуудтай бас харилцаа хийж байгаа мөн одоо бас тодорхой энэ протоколууд Засгийн газар хоорондын энэ хамтын ажиллагааг сайжруулах гэдгээрээ Гадаад харилцааны яам хариуцах уу гэдэг дээр бас яг нэг нэгдсэн байр суурьтай болмоор байгаа юмаа.

Хөдөө аж ахуйн яаман дээр гээд тэгэхэд гадаад харилцааны бас цөөхөн хэдхэн мэргэжилтэн үүнтэй холбогдолтой тодорхой мэргэжил, бодлогуудыг тодорхойлоод явахад бол бас хүндрэлтэй. Тэгэхээр цаашдаа бид бүхэн эдийн засгийг солонгоруулах мөн одоо бас нээлттэйгээр энэ экспортоо дэмжих чиглэлээр явна аа гэвэл энэ бүтэц бүрэлдэхүүний чадамж илүү сайжрах бас хэрэгцээ байгаад байгаа юмаа. Мөн хөдөө аж ахуйн салбар дээр бас Ерөнхий сайдад би бас өөрөө уламжилсан. Шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбогдолтой энэ хуучин Үндэсний хорооны зохион байгуулалттай явж байсан энэ статус бас яг хаана очиж явах вэ гэдэг энэ дээрээ бас одоо албан ёсны тайлбараа бас өгөөд, зохион байгуулалтдаа бас ороод явах нь зөв болов уу гэсэн ийм байр суурьтай бас байгаа юмаа. Ингээд эдгээр асуултдаа хариулт авъя аа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ээ. Энд ямар ч хууль зөрчсөн асуудал байхгүй. Бүх асуудал Үндсэн хуулийн дагуу явж байгаа. Хуульд сүүлд орсон нэмэлт, өөрчлөлтөөр энэ бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал маань Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн барьж байж

хэлэлцэгдэх шаардлагатай гэж одоо Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хуульчид бүгдээрээ ярьж байгаад энэ процедураар явж байгаа юм. Яагаад гэхээр нэн яаралтай горимоор хэлэлцэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэдэг. Засгийн газрын хуралдаан бүрдэхийн тулд сайд нараа томилох шаардлагатай. Ийм учраас энэ бол хууль эрх зүйн хувьд бид хуульчдаас ярьж хэлэлцэж байгаад Улсын Их Хурлын Тамгын газрын хуульчид, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хуульчид хэлэлцээд явж байгаа юм шүү. Түрүүн зарим гишүүд юу гэхдээ тайлбар хийгээгүй болохоор энэ буруу ойлголт яваад байх шиг байна. Хууль зүйн хувьд ямар ч асуудалгүй.

Засгийн газрын бүрэлдэхүүний хууль дээр битгий хэл төсвийн тодотголтой хамт хэлэлцэж байж одоо энэ үндэсний хороод энэ тэр татан буугдахад төсвийн ерөнхийлөн захирагч нар солигдоно. Төсвийн тодотгол хийх яг ийм дарааллаар явж төсвийн тодотгол зайлшгүй хийгдэх шаардлага үүсэж байгаа юм.

Хоёрдугаарт нь бол тэр хороод боомтуудын асуудлууд ер нь маш олон асуудал бий. Жишээлбэл одоо бид нар энэ Хөдөө аж ахуйн хоршооны асуудал аа. Мэдээж хоршоо бол хөдөө аж ахуй дийлсэн малчдын хоршооны асуудал яригдаж байгаа. Тэгэхдээ энийг Шадар сайд дээр одоо үндэсний хорооны асуудал үлдээд, Шадар сайдын түвшинд буюу салбар хоорондын зохицуулалт хийж, үндэсний хэмжээний хоршоожуулах хөдөлгөөнийг өрнүүлж, одоо энэ аймаг, сумдыг үр ашигтай болгох, мал аж ахуйгаа түүхий эд бэлтгэлээс нь авхуулаад гадаадад экспортод гаргах хүртэл энэ бүх боломжийг хангадаг шинэ тогтолцоог бүрдүүлэх гэж байгаа юм. Энэ дээр одоо та бүхэн маань өөрсдөө бас санаачилгатай ажиллах хэрэгтэй байна.

Худалдаа гэдэг тусдаа мянган жилийн түүхтэй эрх зүйн салбар байхгүй юу. Худалдааны хууль байдаггүй. Тэгэхгүйгээр Хөдөө аж ахуйн яам авах гээд л, Гадаад харилцааны яам авах гээд л, Эдийн засгийн яам авах гээд байдаг асуудал биш. Энэ худалдааны эрх зүй, худалдааны салбар гэдэг юм маань өөрөө экспорт, импорт, дотоод гадаад худалдаа тэгээд л одоо демпингийн бодлогоос авхуулаад л дотоод зах зээлээ хамгаалах бодлого цогц бодлого байж байж үндэсний үйлдвэрлэл, эдийн засаг хөгждөг юм.

Ийм учраас энэ Худалдааны хууль, шинэ хоршоо, Цагаан хувьсгал, цагаан хаалт энэ хөтөлбөрүүдийг уялдуулах талаар санаачилгатай ажиллаач ээ гээд би өдөр тантай уулзаад хэлсэн биз. Тэр ажлуудаа харин та бүхэн маань санаачилгатай ажиллаж энэ хууль эрх зүйн хувьд нь холбоотой ажиллах шаардлагатай байна аа гэдгийг би онцолж хэлмээр байна.

Ер нь гадаад худалдааны салбарын асуудал нь Гадаад худалдааны яаман дээр яах вэ хил, гааль, боомт гээд олон асуудлууд бий. Одоо хилийн асуудал гэхэд ч гэсэн би дээр ярьж байсан. Боомтын асуудал. Зам, тээврийн хөгжлийн яамны асуудал. Дэд бүтцийн хувьд. Гадаад харилцааны яамны асуудал. Хоёр улсын хил дамнасан асуудал учраас Сангийн яамны асуудал, Хил хамгаалах ерөнхий газрын асуудал гээд. Ийм гаалийн асуудал яагаад гэвэл нөгөө Сангийн яаманд байдаг ийм олон салбар дундын зохицуулалт шаарддаг салбар байхгүй юу. Тэгэхээр энэ дээр зайлшгүй салбар дундын ажлын хэсэг хороо байгуулагдаж ажиллана. Хуучин тийм механизм байсан юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх...

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Тийм хөдөө аж ахуйн экспортыг дэмжих чиглэл дээр бол яалт ч үгүй бас санал нийлж байгаа юмаа. Ерөнхий сайдыг бас одоо яг энэ бүрэлдэхүүнтэй холбогдолтой асуудал анхаарч байгаа дээр яг энэ хөдөө аж ахуйн салбарын экспортоо нэг бас ахиулах чиглэл дээр. Одоо бол нэг мах, ноос ноолуур. Ингээд нэг одоо цөөхөн хэдхэн нэр төрөл дээр л одоо явж байгаагаа илүү одоо сайжруулах чиглэл дээр илүү тодорхой далайцтай энийг одоо бас нэгжийг Засгийн газрынхаа бас бүрэлдэхүүнд бий болгоод ингээд яваасай гэдэг. Тэгээд нэг нэгэн рүүгээ одоо шидээд байхгүйгээр яг энэ одоо хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг экспортод гаргах чиглэлээр дагнасан энэ бүтэц нь маш тодорхой юу хийх нь тодорхой. Тодорхой үр дүнгээрээ бас одоо ингээд тайлан мэдээллээ өгөөд явдаг байдал нь бол Монголын бас олон одоо бас хөдөө аж ахуйн салбарынхан төдийгүй иргэдэд бас хэрэгтэй байгаа юмаа.

Тэгэхээр энэ чиглэл дээр бас аль чиг үүрэг нь байх вэ гэдгийг л тодруулаад байгаад энэ дээрээ бас анхаарах нь зөв байх аа тийм.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд ээ. Ерөнхий сайд дөнгөж саяхан хамгийн том ажил олгогч бол Засгийн газар боллоо гэж хэлж байна. Ер нь яах вэ, бүтцийнхээ хуулийг, энэ хуулиа, өнөөдөр хэлэлцэж байгаа хуулиа эхэлж оруулж ирээд, дараа нь Засгийн газраа байгуулсан бол их зүгээр байх байсан даа. Тэгээд яах вэ Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт уншигдчихлаа. Тэгээд Үндсэн хууль зөрчсөн эсэхийг чинь цаг хугацаа харуулах биз. Яах вэ хууль нь өмнө нь орж ирсэн бол би бас танд санал хэлэх гээд байсан юм. Ер нь нэг энэ төрийн энэ хэтэрхий энэ данхар энэ бүтцийг нэг жимбийлгээд цомхон бас энэ цаг үедээ зохицсон Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг оруулж ирэх болов уу гэсэн хүлээлттэй байсан юм.

Та харин сая яг миний асуух гэж байсан асуултад Ганхүлэг гишүүний асуултад хариулж байх явцдаа дурдчихлаа. 2015 онд би энэ урд хөршид нэг саммитад оролцоод явж байсан томоохон худалдааны. Урд хөрш цахим худалдааныхаа хуулийг тэр үед баталж байсан юм. 10 жилийн өмнө. Бид үндсэндээ худалдааны хуульгүй, ялангуяа энэ цаг үеийн энэ цахим худалдааг зохицуулах ямар ч эрх зүйн орчингүй явж ирлээ. Худалдааны яам байгуулах байсан болов уу гэж би бодол байсан юм. Хэрвээ хууль нь бүтцээсээ өмнө одоо хуулиа оруулж ирсэн бол.

Цахим худалдааг миний асуулт. Цахим худалдааг зохицуулах талаар ямар арга хэмжээ авах вэ? Цахим орчинд энэ худалдааны салбар одоо хил хязгааргүй болж, худалдааны бизнес, түрээсийн лангуу, худалдааны бизнес эрхэлдэг олон аж ахуйн нэгжүүд бол Монголд бас үүд хаалгаа хааж байгаа. Цахим худалдаанд энэ гадагшаа урсаж байгаа мөнгөн гүйлгээг яаж хянах юм. Одоо энэ гаальтай карго гэдэг ойлголт бий болчихлоо шүү дээ.

Тэгэхлээр энэ гаальтай карго гэдэг ойлголт дээр цахим худалдаанаас гадагшаа гүйлгээ болоод энэ цахим худалдаанаас яаж татвараа авах энэ талаар ямар бодолтой байгаа юм. Цахим худалдааны ашиг гэдэг бол одоо харьцангуй ойлголт болж байхгүй юу. Яг үндсэндээ ингээд шууд худалдан авалт хийж байгаа хүн бол харьцангуй гайгүй. Гэтэл энэнд ямар ч зохицуулалт байхгүй. Цахим

худалдаагаа больё гээд тэгэхэд үндэсний үйлдвэрлэгч нь худалдааны байгууллагын үндэсний үйлдвэрлэгчээсээ илүү ашиг олдог ийм л орчинд бид нар ажиллаж амьдарч байна. Яг энэ дээр ямар байр суурь баримтлах вэ гэдэг асуулт байна аа?

Д.Амарбаясгалан: За хариулт өгье. Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Засгийн газрын бүрэлдэхүүний хуулийн хэлэлцүүлэг дээр бол ямарваа нэгэн хуулийн зөрчил байхгүй ээ. Ийм ч практикт прецедент жишигтэй. 2021 онд Засгийн газрын гишүүдээ томилоод, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах гээд явж байгаад бараг жилийн дараа бүрэлдэхүүний хууль бүтцийн хуульд өөрчлөлт оруулж байсан жишиг ч бий. Бүрэлдэхүүний хуулиа өөрчлөлт оруулаад явж байсан жишиг ч бий. Бүх Засгийн газрын өмнөх жишгүүдийг судалж байгаад өнөөдрийн жишиг хуулийн зөрчилгүй гэж явж байгаа гэдгийг би онцолж байна.

Хоёрдугаарт таны тантай бол 100 хувь санал нэг байгаа юм. Ер нь бидэнд эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийхгүй бол худалдааг дэмждэг эдийн засаг болчихсон. Нэмүү өртөг нэмдэг үндэсний үйлдвэрлэлийн салбар хохиролтой, энэ худалдааны бодлого алдагдсан. Худалдааны яам, экспорт импортын зөвлөл, хороо, экспорт, импортын банк гэсэн тэгээд гааль гэсэн нэг ийм цогц тогтолцоо байж байж худалдааны схем худалдааны эдийн засгийн худалдааны эрх зүйн орчин, бүтэц тогтолцоо ажилладаг ийм журамтай. Харамсалтай нь ингээд 30 жил гажуудсан юмыг нэг өдөр нэг өргөс авсан юм шиг засах бололцоо алга.

Ийм учраас бид Эдийн засаг, хөгжлийн яамыг бараг үндсэн хуульчилж байж шинээр байгуулж, эдийн засгийн худалдаа юмнууд уул нь худалдааны бодлогоо зангидъя гэж төлөвлөж анх энэ эдийн засгийн хөгжлийн бодлого тогтвортой байна аа гэдэг үндсэн санааг Үндсэн хуульд оруулсан юм байгаа юм. Экоммерсын хууль ч гэсэн яг тантай адилхан. Одоо энэ манай орчинд хамгийн дутагдаж байгаа энэ зүйл ийм болоод байна.

Тэгтэл манайх одоо экспанент хөгжлийн загвар буюу үсрэнгүй хөгжлийн загвар бол энэ цахим шилжилтээр хийх бололцоотой. Энэ рүү бид онцгой анхаарч ажиллана. Энэ ташрамд бас дэлхийд Монгол Улсынхаа нэрийг цуурайтуулж, Монгол бахархал омогшлыг төрүүлсэн Монголын залуучууд, Монгол Зи багийн хамт тамирчдадаа Испортын Монголын нэрийг дэлхийд цуурайтуулсан тамирчдадаа бас баяр хүргэе ээ. Энэ индрийг ашиглаад гэж бодож байна. Үнэхээр энэ залуучуудын маань энэ авьяас чадварыг дэлхийд харуулж чадлаа. Цөөхөн хүндээ Монголын залуучууддаа бас баярлаж байна. Тэгэхээр энэ бол нэг яруу тод жишээ. Монголчууд И дижитал шилжилтийг яаж хийж болох вэ гэдгийг. И Коммерс ч гэсэн энэний нэг салшгүй энэнтэй ижил төстэй характертай.

Ийм учраас энэ Экоммерс буюу цахим худалдааны хуулийг яаралтай өргөн мэдүүлж, худалдааны эрх зүйн орчинтой хамт өргөн мэдүүлж барих ёстой гэсэн таны санаачилгыг дэмжиж байна. Энийг ч гэсэн чиглэж ажиллах болно. Гомбын Ганбаатар гишүүн таныг энэ чиглэлээр бас Их Хурлаас санаачилгатай хамтарч ажиллахыг хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Энэ өргөн барьсан хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Нэгдүгээрт, Эдийн засгийн хөгжлийн яам энэ эдийн засгийн бодлогыг, төлөвлөлтийн бодлогыг, хөгжлийн бодлогыг түүчээлж, ер нь манлайлж, удирдаж, чиглүүлж, зүглүүлж одоо ажиллах чиглэлээр ер нь ямар ажил төлөвлөж байгаа вэ?

Өөрөөр хэлбэл ингээд Сангийн яам мэдээд байна гээд ингээд ийм шүүмжлэл гараад байдаг. Яг бодит байдал дээр бол энэ хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны хөгжлийн бодлого, урт хугацааны хөгжлийн бодлого гээд энэ зүйлүүд дээр манай Эдийн засгийн хөгжлийн яам бусад бүх яамдыг одоо нэгтгэж, уялдуулж ажиллахаас гадна хамгийн чухал нь анзаарагдсан зүйл бол энэ бодлогын төлөвлөгөө дунд, богино, урт хугацааны энэ бодлогуудыг маш сайн эхлээд одоо яг энэ зүгт бид нар ер нь явах гээд байгаа юмаа, яг ийм зорилгод хүрэх гээд байгаа юмаа гэдгээ их оновчтой тодорхойлоод тэрний дараа салбар яамд болон орон нутгаас энэнд чиглүүлж энэ одоо малгай энэ зүгт чиглүүлж одоо төлөвлөгөөгөө та нар боловсруулж ирүүл ээ гэхгүй бол энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан байдлаас харахад эхлээд одоо доороос дээш гэдгээрээ эхлээд доороос баахан санал аваад, салбар болон орон нутгаас. Тэгээд тэр нь ийм нэг одоо яг нэгдсэн нэг ийм замбараатай, эмх цэгцтэй ийм бодлогод ерөөсөө орж чадахгүй байгаад байгаа ийм зүйл ажиглагдсан. Тийм учраас цаашдаа энэ зүйлийг анхаараач ээ.

Тэгээд дээр нь одоо энэ ирэх 2025-2030 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөг одоо Засгийн газраас энэ 6 дугаар сарын 28-ны өдрийн дотор өргөн мэдүүлж одоо батлуулах ийм хуулийн зохицуулалттай байгаа. Тэгээд энэ бас одоо өргөн мэдүүлээгүй байгаа. Тэгээд энэ хуулийн хугацаа ингэж зөрчигдөх эрсдэлтэй байгаа шүү. 6 сарын 28 хүртэл бол хэдхэн хоног үлдсэн байна аа. Энийг одоо Хөгжлийн бодлого төлөвлөлтийн удирдлагын тухай хуулиар энийгээ одоо яаралтай өргөн мэдүүлэх ийм шаардлагатай байгаа шүү гэдгийг бас хэлье.

Дээр нь энэ бүсчилсэн бодлогын асуудлыг ер нь яг яаж хариуцаж ажиллах вэ? Энэ дээр яам болон орон нутгийн хоорондын уялдаа холбоог яаж зохион байгуулж зохицуулж ажиллах вэ? Энэ бүсчилсэн бодлого маань нэг тийм тунхгийн шинжтэй болох гээд байна аа. Бүсчилсэн улс төрийн сонгууль явсан. Гэтэл яг энийг дэмжих ийм санхүүгийн механизм, зохион байгуулалтын механизм, энэ зүйлүүд байхгүй байгаад байна. Тэгэхээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулж аймаг, нийслэл, орон нутгийг өөрчилнө гэдэг бол хүндрэлтэй энэ бараг боломжгүй. Тэгэхээр энийг одоо хүлээхгүйгээр эсвэл энэнд одоо нэг тийм шалтаг тавихгүйгээр энэ рүү чиглэсэн нэг том бодлогыг аль салбарт хэрэгжүүлж явах вэ гэдгийг их тодорхой болгож өгөх хэрэгтэй байна аа. Энэ дээр одоо тодорхой санал хэлээд хариулт өгөөч ээ.

Дэд бүтцийн бодлого болон өөрөө өөрийгөө санхүүжүүлэх бодлого гээд. Тэгэхгүй сая одоо Говь-Алтайн Их Хурлын Говь-Алтайгаас сонгогдсон Амгаланбаатар гишүүнд энэ чонын чонотой холбоотой хуулийн төсөл өргөн барьсан. Энэ нь зүүн бүсэд жишээлбэл тохирохгүй байгаа юм. Тэгэхээр ингээд бид нар чинь ийм говь хангай, тал хээр хосолсон өргөн уудам нутагтай. Өмнөд Солонгосоос 20, 30 дахин том нутагтай нэг аймаг нь л нэг улсаас том. Тэгээд энд ялгавартай ийм бодлого хэрэгжүүлэхгүй болбол энэ ингээд нэг бүсчилсэн хөгжлийн бодлого нэг цаасан дээр тунхаг болж үлдэх гээд санаа зовоод байна аа. Бид нар одоо бүсээс сонгогдсон Их Хурлын гишүүн. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг

хэрэгжүүлнэ гээд сонгогдсон. Гэтэл энэ дээр одоо том манлайлал үзүүлэхгүй бол ерөөсөө болохгүй болоод байгаа юмаа. За энийг одоо ямар бодлого барих вэ гэдгийг асууж байна.

Дээр нь энэ хөрөнгө мөнгө төвлөрүүлдэг болон хөрөнгө мөнгө зарцуулдаг гэсэн л нэг ийм 2 чиглэлд зохион байгуулалтын хувьд бол ангилаад тэгээд энэ Шадар сайд нар энэ хөрөнгө мөнгөө төвлөрүүлдэг нь нэг хэсгээ салбар яамдаа хариуцаад, нэг хэсэг нь зарцуулдгаа хариуцаад ингээд явах. Жишээлбэл одоо нөхөн сэргээгдэхгүй уул уурхайн баялгаас орох орлогыг нөхөн сэргээгддэг хөдөө аж ахуйн салбарт яаж зарцуулах юм. Энэ нь яаж уялдаа холбоотой явах юм гээд энэ уялдаа холбоонуудыг их сайн зохицуулж, хүнээс хамаарахгүйгээр ямар нэгэн сайд, даргаас хамаарахгүйгээр энэ санхүүжилт, зохион байгуулалтын механизмыг нь оновчтой болгож өгөхгүй бол урьдын жишгээрээ явбал энэ бол тийм...

Д.Амарбаясгалан: Өнөөдөр чуулган өдөр 14 цагаас зарлачихсан байж байгаад Байнгын хороо тарахгүй жоохон удааширсан. 16 цагт эхэлсэн. Тэгэхээр өмнөө тавьсан зорилгоо хангаад 3 асуудлаа хэлэлцэж дуустал өнөөдөр сунгаад хуралдах нь зүйтэй болов уу гэсэн бодолтой байна. Энэ 7 хоногт бас хэд хэдэн чухал асуудлаа хэлэлцээд энэ хаврын чуулган завсарлах дөхөж байгаатай холбогдуулаад эцэслэн шийдвэрлэх хуулийн төслүүдээ шийдэх нь зүйтэй болов уу гэсэн ийм байр суурьтай байгаа юм. Тэгэхээр сонгож хуралдахыг дэмжиж байна уу гишүүд. Тэгвэл өнөөдөр зорьсон 3 асуудлаа хэлэлцэж дуустал чуулганы хуралдааныг үргэлжлүүлээ.

Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь цахим худалдааны талаар гүйцээгээд ажиллачихад энд нэг цогц бодлого байгаа юм. Судалгаа хийгдсэн юм байна лээ. Тэрний дараа жич танилцуулъя даа. Давхцаж байгаа учраас. Эдийн засгийн хөгжлийн яамтай асуудлыг Тэргүүн шадар сайд Эдийн засгийн хөгжлийн сайд Учрал хариулна.

Ер нь энэ бүсчилсэн хөгжлийн бодлогыг татвар, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулж, орон нутагт эрх, бүсэд эрх мэдлийг шилжүүлэх хэлбэрээр хэрэгжүүлэхгүй болбол өнөөдрийнх шиг Улаанбаатартаа хөрөнгө оруулалт мөнгө шаваад л байх юм болбол бүсчилсэн хөгжлийн бодлого хэзээ ч хэрэгжихгүй. Ийм учраас энэ бол ийм цогц эдийн засгийн бодлого хэлбэрээр хэрэгжих ёстой. Энэ талаар Бадамсүрэн гишүүн ч гэсэн Дорнод аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа тодорхой саналууд АМНАТ хөрөнгө оруулалтаас эхлээд олон асуудлууд ярьдаг. Энэ бол одоо нөгөө бүсчилсэн хөгжлийн бодлогын цогц бодлогын зөвхөн нэг хэсэг нь. Энэ талаар одоо баримталж байгаа бодлогын талаар Эдийн засгийн хөгжлийн сайд, Тэргүүн шадар сайд Учрал хариулна аа.

Д.Амарбаясгалан: Учрал сайд. Учрал сайдын микрофоныг өгье. Ирцэндээ орсон уу. Төхөөрөмжид түр саатал гарсан юм байна. Түр хүлээж байя.

Н.Учрал: Энэ хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хуулиар энэ Эдийн засгийн хөгжлийн яам ямар асуудлыг хариуцах вэ гэдгийг бол их тодорхой хуульчилсан байдаг. Бид бол ер нь өнгөрсөн хугацаанд төлөвлөлтийнхөө араас явж чаддаггүй, төлөвлөлтөө хэрэгжүүлэхгүй байсаар байгаад өнөөдрийг хүрснээс

болоод жишээ нь зарим төсөл хөтөлбөрүүд гэхэд 5 сарын 30-наас, 1-нээс наана одоо хэрэгжиж эхэлдэггүйгээсээ болоод ингээд төсөв татагддаг асуудал үүсдэг.

Дээрээс нь энэ нийгэм эдийн засгийн үнэлгээ, бусад төрлийн үнэлгээнүүд хийгдээгүй төсөл хөтөлбөрүүд энэ төсөвт суудаг. Энэ жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлуудыг салбарын яамдууд авч хийдэг. Энэ ажлуудаас болоод ер нь болбол дандаа одоо энэ төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд бол орхигддог. Тэгэхээр Эдийн засаг хөгжлийн яам болбол өөрөө энэ урт хугацааны бодлого дээрээс нь Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймаг орон нутаг дахь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр өөрөө 5 жилийн үндсэн чиглэл, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт уялдаж байгаа эсэхийг нь хамааруулж авч үзье...

Д.Амарбаясгалан: За гүйцээж хариулъя. Учрал сайд.

Н.Учрал: Түүнийг нь уялдуулаад жилийн төлөвлөгөөг Их Хурлаар оруулж батлуулдаг. Ингээд жилийн турш төлөвлөгөөнд..

Д.Амарбаясгалан: Учрал сайдын микрофон энэ яагаад гацаад унав? Масс гараад байна уу, үгүй юу?

Н.Учрал: Тэгээд энэ жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг нөгөө ирэх оных нь төсөвт суулгаад явдаг. Тэгээд сая гишүүд асуугаад байгаа нөгөө бүсчилсэн хөгжлийн форумын үеэр аймаг орон нутагт тулгараад байгаа асуудлыг шууд газар дээр нь бүсийн хэмжээнд шийдье гэхээр нөгөө ажлууд нь жилийн төлөвлөгөөнд тусаагүй байдаг. Ингээд жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэх гэхээр ингээд хууль зөрчинө. Тийм учраас өнөөдөр Эдийн засгийн хөгжлийн яам болбол төлөвлөөд, төсөвлөөд, хянаад, эргээд мониторинг хийдэг зөв зарчим руугаа шилжье гэдэг утгаараа энэ хяналт мониторингийн буюу нөгөө ДиЭМИ гээд энэ Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусчихсан байгаа чиг үүргийг хэрэгжүүлэх яг энэ циклээр ажиллаж эхлэхийн тулд 4 жилийн хөтөлбөрөө үнэлдэг мониторинг хийдэг.

Тэгээд Их Хурал дээр, Байнгын хороон дээр тогтмол нөгөө тайлагнадаг хуулиараа. Ингээд явах юм болбол цаашдаа өөрөө Монгол Улс шинжлэх ухаанд суурилсан хөгжлийн бодлоготой, дээрээс нь урт хугацааны бодлого руугаа чиглэсэн алсын хараатай байна аа. Тэрнээс биш салбарын яамдууд ч гэдэг юм уу бүсийн хөгжлийн хүрээнд ч гэдэг юм уу шинэ шинэ санаачилга гаргаад ингээд яваад байх нь болбол зохимжгүй учраас бид нар энэ мониторингийг Эдийн засаг, хөгжлийн яам өөрөө нөгөө 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, 5 жилийн үндсэн чиглэлээ хэрэгжүүлж байх хүрээндээ болбол энэ мониторингийн эрх, үүргийг Хөгжлийн яаманд энэ одоо Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хуулиар Ерөнхий сайд бас оруулж, зөв механизм руу бас чиглүүлж байна аа л гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхээр ирэх жил болбол бид бол Төрийн байгуулалтын байнгын хороон дээр 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг болбол, жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг болбол Эдийн засаг, хөгжлийн сайд л танилцуулж түүнийгээ хамгаална. Өнгөрсөн, одоо 2 сарын өмнө болбол төрийн байгуулалт дээр ороод ирэхэд аль сайд нь хариуцах нь одоо тодорхойгүй яваад байсан. Тэгэхээр ерөөсөө энэ Засгийн газрын энэ удаагийн бүтэц бүрэлдэхүүн бол

давхардсан чиг үүргүүдийгээ оновчлоод, яг асуудлыг тухайн сайд толгойгоороо хариуцах ийм бололцоогоор л одоо бүрдүүлж өгч байгаагаараа онцлогтой.

Д.Амарбаясгалан: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Гол тулгамдаад байгаа асуудал нь Учрал сайд аа, нөгөө энэ салбарын стратеги гэж батлахыг энэ хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль батлагдсанаараа ингээд одоо зогсоочихсон юм байна лээ. Тэгэхээр жишээлбэл уул уурхай салбарт гэхэд салбарын стратегийн бодлого байхгүй. Жишээлбэл одоо чухал ашигт малтмал гэж юуг үзэх юм, нүүрснээс бусад одоо ямар ашигт малтмалыг эргэлтэд оруулах юм гэдэг бодлого байхгүй тийм явж байгаа байхгүй юу. Тэгээд шалтгаан нь яагаад байхгүй байгаа юм гэхээр Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиар бүгдийг зохицуулдаг болсон. Салбар салбарын бодлого гэж байхгүй ээ. Нэгдсэн бодлогоор явна аа гэхихсэн. Гэтэл хөгжлийн бодлого төлөвлөж жилийн хөгжлийн төлөвлөгөө бол боловсруулалт нь одоо өнгөрсөн хойно нь сайдыг ажлаа өгсөн хойно нь юм яриад байхад жоохон онцгүй байна. Тэгэхдээ улс орны ажлын төлөө хэлэхэд бол энэ үнэхээр ийм хангалтгүй, ямар ч стратегийн биш бичиг баримт орж ирчихсэн байгаа учраас энийг дагаад төсөв нь ч гэсэн тийм нэг санаандгүй гэнэтийн байдалтай болчихоод болохгүй байгаад байгаа юмаа нэгд.

Хоёрт нь энэ орон нутгийг бие даалгахгүй болбол насанд хүрсэн хүмүүстээ одоо итгэл өгөхгүй байгаа юм шиг ийм болчихоод байна аа. Тэгээд энийг одоо онцгой анхаарч өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын хуулиар төлөвлөлтийг дээрээс нь доош, доороос нь дээш чиглэх тэнцвэрийг хангах суурь зарчмыг хангуулна гэдгийг хуульчилж өгсөн. Энэ хүрээндээ болбол энэ жилийн төлөвлөгөө боловсруулахад төрийн захиргааны төв байгууллагуудын саналыг нэгтгээд уялдуулаад жилийн төлөвлөгөөгөө Их Хурлаар батлуулдаг. Яагаад энэ хоорондоо уялдахгүй байна вэ гэхээр аймаг орон нутгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр тэр жилийн төлөвлөгөөндөө нийцэх эсэх дээр Хөгжлийн яам өөрөө бүрэн дүүрэн ажиллаж чадахгүй байгаа. Энэ болбол өөрөө нөгөө хяналтын функц өөрөө хэрэг эрхлэх дээр.

За хамтарсан Засгийн газрын хувьд бол бүүр үндэсний хороотой. Тэгэхээр хэн хариуцаад байгаа нь ингээд үл мэдэгдэх яваад байсан учраас хөгжлийн бодлогын бүх баримт бичигт тэр 5 жилийн үндсэн чиглэлээ Хөгжлийн яам нь боловсруулсан бол өөрөө хянаад яв аа гэвэл үүрэг хариуцлага нь оновчтой болоод ирэхээр Засаг даргын тэр үйл ажиллагааны хөтөлбөрийг ч гэсэн уялдуулах бололцоо бий болно. Тэгэхгүй одоо болбол жишээ нь жилийн төлөвлөгөө боловсруулахад яамдууд ингээд саналаа нэгтгээд өгчихдөг юм байна. Тэгэнгүүтээ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгадаг саналаа өгчихдөг юм байна. Ингээд бүгдийг нь нэгтгээд жилийн төлөвлөгөөгөө оруулаад ирдэг. Тэгээд зарим ажлууд нь ингээд хоорондоо уялддаггүй. Тэгээд ерөөсөө нөгөө үнэлгээнүүдийг нь хийж чадахгүйгээсээ болоод нөгөө төлөвлөлтгүй баахан ажлууд суулгачихдаг. Тэгээд ингээд татвар төлөгчдийн мөнгө үр ашиггүй зарцуулагдах ийм одоо буруу

хандлага руу болбол ороод байгаа учраас бүх асуудал болбол өөрөө төлөвлөлт рүү явна аа. Төлөвлөлт рүү явна.

Тэгээд төлөвлөсөн бол өөрөө хянадаг болно. Хянах гэж байгаа тэр чиг үүрэг нь байгаа болохоор төлөвлөж байгаа газар болбол ямар нэгэн одоо тийм үнэлгээ нь хийгдээгүй эсвэл ТЭЗҮ нь хийгдээгүй, нийгэм, эдийн засгийн үр өгөөжгүй төсөл хөтөлбөрүүдийг энэ төлөвлөлт дээр тусгаад яваад байхыг болбол илүүд үзэхгүй шүү дээ. Тийм учраас энийг ингээд хасаад явах хандлага руугаа явна. Тэгэхээр одоо бид болбол Засгийн газар дээр тэр нэг үнэлгээ гээд төслүүдийг үнэлдэг систем байсан. Тэр системээ болбол одоо амилуулаад явна. Хамтарсан Засгийн газрын үед бол тухайн үед Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөрийг Эдийн засгийн хөгжлийн яамтай болбол бид хамтарч боловсруулж хийсэн. Тэр 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр бол Их Хурлаар батлагдсан хөтөлбөр. Жилийн төлөвлөгөө болбол Гантөмөр сайд сүүлд оруулж ирээд Их Хурлаар баталчихсан. Тэгээд энэ жилийн төлөвлөгөөг л хэрэгжүүлнэ. Хэрэгжилт рүү анхаарах ёстой болохоос биш энэ сонгуулийн дараа бүрдсэн Засгийн газар биш.

Тийм учраас хамтарсан Засгийн газрын ололт амжилтаа илүү бататгаад төрийн ой санамж байгаа бол залгамж чанараа хадгалаад, харин алдаагаа засна. Ерөнхий сайдын хувьд болбол энэ эдийн засгийн сорилттой үед бол нэгэнт хэмнэлт хийе ээ, чиг үүргийн оновчлогоотой одоо шинжилгээнүүдийг хийе ээ гэж зорьж байгаа учраас энэ манлайллыг болбол манай яамдууд бүгдээрээ дэмжээд, газар, хэлтэс, тэр дарга, цэргийн тоог болбол буулгах энэ асуудал...

Д.Амарбаясгалан: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Амарбаясгалан дарга маань мик битгий хаагаарай гэж гуйж байна шүү. Би нэг элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотой ганцхан асуулт асууя Занданшатар сайдаас. Бид нарыг өнөөдөр энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн сандал суудал ярьж байх хооронд элсэлтийн ерөнхий шалгалт болж өнгөрлөө. Хагас сайн өдөр дууссан. Энэ элсэлтийн ерөнхий шалгалтад нийт 42 мянган суралцагч шалгагдсан. Энэ шалгалт бол нэлээн хуудуутай, нэлээн асуудалтай болж өнгөрсөн гэдгийг Занданшатар сайд мэдэж байна уу, мэдээлэл авсан уу гэж асуумаар байна.

Тэгээд Наранбаяр сайд бол хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өөрийгөө өмөөрч арьсаа хамгаалсан ийм мэдэгдлүүд маш олон удаагийн давталттайгаар хийж байна. Энэ бол нийгмийг талцуулж байна. Тэгээд Монголын ирээдүйн төлөө бид нар энэ Их Хурлын гишүүд бид бас дуугарч дуу хоолойгоо нэгтгэмээр байна. Энэ асуудал гаргасан Боловсролын сайд дээр яаралтай арга хэмжээ авч огцруулах хэрэгтэй гэдгийг Монголын мянга мянган багш нар шаардаж байна аа. Тэгээд ер нь бол гүйцэтгэлийн үнэлгээ элсэлтийн ерөнхий шалгалт гээд бүгдийг нь самраад хаячихлаа. Энэ бол бодитой үнэн шүү. Монголын багш нар бүгдээрээ дуу нэгтэй, тэр багш нарын үйлдвэрчний холбооны групп дээр Наранбаяр сайдыг огцрохыг шаардаж байгаа.

Тэгэхээр энэ дээр одоо манай Ерөнхий сайд ямар бодолтой, ямар одоо зарчимтай байх вэ гэдгийг бас та ард иргэддээ хэлж өгөөрэй гэдгийг хүсмээр байна аа. За баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотойгоор нийгэмд үүсэж байгаа яриа, шүүмжлэлтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны боловсролын яаманд үүрэг өгч, энэ асуудлын талаар сайд нь хянан шалгаад, өнөөдөр хэвлэлийн бага хурал хийж тодорхой мэдээлэл холбогдох газрууд өгсөн байгаа. Ер нь 43318 хүн шалгалт өгсөн. Улсын дунджаас одоо бас 50-60 хувь нь тэнцсэн нь бол улсын олон жилийн дундажтай ойролцоо, шалгалтыг үндэсний хэмжээнд нийт 50 шалгалтын төвд зохион байгуулсан. Олон бүрэлдэхүүнтэй эмч, үйлчлэгч, цагдаа одоо бүгд хяналт тавьж ажилласан. Тэр тест энэ тэр задарсан асуудал байхгүй. Зүгээр 7 сурагч гар утастай ороод хураагдаж шалгалтаа тэглэсэн ийм зөрчил гаргасныг эс тооцвол үндсэндээ болбол зөрчилгүй гэсэн ийм мэдээллийг өгсөн.

Гэхдээ бид энэ чиглэлээр холбогдох газруудтай хамтарч шалгалтын ажлыг явж байна. Шууд засалтыг шилэн технологи ашиглан шалгалт бүрийн дараа шалгалтын байрны тусгайлсан, тусгайлан зассан байрны шалгуулагчийн анхны оноог мэдээлсэн. Ил тод байдлыг хангасан. Энэ бүх мэдээллийг Боловсролын үнэлгээний төв дээр ил тод болгосон. Энийг ард түмний өмнө ил тод нээлттэй байгаа. Ингээд хэвтээ хариуцлагын тогтолцоо үнэхээр алдаа дутагдал гарсан бол тэр холбогдох хүмүүст хариуцлага тооцохыг сайдад болон холбогдох газарт үүрэг даалгавар өгсөн байгаа. Энэ талаар илүү тодорхой мэдээллийг сайд нь өгсөн нь зөв байх аа гэж бодож байна. Наранбаяр сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд нэмж хариулъя. Наранбаяр сайдын микрофоныг өгье.

П.Наранбаяр: За баярлалаа. Энэ асуудалд бас нэмж хариулъя. Тэгэхээр зэрэг ямар нэгэн байдлаар бол материал задраагүй, яг л энэ явдгаараа явсан. Түүний зэрэгцээ бүх шалгалтын яг 10 төрлийн шалгалт байгаа бүгдийг нь ил тавьсан байгаа. За тэгээд эхнээсээ бол багш нар энэ ерөнхийдөө жил жилд ирдэг энэ дундажтайгаа адил ийм агуулгын хувьд бол ийм байна аа гэсэн ийм дүгнэлтүүдийг өгч байна. Ерөөсөө энэ нууц байдлыг бол маш сайн хадгалсан. Шалгалтын өмнөх, шалгалт явсны дараа бол ил тавиад олон хүний бас эргэлзээг тайлах нь зүйтэй гэсэн. Ноднин жил болбол 7 дугаар сард бид ил тавьж байсан. Энэ жил бол бид энэ одоо шалгалт явагдаад тэр даруй дараа өдөр нь ингээд тавьж байгаа юм. Ийм байгаа юм.

Хоёрдугаарт, тэр гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой асуудлыг ярьж байна. Яг үнэндээ бол 37 мянган багшаас гүйцэтгэлийн үнэлгээг нь аваад, гүйцэтгэлийн үнэлгээ бол өөрөө эерэг үр дүн үзүүлээд байгааг хэлээд байгаа шүү дээ. Илүү одоо цөм хөтөлбөр хэрэгжүүлье. Илүү хүүхдэдээ хүргэе. Ингээд гүйцэтгэлийн үнэлгээгээ 4 түвшиндээ үнэлүүлсэн нь юугаа урамшуулал авдаг, 5 дахь хүчин нь авч чадахгүй. Ингээд бас энэ сайн ажиллаж байгаа багш нь илүү гүйцэтгэлийнхээ үнэлгээгээр үнэлүүлээд явдаг ийм л тогтолцоо үйлчилж байгаа. Энэ дээр бол эндээ, яг энд, одоо шударга явуулах энэ тал дээр бид онцгой анхаарсан. Харамсалтай нь нэг 248 багш дээр хүүхдүүдээ хуулуулсан гэсэн ийм асуудал үүссэн. Ийм ямар нэг, ийм одоо нөгөө өнөөгийн байдлаар бол ийм сэжиглэх ийм нөхцөл байдал үүссэн учраас тодруулах ажил ид явагдаж байгаа. Багш нар бол амарч байгааг ойлгож байгаа. Ийм

учраас энэ амралтыг нь дуусгаад тодруулах ажлыг бол хийгээд, ингээд одоо шийдийг нь гаргана аа.

Аливаа зүйл яг л шударга явах хэрэгтэй. Ингэж байж энэ нийгэмд чинь багш нь өөрөө шударга, ёс зүйтэй байж байж энэ нийгэмд чинь шавь нар нь, сурагч нь тийм болно ийм байгаа юм. Тийм учраас танд хүсэхэд энийг битгий дэвэргээд бай. 37 мянган багшаас 248 дээр нь асуудал үүссэн байна. Энийг бид хууль эрх зүйн хүрээндээ л шийдээд явна. Яг холбогдох үйлдвэрчний эвлэл манайх энэ тал дээр бол байгуулсан үйлдвэрчний Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоо гэж байгаа. Багш нарын. Монголын үйлд...

Д.Амарбаясгалан: За тодруулж асууя. Мөнхтуяа гишүүн.

Ц.Мөнхтуяа: Наранбаяр сайд аа. Би материал задарсан гэж нэг ч үг асуугаагүй танаас. Материал задарсан, задраагүй тухай ерөөсөө асуулт асуугаагүй. Та хүний асуулт ядаж ойлгож хариул л даа. Тэгээд гүйцэтгэлийн үнэлгээн дээр багш нарыг хуулуулсан гэж хэлэхээсээ та ичдэггүй юм уу? Багш нар яаж хуулуулах юм. Тэрийг чинь өөр дүүргийн багш нар өөр ингээд сургууль сургуулиа солиод авчихсан шүү дээ. Ангийнх нь багшийг хөөгөөд гаргачихсан шүү дээ. Тэгээд яаж хуулах вэ. Жишээ нь 1 дүгээр ангийн хүүхэд хуулна гэж байх уу. Таны ой тойнд яаж орж байна аа? Ийм балай юм яриад сууж байдаг салбарын сайдтай байхаасаа ичиж байна. Юу гэж хүүхдүүд тэр бага насны хүүхдүүд бие биеэсээ хуулаад суух юм тэр богинохон хугацаанд. Ийм болчимгүй юм ярьж болохгүй ээ Наранбаяр сайд аа.

Тэгээд Монголын ирээдүй болсон хүүхэд багачуудыг та нар битгий мөнгө гэж хараад бай за юу. Өнөөдөр тэр шалгалтыг чинь баллуур, харандаа нь хүртэл ажиллахгүй байгаа, баллаж чадахгүй, харандаа нь үзүүр нь хугараад, баллуур нь болохгүй байна гээд...

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: За ойлголоо. Би тантай бол одоо нэг хар зах дээр яаж байгаа юм шиг юм яримааргүй байна. Тэгэхээр зэрэг зүгээр би бол одоо бодитой болсон явдлыг л шалгаж байна гэдгээ хэлсэн шүү дээ, шалгаж байна. Яг ийм ижилхэн хариултууд хүрээд ирчихсэн, яг одоо том хүний бичгийн хэвтээ ийм нотлох баримтууд нь байж байна. Гэхдээ бид шалгаж байна. Энийг эцэслээгүй. Энэ дээр тийм улс төржүүлээд байх юм байхгүй.

Хоёрдугаарт, харандаа баллуурын асуудал яригдсан. Тэгэхдээ яг албан ёсоор өнөөдөр яг гомдол бол ирээгүй байна. Тухайн үедээ бол нөөцөд нь харандаа баллуурууд бол бүрэн байсан...

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Мөнхтуяа гишүүний асуултад бас хүндэтгэлтэй хандаж байна. Гэхдээ шүүмжлэх гэж шүүмжилж биш одоо шүүмжлэл бодитой, нотолгоонд суурилсан байх ёстой. Ийм учраас бид 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс өнөөдрөөс өөрөөр хэлбэл 6 сарын 28, 29-ний өдрийг хүртэл элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотой өргөдөл гомдлыг ШУТИС-ийн Т байрны 3 давхрын 307 тоотод хүлээн авах бас цахимаар хүлээж авах үүрэг даалгавар өгсөн байгаа. Ингээд

одоо гарсан гомдлуудыг шуурхай хянан шийдвэрлэх үүрэг өгчихсөн байгаа. Шаардлагатай бол холбогдох хууль хяналтын байгууллагуудад бас өгсөн байгаа. Тэр чиглэлээр бас тодорхой нотолгоотой.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Нэг ийм асуулт байна. Бүрэлдэхүүний тухай хууль, бүтцийн тухай хууль орж ирэх юм болов уу. Энэ нөгөө инновац технологийн бодлого хэрэгжиж өгөхгүй, санхүүжилт нь бас байхгүй ингээд ойлгомжгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ энэ чигээрээ байж байгаад 2028 он хүртлээ шинэ дүрмээрээ учраа олох гэж үзнэ гэж бодож байгаа юм болов уу. Эсвэл энэ дээрээ нэг шийдэл гаргах гээд ажиллах юм болов уу? Ийм асуулт байгаа юм.

Сургалт одоо судалгаа, шинжлэх ухаан, технологи, инновац гээд дараалал нь сургалт судалгаа нь энэ Боловсролын яаманд, шинжлэх ухаан нь эдийн засаг хөгжил нөгөө инновац нь болохоор инновац, цахим хөгжил, инновац, харилцаа холбоо гэдэг 3 яаман дээр оччихоод даргууд нь өөр өөр харьяалалтай, санхүү нь бас өөр өөр болчихоод хоорондоо нэлээн хэцүү байгаад байна. Тэгээд ингээд хүлээлт байгаад байгаа. Тэгэхээр нэгэнт тогтчихсон бүтэц гээд эцсээ хүртэл явах гэж байна уу, эсвэл энэ дээр ажиллах бодол байгаа болов уу? Бүтцийн тухай хууль орж ирэх юм болов уу. Ийм асуулт байн аа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье. За Батшугар сайд.

Э.Батшугар: Тийм. Ер нь болбол та бас мэдэж байгаа юу. Мэдээлэл технологи үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль дээр л гацаад байгаа шүү дээ. Үүн дээр нөгөө нэг виртуал бүс болон одоо бүртгүүлсэн компаниуд тодорхой хэмжээний гранд татварын болон татварын бус дэмжлэг орно гээд орчихсон байгаа. Тэгээд инновацын тухай мөн Инновацын сан нь болбол Эдийн засгийн хөгжлийн яаман дээр одоохондоо байгаад байгаа. Гэхдээ бодлого нь болон одоо шалгаруулалт нь болбол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хийж байгаа.

Мөн цаашид хариулахад тэр Виртуал бүсийн тухай журам яамандаа одоо боловсруулагдаж байгаа юм байна лээ. Арай батлагдаагүй. Тэгэхээр энэ журмаа ямар ч байсан маш түргэн хугацаанд батлаад үүнд нөгөө мэдээлэл экологийн компаниуд нь бүртгээд, тэгээд татварын болон татварын бус дэмжлэг мөн одоо Гранд эд нарыг олгох энэ ажлыг одоо маш шуурхай хийнэ ээ гэж танд хариулъя аа.

Д.Амарбаясгалан: Золжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Золжаргал: Саяын Батшугар сайд мэдээлэл технологийн талаар ярилаа. Тэрэнтэй бол санал нэг байгаа юм. Цаана нь бас өөр юмнууд байгаад байна. Жишээлбэл ХААИС-ийн хашаан дотор байдаг 2 хүрээлэн Эдийн засаг, хөгжлийн яаманд харьяалагдах болсноороо удирдлага нь тэндээсээ томилогддог, төсөв нь өөр, тэгээд судалгаа, сургалт, тэгээд шинжлэх ухаан гэдэг юмаа явуулахын тулд нөгөө сургууль нь дахиад шинээр хүрээлэн байгуулах уу гэж бодоод төлөвлөөд явж байгаа нэг жишээ. Тэгэхээр иймэрхүү юмнууд ингээд бусад их сургуулиуд юмнууд дээр бол бас байгаад байна. Тэгээд та бүхэн бүтцээ бодоход энэ асуудлыг нэг бодож үзээрэй гэж хэлмээр байна. Судалгаа хийдэг маш олон багш нар академикууд энэ асуудлыг яриад...

Д.Амарбаясгалан: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Эрхэм сайд Наранбаяр Их Хурлын гишүүд танд үг хэлэх эрхтэй юм. Та Их Хурлын гишүүдийн үгийг сонсох гэж сайд болсон юм. Тэгээд 1 эмэгтэй гишүүн үг хэлэхээр нэг хар яр гээд байгаа юм байхгүй. Ер нь бол энэ сайдын суудлаас огцрох болзлоо хангачихсан нөхөр шүү энэ Ерөнхий сайд Занданшатар даргад хэлэхэд бол. 2025 оны төсөв хэлэлцэж байхад үгсэн хуйвалдах замаар төсөв хулгайлах гэж оролдсон. Үүнийгээ буцаан татсан. Хууль давсан тушаал гаргасан. Хэсэг гишүүд шүүмжилсэн. Одоо зарим нь хамт сайд болчихсон кабинетад нь сууж байгаа мартчихаагүй байлгүй дээ. Улс төржсөн томилолт хийсэн. Одоо тэр 2025 оны 1 сарын 31-ний өдрийн Б5 дугаар тушаалаар томилсон томилгоо нь хууль бус юмаа гэдгийг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 5 сарын 30-ны өдрийн 227 дугаар тогтоолоор баталчихсан байна аа. Үүнийгээ зас аа гэдэг шийдвэрийг танд өгсөн байна аа. Харамсалтай нь одоо хүртэл энэ мэтчилэнгээр улс төржсөн, намчирхсан, бусдыг бүлэглэн шахсан томилгоо хийдэг байдлаа зогсоох ёстой энэ нөхөр бол.

Ер нь олон мянган багш нарыг доромжилж, гүтгэж, урдаас нь мэдэмхийрч болохгүй. Багшийн их сургуулийг би төгссөн хүн. Бакалавр, магистр, докторын суралцсан хүн. Тэр элсэлтийн ерөнхий шалгалтыг бүгд сошиалаар мэдэж л байна шүү дээ. Юу асуучихсан юм. Захын наймаа шиг 6 оноо нэмж өгье гэдэг яриа гарчихсан гээд явж байгаа. Энэ гудамжны яриа биш шүү. Энэ боловсролын бодлогын асуудал шүү. Энэ улс орны хөгжлийн том тулгуур тэнхлэг цэг бол боловсролын салбар юм. Бидний хөгжих, хөгжихгүй гол асуудал бол боловсролын салбар юм. Энэ боловсролын салбарыг хөгжүүлж байж бид урагшаа явах юм. Тийм учраас Занданшатар сайдыг томилогдсон ч би бас энэ үгийг хэлж байсан. Боловсролын салбарын хүн сайд болж байгаа учраас энэ асуудалдаа анхаарах ёстой гэж бодож байгаа.

Хамгийн түрүүнд хариуцлага тооцох ёстой сайд чинь энэ нөхөр Наранбаяр шүү Занданшатар дарга аа. Ийм учраас нөхөр Наранбаяраас надаас асуугаад байх юм алга. Харин сайд Аубакираас асуух асуулт байна. Тэр ахмадын тэтгэврийн асуудлууд яригдаад байгаа. Тэр банкн дээр одоо зээлийг нь өгөхгүй, барихгүй гээд юм гарчихсан юм байна лээ. Энэ асуудал дээр бодлогын яам ямар байр суурьтай байгаад байгаа юм. Хэдэн муу ахмадууд гадаа жагсаад байдаг. Зарим нэг нөхдүүд би урдаас нь очиж жагсана гээд энэчээ улс төр хийгээд байдаг Тэгээд одоо нэг хэсэг нь ахмадууддаа хайртай, нөгөө хэсэг нь ахмадууддаа дургүй болчихсон юм уу. Энэ бодлогын яам нь энэ дээр ямар байр суурьтай байгаад байгаа юм? Энэ дээр Аубакир сайдаас асуулт асууя. Тэгээд Боловсролын сайдын асуудлаа Занданшатар сайд анхаарч ажиллаарай. Тэгээд энэ Засгийн газрын асуудлыг дэмжиж байна.

Д.Амарбаясгалан: Аубакир сайд.

Т.Аубакир: Баярлалаа. Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя аа. Энэ өр орлогын харьцааг 50, 50 байлгах тухай шийдвэр Монгол банкны ерөнхийлөгчийн 2025 оны 6 сарын 13-ны өдрийн тушаалаар 50, 50-ийн харьцаатай байхаар шийдвэр гарчихсан юм байна лээ. За бид нар бас тодруулсан. За өнөө өглөө бас ахмадын төлөөлөлтэйгөө уулзсан. Яах арга байхгүй амьдрал баян шүү дээ. Одоо зээлээ аваад л жижиг бичил бизнес эрхлэх одоо ааруул эзэгий юу байдаг юм. Оёдол нэхмэл гэдэг ч юм хийдэг ахмадууд бас байдаг юм байна. Тийм учраас Монгол

банкны нөхдүүдтэй энэ тушаалаа бас эргэж хараач ээ гэсэн хүсэлтийг тавьж байгаа. Бас одоо ийм хямралтай үед аливаа зүйлийн одоо үнэ өртөг өсөж байгаа энэ үед бас ахмадуудаа харж үзэх нь зөв байх. Яагаад гэвэл эргэн төлөлт нь бол бас тийм өндөр төлөлттэй зээлийн зээлд орж явдаг юм байна шүү дээ. Тийм учраас энэ асуудал эргээд шийдэгдэх байх.

Ер нь яг одоо хийж байгаа зохицуулалт нь болбол шинээр тэтгэврийн зээл авах гэж байгаа хүмүүст бол 100 хувийн нээлттэй байгаа биш ээ хуучин зээл аваад хэрэглээд явж байсан тэгэх юм бол дахиад зээл авъя гэдэг хүсэлт тавих юм бол 100 хувь олгож байгаа юм байна. За шинээр огт тэтгэврийн зээл аваагүй байж байгаад одоо тэтгэврийн зээл авъя аа гэхтэй нь зэрэг хязгаарлалт тавьж өгч байгаа юм байна. Ер нь энэ зөвхөн одоо тэтгэврийн зээл биш. Монгол банк маань ер нь хэрэглээний зээлийг болбол тодорхой хэмжээнд бууруулах бодлого барьж байгаа юм байна. Бид нар хэтэрхий их хэрэглээгээ дэмжээд байгаа юмаа. Энэ маань буцаад одоо импортыг хөөрөгдсөн байдаг ч юм уу ийм байгаа учраас бид нар зөвхөн одоо тэтгэврийн зээл биш ээ бусад төрлийн одоо гар утасны зээл, машины зээл гэдэг ч юм уу эдгээр зүйл дээр Монгол банк бол ажлаа хийгээд явж байгаа юм байна. Энэ асуудлын араас болбол хөөцөлдөнө өө. Одоо орон нутгийн иргэдээс маш их хүсэлт ирж байгаа.

Тийм учраас энэ шийдвэрээ бас эргэж хараач ээ гэсэн саналыг тавьчхаад байж байгаа. Гэхдээ манай яамны хувьд болбол бас Нийгэм хамгааллын салбар яам шүү дээ. Тийм учраас ахмадуудыгаа бас эрсдэлд оруулахгүй байх талаас нь бас бид нар анхаарч ажиллаж байгаа гэж хариулъя аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн тодруулж асууя.

Н.Батсүмбэрэл: Аубакир гишүүн тэгээд тэрийгээ сайн анхаарч ажиллаарай. Тэгээд сая хагас сайнд 1200 ахмадтай уулзахад ерөөсөө энэ зээлийг л ярьж байна лээ. Тэгээд энэ бол одоо маш их хүлээлттэй, маргаантай асуудал болчихсон байна. Тэгээд Ерөнхий сайд минь сая Боловсролын сайдын асуудлыг онцгой анхаараарай. Энэ манай ХҮН-д чинь Мөнхсоёл, Уянгахишиг гээд боловсролтой эмэгтэйчүүд бас байдаг юм шүү дээ. Боловсрол аваад явчихаар.

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Оройн мэнд хүргэе. Ерөнхий сайдаас 3 асуулт байна аа. Нэгдүгээрт, би асуулт асууя Сандаг аа. Асуулт асуучихъя аа. Энэ газрын харилцаа геодези зураг зүйн газар гэж байгаа юм. Ерөнхий сайдын харьяанд байдаг. Тэгээд уул нь бол тэр агентлаг Хот байгуулалтынхаа яамтай хамтарч ажиллах ёстой. Хот байгуулалтынхаа сайдын доор хот байгуулалт, газрын харилцаа гэдэг чинь яг нэг асуудал шүү дээ. Тэгээд энэ агентлагийг та бүхэн энэ Барилга, хот байгуулалтын сайдын харьяанд аваачих цаг болоогүй юу. Одоо нэг нөхөр оччихсон одоо ингээд тэнд бараг Ерөнхий сайдын харьяаны агентлаг гээд яамаа ч тоодоггүй нэг тийм байгууллага бий болсон байгаа юм. Тэгэхлээр хот байгуулалтынхаа салбартай уялдуулж, энэ агентлагийг тэр салбарт нь аваачих цаг болсон уу, үгүй юу нэгдүгээрт та юу гэж бодож байна.

Хоёрт нь энэ дэд сайд гээд хүмүүс гадуур тодорчихсон явж байна аа. Би дэд сайд болно ч гэж байх шиг. Тийм орон тоо танай Засгийн газарт байгаа юм уу.

Цаашдаа гаргах юм уу. Тэр ер нь яг ямархуу байр суурьтай байгаа юм бэ? Би зүгээр олон хүмүүст дэд сайд хэрэгтэй л гэдэг юм. Миний хувьд одоо огт шаардлага байхгүй байх аа. Яамны Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нар ажлаа хийгээд явах бүрэн бололцоотой гэж бодож байгаа. Заавал хүмүүст өртэй биш тийм албан тушаал гаргаж өгөх шаардлага байна уу, үгүй юу? за хоёр дахь асуулт нь ийм байгаа.

Гуравдугаарт нь төрийн албан хаагчдыг цомхотгох асуудал яригдаж байгаа. Энэ дээр одоо маш их тийм болгоомжтой хандаарай. Дандаа хүний ард нь амьдрал явж байгаа. Тийм учраас та бүгд маань энэ дээр маш болгоомжтой хандаж, маш сайн тооцоо судалгаа хийж, одоо хий хоосон орон тоонуудыг нь цомхотгох чиглэлээр ажиллахгүй бол одоо ажиллаж байгаа улсуудыг халж цомхотгоно гэдэг өөрөө асар том эрсдэл дагуулах байх аа гэж бодож байна. За энэ 3 асуултад хариулж өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Жуковын Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Энэ газрын асуудал бол хамгийн суурь хуулийн нэг ээ. Газрын тухай хуулийг өмнөх Засгийн газраас өргөн барьж шийдвэрлэхдээ ийм бүтэц хийчихсэн. Тийм учраас энэ бүрэлдэхүүний тухай хуулиар өөрчлөх бололцоогүй юм билээ. Бид бас энэ асуудлыг шийдвэрлэх ёстой гэж үзэж бүрэлдэхүүнээр өөрчилье гэж үзсэн боловч Газрын тухай хуулиараа ажил үүргийн хуваарилалт бүх зохицуулалтыг нь хийгээд Ерөнхий сайд дээр Засгийн газрын хуралдаанаар газар төлөвлөлтийн асуудал шийддэгээр ингээд зохист харилцаа зохицуулчихсан учраас бүхэлд нь Газрын тухай хуульдаа өөрчлөлт оруулж байж шийдэх юм байна лээ.

Ийм учраас би Барилга, хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд Бат-Амгаланд үүрэг намрын чуулганаар энэ хуульд өөрчлөлт оруулах судалж оруулж ирэх чиглэл өгсөн байгаа. Энэнээс болоод 2 сараас хойш бүх аймгууд дээр үндсэндээ газар олголтын асуудал зогсчихоод байна. Одоо энэнээс болоод айлын хашааны газрын асуудал ч шийдэгдэж чадахаа больчихоод. Бүх хэт төвлөрүүлээд Засгийн газар дээр авчирчихсан энэ бол алдаатай бодлого гэж үзэж байгаа. Тэгэхдээ энэ газрын харилцааны асуудал бол эмзэг цогц асуудал аа. Газрын асуудал чинь одоо ямар их шуугиантай билээ. Ийм учраас энийг цогцоор нь шийдэх үүргийг сайд Бат-Амгаланд өгсөн байгаа. Намрын чуулганаар газрын хуульд өөрчлөлт оруулах асуудлыг оруулж ирж түүгээр шийдэх бодолтой байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаар асуудлын хувьд дэд сайдын асуудал чинь угаасаа энэ хууль дээр байж л байна шүү дээ. Өмнөх Засгийн газрын үед ч гэсэн орон тоо төсөвтэйгөө бүгд байгаа юм байна лээ. Одоо хэл ам шүүмжлэлээс айгаад юм уу ингээд томилогдоогүй юм байна лээ. Үнэхээр одоо нэг 10, 20 хүний асуудал бол хэрэгтэй юу, хэрэгтэй юу гэвэл 10, 20 хүний төсөв хэмнэснээсээ энэ 1 мянга, 2 мянган хүний ажлыг хийх бололцоотой үр ашигтай ажиллуулах л асуудал гэж ойлгодог. Гадаад харилцааны сайд гадаад явчихлаа, оронд нь гаднын зочин ирлээ. Орлогч сайд байх ёстой юу орлох хүн. Ямар ч компани удирдлагын нэгжид заавал орлох систем байдаг. Засаг дарга ч гэсэн таныг одоо ажиллаж байхад Хан-Уул дүүргийн орлогчгүй болбол ажил явдаггүй биз дээ тиймээ. Тийм учраас орлогчийн асуудал бол яг бодитой харах юм бол...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Тэгэхээр орлогчийн асуудал одоогийн хуульд ч байж байгаа юм билээ. Төсөв орон тоо нь ч байж байгаа юм билээ. Тэгэхдээ энэ төсвийн тодотгол энэ тэрээр бол бид нар таны хэлсэн, манай гишүүдийн хэлсэн ч гэсэн 1440 хүний орон тоо болбол дарга сайд нар цомхотгох асуудал ярьж байгаа. Тэгэхдээ ер нь орлогч сайд гэдэг бол дэлхийн бүх улсад байдаг албан тушаал аа. Нэгээр тогтохгүй байдаг албан тушаал. Энэ бол улс төрийн албан тушаал. Тийм учраас энийг бас сайн судалж байж нэг их хэмнэх гэснээсээ илүү бодит үр дүн юу байна, үр ашиг юу байна гэдгээс бодож одоо энийг бас шийдэх ёстой гэж энийг бол Засгийн газрын хуралдаан, бас Улсын Их Хурлын гишүүдийн санал бодолтой зөвшилцөөд шийдэх ёстой байх гэж бодож байгаа юмаа.

Гурав дахь асуудал нь Ти Эй гэдэг чинь төрийн алба тийм. Төрийн алба бол мэдээж олон хүний...

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Засгийн газрын гишүүний байр суурийг ойлголоо. За хүндэтгэлтэй хандана аа. Дэд сайд нарын асуудал дээр. Гэхдээ та хэд маань дэд сайд нараа сонгохдоо бас нэр цэвэр, тэгээд л нэг саяынх шиг энд тэнд явж байдаг хүн битгий томилоорой. Салбартаа бас одоо хүлээн зөвшөөрөгдсөн тийм ээ бас мэргэжлийн улсуудыг аль болох оруулж томилж өгөхийг хүсэж байна. Энэ бас Монголын төрийн нүүр царай учраас тэр шалгуурыг одоо бас бариасай гэж хүсэж байна аа. За газрын харилцааны агентлагийн хувьд болбол та бүгд маань хуулиа маш яаралтай санаачилж намрын чуулган ч гэлтгүй дориун санаачлаад орвол энэ ээлжит бус чуулган хэрвээ болдог бол энэ асуудлыг тэр яамд нь өгөх нь зөв юм байна лээ. Хуучин тэгж явж ирсэн, болж байсан. Тэгээд ганц хүний лоббигоор тэр одоо дээшээ явчихсан, одоо тэрийг буцааж байранд нь тавих цаг болсон гэж бодож байгаа. За баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Монгол Улсын Ерөнхий сайдад олгогдсон өөрийн, одоо хэнтэй ч хуваалцахгүй бүрэн эрхийн хүрээнд оруулж ирж байгаа учраас уг асуудал дээр бол одоо гишүүдийн зүгээс зүгээр саналаа хэлэх байдлаар оролцоно. Түүнээс биш одоо яг заавал ийм байх ёстой энэ тэр гэдэг зарчмаар бол хандахгүй ээ гэдэг зүйлийг хэлье. Тэгээд энэ саналыг бол хүндэтгэлтэй хандаж байна.

Ер нь тэгэхдээ нэг ийм байгаа юмаа. Монголын парламентын түүхэнд Ерөнхий сайд яг энэ бүрэн эрхээ эдлэхдээ бас нэг тодорхой хэмжээний гарын нэг авлага, харьцуулалтууд энэ тэр ер нь цаашдаа аль институцээсээ байх ёстой ер нь хийж явмаар юм билээ. Өнөөдөр газрын асуудал гэхэд 5-6 яаман дээр байгаа байхгүй юу. Барилга хот байгуулалтын яаман дээр байна, Ерөнхий сайд өөр дээр нь байна. Газрын асуудал бол Хил хамгаалах ерөнхий газар гээд Хууль зүйн сайд руу ороод ирдэг. Чөлөөт бүсийн асуудал гэхээрээ Шадар сайд руу ороод ирдэг. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал гэхээр Байгаль орчны сайд руу ороод

ирдэг. Ашигт малтмал ашиглуулах талбайн хэмжээг тогтоох гэхээр уул уурхайн сайд руу ордог ч юм уу энэ үндсэн одоо эдийн засгийн нөөц болсон капиталаа бид нар хэрхэн яаж менежмент хийх вэ гэдэг зүйлээ бид нар ерөөсөө ингээд салангид байдлаар явж ирсэн юм. Тэгэхээр энийг бол сая Алдаржавхлан гишүүн бас хөндөж байна. Би энэ бол зөв өө.

Тэгэхээр энийг нэг ингэж харьцуулж бас нэг ийм гарын авлага бас энэ дээрээ дүгнэлтээ хийгээд бүтэц бүрэлдэхүүнээ нэг ийм байдлаар зурна аа гэдэг ч юм уу ерөнхий зүйлүүд бас цаашдаа нэг юм бид хэд бас энэ парламентыг төгөлдөржүүлэх гэдэг юм уу, төрийн бүтээмжийг сайжруулах, давхардал чиг үүргийг арилгая гэвэл бас нэг анхаармаар байгаа юм. Тэгэхээр энийг болбол бас Ерөнхий сайд бас дараа дараагийн хүмүүстээ бэлдэж бас энийг магадгүй одоо Хэрэг эрхлэх газар маань л бас зөвлөх байх л даа. Энийг анхаараач ээ гэдэг зүйлийг хэл байгаа юм.

Хоёрдугаарт, нэг зүйл байна аа. Энэ боомт Засгийн газрын үйл ажиллагааны одоо чиг үүргүүдийг бас давхцуулаад хэд хэдэн Засгийн газрын гишүүн ч ажиллалаа. Засгийн газрын гишүүдтэй зэрэгцээд үндэсний хороодуудыг ч гэсэн байгуулж ажиллалаа. Магадгүй компаниуд ч бас өгч ажиллалаа.

Тэгэхээр энэ зүйлүүдийг бас Ерөнхий сайд зоригтой шийднэ гэж байгааг болбол үнэхээр дэмжиж байгаа шүү. Энэ хуульд байхгүй Үндэсний хороо зөвлөл нэртэй байгууллагуудыг бол одоо татан буулгах цаг нь болсон. Эдгээр байгууллагууд чинь яамдуудын ажлыг хийлгэхгүй байна аа. Тоон мэдээ гаргаж өг пресентац бэлдэж өг гээд нэг хэдэн ярвайсан дарга царайлсан хүмүүс ерөөсөө яамдуудын ажлыг хийлгэхгүй ийм байдалтай байж байгаа. Энэ бол бодит, бүүр бодит практик шүү. Тэгээд гадуур нь гараад пиар хийх болохоороо би хийлээ, чи хийлээ гээд байдаг байхгүй юу. Тэгэхээр би бол ийм зүйлүүдийг бас цэгцэлж байгаад нь бол дэмжиж байна. Тэгэхээр энэ яах вэ зүйлүүдээ бас анхаарна биз. Хуульгүй төр үндэсний хороодуудыг би ярьж байгаа шүү. Ялангуяа яах вэ эрчим хүчин дээр би жишээ авчихъя. Ийм зүйлүүдийг бас цаашдаа дахиж гаргамааргүй байна аа гэдэг зүйлийг бас хэлмээр байна.

Хоёрдугаарт, энэ Боомтын үндэсний хороог татан буулгаж байгаа. Тэгэхдээ бас яах вэ болгоомжилж хэлж байгаа юм. Цаашдаа Сангийн яам маань аваад явах юм байна. Энийг битгий нэг хавсарга байдлаар авч яваарай. Энэ боомтын асуудлыг бас цэгцтэй авч яваагүйгээс шалтгаалаад манай экспорт импортын асуудлууд бол хумигдсан шүү. Зөвхөн Замын-Үүд боомт дээр осол гарлаа гэхэд Монгол Улс үндсэндээ зогсож байгаа шүү. Замын-Үүд боомтоороо хүн зорчигч нь ч явдаг, аюултай ачаа бараа нь ч явдаг, уул уурхайн түүхий эд нь ч явдаг орон бараг манайхаас өөр байхгүй байна. Тэгэхээр энэ боомтын асуудлыг онцгой анхаараарай гэдэг зүйлийг хэлье. Тэгээд Хууль зүй, дотоод хэргийн сайд байна, сайд байна.

Ер нь И Гэйтийн асуудлыг 3 боомт дээр хийсэн юмаа. Энийг үнэхээр одоо бас л Хууль зүй, дотоод хэргийн яаманд байж байхдаа тухайн үедээ Сангийн яамтайгаа зөвшилцөөд хийсэн. Буянт-Ухаа дээр тавилаа, Замын-Үүд дээр тавилаа, Алтанбулаг дээр тавилаа. Илүү олон боомт дээр тавиарай гэж одоо хүсэж байна. Ингэвэл одоо бас боомтын нэвтрүүлэх чадвар нэлээн сайжирна аа.

Эцсийн үгийг би энэ сонгогчдынхоо өмнөөс хэлж байгаа юмаа. Сая Батсүмбэрэл гишүүн бас хэллээ. Манай энэ хагас бүтэн сайнд СХД-ийн сонгогчдоос

маш их гомдол ирлээ. Энэ элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотой. 42 мянган хүүхэд энэ алтан гахай жилд төрсөн хүүхдүүд маань төгсөж байгаа юм байна. Эдгээр хүүхдүүдийн амьдралын одоо алхам хийх гэж байгаа энэ үе дээр нь ингэж одоо хайхрамжгүй, ямар ч одоо хандсан ажилдаа ийм одоо зохион байгуулалтгүй ингэж оролцож байгаа хүмүүст нь бол арга хэмжээ аваарай. Дээрээсээ эхлээд доошоо хүртэл аваарай гэж хүсэж байна.

Тэгээд би бас Улсын Их Хурлын дарга бас анхаараасай гэж хүсэж байгаа юм. Юу вэ гэхээр энэ Боловсрол, шинжлэх ухааны байнгын хорооноос энэ дээр хяналт шалгалт явуул...

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд хариулах уу?

Г.Занданшатар: Сайнзориг гишүүн маш чухал асуудал хөндлөө. Санал нэг байна аа олон асуудлаар. Энэ олон үндэсний хороод жишээлбэл 11 үндэсний хороо, 9 санг татан буулгах тийм зорилттой энэ хуулийн төсөл орж ирсэн гэж ойлгож болно. Тэгээд энэ үндэсний хороод энэ олон чиг үүргийн давхардлууд сайн юм болохоор эзэн олон, булаацалдаад л давхичихдаг. Муу юм болоод хариуцлага тооцох болохоор эзэн олддоггүй ийм болчихсон юм билээ. Энэ бол нөгөө хариуцлагын тогтолцооны ч, чиг үүргийн давхардал нь ч нэг ч шинж ээ гэж бидний хийсэн чиг үүргийн шинжилгээний судалгаанд шинжээч нар дүгнэсэн.

Ийм учраас энэ олон чиг үүргүүдийг нэгтгэж нийтдээ 60 гаруй хороодыг бас бид нар цэгцлээд тэр дотроо 28 үндэсний хороог нэгтгээд зохицуулаад ингээд үндсэндээ болбол энэ 9 санг татан буулгаснаар нийтдээ нэг 50, 60 гаран бүтэц байгаа. Хороо, зөвлөл хэлбэртэй үйл ажиллагаа явуулдаг 60 гаран бүтцийг цэгцэлж байгаа юм. Үүнээс 45 нь салбаруудын хуулиудад хороо зөвлөлтэй байхаар заагдсан. 19 нь бол хуульгүй ажлын албатай нийтдээ 284 орон тоо байгаа. Эдгээр хороо зөвлөлүүдийн бүтцүүд нь ихэвчлэн салбар дундын уялдаа холбоог хангаж, хамтарсан шийдвэр гаргах зорилготой байгуулагдсан ч гэсэн яг практик амьдрал дээрээ яамныхаа чиг үүрэгтэй давхцаад хоорондоо сөргөлдөөд одоо Эрчим хүчний яаман дээр болсон юм ч тэр, олон толгойтой болсон тохиолдлууд зөндөө байна аа.

Дахин хэлэхэд одоо сайн юманд нь болохоор эзэн нь мунддаггүй, муу юманд хариуцагч олддоггүй. Ингээд 2 юмны уялдааг хангах гэж зөвлөл байгуулаад, сүүлдээ зөвлөл нь уялдахаа байгуулаад 3 талын болох жишээтэй. Боомт энэ тэр ч гэсэн ерөнхийдөө бол салбар хоорондын ажлын хэсэг хэлбэрээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, боомтын зөвлөл гээд ажиллаад болоод ирж байсан юм. Одоо тэнд дэд сайд нар энэ тэр нь ажилладаг байсан юм. Тэгээд хоорондын уялдааг хангаад л. Яам дундын дунд боомт гэхэд энэ чинь Хил хамгаалах ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Гаалийн ерөнхий газар гээд олон салбар дундын зохицуулалт шаарддаг ийм салбаруудыг ийм зөвлөл хэлбэрээр шийддэг байсан. Энэ зарчмаар нь ажиллуулахад асар их мөнгө хэмнээд зогсохгүй, энэ дээр яриад байгаа тэр орлогч байна уу, дэд сайд байна уу энэ тэр гэдэг нь мэдээж гол биш.

Ер нь ингэж их мөнгө хэмнэх бололцоо бол энэ хуулиар бий болно гэж бодож байна аа. Тэр элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотой асуудлаар сайд нь тодорхой хариулсан. Энэ талаар нэгдсэн хяналт шалгалт явуулаад, тодорхой хариулт өгөх болно оо. За бусад асуудал дээр манай Жавхлан сайд нэмж хариулъя.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд 1 минут байна. Тэгээд энэ давхацсан яамдуудын чиг үүрэгтэй давхацсан хороо зөвлөлийг татан буулгаач ээ гээд түрүү жилийн төсөв батлахаас л явсан. Энэ зарчим дээрээ хэвээрээ. Тэгээд Энхбаяр болон Мэндсайхан гишүүнтэй бас Ерөнхий сайдад тухайн үедээ асуулт тавьж байсан. Яг л одоо Ерөнхий сайд Занданшатар даргын хариулж байгаа шиг л бид хэдэд хэлж байсан. Жоохон болж байгаа ажлууд дээр булаацалдана аа, дараа нь хариуцлага хүлээхгүй болно оо. Эрчим хүчний салбар дээр яг энэ тохиолдол гарсан юм. 4, 5 жилийн өмнө билүү дээ Даваасүрэн сайд тухайн үеийн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хороо компаниудаа булаацалдаад тог тасарсан чинь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хороо нь Эрчим хүчний яам руу бүх компаниудаа өгч байсан байхгүй юу. Яг л ийм юм болж байсан ийм зүйлүүд байна аа.

Тэгээд хоёрдугаарт Хурлын дарга Боловсрол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу энэ элсэлтийн ерөнхий шалгалтын дагуу хяналт шалгалт явуул аа. Яам нь биеэ хамгаална аа. Энэ 42 мянган хүүхдийн хувь заяагаар ингэж тоглож болохгүй шүү. Энэ цаашдаа Монгол Улсын хөгжлийн асуудал. Бид хэд энэ дээрээ ийм одоо юу гэдэг юм за яах вэ дээ гэж...

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд боомтын асуудлаар хариулт өгье.

Б.Жавхлан: Сайнзориг гишүүний асуултад нэмэлт хариулт өгье өө. 2022 онд Засгийн газрын бүтцэд бүрэлдэхүүнд бас өөрчлөлт орж байхад энэ боомтын асуудал тэр болтол Сангийн яаман дээр байсан юм. Бас тэгээд би давхар хариуцдаг байж байгаад энийг ер нь нэг сайдтай болгох хэмжээнд ач холбогдол өгч ингэж бүтцэд өөрчлөлт оруулъя аа гэдэг ийм санал оруулаад ингээд сайдтай болж байсан юм. Одоо ингээд харамсалтай нь үнэхээр яах аргагүй төсвийн орлого энэ байдалтай уялдуулж бид нэлээдгүй хэмнэлт энэ бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байгаа учраас ингээд сайдгүй болж байна. Тийм учраас одоо өмнөх шигээ өндөр ач холбогдол өгч ингэж ажиллаж явна аа.

Ер нь манай улс маань өөрөө худалдааны эдийн засагтай улс. Яах вэ, одоо бид дунд, урт хугацаанд шилжилт хийж байна. Үйлдвэрлэгч эдийн засаг руу ийм улс руу явж байна. Гэхдээ л хэдэн жилдээ энэ боомтын асуудал бол одоо манай хамгийн чухал асуудлуудын нэг байх болно. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ч одоо боомтын сэргэлт гэж орж байсан. Одоо дараагийн 14 мега төслийн хүрээнд ч боомтын асуудлууд мөн л одоо нэгдүгээр эгнээнд байгаа. Тийм учраас боомтын асуудал бол үргэлж чухал Засгийн газрын бодлогын төвд байх болно оо.

Д.Амарбаясгалан: Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн асуулт асууя.

Э.Одбаяр: Их Хурлын гишүүддээ оройн мэнд хүргэе ээ. Тэгээд би энэ өргөн барьсан хуулийг дэмжихгүй байгаа юмаа. Тэгээд яагаад дэмжихгүй байгаа вэ гэдэг үндэслэлээ бас та бүхэндээ хэлье. Тэгээд Ерөнхий сайдаас 2 асуулт байна.

Нэгдүгээрт одоо энэ шинэ Засгийн газар бүрдээд эхний ээлжид хэмнэлтийг өөрөөсөө эхэлнэ ээ, тэгнэ ээ, ингэнэ ээ гээд нэлээн сүртэй лоозон тавьсан. Тэгээд үр дүнд нь яасан бэ гэхээр орон тооны бусаар ажилладаг байсан хэдэн Үндэсний

хороодоо татан буулгаад, яг үндсэн хэмнэлт гаргана гэж байгаа танай манай улс төржилгүйгээр ажил хийгээд явж байгаа төрийн албан хаагчдыгаа цомхотгоно гэдэг мэдэгдлийг хийсэн. Тэгэхээр яах вэ гэхээр төрийн албан хаагчдаа цомхотгоод, ажлаас халагдсаны тэтгэмжийг нь төлөөд явахаар яриад байгаа тэр хэмнэлт чинь бас гарах уу?

Хоёрт, одоо бас хэдийгээр нөгөө хамтарч байгаа субъектүүд нь өөр болсон боловчиг одоо бас хамтарсан засаг ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Өмнөх жишгүүдийг нь харахад хамтарсан Засгийн газрынх нь Тэргүүн Шадар сайдаар Засгийн газрыг бүрдүүлж байгаа 2 дахь том намынх нь дарга нь ажилладаг байсан. Тэгэхээр одоо ажиллаж байгаа 3 шадар сайдынх нь 2 нь нэг намаас буюу эрх барьж байгаа намаас томилогдоод ажиллаж байгаа. Зүй нь бол энэ Доржханд даргыг Тэргүүн шадар сайдаар томилоод, тэгээд Батбаатар даргыг бас нэг Шадар сайдаараа томилоод ажиллуулсан бол бас тийм улс төрийн соёлтой харагдах байх байсан болов уу гэж ойлгож байна МАН-ыг. Тэгээд хэмнэгдэж байгаа төрийн албан хаагчдынхаа хариуд нь улс төрийн албан тушаалтнууд буюу энэ дэд сайдуудыг бас эргээд томилно гэж ярьж байгаа нь бас нэлээн зөв юм уу, буруу юм уу? Бас хариуцлагагүй мэдэгдэл байна гэж би ойлгож байна. Тэгээд энэ дээр хэдийгээр Үндсэн хуулийнхаа дагуу өөрийн бүрэн эрхийн хүрээнд бүтэц бүрэлдэхүүнээ оруулж ирж байгаа Ерөнхий сайд хариултаа өгнө биз.

Хоёр дахь асуултаа би Сангийн сайдаас асуух гэсэн юм. Сангийн сайд өнгөрсөн кабинетад бас энэ албыг хашиж ирсэн хүн. Тэгээд ямар нэгэн байдлаар төсвийн тодотгол хийх нөхцөл байдал үүссэн үү гэдэг асуудал дээр хуулийн шаардлага үүсээгүй байна аа гэдэг тайлбарыг одоо 2-3 удаа бас хэлж байсан. Тэгээд одоо болохоор тодотгол хийх шаардлагатай гэдэг байдлаар асуудал яригдаж байх шиг байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр засаг засаглалын тогтворгүй байдал үүссэнээр энэ эдийн засагтаа санхүүдээ тогтворгүй бус байдал үүсгээд, тодотгол хийхээс өөр зайлшгүй нөхцөл байдал үүссэн гэдгийг хүлээн зөвшөөрч байна гэж ойлгож болох уу? За энэ 2 асуудал дээр би хариулт авах гэсэн юм.

Д.Амарбаясгалан: За хариулт өгье. Учрал сайд.

Н.Учрал: Энэ төсвийн зарлага бууруулах үндсэн болбол 3 зарчмыг Ерөнхий сайд бол бас томъёолоод байгаа юм. Нэгд бол, энэ Үндэсний хороо зөвлөлийг татан буулгах асуудал одоо энэ сүүлийн байдлаар бол нэг 59 Үндэсний хороо гээд бодоод үзэхээр үүнээс нэг 28 хороо, Үндэсний зөвлөл ажлын албатай, тодорхой төсөв мөнгөтэй. 28 хороо, Үндэсний зөвлөлийг татан буулгахад нийтдээ нэг 311.5 тэрбум төгрөгийг хэмнэнэ гэдэг эхний тооцоолол байна. Томилолт, эд хогшил, хангамж, хурал, уулзалтууд, олон улсын янз бүрийн хэвлэл мэдээлэлд гарах асуудлууд гээд ингээд хэмнэхээр 410-ны 1 тэрбум төгрөг. Сая хөрөнгө оруулалтын төслүүдийн санхүүжилтийн хэмнэлт гээд 325 тэрбум төгрөг гээд ингээд хэмнэлтүүдийг хийнэ гэж одоо бидний бид бол эхний байдлаар үзэж байгаа.

Төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчдын дунд бараг сул орон тоо болбол одоо бид нар нэгтгэж байна л даа. Бараг 6 мянга хүрнэ. Сул орон тоо. Тэгэхээр хэн нэгэн ажиллаж байгаа биш. Гэхдээ сул орон тоо үүсгээд, сонгон шалгаруулалт зарлаад, ингээд энд нь нөгөө цалингийн багцад нь яваад байдаг. Үүний цаана мэдээж одоо нөгөө төрд ажиллаж байгаа төрийн албан хаагч нараар

одоо хэмнэлтийн асуудал яригдана. Гэхдээ бид бол энэ эдийн засгийн сорилтыг ард түмнийхээ ар нуруун дээр болбол үүрүүлэхгүй гэдэг зарчмыг болбол барьж байгаа.

Тийм ч учраас одоо энэ бүтэц бүрэлдэхүүний хууль, энэ төсвийн тогтвортой байдлын хууль батлагдсаны дараа бол энэ Эдийн засгийн хөгжлийн яамнаас ч гэсэн Засгийн газарт энэ төсвийн хүрээний мэдэгдэл ирэх оны тэр төсвийн төсөөлөлтэйгөө уялдуулан оруулж ирэх үеэрээ бол бид нар тэр зарлага талдаа бичигдэж байгаа гадаадын зээл тусламжийг бол төсвийн алдагдал гэж үзээд ийм эдийн засгийн хүндрэлтэй цаг үед бол бид өнөөдөр зүгээр ажлаа хийж байгаа төрийн албан хаагч нарын асуудал руу болбол орохгүй. Сул орон тоогоо хэмнээд, үндэсний хороо зөвлөл шаардлагагүй одоо энэ зардал мөнгөө багасгачихад болбол бид тодорхой бас хэмнэлтийн горим руу шилжих бүрэн бололцоотой гэж ингэж үзэж байгаа.

Тийм учраас болбол төрийн албан хаагчдыг одоо ажлаа хийж байгаа, төрдөө тангаргаа өргөсөн, жинхлэгдчихсэн, түр орлон гүйцэтгэгч биш ийм хуультай, хуулийн дагуу ажлаа эрхэлж байгаа хэн нэгний эрх зүйн байдлыг дордуулсан үйлдэл болбол огт хийхгүй. Зүгээр бүх түвшинд 9 хувийн хэмнэлт хийнэ ээ гээд сая судалгаанууд хийхэд бол төрийн өмчит компаниуд дээр ч тэр, яамдууд дээр ч тэр, агентлаг дээр ч тэр ихэвчлэн бараг ингээд сул орон тоонууд бүртгэгдээд байгаа юм. Зарим яам агентлагууд дээр болбол 9 хувь болбол бүр бага юм байна лээ. Зарим газар болбол бараг одоо 20 орчим хувийн сул орон тоонууд ч элбэг байгаа. Жишээ нь Эдийн засгийн хөгжлийн яаман дээр ч гэсэн 28 газар хэлтсийг бол бид нар 7 газартай, 10 хэлтэс...

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Одбаяр гишүүний асуултад хариулъя аа. Төсвийн тодотгол хийх хуулийн үндэслэл шаардлага гэж байдаг. 34.1-4 хүртэл ийм 4 заалт байгаа, 4 үндэслэл байдаг гэсэн үг. Тэгэхээр өнөөдрийг хүртэл энэ 4 үндэслэлийн бидний гол барьж байсан нөгөө алдагдал. Алдагдал гэдэг нь энэ 34.1.3-аар дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувьд хэрвээ алдагдал хүрвэл төсөвт тодотгол хийнэ ээ гэсэн ийм заалттай. Та биднийг 2, 3, 4 саруудад ярьж байхад бол нөхцөл байдал өнөөдрийг бодвол арай дээр байсан. Ер нь бол 5 сарын 14 хүртэл бол арай дээр байсан шүү. Одоо ингээд шинэ нөхцөл байдал үүсээд тодотгол хийх үндэслэл нь 34.1.4 буюу төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд зохицуулалт хийх шаардлага үүсэж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байна аа гэсэн үг. Тэгэхээр ямар нэг яам бүтцийн нэрэн дотор ингээд цэг таслал хүртэл өөрчлөгдөхөд тодотгол хийх ийм нөхцөл үүсэж байна. Энэ удаа бол бүтэц бүрэлдэхүүнд бас бага...

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Эрдэнэбилэгийн Одбаяр сайдад хандаж нэг үг хэлье ээ. Сайд байсан хүн хяналтын сайд байсан хүн Улсын Их Хурлын гишүүн ийм загасны ой санамжтай байж болохгүй ээ. Таны баталсан хууль чинь дэд сайд байна аа гэдгийг хэлсэн болохоос биш таны баталсан бүрэлдэхүүний хуульд ч хуучин хуульд чинь, бүтцийн хуульд чинь дэд сайд байж байна. Таны баталсан төсөв чинь дэд сайдын орон тоо байж байна. Би тэрнийг хэлсэн болохоос дэд сайдыг бий болгоё гэж би яриагүй ээ. Шинээр бий болгох гээд байгаа юм биш ээ. Одоо хяналтын таны

хариуцаж байсан ажил гэхэд боомт хяналт шалгалт 20 минутын хотын асуудал хариуцсан 3 үндэсний хорооны ажлын албанд 48 хүн байгаа. Бүүр дээр нь нэмэгдээд тэр асар их зардлууд байж байгаа нь төсвийн хэмнэлт нь 8.4 тэрбум төгрөг. Тэгээд төрийн өмчийн компаниуд томилсон хяналтын менежерүүдийн үр ашиг юу байна. Энэ үр ашиг татвар төлөгчдийн мөнгийг үр ашигтай зарцуулах асуудал ярьж байгаа болохоос биш зүв зүгээр удаан жил ажиллаж байсан төрийн албан...

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Халж солих гээд байгаа асуудал биш ээ. Одоо ард түмнийг чирэгдүүлээд байгаа цүнх баригчид тэгээд улс төрийн шугамаар орж ирээд төрийн албыг ч дарангуйлаад байгаа, ард иргэдэд ч чирэгдэл учруулаад байгаа тэгээд данхайсан бүтэц болгосон дарга орон тоо хэт нэмэгдсэний ганцхан жишээ Эдийн засгийн хөгжлийн яаман дээр одоо 10 яам газартай ажиллаж болох газар 28 газар, хэлтэстэй болчихсон гэдгийг би онцолж хэлээд байгаа шүү дээ.

Эрчим хүчний яаман дээр ингээд давхардуулсан 5 бүтэц бий болсноороо юу болов үндэсний хороо өнөөдрийн энэ одоо хариуцлагагүй байдал бий болсон. Ийм учраас энийг нэгтгэж зангидаж байгаа юм. Ийм учраас одоо хяналтын асуудал гэхэд бүх яаман дээр давхацсан, хөдөө, орон нутагт эзэнгүйдсэн. Энийг харин одоо цэгцлэх шаардлагын үүднээс хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн хяналт нь бол хуулиараа Эдийн засгийн хөгжлийн яам, Шадар сайдад хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт нь Хэрэг эрхлэх газартаа ирсэн ийм зарчмаараа хуучин явж болж байсан, цаашдаа ч илүү үр дүнтэй ажил...

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль, тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал дүгнэлттэй холбогдуулан дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай Улсын Их Хурлын гишүүд намын бүлгийг төлөөлж үг хэлнэ ээ. 2 гишүүн байна. Сархадын Зулпхар гишүүн үг хэлнэ. Алга байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн үг хэлнэ. Индэрт гаръя. 1 дүгээр индэр.

Д.Рэгдэл: Баярлалаа. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг хэлэлцээд явахыг дэмжиж байгаа. Тэгэхдээ зэрэг энэ хуулийн төслийг харьцангуй богино хугацаанд бас 2025 оны төсвийн тодотголтой уялдуулан хэрэгжүүлэх гэж байгаа нь сайшаалтай хэрэг ээ. Хуулийг хэрэгжүүлээд явахдаа анхаармаар байгаа ганц 2 зүйл байгааг бас хэлэх нь зүйтэй гэж бодож байна аа.

Нэгдүгээрт, энэ шинэ Засгийн газар өнгөрсөн нэг жилийн хугацааны энэ яамдын үйл ажиллагаандаа нэг дүгнэлтийг ойрын үед хийж аваад ажлаа үргэлжлүүлбэл их зохистой санагдаад байгаа юм. Тэгэхээр миний бие шинжлэх ухаан, технологийн салбарыг төлөөлж сонгогдсон гишүүний хувьд Эдийн засаг хөгжлийн яамтай бас тодорхой хэмжээгээр энэ жил холбогдож ажиллалаа. Шинжлэх ухаан технологийн салбарыг үндсэнд нь энэ яаманд харьяалуулсныг манай салбарынхан ихэвчлэн дэмжиж ажиллаж байгаа юмаа. Гэтэл өнгөрсөн 11 сарын хугацаанд яамнаас хийж байгаа арга хэмжээнүүд шинжлэх ухааны салбарынханд ер нь огт мэдрэгдэхгүй байна гэж шүүмжлээд байх болсон.

Нэгдүгээрт энэ яамны одоо аппарат шилжиж очсон шинжлэх ухаан технологийнхоо газрыг өөртөө интернацилж авч чадсангүй ээ. Энэ одоо яагаад ийм юм болчхов. Учрал сайд одоо энийг сайн задалж үзмээр байгаа юм. Энэ Эдийн засаг хөгжлийн яамны нэрийг аваад үзсэн ч гэсэн энэ бол 1 дүгээрт эдийн засаг тэгээд таслал хөгжлийн асуудал. Эдийн засгийн хөгжлийн хэсэг нь эдийн засгийн эрх чөлөө гэдгийг онолын талаар бараг яриад, том төслүүдээ том ачаа гэж бодоод тодорхой юм хийхгүй байгаад байх шиг ийм сэтгэгдэл төрүүлдэг. Энэ хэсэг болбол эдийн засгийн хөгжлийн загвар зохиож байх ёстой, бодож байх ёстой газар гэж ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: За нэг минут.

Д.Рэгдэл: Хөгжил дээр бол одоо яах аргагүй шинжлэх ухаан технологитойгоо явахгүй бол болохгүй ээ. За тэгээд энэ бүтэц дээр нэг санал хэлмээр байгаа юмаа. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалт нь бол Эдийн засаг хөгжлийн яам шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлого хариуцна гээд биччихсэн. Гэтэл дэлхий даяар шинжлэх ухаан, технологи, инновац 3 бол ерөөсөө л байнга цуг явдаг. Ингэж байж нэг ажил болдог. Нэг юмны одоо бүрдэл 3 хэсэг байгаад байгаа юм. Тэгэх дээр зэрэг энэ Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20 дахь хэсгийн 3 дахь заалт өндөр технологи, үндэсний инновацын тогтолцооны бодлого төлөвлөлт хөгжүүлэх асуудал гэдгийг энэ шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлого гэдэг рүү оруулаад шинжлэх ухаан, технологи, инновацын нэгдсэн бодлого гэж зохицуулалт хийвэл их зохимжтой байна гэж нэг ийм санал хэлмээр байна.

За 3 дугаарт болбол ер нь энэ цахимжуулалт нэмэгдээд байгаа. Цахимжуулалт нэмэгдээд байгаа мөртөө төрийн алба томроод байгаад бол маш нарийн дүгнэлт хиймээр байгаа юм аа. Тэнд төрийн асар олон үйлчилгээ цахимжчихсан байгаа.

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн 2 дугаар индрээс үг хэлье.

С.Цэнгүүн: Оройн мэнд хүргэе. Тэгэхээр Ерөнхий сайд та анх томилогдоод бас амлалт өгч байсан. Төрийн өмчит компаниудыг 50 хувиар бууруулна гээд. Тэгэхээр ТӨК-иуд болон орон нутгийн өмчит компаниуд нийлээд нэг 450 орчим байгаа юм. Тэгэхээр таны шууд удирдлаган доор одоо Төрийн өмчит бодлого зохицуулалтын газар дээр 99 компани байгаа юм. Тэгэхээр энэ 99 компанид бол 58 мянган хүн одоогоор ажиллаж байна. За нийтийн үйлчилгээний албан хаагчид биш зүгээр зах зээл дээр ажиллаж болох байсан 58 мянган хүн маань төрийн өмчийн компанид ажиллаж байна гэдэг маань бол манай ажиллах хүчний хомсдол үүсгэж байгаа хамгийн том шалтгаануудын нэг байгаа юм.

Энэ 99 компани дотор маань бол 36 төрлийн салбар дээр энэ компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа юм. Зах зээлээр нь хуваагаад үзэх юм бол 17 ТӨК маань бол зүй, ёсны, монопол зах зээл дээр ажиллаж байна. 55 ТӨК бол хагас өрсөлдөөнт зах зээл дээр ажиллаж байна. 27 ТӨК бол бүрэн өрсөлдөөнт зах зээл дээр ажиллаж байгаа юм. Нийт 99 ТӨК-ийн 83 нь бол алдагдалтай буюу хасах баланстай гарсан байна. Эндээс харахаар хамгийн амархнаар шийдэх боломжтой буюу 27 ТӨК маань чөлөөт зах зээл дээр өрсөлдөөд явах боломж бол бүрэн харагдаж байгаа юм.

Тэгэхээр хагас өрсөлдөөнт зах зээл дээр байгаа 55 компанийнх нь хувьд бол бид нар энэ бизнесийнхний хувийн хэвшлийн боломжийг нь хязгаарладаг бодлогууд тэгээд дээрээс нь энэ ТӨК-иуд дээр олгодог давуу талуудыг нь хасаад өгөх юм бол хагас өрсөлдөөнт энэ зах зээлүүд маань бас чөлөөлөгдөөд өгч болно. Тэгэхээр төрийн өмчийн менежментийн шинэчлэлийг өмчийн бүтцийн өөрчлөлттэйгөөр нь бүтэн хийх боломжтой одоо судалгаанууд нь бол энд бүрэн хийгдээд гараад ирчихсэн байгаа. Ибиарди-гийн санхүүжилт дээр гарсан маш сайн зөвлөгөөнүүд бол гарсан байна.

Тэгэхээр та бэлэн байгаа энэ дүгнэлтүүд дээр үндэслээд ТӨК-иудыг 50 хувь бууруулах бүрэн боломжтой байгаа юмаа. Тэгэхээр ердөөсөө Засгийн газар байгуулагдаад 100 хоног дотроо та өөрийнхөө бүрэн эрхийн хэмжээнд эдгээр компаниуд дээр болон зах зээлүүдийг чөлөөлж өгөхийг хүсье. Тэгээд хэрвээ энэ 100 хоногийн дараа та яг л өмнөх одоо Ерөнхий сайдууд шигээр эс үйлдэхүй хийгээд, ямар нэгэн шалтаг тоочоод байж байх юм бол бид бүхэн үнэхээр ард түмэн маань бас асуудлыг зөвөөр хараасай гэж хүсэж байна. Яагаад гэхээр юм асуудал гаргаж ирэхээр судалж байна, хянах шаардлагатай гэдэг бол өнөөдөр бид бүхэн хангалттай судалгаанууд баримтууд байгаа учраас энэ төрийн өмч компаниудын цомхотгол дээр та яг зориг гаргаж хийгээсэй гэж хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Очирбатын Амгаланбаатар гишүүн. Хэлмээргүй байгаа юм уу? За индэр дээрээс дэг нь тийм, хууль нь тийм. 2 дугаар индэр.

О.Амгаланбаатар: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ та бүхэнд. Даахгүй нохой булуу хураана гэж үнэхээр энэ дарга нарын тоо хэрээс хэтэрчихсэн юм байна лээ. Миний хувьд бас 3 сарын өмнө энэ Монгол Улсын хэмжээний дарга нарын тоог тоолоод жилд нэг малаа тоолчихдог юм, дарга нараа тоолъё гэсэн дарга нарынхаа тоог болбол алдсан. Тэгээд зөвхөн одоо энэ төрийн албанд байдаг хэдэн тоо ирчихдэг, аж ахуйн нэгжүүдэд байж байгаа тэр нэг ахлах, менежер, зөвлөх гэх зэргээр үнэхээр хэрээс хэтэрчихсэн байна аа. Одоогоос 7 сарын өмнө 68 гишүүнтэй нийлээд хэмнэлтийн тухай хуулийг хүчингүй болгож өгөөч ээ. Энэ одоо хуулиараа бол Засгийн газар өргөн барих юм байна лээ. Тэгээд тийм одоо албан бичгийг Ерөнхий сайдад тухайн үед өгч байсан. Харамсалтай нь одоо тэрийг ингээд хав дараад өнгөрсөн.

Гэтэл яг Улаанбаатар хотод байгаа энэ яамд болон Их Хурал, ингээд Засгийн газар нь улам томроод том аж ахуйн нэгжүүд нь томроод байдаг. Хөдөө орон нутагт ерөөсөө ингээд одоо ямар ч ажил явах аргагүй болсон. Тэгэхээр одоо аймаг орон нутгийн тэр иргэдийн хурлын төлөөлөгч нарыг төрийн албанд орох тэр замыг нээж өгмөөр байна. За дахиад дээр нь болох дээр тэр 2 орлогчтойгоос авхуулаад аймгийн ажлыг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж өгөхгүй болбол Хэмнэлтийн хууль нэртэй яг нэгж дээрх ажлыг бүгдийг нь гацаачхаад, энэ дээрээ болох дээр улам томроод байдаг ийм л одоо Монгол Улсыг одоо өмнөх засгууд чинь ингээд угсарчихлаа. Энийг яаралтайгаар болиулж өгөхгүй болбол Дүүргийн Иргэдийн хурал гэдэг чинь Засаг даргын Тамгын газраасаа том бүтэцтэй болчихсон байдаг юм байна.

Гэтэл сумын иргэдийн хурал чинь хоёрхон хүнтэй үйл ажиллагаа явуулж байдаг. Аймгийн иргэдийн хурал чинь хэдхэн хүнтэй үйл ажиллагаа явуулж болоод

байдаг. Гэтэл ингээд нэг нөгөө даахгүй нохой булуу хураадаг шиг ингээд л нэмээд байдаг. Одоо энэ улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулж энэ хатуу гишүүнчлэлийнхээ асуудлыг та бас энийг одоо гаргаж ирэхгүй болбол одоо ингээд 76 гишүүнтэй байж байгаад 126 болоод ингээд нэг 50 хүнээр нэмэгдсэн, тэр хэмжээгээр нөгөө ухуулагч, менежер, шадар туслах, нөгөө арыг нь дааж явдаг хүмүүсийнхээ ажилтай орлоготой байлгах гэж ингэж явсаар байгаад ийм болчихлоо.

Тэгээд миний хувьд одоо энэ Улсын Их Хурлын гишүүдийг 100 дотор оруулж ирэх одоо ард нийтийн санал асуулгыг санаачилна аа. Тэгэхээр энийг бас та бүхэн дэмжээрэй гэж ингэж хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэл хангая.

Өнөөдөр бас энэ бороо орсонтой холбогдоод энэ Төрийн ордонд 4 ч удаа тог бас тасалдсан явдал болсон. Тэгээд энэ нөгөө технологийн газраас 2 удаа туршилтын ирц бүртгэлийн санал явуулж үзээдэх гэсэн. Алдаа гарч байна уу, үзэх үү. Систем 2 удаа унтарч ассан гэж байна. За тэгэхээр ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Эхнийх нь.

10 минут системийг унтрааж асаатал 10 минут хэрэгтэй байна аа. Өнөөдөр энэ гэнэтийн байдлаар бас энэ бороо орсноос болоод масс үүссэн юм шиг байна гэсэн. Энэ Төрийн ордонд.

Дараагийн асуудлыг танилцуулж байя. Бүрэн унтрааж асаах юм байна. Микрофон ажиллахгүй болох юм байна. Тийм учраас 10 минутын хугацаагаар түр завсарлалаа. 10 минутын хугацаагаар.

Д.Амарбаясгалан: Гишүүд танхимдаа цуглая. Санал хураалтад бэлдье. Санал хураалтаа эхлүүлье. Байнгын хорооны саналаар Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтад санал хураалт явуулна аа. Санал хураалтад бэлдье гишүүд.

Ирц бүртгэлийн санал хураалт нэг явуулъя. Санал хураалт. Сайнзориг гишүүний төхөөрөмж орохгүй байна гэж байна. Дахиад унш л даа хуруугаа, хурууныхаа хээг сайн уншуулаадах даа. Өөр төхөөрөмж дээр асуудал үүсэж байгаа гишүүн байна уу? Алга байна. Сайнзориг гишүүн. За санал хураалтдаа бэлдье гишүүд. Сайнзориг гишүүн өөр төхөөрөмж дээр суугаад үз. Санал хураалтад бэлдсэн байна. Санал хураалт явуулъя.

За бүртгэлийн ирц бүртгэлийн санал хураалт дахиад нэг явуулаадахъя. Гишүүд санал хураалтдаа идэвхтэй оръё. Санал хураалт.

Цогтбаатар гишүүн, Батболд гишүүн, Наранбаяр сайд, Батын Батбаатар сайд Батцэцэг гишүүн, Идэрбат гишүүн, Алтаншагай. Тэгвэл ирц хангалттай байгаа гэсэн үг. Хурууныхаа хээг уншуулаад санал хураалтад бэлдсэн. За санал хураалт.

1.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалт.

61 гишүүн буюу 59.2 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

61 гишүүн буюу 59.2 хувиар дэмжигдлээ.

3.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалт.

61 гишүүн буюу 59.2 хувиар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

62 гишүүн буюу 60.2 хувиар санал дэмжигдлээ.

5.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

64 гишүүн буюу 62.1 хувиар санал дэмжигдлээ.

6.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

64 гишүүн буюу 62.1 хувиар санал дэмжигдлээ.

7.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

62 гишүүн буюу 60.2 хувиар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

66 гишүүн буюу 64.1 хувиар санал дэмжигдлээ.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ. Төсвийн байнгын хороонд мөн шилжүүллээ.

18:30

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд оръё. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна аа. Индэрт урьж байна. Жадамбын Энхбаяр сайд гаднын айлчлал хүлээж авч байгаа. Узбекистаны Шадар сайдыг хүлээж авч байгаа учраас танилцуулгыг Сандагийн Бямбацогт сайд танилцуулна аа. Индэрт урьж байна

С.Бямбацогт: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хэлэлцэж, улаан буудайн гурил, мал амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлж, тоо хэмжээний болон хугацааны хязгаарлалтгүй импортлохоор эцэслэн баталсан. Хууль хэрэгжиж тухайн цаг үеийн хүндрэлтэй нөхцөл байдалд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, МАА-н салбарыг эрсдэлээс хамгаалах зорилгодоо хүрсэн учраас Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болгож болох уу тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй ээ.

Энэ хуулийн үйлчлэл нь зөвхөн улаан буудайн гурил үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд бус ХАА-н салбарын суурь үйлдвэрлэл болох газар тариалан, МАА болон тэжээлийн үйлдвэрлэл, түүнчлэн техник тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, бордооны ханган нийлүүлэлтийн үйл ажиллагаа зэрэг ХАА-н нийлүүлэлтийн сүлжээнд тогтворгүй байдлыг бий болгож байна аа. Хүнсний тухай хуулиар монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг стратегийн хүнс гэж тодорхойлон эдгээр хүнсний дотоодын үйлдвэрлэл, хангамжийг тогтвортой байлгах. Улирлын болон улсын нөөц бүрдүүлэх, импортын хамаарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг төрөөс хэрэгжүүлдэг ээ.

Өөрөөр хэлбэл монгол хүний анхдагч суурь хүнсний хэрэглээ нь стратегийн хүнсний хүнс бөгөөд эдгээрийг дотоодын үйлдвэрлэлээр хангах чадавхтай байх нь манай улсын хүнсний аюулгүй байдлын баталгаа төдийгүй үндэсний аюулгүй байдлын нэгэн чухал илэрхийлэл гэж үзэж болно.

Цаашид энэхүү хуулийн үйлчлэх хугацаа үргэлжлэх нь стратегийн хүнсний үйлдвэрлэл, хангамжийн тогтолцоог гажуудуулж, улмаар Монгол Улсын хүнсний баталгаат аюулгүй байдлын эрсдэлт эмзэг нөхцөл байдлыг нэмэгдүүлнэ ээ.

Мөн гаалийн албан татварыг үргэлжлүүлэн чөлөөлөх нь Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилж, УИХ-аас баталсан Хүнсний хангамж аюулгүй байдлын талаар авах арга арга хэмжээний тухай 36 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын атрын 4 дүгээр тариалангийн тогтвортой хөгжлийн аян зэрэг дунд хугацааны бодлогын хэрэгжилт уялдахгүй бөгөөд ХХАА-н салбарт оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж, ААН үйлдвэрлэгч, малчид, тариаланчдыг өрийн дарамтад оруулах, хөдөөд ажлын байрыг бууруулах, хот сууринд шилжин ирэх хүн амын нягтралыг нэмэхэд түлхэц болохоор байна. ХХАА-н салбарт биднээс үл хамааран байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, олон улсын харилцаа, эдийн засгийн ээдрээтэй бөгөөд таамаглашгүй нөхцөл байдлаас олон эрсдэл учирдаг аа. Ковид цар тахлын сорилтууд бидэнд бие даасан, тогтвортой тэсвэртэй, даван туулах хүч чадалтай байх сургамжийг өгсөн нь саяхан.

Улсын хэмжээнд 2025 оны хаврын тариалалт 6 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 470.3 мянган га буюу 73.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд тариалалтын технологит хугацаа дууссан энэ үед улаан буудай 264 мянган га буюу 85 хувийн гүйцэтгэлтэй байна аа. Гадаад улс орны геополитикийн нөхцөл, улс төрийн хурцадмал байдал ОХУ-аас баримталж буй төрийн бодлого, шийдвэрийн хүрээнд тодорхойгүй хугацаагаар улаан буудай, малын тэжээл, экспортыг хязгаарласан. Түүнчлэн валютын ханшийн өөрчлөлт зэргээс шалтгаалан импортын гурилын үнэ өсөх нөхцөл үүсэж байна аа. Иймээс ХАА-н салбарт үүссэн бодит байдлыг үндэслэн Гаалийн албан татварыг чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан болно оо.

Импортын хараат байдлаас ангижрах бодлогыг цаг ямагт хэрэгжүүлэх нь үндэсний эрх ашгийг хангах тусгаар улсын үүрэг бөгөөд цаашид импортын гурилын үнэ дотоодод үйлдвэрлэсэн гурилын үнээс хямд байх баталгаа байхгүй тул Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хууль хүчингүй болгох тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатар уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Да.Цогтбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр УИХ-д Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, Төсвийн байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль санаачлагч Монгол УИХ-аас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталсан хууль нь тухайн цаг үеийн хүндрэлтэй нөхцөл байдалд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, МАА-н салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасралтгүй байх зорилгоор улаан буудайн гурил болон мал, малын тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлөх зорилгодоо хүрсэн гэж үзэн хуулийн үйлчлэх хугацааг тодорхой болгох зорилгоор Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Хуулийн төсөл батлагдсанаар ХХАА-н салбарын хэвийн үйл ажиллагаа хангагдаж, хүн амын стратегийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах нөхцөл бүрдэж, орон нутагт ажлын байрыг хадгалах, газар тариалан, МАА, гурил үйлдвэрлэлийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлж, үндэсний эрх ашгаа эрх ашиг хангагдана гэж төсөл санаачлагч үзсэн байна аа.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Д.Пүрэвдаваа УИХ-ын гишүүдийн олонх дэмжээгүй хуулийн төслийг дахин өргөн мэдүүлсэн нь хууль эрх зүйн хувьд шаардлага хангаж байгаа эсэх талаар, УИХ-ын гишүүн З.Мэндсайхан 2026 оны хаврын тариалалтын мэдээгээр хүнсний ногооны тариалалт буурсан шалтгаан, тариалсан улаан буудайн чанар нь дотоодын гурил үйлдвэрлэлийн хэрэгцээ шаардлагыг хангах эсэх талаар, УИХ-ын гишүүн Р.Батболд энэ онд импортлох улаан буудайн хэмжээ нь дотоодын гурилын үйлдвэрүүдийн хэрэгцээг бүрэн хангах эсэх мөн манай улсад улаан буудай гурил нийлүүлэх гадаад зах зээлийн талаар мэдээллийг мэдээллийн талаар, УИХ-ын гишүүн Ж.Батжаргал салбарын яамнаас гурил импортлогч томоохон ААН-үүдийн талаар баримталж байгаа бодлого болон цаг агаарын хэт халалтаас шалтгаалсан намрын ургац хураалтын төсөөлөл хэрхэн өөрчлөгдөх тооцооллын талаар асуулт асууж хариулт авлаа.

Мөн УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн 2024 онд батлагдсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн нөлөөгөөр манай улсын хүнсний хэрэглээнд импортын гурилын хамаарал үүсэх мөн валютын нөөцийг гадагш нь алдах эрсдэл үүсэж байгааг анхааруулж, Засгийн газраас баруун аймгуудын газар тариалан эрхлэгчдийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй талаар үг хэллээ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Цэндгомбын Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрлэл үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга.

Одоо УИХ-ын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна аа. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Энэ хууль 2 дахиа орж ирж байна. Ер нь татвар чинь тэгээд орлого бүрдүүлэх, зарим нь бүртгэлийн үүрэгтэй тэгээд ихэнхдээ бас дотоод зах зээлээ хамгаалах зэрэг ингээд үүргүүдтэй. Тэгэхээр энэ гаалийн татвар дээр явж байгаа энэ нэг 5 хувийн татварын хүрээнд энэ зүйлүүд ингээд яригдаад явж байгаа.

Энэнээсээ гадна миний хувьд сая Засгийн газраас санал авахаар нэг хуулийн төслийг Засгийн газарт явуулсан. Энэ нь нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой. Нэмэгдсэн өртгийн албан татварыг бид нар бүртгэлийн татвар гэж бас ярьдаг онолынхоо хувьд. Мэдээж орлого нөгөө талдаа яг энэ татварт өөрт нь дотоод зах зээлийг тодорхой хэмжээнд бас ингээд менеж хийх хамгаалах ийм боломж бололцоо байна аа. Тэр тусмаа манай бид нарын хувьд нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалт гэдэг ойлголтыг нэлээн тийм хэвшмэл ойлголт болоод хувирчихлаа. Одоо бүгдээрээ 2 хувийн буцаалттай.

Тэгэхлээр би Засгийн газраас санал авахаар явуулсан энэ хуулийн төсөл дээр үзэл баримтлалын түвшинд энэ буцаалтыг ялгаатай болгочихъё, дотоодын үйлдвэрлэлийг тодорхой хэмжээгээр ялгаатай магадгүй 5 хувь хүртэл хувийн буцаалт дотоодын үйлдвэрлэл, дотоодын бараа бүтээгдэхүүнд өгч болдог. Нийтлэг импортын бараа тодорхой хувь хэмжээ 2 хувьтайгаа байдаг, магадгүй архи, тамхи зэрэг бараа бүтээгдэхүүнүүд дээр 0 хувийн буцаалт өгч болдог буюу ингэж ялгаатайгаар асуудлыг шийдэж болох боломж бололцоо бас байгаа гэж үзэж Засгийн газраас санал авахаар явуулсан юмаа.

Тэгэхээр энэ яг одоо энэ нэг гааль дээр яригдаад байгаа энэ нэг 5 хувийн асуудлууд энэнээсээ гадна өөр хуулиуд дээр бид нарт бас нэг ийм боломж бололцоонууд байгаа шүү. Тэгэхээр ер нь яг саяын хуулийн үзэл санаа энэ олон олон зүйлүүд дээр би бас энэ Засгийн газрын Энхбаяр сайд байхгүй байх шиг байна. Яагаад саяны хуулийг би ялгаатай буцаалт, ялгаатай НӨАТ-ын ялгаатай татварын тухай үзэл санаа яагаад чухал вэ гэхээр энэ нь өөрөө ХХАА, хүнс энэ хөнгөн үйлдвэрийн салбарт илүү их тийм бодлогын хөшүүрэг болж чадах юмаа. Чадах одоо чадах ийм үндэслэл байна аа. Мэдээж энэ дотор дахиад дотоодын үйлдвэрлэлийг, дотоодод үйлдвэрлэсэн, дотоодод бий болж байгаа энэ баялгийг үйлдвэрлэлийн өртгийг яавал дотоодын үйлдвэрлэл гэж үзэх юм, хэдээс дээш өртгийнх нь хэдэн хувь нь шингэсэн байвал Монголын үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүн гэж үзэх юм гэдэг дахиад энэний цаана дагавар хийгдэх ёстой олон олон зүйлүүд бас гарах байх.

Тэгэхлээр ийм хуулийн үзэл баримтлалд хэрвээ Засгийн газраас ингээд санал авахаар очвол одоо энэ дээр нэг байр сууриа Засгийн газрын байр сууриа хуваалцаж өгөөч. Энэ Сангийн сайд байх шиг байна Сангийн сайдаас асууя.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя аа. Сайн судлах л хэрэгтэй дээ Цогоо гишүүн ээ. Яах вэ олон улсын практикт ийм зүйл байдаг эсэхийг сайн мэдэхгүй юм. Ер нь их л ховор байх даа. Би ер нь байдаг гэж дуулаагүй юм. Зүгээр системийн хувьд болбол маш хүндрэлтэй. Тэгэхдээ яах вэ систем гэдэг бол өөрөө техник. Татварын үзэл баримтлал бодлогын хувьд ямар байх нь вэ судалъя аа. Танаас санал ирэхээр судалж байгаад хариу өгье.

Д.Амарбаясгалан: Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Ажлын хэсгээс асууна аа. Тэгэхлээр зэрэг түрүүчийн удаа энэ хуулийг оруулж ирээд батлах санал хураалтад дэмжсэн хүний нэг байгаа юмаа. Тэгэхдээ бас дотор жаахан эргэлзээ байсан. Одоо тэр эргэлзээгээс бас арилгах үүднээс асуулт байгаа юм.

Одоо баруун талын 5 аймаг дээр бүүр гурилын үнэ бол тогтворжчихсон, Улаанбаатараас хямд гурил идэж байгаа. Тэгэхээр зэрэг одоо энэ хууль батлагдаад гарсны дараа энэ нөхцөл байдал өөрчлөгдөхгүй байх ямар баталгаа байна вэ? Өөрөөр хэлбэл Засгийн газар энэ улаан буудайн импортод тодорхой хэмжээний квот тогтоох болон бусад асуудлыг хэд хоногийн дотор шийдээд тэр ард түмэнд хүрчих ёстой юм бол үр дүн нь. Энийг нэг тодорхой хариулж өгөөч ээ гэж бодож байгаа.

Яагаад гэвэл бид нарын хувьд дотоодын үйлдвэрлэлийг нь дэмжих, дотоод зах зээлээ хамгаалах энэ чухал асуудал мөнөөс мөн. Гэтэл нөгөө талд нь хүнсний түүхий эд бүтээгдэхүүний хангамж болоод хүртээмжийн асуудал бол энэнээсээ дутуугүй чухал асуудал байгаа юм. Тийм учраас энэ жил энэ газар тариалангийн үйлдвэрлэл дээр хүндрэлтэй нөхцөл үүсэж эхлээд байгаа энэ байдлыг харгалзан үзээд Засгийн газар тэр гурилын үнэ нэмэгдэхгүй байх тал дээр одоо шалавхан арга хэмжээ авч өгөх нь чухал байна. Ийм л асуулт байна.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье. Рэгдэл гуай гишүүн чухал асуулт хөндөж байна аа. Ер нь одоо баруун бүс нутаг, баруун аймгууд тэгээд Улаанбаатараас холдох нь зүүн аймгууд гээд энд тэгээд Улаанбаатараас холдох тусмаа л бараа бүтээгдэхүүний үнэ өртөг нэмэгдэж байдаг. Яагаад гэвэл тээврийн зардалтай, тээвэрлэлттэй холбоотой хүртээмж хангамжтай холбоотой. Үүнээс болоод үндсэндээ болбол анх бол энэ гаалийн албан татварыг тавих асуудал бас л баруун бүс нутагт гурилын үнэ хэт өндөр болсон учраас гаалийн албан татвараас чөлөөлсөн. Баруун бүс нутагтаа тухайлаад чөлөөлчихсөн байсан бол уул нь одоо юу гэдэг юм улсын хэмжээнд чөлөөлөх шаардлагагүй болох байсан. Гэтэл одоо улсын хэмжээнд чөлөөлөөд, тодорхой хэмжээгээр бас гурилын үнэ хямдарсан буусан. Одоо буцаагаад одоо тавих шаардлагатай гэж байгаа.

Сая ч гэсэн одоо УИХ-аар энэ хууль дэмжигдээгүй нэг шалтгаан бол таны ярьж байгаа энэ одоо бас баруун бүс нутгийн гурилыг яаж тогтвортой, хямд, хүртээмжтэй хангах вэ гэдэг асуудал бас шийдэгдээгүйтэй холбоотой. Бас зарим гишүүд бас буцаахад саналаа бас илэрхийлж байсан. Тийм болохоор энэ удаа бас энэ тогтоол дээр болбол энэ баруун бүс нутагт гурилын татварыг улсын хэмжээнд одоо тогтооно. Гэхдээ баруун бүс нутагт газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх,

гурил тэжээлийн үйлдвэрлэл, хангамжийг тогтвортой байлгах, тодорхой төлөвлөгөөг Засгийн газар боловсруул аа гэсэн ийм үүргийг УИХ-аас өгөхөөр тогтоолын төсөл бэлдсэн байгаа.

Мөн одоо бас баруун бүсийн гурил тэжээлийн үнийн өсөлт инфляцад нөлөөлөх нөлөөллийг бууруулахтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд тээврийн зардал дээр нь одоо татаас өгөх ийм одоо бас төсвийн талаарх саналыг боловсруулж, шаардагдах төсвийн санхүүжилтийн санхүүжүүлж одоо хэрэгжилтийг хангаж ажиллах гэсэн үүргийг УИХ-аас Засгийн газарт бас өгөхөөр бас ийм УИХ-ын тогтоолын төсөл бас энэ хуулийг дагаж орж ирж байгаа. Энэ хүрээндээ үндсэндээ бол алслагдсан бүс нутагт одоо амьдарч байгаа ард иргэдийн гурил тэжээл одоо бас хүнсний хангамжийн асуудал дээр ийм одоо зохицуулалтыг давхар хийхээр ийм бас уян хатан зохицуулалт энэ юуг хуулийг дагаж орж ирж байгаа гэдгийг хариулъя аа.

Д.Амарбаясгалан: Мөнгөнцаогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Гишүүд болон ажлын хэсгийнхэндээ оройн мэндийг хүргэе ээ. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн асуудлыг 2 дахь удаагаа бас хэлэлцэхээр болж байна аа. Асуудлыг анхнаас нь бас үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, ХАА-н салбараа тогтвортой байлгах, нэг гараараа бас дэмжээд, нөгөө гараараа бас татан унагаж байгаа энэ байдлыг бас байж болохгүй юмаа гэсэн байр суурьтайгаар бас дэмжиж ирснийг бас одоо хэлье. Дахин бас одоо шуурхай оруулж ирж байгаа нь бол зөв өө. Гишүүдийн зүгээс бас тавьж байгаа энэ асуудлууд дээрээ салбарын яам бас дахиад сайн одоо бас ажилласан уу?

Зудын эрсдэлийн нөхцөл байдал, гурилын үнийн одоо бас өсөлттэй холбогдолтой түр хугацааны энэ зохицуулалт бол үр дүнгээ өгсөн гэж бас харж байгаа юм аа. Зудын эрсдэлт нөхцөл байдлын энэ цаг хугацаанд бас тодорхой хэмжээнд бас хуулийн хэрэгжилт бас үр дүнгээ өгсөн. Гэхдээ энэ тогтоол бас 8 агуулга бүхий 31 дүгээр тогтоол одоо болж хамтдаа бас гарсан. Түүнийг л үндсэндээ гишүүд асуугаад, хэрэгжилтийн явц, цаашдаа хэрэгжүүлэх арга хэмжээ, бүс орон нутгийн хувьд бас ялгамжтай байх боломжтой юу гэдэг энэ агуулгаар бол үндсэндээ асуултуудыг асуугаад зөвхөн хориглох, хориглосныг болих гэдэг энэ асуудлаас гадна энэ салбарын суурь асуудлуудыг бол биднээс нэхээд байгаа юмаа. Тэгэхээр үүнтэй холбогдолтой асуудлууд дээр бас илүү бодлогын чанартай хэрэгжүүлсэн ажил юмнууд бас нэмэлт мэдээллүүд байгаа бол салбарын яамнаас бас өгөх нь зөв байх аа гэж бодож байна.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд хүнсний, хөнгөн одоо үйлдвэрлэлийг дэмжих, хоршоог дэмжих, газар тариаланг дэмжих 4 том хөтөлбөрийн хүрээнд 9, 10 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гаргах эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр олгож байгаа. 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэх зорилт тавиад бид өнөөдөр мах, гурил, төмс гэсэн 3 нэр төрлөөс бусад бүх нэр төрлөө гаднаас авч байгаа нь бас одоо болохгүй байна аа. Үндэсний аюулгүй байдлын асуудал байна аа гэдэг энэ бодлогыг бид нар дуу нэгтэйгээр хэрэгжүүлээд 3 дахь жил рүүгээ орж байгаа.

Өнөөдөр тодорхой үр дүнгүүдээ өгөөд 2, 3 мянган бас ААН-үүд хүнсний үйлдвэрүүд зээлээ аваад ингээд ажиллаж байгаа юмаа. Тэгэхээр цаашдаа бид нэг

гараараа дэмжээд, нөгөө гараараа бас энэ бодлогынхоо эсрэг байдаг энэ арга хэмжээнүүдийг авахгүй байх тал дээрээ бид бүхэн бас анхаарах нь зөв өө. Алдаагаа бас одоо дор бүр нь засаад явах нь зөв юмаа гэсэн ийм байр суурьтай байгаа. Тариалалтын хувьд бид бүхэн бас одоо оройтсон ийм нөхцөл байдал бас үүсэж байна аа. Тэгэхээр нөхцөл байдалтай холбогдолтой энэ жилийн тариалалтын явц одоо ямар байгаа вэ?

Мөн одоо энэ шийдвэрийг гарахыг бас хүлээж, тарина, тарихгүй гэж байсан тариалан эрхлэгчид маань одоо бас үндсэндээ ямар шийдвэрүүдийг гаргаж, ирэх жил бид бүхэн бас ямар байдалтай нүүр тулах вэ гэдэг дээр тодорхой бас хариултуудыг авъя аа. Яг салбарын хувьд бол энэ үйлдвэрлэлийн одоо өртгийн сүлжээний энэ бүхий л шатыг цогцоор нь авч үзэх шаардлагатай байгаа юмаа. Бид бүхэн зөвхөн энэ гурилын асуудал улаан буудайн асуудал гэхээсээ илүүтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн энэ өртгийн шатандаа өсөөд байгаа асуудлыг илүү нарийвчлан судалж байгаа ийм зүйл байна уу? Үндсэндээ түүхий гурил хэрэглэдэг хэрэглээ үндсэндээ одоо эцсийн бүтээгдэхүүн болж хэрэглэж байгаа хэрэглээ 2-ын энэ хамаарал бол эрс өөрчлөгдөж байна аа. Дандаа үндсэндээ одоо эцсийн бүтээгдэхүүн иргэд маань бол хэрэглэдэг болж байна аа.

Тийм учраас зөвхөн одоо үйлдвэрлэлийн анхан шат биш бусад шатууд дээр гарч байгаа бас энэ алдааг хэрхэн зохицуулж болох вэ гэсэн асуултууд дээр илүү нарийвчлаад бол тодруулъя. Хуулийн төслийг бас дэмжиж байгаагаа илэрхийлье ээ.

Д.Амарбаясгалан: Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Улаан буудайн тариалалт одоо дууссан байгаа юм. Ингээд дууссан байхад харахад болбол энэ жил бол нэг 280 орчим мянган га газар улаан буудай тариалсан. За нэг 250 орчим мянган тонн одоо бас улаан буудай хурааж авах болов уу гэсэн ийм одоо урьдчилсан тооцоо гарсан байгаа. 2021 онд одоо хамгийн оргил үедээ 566 мянган га-д улаан буудай тариалж байсан. Түүнтэй харьцуулах юм бол 2 дахин бага талбайд улаан буудай тариалсан байна аа. 2023 онд 443 мянга, 2024 онд 386 мянган га-д улаан буудай тариалсан. Энэ жил одоо бас нөгөө энэ гурилын импортын татварыг чөлөөлсөнтэй холбоотойгоор, улаан буудайг бас чөлөөлсөнтэй холбоотойгоор тариалалт улаан буудайн тариалалт одоо багасаад 280 мянга буюу одоо үндсэндээ 2020 оноос хойш хамгийн доод түвшиндээ хүрч байна.

Тийм болохоор энэ жил бас яаралтай арга хэмжээ авч тодорхой дагаж байгаа тогтоол дээр 100 мянган тонн улаан буудай бас гаднаас оруулж ирж нөөцлөх энэ асуудал дээр арга хэмжээ ав аа гэсэн шийдвэрийг Засгийн Газраас УИХ-аас Засгийн газарт одоо бас өгөх ийм төсөл явж байгаа. Энэ жилийн хувьд одоо ингээд 7 нэр төрлийн үр тариа, буудай, бусад үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээл, тосны ургамал гээд ингээд 7 нэр төрлийн газар тариалангийн бүтээгдэхүүн тариалахаар төлөвлөснөөс зөвхөн тосны ургамал дээр нөгөө рапс дээр 114 мянган, 14 хувьтай буюу одоо гүйцэтгэл нь 100 хувьтай, бусад одоо болбол малын тэжээл 20 хувьтай хамгийн бага, хүнсний ногоо одоо 55 хувьтай тариалж дуусаагүй байгаа гэхдээ. Нийт дүнгээрээ нэг 73 хувийн гүйцэтгэлтэй байж байна аа. Энийг та бүхэндээ бас хэлье.

Тэгээд стратегийн хүнсний хувьд болбол малын мах, сүү тэгээд дээрээс нь одоо тарианы үр, улаан буудай, гурил, ундны ус стратегийн хүнс гэж үздэг. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс бас санаачлаад энэ Хүнсний хувьсгал хөтөлбөрийг санаачилсан. Засгийн газраас бас атрын 4 дүгээр аяныг бас санаачилсан. Энэ хүрээндээ бас тодорхой одоо хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, газар тариалангийн болон бусад МАА-н чиглэлийн үйлдвэрүүд дээр бас хөнгөлөлттэй зээл олгох гэх мэтийн бас хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа.

Саяын одоо бас энэ гурилын одоо улаан буудайн гаалийн татварыг чөлөөлсөнтэй холбоотойгоор энэ хөтөлбөрт бас сөрөг нөлөө үзүүлэхээр байсан бол одоо ингээд бас асуудлаа засаад, цаашдаа бас энэ хүнсний хангамжийг нэмэгдүүлэх одоо бас бодлогоо үргэлжлүүлж хэрэгжүүлэх ийм бас боломж бололцоо энэ татварыг тавьснаараа бас ингээд бий болно. Ер нь одоо бас нэг идэх хоолоо, уух усаа, уух сүүгээ, одоо махаа бид нар гаднаас гуйдаггүй, өөрсдөө дотооддоо үйлдвэрлэдэг, өөрсдөө хангадаг болчих болбол Монгол Улсын бас хамгийн одоо үндэсний аюулгүй байдлын бас нэг чухал зорилтоо. Тэгээд энийг хэрэгжүүлэхийн төлөө бас тал талдаа бид нар бас анхаарч ажиллах ёстой байх аа гэдгийг бас хэлье.

Нэмэлт асуулт дээр Болорчулуун дарга, Довчинсүрэн дарга хариулчих уу? Сая үлдсэн асуудал дээр.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индэр.

Ц.Болорчулуун: ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Ганхүлэг сайдын гишүүний асуултад хариулт өгье өө. Тэгэхээр 2024 оны 4 сарын 19-нд энэ Гаалийн албан татварын тухай хууль батлагдсантай холбоод дагаж УИХ-ын 31 дүгээр тогтоол гарсан 7 заалт бүхий. Энэ 7 заалтыг заалт болгоноор нь бид нар бас хэрэгжилтийг гаргаж холбогдох Байнгын хороонд бол хүргүүлсэн байгаа. Тодорхой ажлууд бол хийгдсэн. Тухайлах юм болбол энэ хуультай холбоотой 1 заалт байсан. Өрсөлдөөний болон худалдааны демпингийн тухай хуулийг бол боловсруулж өргөн мэдүүлэх тухай. Энэ дээр болбол Эдийн засаг, хөгжлийн яам тодорхой ажлын хэсэг гаргаад эндээс бол санал аваад энэ хуулийн төслүүд бол хэрэгжээд явж байгаа.

Тариаланчид, улаан буудай, гурилын үйлдвэрлэгчдийн хооронд гардаг маргаантай холбоотойгоор ер нь болбол энэ ХАА-н бирж дээгүүр биржээр дамжуулж арилжааг зохион байгуулах гэсэн ийм заалт байсан. Энэ дээр тодорхой үр дүнгүүд гараад өнгөрсөн оны намрын ургацын бүх буудай...

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ц.Болорчулуун: ХАА-н бирж дээр худалдаж нийтдээ 10 сортын 5.5 мянган тонн үрийн будаа, 40.8 мянган тонн хүнсний улаан буудайг бол 327 иргэн, ААН-д ХАА-н биржээр дамжуулж борлуулсан. Гэх мэтчилэн бид нар энэ биелэлтийг бол 31 дүгээр тогтоолоор тодорхой хэмжээнд гаргасан байгаа. Тэгээд ингээд ер нь бас нэг тариаланчдын дунд үүсдэг одоо элеваторыг ХАА-н корпорацад байгаа элеваторыг тариаланчдад ашиглуулах боломжийг бол бүрэн хангасан. Тариаланчид маань энэ элеваторт зориулалтын дагуу будаагаа хадгалаад, цэвэрлүүлээд гурил үйлдвэрт нийцүүлээд тушаах боломжоор нь одоо хангаж өгсөн. Энд бас тодорхой хэмжээний

ААН-үүд бол хамрагдаад нийтдээ 36 мянган тонн буудайг бол энэ тус элеваторт хадгалаад гаргасан байж байгаа.

Гурилын буудайн чанартайтай холбоотойгоор бид ХАА-н корпорацын 3 салбарын лабораторийг итгэмжлэх ажлыг бол Стандартчилал, хэмжил зүйн газартай хамтарч зохион байгуулж байна. Түүнчлэн...

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя. Болорчулуун дарга хугацаандаа багтаж хариултаа өгч байхгүй бол илтгэл тавих гээд байна шүү.

Д.Пүрэвдаваа: Оройн мэндийг хүргэе ээ. Хэд хэдэн удаагийн Байнгын хорооны хурлууд болон энэ бусад хурлууд дээр өгсөн мэдээллийг үндэслээд энэ асуудлыг бол дэмжих нь зүйтэй юм байна аа гэсэн байр суурьтай байгаа. Гэхдээ хэд хэдэн зүйлийг онцолж бас асууж хэлмээр байна аа. 1 дүгээрт бодлогын уялдаагүй байдал байна аа. Хуулиа батлаад хуулиа хүчингүй болгох энэ хоёрын хугацаа ердөөсөө жил гаруйхны дотор. Энэ нь юу илтгэж байна вэ гэхээр зэрэг эрх баригчдын алсын хараа 2050 гэдэг бол үнэхээр төөрсөн асуудал байна аа гэдгийн л илрэл.

Сонгуульд нэр дэвшихдээ та бүхэн маань, ялангуяа манай сайд, дарга нар маань алсын хараа 2050-ийг бол маш ийм дунд хугацаа, урт хугацаандаа бид нар ажиллаад төлөвлөж чаддаг аа гээд санал авсан. Гэтэл энэ яг бодит жишээ нь хуулиа батлаад хүчингүй болгох энэ интервал нь ердөөсөө жил гаруйхны хугацаа байгаа гэдэг нь бол төрийн уялдаагүй бодлого хадгалагдсаар байна аа гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгээд энэ бодвол одоо энэ татварыг бий болгосон хуулийг санаачлахдаа бас л зайлшгүй хэрэгцээтэй байсан гэдгээр санаачилсан байх гэж бодож байна. Тэгэхээр цаашдаа энэ бодлогын уялдаагүй байдал хэдэн хувиар багасах юм бэ. Ойрын хугацааны төлөвлөгөөг чинь сонсмоор байна аа.

2 дугаарт импортын хэмжээ нэмэгдсэн нь буруу төлөлтийн үр дүн гэж хэлмээр байгаа юм. Энэ чинь мэргэжлийн байгууллагууд байгаа л биз дээ. Анхнаасаа ийм төлөлт бий болох эрсдэл байгаа гэдгийг ялангуяа дотоодын үйлдвэрлэгчдийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх ёстой гэдэгтэй мэргэжлийн байгууллагууд санал нийлэх байх. Үүнийгээ урьдчилан тооцох тийм боломжгүй байсан юм уу? Тийм мэргэжлийн байгууллагууд нь хомс байгаад байгаа юм уу гэж асуумаар байна.

Дараагийн дугаарт энэ нийгмийн оролцоо ялангуяа хөндлөнгийн байгууллагуудын авсан санал надад бол хангалттай санагдаагүй. Тарааж өгсөн материалыг уншиж танилцваас. Цаашдаа энэ нийгмийн оролцоо ялангуяа одоо энэ тэр энэ салбарт ажиллаж байгаа улсууд зээлээр компаниа авна. Түлшний үнэ өсчихсөн байгаа, ажиллах хүчний хомсдол гэх мэт асуудлуудыг энэ яг салбарт ажиллаж байгаа улсуудаасаа л сонсох ёстой. Энүүхэндээ гэж хэлэхэд Монгол Улсын төр үндсэндээ дүлий байна шүү. Хүмүүсийн үг сонсохгүй байна шүү гэдгийн илрэл байна аа. Цаашдаа энэ дээрээ хэрхэн яаж анхаарч ажиллах вэ?

Дараагийн дугаарт яг энийг хүчингүй болгосноороо ямар үр нөлөө гарах юм бэ? Тарааж өгсөн материал дээр бол аягүй ерөнхий заалтууд байна аа. Тоон

үзүүлэлт дээр. Дээрээс нь ирэх жилүүдэд ямар өөрчлөлт гарахыг одоо календарьчилсан байдлаар танилцуулж болох уу гэж асуух байна аа? Баярлалаа. Тодруулга нь.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя аа. Таны хэлж байгаа төрийн бодлого тогтвортой, бас залгамж чанартай, харилцан уялдаатай байх ёстой гэдэг дээр санал нэг байна аа. Ер нь өнгөрсөн бас нэг одоо 1990 оноос хойш Улсын төлөвлөгөөний комисс татан буугдсанаас хойш бол Монгол төрийн бодлого тодорхой биш, тогтвортой биш, залгамж чанар харилцан уялдаа гэдэг юм алга болчихсон байсан 2019 онд бид Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж төрийн бодлого тогтвортой байх асуудлын Үндсэн хуульд оруулсан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийг 2020 онд УИХ-аар баталсан. Үүнээс хойш үндсэндээ болбол төрийн бодлого тогтвортой, харилцан уялдаатай, тодорхой байх асуудал бол ингээд явж байгаа алсын хараа 2050 урт хугацааны бодлогын бичиг баримт, дунд хугацааны зорилт хөтөлбөрүүд 5 жилийн үндсэн 5 жилийн одоо үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр жилийн төлөвлөгөө гэсэн бичиг баримтуудыг бид батлаад одоо хийж хэрэгжүүлэхээр явж байгаа.

Үүний одоо ингээд хэрэгжилтийг бас Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас бас үнэлэлт дүгнэлт өгсөн байна лээ. Энэ дээр ингээд аваад үзэхэд улсын жилийн төлөвлөгөөний туссан арга хэмжээний хэрэгжилт 45 хувьтай буюу эрчимжүүлэх шаардлагатай. Засгийн 2021-2025 оны 5 жилийн үндсэн чиглэл 52 хувь буюу одоо эрчимжүүлэх шаардлагатай. 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 25 хувь буюу одоо хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгүй гэж гарсан байна лээ. Тийм болохоор цаашдаа бид одоо бас энэ бодлогын залгамж чанар бодлогын харилцан уялдаа холбоо төрийн бодлогын энэ дээр илүү бас анхаарах ийм шаардлага үүсэж байгаа. Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам энэ одоо бас төрийн бодлогын бичиг баримтуудыг хариуцдаг, УИХ-аар хэлэлцүүлж батлуулдаг. Одоо бас энэ Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн заалтаар одоо хяналт тавих чиг үүрэг нь бас тийшээ шилжиж байгаа. Тийм болохоор төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих функц болбол Эдийн засгийн хөгжлийн яаман дээр очно. Үүнийгээ дагаад илүү бас үр дүнтэй болох болов уу гэж харж байгаа.

Цаашдаа одоо юу гэдэг юм. Нэг өглөө унтаад босохдоо ингээд төрийн бодлогын бичиг баримтыг өөрчилдөг энэ асуудал дээр бид бас анхаарах ёстой. УИХ-ын гишүүд ч гэсэн ялгаа байхгүй одоо юу гэдэг юм дур дураараа бас төрийн бодлогын бичиг баримттай зөрчилдсөн хууль санаачилдаг, улс орны одоо үндэсний эрх ашиг, улсын төсөв, одоо эдийн засгийн байдал үүнийгээ бас нэг бодож болгоож хууль санаачлах тал дээр бас цаашдаа бас илүү анхаарч ажиллах ёстой байх аа гэж би бодож байгаа. Тэгээд тэр трактор тариаланчтай холбоотой одоо хэдий хэр хэмжээтэй байгаа, ер нь энэ хууль батлагдсанаар бас ямар үр дүн гарах юм бэ гэдэг дээр хийсэн тооцоо судалгаагаа бас ХААЯ танилцуулчих уу? Асуултад нэмэлтээр хариулаад.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индэр.

Ц.Болорчулуун: Пүрэвдаваа гишүүний асуултад нэмэлт хариулт өгье өө. Тэр тухайн хууль бол 2023-2024 оны өвөлжилт хаваржилтын нөхцөл байдалтай

уялдаж одоо гарсан хууль байгаа. Үнэхээр одоо зудын нөхцөл үүссэн учраас малчдын орлогыг нэмэгдүүлэх тухайн байдал нөхцөл байдлаас хүндрэл багатай гарах зорилгоор энэ хуулийн төслийг санаачилж одоо хэрэгжүүлсэн. Хуулийн хэрэгжилтийн явцад бол үнэлгээ хийгээд үнэлгээ дүгнэлт өгөөд энэ хууль бас хэрэгжих хугацаандаа бас үр дүнгээ өгсөн гэж үзээд энийг дахин хүчингүй болгох хуулийн төслийг бол оруулж ирж байгаа юмаа.

Тэгээд хуулийн төсөл мэдээж одоо энэ хууль хүчингүй болгох хуулийн төсөл батлагдсанаар дотоодын үйлдвэрлэл маань тогтворжих, энэ газар тариалангийн үйлдвэрлэл зөвхөн одоо гурил үйлдвэрлэгчид тариаланчид биш энийгээ дагасан олон субъектүүд буюу одоо техник тоног төхөөрөмжийн дилер компаниуд, дээрээс нь ургамал хамгааллын бодис бордоо нийлүүлэгч ААН-үүд гээд тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа энэ томоохон үйлдвэрлэлд одоо харилцагч болж орж байгаа энэ томоохон ААН-үүдийн...

Д.Амарбаясгалан: Пүрэвдаваа гишүүн тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: Ер нь бол яг тодорхой хариулт авсангүй ээ. Тэгэхдээ дараа нь энэ албаны улсуудаас бичгээр авъя аа гэдэг саналыг хэлмээр байна. Ер нь энэ бизнес эрхлэгчид ялангуяа энэ салбарын үйл ажиллагаанд одоо идэвхтэй оролцдог улсууд маань энэ ажлаа төлөвлөдөг юм шүү. Тэр улсууд чинь зээл хунар авдаг юм шүү. Урт хугацааны одоо санхүүгийн төлөлтөө хийдэг учраас төр маань байнга ингэж эргэж буцсан шийдвэр гаргаж болохгүй шүү гэдгийг л та бүхэнд захиж хэлмээр байна. Тэгээд цаашдынхаа үйл ажиллагаанд анхаарна биз ээ.

Дээрээс нь нөгөө олон нийтийн оролцоо гэдэг зүйлийг бас онцгой анхаараарай. Тэрэн дээрээ бас ийм мэргэжлийнхнийг бас оролцуулсан тийм одоо дүгнэлт тийм анализуудыг сайн хийгээрэй л гэж хэлэх байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: 3 асуулт байна. 1 дүгээрт бол энэ зах зээлийн эдийн засагт хувийн өмчийг дэмжих, хамгаалах хувийн одоо бизнесийг бол дэмжих нь бол зүй ёсны хэрэг. 2-т нь зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих нь хамгийн чухал. Тэгээд энэ зүйл дээрээ л том алдаа гаргаад байна уу гэж харж байгаа. Ялангуяа энэ одоо Монополын эсрэг газар гээд энэ газар ерөөсөө ажлаа хийхгүй байна аа. Тэгээд ингээд тунхгийн шинж чанартай одоо бүүр сүүлдээ ингээд бүүр мэдэгдэхээ ч болилоо ийм газар байдаг билүү, үгүй бил үү. Уул нь зүй нь болбол энэ чөлөөт өрсөлдөөнийг хянадаг энэ монополыг газар авхуулахгүй байх, үгсэн хуйвалдаж үнэ нэмэхгүй байх энэ зүйлийг хянадаг газар маань илүү том дархлаатай, илүү том хүрээнд ажлаа хийх ёстой байгаа юмаа. Тэгээд энэ бол бас гурилын үнэ өсөхөд нөлөөлсөн нэг шалтгаан гэж одоо дүгнэлтийг бол түрүүн энэ хуулийг хэлэлцэхэд бол бас танилцуулсан.

Тэгээд энэнтэй холбоотой ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа вэ гэдгийг 1 дүгээрт асууж байна. Тэгээд бас одоо зах зээлийн эдийн засагт нөлөөлж байгаа нэг зүйл нь энэ одоо төр бизнес хийхгүй, төрийн хүн бизнест одоо оролцож нөлөөлөхгүй байх. Тэгээд энэ зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр яг энэ одоо гурилын тухайд энэ үнэ өсөх энэ өнгөрсөн хугацаанд үүссэн, үгсэн хуйвалдсан гэдэг энэ

шалтгаан дээр энэ хэрхэн нөлөөлсөн гэж дүгнэж байгаа вэ? Мэргэжлийн одоо байгууллага.

Дараагийн асуулт бол баруун бүсэд гурилын үнэ өндөр байна аа, их олон дахин өндөр байна аа гэдэг асуудал одоо маш их яригдаж байгаа. Тэгээд баруун бүсэд энэ гурилын үнэ одоо яагаад өндөр байгаад байгаа шалтгаан нөхцөлийг ер нь оношилж тогтоосон уу? Энэнээс одоо урьдчилан сэргийлэх энэ хуулийг одоо хэрвээ батлагдсан тохиолдолд энэнээс сэргийлэх талаар ямар бодлогын арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа вэ? За энэ асуудал бол одоо хамгийн чухал асуудал шүү. Өнөөдөр яах вэ ингээд энэ хууль батлагдаагүйтэй холбоотой баталсангүй гэдэг нэлээн асуудлууд яригдаж байгаа. Тэгвэл нөгөө талд нь энэ хууль хэрвээ батлагдах юм бол гурилын үнэ өснө шүү гэдэг маргаан дахиад явна. Тэгээд энийг урьдчилж одоо яаж яг харж тооцож байгаа юм.

Тэгээд баруун бүс дээр одоо энэ түгээлтийн хүргэлтийн сүлжээ энэ тээврийн зардал юунаас болж одоо энэ үнэ нь өсөөд байгаа юм. Яг борлуулалт дээрээ тэр дэлгүүр хоршоон дээр өсөөд байгаа юм уу, тээвэр дээрээ өсөөд байгаа юм уу. эндээс төр юм бол одоо бодлого арга хэмжээ авах ёстой шүү дээ. Тэгээд яг ямар арга хэмжээ авахаар одоо төлөвлөсөн бэ?

Дараагийнх нь түрүүн энэ хуулийн төсөл орж ирэхэд миний бие Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд энэ дагалдуулж гарах тогтоолын төсөл санаачилж одоо оруулсан. Зарчмын зөрүүтэй саналыг УИХ чуулганаараа одоо эхний хэлэлцүүлгээр дэмжсэн. Тэгээд харамсалтай нь нөгөө энэ хууль маань эцэслэн батлахаар санал хураахаар оруулж ирэхдээ энэ тогтоолын төсөл маань цуг орж ирээгүй. Тэгээд үүнээс шалтгаалаад би бол дэмжих санал бол өгөөгүй, дэмжээгүй. Энэ тогтоол гарсан тохиолдолд бол дэмжье ээ гэдэг ийм л одоо саналаа бол илэрхийлээд байгаа ийм саналтай олон хүн байгаа гэж бодож байгаа.

Өөрөөр хэлбэл энэ тогтоолын гол агуулга бол үнэ өсөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой болзолтой. Өөрөөр хэлбэл одоо Үндэсний статистикийн хорооны 6 сар тутмын дүнгээр гурилын үнэ өсөх юм бол дахиад энэ гурилын импортыг одоо импортын хуулийг дахин тэглэх. Өөрөөр хэлбэл орж ирж байгаа 15 хувийн гурилын татвар, тэжээлийн 5 хувийн татварыг тэглэх энэ агуулгыг одоо дахин оруулж ирэх гэдэг энэ замаар гурил үйлдвэрлэгчдэд үгсэн хуйвалдаж үнээ нэмэхгүй байх, гурил үйлдвэрлэгчдийг одоо хэт ийм одоо үнийн өсөлт үүсгэж ард иргэдийн амьдралд энэ нөлөөлөхгүй байх ийм л нэг одоо болзол тавих ёстой гэдэг л ийм утгатай л тогтоолын төсөл санаачилсан юм. Тэгээд энэ маань сүүлд ингээд хамт орж ирээгүй. Одоо ингэж хамт оруулж ирэх үү? энэ дээр ямар одоо хууль санаачлагчийн хувьд бол ямар байр суурьтай байгаа вэ? Энэ их чухал шүү.

Өөрөөр хэлбэл гурилын татвар тогтоож, дотоодын үйлдвэрлэлээ дэмжье нөгөө талдаа үнэ өсгөхгүй байх одоо ийм тодорхой болзол тавья аа. Энэ нь болбол энэ гурил үйлдвэрлэл...

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хороон дарга Даваасүрэн дарга эхлээд хариулт өгчихье.

Ц.Даваасүрэн: Тийм Бадамсүрэн гишүүний өмнө санаачилсан байсан тогтоолын хэрэгжилтийг хангах тухай тогтоол нөгөө үндсэн тогтоол маань

батлагдаагүй учраас дагаж гарах хуулиуд, дагаж гарах байсан тогтоолууд маань одоо хэлэлцэх боломжгүй болоод буцаачихсан гэсэн үг. Тэгэхээр одоо энэ тогтоолтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулаад тогтоолын төсөл шинээр санаачлаад ингээд хэлэлцээд явах боломжтой. Тийм учраас одоо энэ анхны хэлэлцүүлгийн явцад та бүхэн тогтоолын саналаа дахиж өргөн бариад ингээд хэлэлцээд явбал болно оо гэдгийг хэлэх байна аа.

Тэр баруун бүсэд яагаад одоо гурилын үнэ өндөр байдаг вэ гэдэг тал дээр бас Байнгын хороон дээр асуудал гарсан. Гол нь тээврийн зардалд гэдэг ийм зүйл яригдаад байгаа юм. Нөгөө талаасаа бас тэнд газар тариалан эрхэлж байгаа ААН-ийн асуудал бас байгаад байгаа юм. Жишээлбэл Дорнод зах хязгаар мөн үү мөн. Тэгвэл танайд тийм асуудал байхгүй. Яагаад гэвэл тэнд гурилын үйлдвэр байна, газар тариалан байна. Баруун бүсэд тээврийн зардлаас гадна тэр нь дутагдаад байгаа юм. Тийм учраас бас хэлэлцүүлгийн явцад гишүүд ХАА-н сайдад баруун бүсэд газар тариалан эрхлэлтийг дэмжих тусгайлсан хөтөлбөрүүд гаргах, зээлийн хөтөлбөрүүд гаргах, ийм дэмжих бодлогыг одоо хэрэгжүүлэх хэрэгтэй байна аа гэсэн ийм саналуудыг бол гаргаж байсан гэдгийг хэлье.

Тэгээд Монополын эсрэг агентлаг ч гэсэн муу ажиллаж байгаа гэдэгтэй болбол санал нэг байна. Уг нь бол тийм л дээ. Үнийн зохицуулалтыг хийгээд Засгийн газарт оруулаад тодорхой хэсэгчилсэн бүсчилсэн ийм арга хэмжээнүүд аваад явахын оронд нэг бүс нутгийн асуудлыг бүх Монголын хэмжээний болгож яваад байгаа нь өөрөө бас буруу шийдвэр гарах нэг үндэслэл болж байгаа байж магадгүй ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Тэгэхээр өмнөх одоо хэрэгжиж байгаа хууль батлагдсанаар бас баруун бүс нутагт гурилын үнэ бараг 2 дахин хямдарсан. Нэг уут нь 120 мянга байдаг байсан бол 60, 70 мянга болж. Одоо ингээд буцаад татвартай болчихоор бас гурилын үнэ тодорхой хэмжээгээр өснө. Тэгээд үүнийг зохицуулах гэж баруун бүс нутагт одоо газар тариалан эрхлэх бизнес эрхлэхийг дэмжих, мөн одоо бас гурилын үнийг тогтвортой байх тодорхой хэмжээний тээврийн зардал дээр нь татаас өгөх ийм зохицуулалтуудыг энэ хуулийг дагаж батлагдах УИХ-ын тогтоол дээр орж ирж байгаа. Баруун бүс нутагт яагаад ингээд өндөр үнэ өндөр байгаа юм бэ гэхээр зөвхөн гурил биш бензин шатахуун, будаа, тэгээд чихэр, даавуу даалин бүгд өндөр үнэтэй. Тэр нь ерөөсөө л тээврийн зардалтай холбоотой. 1500 км, 1700 км Улаанбаатараас хол учраас тээврийн зардлаа дагаад л өсчхөөд байдаг. Ийм учраас л бас одоо юу гэдэг юм Тээврийн зардал дээр нь гурилаас эхлээд одоо татаас дэмжлэг үзүүлье.

Цаашдаа шаардлагатай бол одоо бусад бүтээгдэхүүн дээр бас татаас дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт үзүүлэх ийм бас...

Д.Амарбаясгалан: За гүйцээж яриулъя Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Мөн одоо бас Өрсөлдөөний тухай хууль энэ хуулийг дагуулж УИХ-ын тогтоол Худалдааны болон одоо демпингийн хуулийг одоо тус тус боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхийг Засгийн газарт бас үүрэг болгосон. Ийм одоо тогтоол орж ирж байгаа. Мөн одоо бас таны ярьж байгаа гурилын үнийг

үндэслэлгүйгээр үнэ өссөнийг тогтоосон тохиолдолд бүх талын одоо хариуцлага тооцох арга хэмжээг хурдан шуурхай авахыг бас Засгийн газарт УИХ-аас үүрэг болгосон заалт энэ УИХ-ын тогтоолыг дагаж бас орж ирж байгаа.

Иймэрхүү байдлаар цаашдаа гурилын үнийг одоо өсгөхгүй байх, хоорондоо үгсэн хуйвалдахгүй байх нийлүүлэлтийг нэмэгдүүлж, үнийг хямдруулах ийм бас бодлогын зохицуулалтыг хийж хэрэгжүүлэх үүргийг УИХ-аас Засгийн газарт өгсөн тогтоол дагаж орж ирж байгаа. Энэ тогтоол дээр Бадамсүрэн гишүүн бас шаардлагатай нэмэлт бас заалтуудыг хэлэлцүүлгийн явцад нэмээд оруулаад явах бүрэн бололцоотой болж байгаа гэдгийг бас хэлье.

Д.Амарбаясгалан: Тийм өмнөх хэлэлцүүлэг дээр гарч байсан яг Бадамсүрэн гишүүний санал үндсэндээ одоо өнөөдөр албан ёсоор тогтоолын төсөл болж хуулийн төсөлтэйгөө хамт өргөн баригдаад хэлэлцэгдээд батлагдах гээд явж байна гэсэн үг болж байгаа юм. Тийм учраас одоо энэ хуулийн төслийг ахиж хэлэлцээд батлаад явах нь зөв болов уу гэж л орж ирээд хэлэлцэгдэж байна. Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Тэгэхээр энэ Байнгын хороон дээр яригдсан тогтоолын төсөл дээр нь нөгөө гол миний оруулсан энэ санал байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энийг ингээд авъя гэдгийг одоо хууль санаачлагчийн зүгээс хүлээж авч байгаа юм байна гэж ойлголоо Бямбацогт сайдын хувьд нэг. 2 дугаарт нь энэ тээврийн зардлын хувьд бол баруун бүс рүү 1 мянга орчим километр тээвэрлэхэд 350-400 орчим төгрөг. Одоо нэг килограмм гурил дээр нэмэгдэхээр ийм тооцоолол гарч байна лээ л дээ бас тооцож үзсэн энийг.

Тэгэхээр энэ энэнээс гадна өөр энэ үнийг өсгөөд байгаа ямар шалтгаан байна вэ гэдгийг л маш сайн оношилж тогтоох ёстой байхгүй юу. Тэгээд энэ дээр би мэргэжлийн яамнаас гол нь асуух гээд байгаа юм. Тэгээд л нэг ерөөсөө ганцхан арга нь хаадаг хориглодог өөр ямар нэгэн уян хатан механизм ерөөсөө бодож олдоггүй, толгой тархиа ажиллуулдаггүй, гарц гаргалгаа хайдаггүй. Одоо жишээлбэл танай яам одоо ХААЯ баруун бүс дээр очиж яг энэ газар дээр нь биечилсэн ийм танилцах ажил ийм оношлох ажлыг ер нь үзсэн...

Д.Амарбаясгалан: За хууль санаачлагчаас тэгье. Болорчулуун дарга 4 дүгээр индрээс. Тэрнээс өмнө Төсвийн байнгын хороон дарга Даваасүрэн дарга хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Бадамсүрэн гишүүний асуугаад байгаа тэр тогтоолын төслийн асуудлыг болбол Байнгын хороо санаачилдаг дэгийн дагуу явагдана. Тэгэхдээ Байнгын хороо гэдэг чинь Их Хурлын гишүүн санаачилна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр хуучин шиг Тамгын газраар одоо хийлгээд ингээд оруулж ирэхгүй ээ. Заавал гишүүдээр санаачилна. Тийм учраас ажлын хэсэг байгуулаад, ажлын хэсэг та өөрөө ороод тэгээд өмнөх тогтоолынхоо юун дээр нэмэх зүйл байвал нэмээд, хасах зүйл байвал хасаад ингээд энэ тогтоолын төслийг Байнгын хороо санаачилсан гэдэг агуулгаар бол ингээд хэлэлцээд явах асуудал нээлттэй байгаа шүү.

Тийм учраас та бүгд дараагийн маргааш хуралдах хуралдаан дээр энэ тогтоолын төсөл ажлын хэсэг байгуулах энэ тэр асуудлаа шийдүүлээд явчих нь зүйтэй байх.

Д.Амарбаясгалан: Болорчулуун дарга 4 дүгээр индэр.

Ц.Болорчулуун: Бадамсүрэн гишүүний асуултад нэмэлт хариулт өгье өө. Тэр гурилын үнэ бол өсөх хэд хэдэн шалтгаан одоо баруун бүс дээр байгаа. Мэдээж энэ дээр тооцоо судалгаа хийж үзэж байгаа. Гурилын үнэ эндээс үйлдвэрийн үнээр бол бүгд л одоо нэг үнээр гарч байгаа. Тэгээд тээврийн зардал байна. Дээрээс нь тухайн одоо худалдан борлуулж байгаа ААН иргэд бол тодорхой хэмжээний өөрсдийнхөө ашгийг нэмж байгаа. Тэгэхдээ ашгийг нэмэхдээ бол мэдээж худалдааны хуулийн зохицуулалт байхгүй учраас харилцан адилгүй ашиг нэмж байгаа. Зарим одоо худалдан борлуулагч нар 300 төгрөг зарим нь одоо 500 төгрөг нэмэх жишээний. Ийм эдгээр нөхцөлүүд байгаа.

ХХААХҮ-ийн сайдаас энэ сая хууль хэлэлцэж байгаад буцсаны дараа болбол баруун бүсийн газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, тэнд шаардлагатай одоо арга хэмжээ авах чиглэлээр ажлын хэсэг байгуулсан. Энэ ажлын хэсэг орон нутагт ингээд орон нутгийн төлөөллийг оролцуулаад эндээс бас эрдэмтэн судлаачдыг оролцуулаад энэ ажлын хэсгийн ажил эхэлчихсэн байж байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсгийн дүгнэлтээр болбол ялангуяа одоо Увсын Баруунтурууны хуучны сангийн аж ахуйг сэргээн...

Д.Амарбаясгалан: Бадамсүрэн гишүүн дахин тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Яах вэ би гол нь ийм л юм хэлээд байгаа юм. Түрүүн энэ хуулийг хэлэлцэхэд УИХ-ын чуулганы эхний хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг 1 дүгээрт хуулийг эцэслэн батлахдаа яагаад оруулж ирэхгүй байгаа юм бэ нэгд. 2 дугаарт тогтоолын төслийг дахин боловсруулахдаа, дахин одоо хуулиа өргөн мэдүүлэхдээ өмнө нь УИХ-ын чуулганаар УИХ-ын гишүүний санаачилсан зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн энэ агуулгыг яагаад тогтоолдоо оруулж ирэхгүй байгаа юм бэ. Яагаад ажил хэрэгчээр энэ асуудалд хандахгүй байгаа юм бэ гэдэг дээр л би гол нь одоо асуугаад байгаа байхгүй юу нэгд.

2 дугаарт нь баруун бүсэд газар дээр нь очиж ерөөсөө ажиллаагүй байгаад байхгүй юу. Энэ очиж ажиллах ёстой байхгүй юу. Энэ Уул уурхайн сайд, энэ ХАА-н сайд одоо энэ газар дээр нь очиж ажиллахгүй болохоор чинь энийгээ зөв оношлоход хүндрэл гараад байна аа гэдэг зүйл хэлээд байгаа юм. Тэгээд яагаад одоо энийг ингээд мартаад байна аа. Өмнө нь дэмжигдсэн асуудлыг яагаад оруулахгүй мартаад хүндээ байна уу, эсвэл одоо хуульдаа байна уу энийг л асуугаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Жадамбын Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Энэ хууль маань өөрөө тэдэн сарын тэднээс хүчингүй болсонд тооцсугай гэсэн л ганц л өгүүлбэр байгаа юм. Тэдэн сарын тэднээс хүчин төгөлдөр болсугай гэсэн өгүүлбэрийг л хүчингүй болгосугай гэсэн өгүүлбэрээр сольж байгаа. Тэгэхээрээ хууль маань өөрөө өргөн барьсан тэр үзэл баримтлалын хүрээнд л явах гээд байдаг. Хамгийн гол нь энэ хууль гарсан нөхцөлд хуулийн хэрэгжүүлэх хуулийг

хэрэгжүүлэх арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл дагалдаж байгаа юм. Тэр тогтоолын төсөл таны яриад байгаа энэ асуудлууд, сая энэ хуулийн хэлэлцүүлгийн хугацаанд гарсан. Тэр баруун бүсийн гурил тэжээлийн үнийн өсөлт инфляцад нөлөөлөх нөлөөллийг бууруулах, баруун бүсэд газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх гурил тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах, тэгээд нөөцийн 100 мянган тонны нөөц бүрдүүлэх мөн...

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Ингээд 7 заалттай, ингээд тогтоолын төсөл дагаж Засгийн газарт үүрэг бид нар хүлээж авч байгаа юм. За энэ хүрээнд тэр өрсөлдөөнд байгаа хуулиа шинэчлэх, худалдааны болон тэр демпингийн эсрэг хуулийн төслийг боловсруулж Их Хурлаар оруулах. Ингээд хэрвээ үнийн өсөлт үндэслэлгүйгээр үнэ өссөн аливаа асуудалд бол шуурхай арга хэмжээ авч зохион байгуулах гээд хэлэлцүүлгийн явцад гарсан бүх саналуудыг тусгасан. Хууль батлагдсантай холбогдуулан хуулиа хэрэгжүүл гэдэг Их Хурлын тогтоолын төслийг их дэлгэрэнгүйгээр дагалдуулж явж байгаа. Ингээд явахаар энэ бүх юм зохицуулчих бололцоотой. Хууль батлагдвал энэ хууль батлагдсантай холбогдвол тэгнэ. Байнгын хорооны асуудал байгаа тэгнэ.

Д.Амарбаясгалан: УИХ-ын гишүүд асуулт авч хариулт авч дууслаа. Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу үг хэлнэ ээ. Чинбатын Номин гишүүн үг хэлнэ, Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ. 1 дүгээр индэр. 1 дүгээр индрийн микрофон өгье.

Ж.Батжаргал: Их Хурлын дарга, эрхэм гишүүдийнхээ энэ оройны амар амгаланг айлтгая аа. Гаалийн албан татварыг чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд бүрэн дэмжиж байгаа. Их Хурлын гишүүдийгээ би энэ хуулийг дэмжиж өгөөч гэж албан ёсоор хүсэж байна аа.

Монголын төр энэ газар тариалангийн салбарыг шинжлэх ухааны үндэслэлтэй бие даасан салбар болгож хөгжүүлж, газар тариалангийн гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр хүн амаа бүрэн хангах, МAA-н салбараа эрсдэлээс хамгаалах тэжээлийн баттай бааз суурьтай болох том зорилтыг дэвшүүлж, Атрын 4 аяныг эхлүүлж бараг зуугаад жил зүтгэсэн. Энэнийхээ үр дүнд газар тариалангийн салбараасаа бид хүн амынхаа хүнсийг бүрэн хангаж чаддаг болсон. МAA-н салбар тэр тусмаа эрчимжсэн МAA-н салбарынхаа тэжээлийн дийлэнхийг эндээсээ бүрэн хангаж чаддаг байсан юмаа. Харамсалтай нь бид хэд хэдэн жилийн их тааламжтай үр дүн дээр тулгуурлаад тэгээд дотооддоо тарифын хийгээд тарифын бус зохицуулалтаар зохицуулж болох асуудлыг дотоод зах зээлээ хамгаалах, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, за энэ салбарт ажиллагсдынхаа итгэл урам зоригийг өгөх ёстой тарифынхаа хязгаарлалтаар оролцсон нь тун таагүй үр дагаврыг авчирлаа.

Энэ хууль батлагдсанаас хойш 2 жилийн хугацаанд бид газар тариалангийн салбарт дам дамаа улаан буудайн үйлдвэрлэл дээр тариалалт 2 дахин буурсан байна. Гурилын үйлдвэрлэл бараг 60 орчим хувиар буурах бодит нөхцөлийг бий болгосон байна. Энэ цаашид үргэлжлэх юм бол хэдүүлээ идэх гурилгүй хүнээс будаа гурилаа гуйх болно шүү. Гадаад нөхцөл байдал чинь өдөр өдрөөр

таашгүйгээр өөрчлөгдөж байна аа. Бидэнд будаа ав аа, гурил ав аа гээд гар сунгадаг улс орон олдохгүй болж мэдэхээр байна. Дээр нь ган гачиг гэж нэг айхтар зүйл байна. Тэгэхээр зэрэг бид энэ үндэстнийхээ бий болгосон чадамжийг дахиж, энэ салбарт ажиллагсдыг урам зоригтой үйлдвэрлэлээ эрхлэх боломжийг нь хангаж, энэ гаалийн албан татварыг чөлөөлсөн нь энэ хуулиа хүчингүй болгох ёстой. Энэ туурга тусгаар улс орон бол үйлдвэрлэгч байх ёстой. Бид үйлдвэрлэлээ дэмжих ёстой. Үүгээрээ дамжуулж бид нэмүү өртгөө бий болгох ёстой, ажлын байраа бий болгох ёстой, эдийн засгаа өсгөх ёстой, төсвөө бүрдүүлэх ёстой. Энэ шаардлагын үүднээс хэдүүлээ энэ хуулийг нэг эр зориг гаргаж улс үндэстнийхээ эрх ашгийг ёстой нэгд тавьж баталъя аа.

Энэ хуулийг дагуулж гарах тогтоолын төсөл нь бэлэн болсон юм билээ. Хэлэлцэх эсэхийг дэмжсэний ард дээр анхны хэлэлцүүлгийн үед энэ тогтоолын төслийг холбогдох гишүүд Байнгын хороотойгоо ярьж санаачлаад илүү боловсронгуй болгоод батлуулъя аа. Ингэснээрээ газар тариалангийн үйлдвэрлэл сул хөгжихөөд байгаа гэдэг юм уу, өмнөх нийгмийн үед хүрсэн түвшнээсээ буурчхаад байгаа бүс нутгууд дээр тэр түвшинд нь хүргэх төрийн тусгайлсан зохицуулалттай бодлогыг авч хэрэгжүүлэе ээ гэдэг ийм л саналтай байна аа. Баярлалаа та бүгдэд.

Д.Амарбаясгалан: УИХ-ын гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал. За хэдэн гишүүн. Одоо Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжэе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

65 гишүүн буюу 63.7 хувиар санал дэмжигдлээ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

19:25

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд орьё.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна аа. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Монгол УИХ-ын дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.3 дахь заалтад Аудитын дүгнэлт гарснаас хойш ажлын 7 өдрийн дотор нэгдсэн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитын дүгнэлтийн хамт УИХ-д өргөн мэдүүлэх, 8.10.4 дэх заалтад УИХ Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн Улсын төсвийн гүйцэтгэлийг батлах гэж заасны дагуу Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байна аа.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвийн 39 төсвийн ерөнхийлөн захирагч, 21 аймаг, сум, нийслэл, дүүргийн нийт 3718 төсөвт байгууллага болон Үндэсний баялгийн сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сангийн төсвийн гүйцэтгэлийг нэгтгэлээ. Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд 5559 төсөвт байгууллага, 349 төсөл сан, төрийн өмчийн 638 ААН-ийн тайланг хамрууллаа. Монгол Улсын гадаадын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 онд 27.4 тэрбум ам.доллар болж өмнөх оноос 12.1 хувиар өссөнөөр гадаад худалдааны тэнцэлд 4.2 тэрбум долларын ашигтай гарлаа.

Экспорт оны өмнө мөн үеэс 3.9 хувиар өсөж, 15.8 тэрбум төгрөг долларт хүрэхэд зэсийн баяжмал, алт, төмрийн хүдрийн экспортын өсөлт голлон нөлөөллөө. Төлбөрийн тэнцэл 622 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн жил 4.9 тэрбум доллар байсан гадаад валютын улсын нөөц 2024 оны эцэст 5.5 тэрбум долларт буюу түүхэн дээд хэмжээний хүрсэн байна аа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 оны 29 их наяд 670.8 тэрбум төгрөг. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30 их наяд 591.1 тэрбум төгрөг, Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 451 тэрбум төгрөгөөр сайжирч, 920.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж ажиллалаа. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 20 их наяд 533 тэрбум төгрөг, зарлага 21 их наяд 372.4 тэрбум төгрөг нийт тэнцэл 1 их наяд 220.8 тэрбум төгрөгөөр сайжирч, улсын төсөв 1 их наяд 283.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

2024 онд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдээс тоймловол эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд өмнөх онуудад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг хадгалж, макро тогтвортой орчныг дэмжсэн төсөв мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн улсын зээлжих зэрэглэлийг ахиулах зорилт тавьж ажилласны үр дүнд олон улсын зээлжих зэрэглэлийн Fitch Rating болон S&P Global Ratings агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “+B” Moody’s агентлаг, B2 тогтвортой болгон тус тус нэг шатлалаар нэмэгдүүлэн сайжрууллаа. Энэ нь Монгол Улсад гадаадын шууд хөрөнгө оруулалт татах олон улсын санхүүгийн зах зээлээс хүү багатай санхүүжилт босгох боломжийг нэмэгдүүлэх, улмаар төсөв, төлбөрийн тэнцэл, валютын ханшид эерэг нөлөө үзүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн өрийн зохицуулалтын арга хэмжээний хувьд жил ирэх тусам эрсдэлийн нэмэгдлийг бууруулж байна. Энэ нь ам.долларын эрсдэлгүй хөрөнгө оруулалтын өгөөжөөс давж буй хүүгийн хэмжээг харуулах бөгөөд Монгол Улсын Засгийн газрын хувьд 2021 онд гаргасан үнэт цаасны хувьд 3.6 хувьтай 2023 онд гаргасан үнэт цаасны хувьд 3.6-4.9 хувьтай, 2025 онд гаргасан үнэт цаасны хувьд 2.3 хувьтай тус тус тэнцэж байна аа. Энэ нь олон улсын зах зээлд тогтмол оролцож хөрөнгө оруулагчдын итгэх итгэлийг нэмэгдүүлж байсантай шууд холбоотой бөгөөд ингэснээр 2025 онд 8.5 хувьтай гарах боломжтой байсан үнэт цаасны хүүгийн түвшнийг 6.625 болгон бууруулсан ач холбогдолтой болно оо.

УИХ-аас 2024 онд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоо бий болсон. Хууль батлагдсантай холбогдуулан Үндэсний баялгийн төрөлжсөн сангийн дансыг Монгол банктai монгол байршуулж тайлан тоонд 1 их наяд 341.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 495.6 тэрбум төгрөгийг Монгол банктai гэрээ байгуулан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд оны эцсийн харилцах дансны үлдэгдэл 3 их наяд 979.4 тэрбум төгрөг боллоо.

Засгийн газрын 2024 оны 224 дүгээр тогтоолоор Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг баталж хуримтлалын сангаас нэрийн данс үүсгэн иргэн бүрд 138 мянга 993 төгрөгийг хуваарилсан болно оо.

Засгийн газрын хилийн боомтуудын нэвтрэх хүчин чадлыг сайжруулж, Замын-Үүд, Гашуун сухайт боомтын импортын тээврийн хэрэгслийн 9 гарцыг 23, экспортын 5 гарцыг 27, нүүрс тээврийн хэрэгсэл нэвтрүүлэн экспортын 6 гарцыг 10 болгон өргөтгөж, Шивээ хүрэн боомтын хилийн шалган нэвтрүүлэх 8 хаалгыг шинээр ашиглалтад оруулснаар экспортыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллалаа. За үүний үр дүнд 2024 онд нүүрсний экспорт 83.8 сая тоннд хүрч, өмнөх оноос 20 хувиар нэмэгдлээ. Оюу Толгойн далд уурхайн нөлөөгөөр зэсийн баяжмал экспорт 2024 онд сая 695 мянган тоннд хүрч өмнөх оноос 11 хувиар, олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 7 сая 511 мянган тоннд хүрч өмнөх оноос 31 хувиар тус тус өслөө.

Иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах төрийн албан хаагчдын цалинг нийгмийн даатгалын сангаас олгох, тэтгэвэр тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх хүрээнд төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар, нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр тэтгэмжийг 100 мянган төгрөгөөр, нийгмийн халамжийн сангаас олгож байгаа 4 төрлийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг 10 хувиар тус тус нэмэгдүүллээ.

Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргааны үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төвийн болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар бодож сар бүр олгохоор шийдвэрлэсний дагуу 101.4

мянган төрийн албан хаагчдад улсын төсвөөс 239.9 тэрбум төгрөгийн нэмэгдэл олгосон байна аа.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсантай холбоотойгоор тухайн бүс нутгийн онцлогт тулгуурласан хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр хангайн бүсийн 179 төсөл арга хэмжээг 292, 85 хувийн, баруун бүсийн 294 төсөл арга хэмжээг 448.4 тэрбум төгрөгөөр 70 хувийн, хойд бүсийн 160 төсөл арга хэмжээг 210 тэрбум төгрөгөөр 76 хувийн, төвийн бүсийн 153 төсөл арга хэмжээг 410 тэрбум төгрөгөөр 79 хувийн, зүүн бүсийн 117 төсөл арга хэмжээг 427.6 тэрбум төгрөгөөр 85 хувийн, говийн бүсийн 88 төсөл арга хэмжээг 371.4 тэрбум төгрөгөөр буюу 88 хувийн, Улаанбаатар хотод 380 төсөл арга хэмжээг 2 их наяд 412.4 тэрбум төгрөгөөр буюу 86 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 1320 төсөл арга хэмжээнээс шинээр хэрэгжүүлсэн 712 төсөл арга хэмжээнд 1 их наяд 687 тэрбум төгрөг, өмнөх онуудаас шилжиж шилжин хэрэгжиж буй 600 төсөл арга хэмжээнд 1 их наяд 406.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож гүйцэтгэл 80.3 хувийн биелэлттэй байна аа.

Монгол УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан танилцуулгатай танилцаж, Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. Магнайсүрэн даргыг индэрт урьж байна.

С.Магнайсүрэн: Монгол УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлт зөвлөмжийн талаар хураангуйлан танилцуулъя аа.

Нэг. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд төсвийн тухай хуулийн дагуу аудитыг гүйцэтгэж, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 29 их наяд 670.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 30 их наяд 591.1 тэрбум төгрөгөөр баталгаажууллаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 29 хувиар өссөн. Тайлан тоонд төлөвлөснөөс 534.5 тэрбум төгрөгөөр

тасарсан боловч Үндэсний баялгийн санд 1 их наяд 341.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30 их наяд 591.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 35.9 хувиар өссөн нь цалин хөлс 3 их наяд 41 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 2 их наяд 782.6 тэрбум төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1 их наяд 430.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 920.3 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ний 1.2 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаарт багтаж байна. Засгийн газрын өрийн нэрлэсэн үнээр илэрхийлсэн үлдэгдэл 33 их наяд 399.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 41.8 хувьтай тэнцэж байгаа нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан хязгаарт багтаж, Засгийн газрын өрийн нийт хэмжээнээс 14 их наяд 129.5 тэрбум төгрөгөөр бага байна. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 27 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тухайн онд шинээр хэрэгжих 712, он дамжин хэрэгжих 607, нийт 11 их наяд 579.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1319 төсөл арга хэмжээг тайлан тоонд 3 их наяд 828.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 62.7 хувийн санхүүжилтийг олгож, хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 579 төсөл арга хэмжээний хэрэгжилт 69 хувьтай буюу хангалтгүй байна аа.

2.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын талаар.

Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нийгмийн болон ЭМД-ын сан 61 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан тэдгээрийн харьяа байгууллагуудын нийт 6832 санхүүгийн тайланг аудитад хамрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 33, хязгаарлалттай 29, сөрөг 1 дүгнэлт өгсөн бөгөөд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 9 их наяд 292.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн тул хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Аудитаар УИХ-д 5 асуудлыг толилуулж, Монгол Улсын Ерөнхий сайдад 20, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдад 5, Сангийн сайдад 18, Аж, үйлдвэр эрдэс баялгийн сайдад 1, ХЗДХ-ийн сайдад 1, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны даргад 2, Эрүүл мэндийн сайд бөгөөд ЭМД-ын Үндэсний зөвлөлийн даргад 1, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт 4 зөвлөмжийг тус тус хүргүүлээд байна.

Төрийн аудитын байгууллагаас өмнөх жилүүдэд Засгийн газар бүх шатны төсвийн захирагч нарт өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдан гарч байгаа тул УИХ-аас аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дараах асуудлаар Засгийн газарт чиглэл өгч хүргүүлж, төсвийн сахилга батыг дээшлүүлэх шаардлагатай байна. Үүнд нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байгаа боловч тухайн жилийн Төсвийн тухай хуулийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилснөөс дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үр нөлөөг бууруулж, төсвийн тогтвортой байдлын

зарчмыг алдагдуулж байгааг анхаарч, цаашид нэгэнт тогтсон бодлогоо баримталж хэрэгжилтийг хангуулах.

2 дугаарт уул уурхайн салбараас хэт хамааралтай төсвийн орлогын бүтцэд оновчтой зохион байгуулалт хийж, төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх.

3-т нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулахгүй байх хуулийн шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангах.

4-т нь дампуурсан банк, ХЗХ-дын хохирогчдоос үүссэн авлага барагдуулах ажил зогсонги байдалтай байгаад дүгнэлт хийж, асуудлыг шийдвэрлэх гарц шийдлийг гаргаж шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авах.

5-д нь гадаадын дамжуулан зээлээс олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй, тооцоо нийлж баталгаажаагүй авлагын асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу үе шаттай шийдвэрлэх.

6-д нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтийн зорилтот түвшнийг хангахуйц төсөв батлагдсан боловч зарим хөтөлбөр арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй, хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж үнэлдэггүй байдлыг халж батлагдсан төсвийг үр ашигтай хэрэгжүүлэх.

7-д нь дотоод аудитын эрх зүйн орчин бүрдээгүй, тогтолцоо төлөвшөөгүй, хараат бус байдал хангагдаагүйгээс зөвхөн санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, засаглалыг сайжруулах, эрсдэлийг удирдах үндсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарч, энэ чиглэлд бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

8-д нь аудитын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь зөвхөн аудитын зорилт биш, төрийн өмч, санхүү, төсвийн удирдлагыг сайжруулах үндэслэл болох юм. Иймд зөвлөмжийн хэрэгжилтийг хангах асуудлыг хууль, бодлогын түвшинд дэмжиж, хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох тогтолцоонд дүн шинжилгээ хийх, төрийн өмч, төсвийн хөрөнгийг үр ашигтай хариуцлагатай удирдах менежментийг төлөвшүүлэх шаардлагатай байна.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын талаар товч танилцууллаа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: За ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Лхагвын Мөнхбаатар ХЗДХ-ийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Батын Батбаатар Байгаль орчин уур амьсгалын

өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам тээврийн сайд, Чинбатын Ундрам Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын сайд, Энхтайваны Бат-Амгалан Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр ХХААХҮ-ийн сайд, Энхбаярын Батшугар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Жигжидсүрэнгийн Чинбүрэн Эрүүл мэндийн сайд.

Сайд нар гишүүдийн асуултад асуухад бэлдэж чуулгандаа орж ирээрэй. Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг ШЕЗ-ийн дарга, Доржгочоогийн Ариунтуяа Шүүхийн сахилгын хорооны дарга, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Барсүрэнгийн Баасандорж Монгол УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Түндэвийн Жамбаажамц СЗХ-ны дарга, Батмөнхийн Батаа ҮСХ-ны дарга, Дугарын Сүнжид Монгол Улсын ХЭҮК-ын дарга, Данхүүгийн Баянбилэг Монгол Улсын ҮХЦ-ийн Тамгын газрын дарга, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ядамын Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал тэргүүлэх аудитор, Сүрэнжавын Гансэлэм УЕП-ын Хэрэг эрхлэх газрын дарга, Батцэнгэлийн Энх-Амгалан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, Идэшийн Батхүү Эдийн засаг хөгжлийн яамны ТНБД, Лхагважавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны ТНБД, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Сэрээтэрийн Жавхланбаатар Аж, үйлдвэр эрдэс баялгийн яамны ТНБД, Дагвадоржийн Ганхуяг БХЯ-ны ТНБД, Цэцэгмаагийн Уртнасан Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ханджавын Батжаргал Боловсролын яамны ТНБД, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны ТНБД, Сандагдоржийн Батболд Зам тээврийн яамны ТНБД, Санжаадоржийн Оюунбилэг Соёл спорт, аялал жуулчлал залуучуудын яамны ТНБД, Төмөрхуягийн Жамбалцэрэн ХХААХҮЯ-ны ТНБД, Пушагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дагвадоржийн Очирбат ЭМЯ-ны ТНБД, Рэгжийбуугийн Отгонжаргал ГЕГ-ын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Бэлтрэгийн Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Огнонгийн Хуягцогт ЭХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Билэгжамцын Энхтайван ГЕГ-ын дарга, Хамжаагийн Энхболд Татварын ерөнхий газрын дэд дарга, Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ СЕХ-ны Тамгын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Шаравын Бат-Эрдэнэ Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Нямдаваагийн Саруул Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцооны хэлтсийн дарга Лхагвадоржийн Эрдэнэбадрах НЗДТГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга гэсэн ийм том бүрэлдэхүүнтэйгээр өнөөдөр 2024

оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлахыг хэлэлцэж байна аа.

За ингээд хэлэлцэх асуудалтай холбоотойгоор илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан түүнд одоо Засгийн газрын гишүүдээс төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Монгол Улсын ерөнхий аудиторроос асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрээ өгнө үү. Тийм нээлттэйгээр шууд нэр.

УИХ-ын гишүүн Буланы Бейсенээр тасалъя. УИХ-ын гишүүн Батбаярын Жаргалан.

Б.Жаргалан: 2024 оны макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг харвал эдийн засгийн өсөлт 4.9 хувьтай гарсан хэдий ч энд анхаарал татаж байгаа хамгийн том зүйл бол ХАА-н салбар 28.7 хувиар агшсан явдал байлаа. Тэгээд одоо шинэ Засгийн газрын хувьд энэ ХАА-н салбарыг хэрхэн яаж дэмжих вэ гэдэг дээр бас тодорхой саналуудыг нь сонсмоор байна. Өнгөрсөн одоо 2024 оны төсөв дээр тавигдсан ХАА-н салбартай холбоотой хөтөлбөрүүдийн хэрэгжилт, эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллүүд ямар байгааг Энхбаяр сайдаас бас асууя.

Мөн татварын зарлага гээд бас нэг зүйл анги байгаа. За үүнд болохлоор татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн асуудал хөндөгдөж байгаа. Тэгээд 2024 оны улсын нэгдсэн төсвийн хувьд 1.4 их наядын татварын хөнгөлөлт чөлөөлөлт олгосон байна. Үүнээс бол ААНОАТ-ын тухайд 946 тэрбум төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлтийг 9530 аж ахуйн нэгжид олгосон гэжээ. Энэ яг ямар зүйл заалтын дагуу ямар ААН-үүдэд хөнгөлөлт чөлөөлөлт олгосон талаар Жавхлан сайдаас бас асууя.

Өнгөрсөн намрын чуулганаар батлагдсан нөгөө нийгмийн хариуцлагын хүрээнд гэж байгаа зүйл дээр хөнгөлөлт чөлөөлөлт олгосон зүйлүүд байгаа юу? За тэдгээрээс одоо хамгийн өндөр дүнтэй хөнгөлөлт чөлөөлөлт нь яг нэр бүхий ямар ААН-үүд дээр олгосон байгаа вэ гэдгийг бас нэг тодорхой хэлж өгнө үү. Одоо нэг эхний нэг 3 аж ахуйн нэгжийг ч гэдэг юм уу. Дээрээс нь өнгөрсөн 2024 оны улсын төсвийг 8 сард тодотгосон. Энэ улсын төсвийн тодотголоор болохлоор Засгийн газрын ордон барьж байгуулах 700 тэрбум төгрөг гэлүү дээ одоо буруу санаагүй бол. Ийм зүйлийг бол төсвийн тодотголоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сайдад тухайн үед Учрал сайд ажиллаж байсан тэгээд төсвийн тодотголоор болохлоор бас нэлээн өндөр дүнтэй зүйлийг бол 2024 оны төсөвт бол суулгасан байгаа. Энэ ЗГ-ын ордонтой холбоотой асуудал бол ямар түвшинд, яаж явагдаж байгаа вэ гэдгийг одоо Учрал сайдаас бас асуумаар байна.

Тэгээд төгсгөлд нь хэлэхэд өнгөрсөн хугацаанд намрын чуулганаар одоо ээлжит бус чуулганаар хэлсэн төсвийн тодотголын хүрээнд бол бид нар энэ 2024 онд уул уурхайн бараа бүтээгдэхүүний үнийн дүнг маш өндрөөр тавьсан байна аа. Үүн дээр бол одоо гүйцэтгэл гарахгүй байх даа гэж хэлж байсан бол бас ёсоор боллоо тиймээ. Тэгээд одоо энэ Засгийн газар шинээр төсвийн тодотгол оруулж ирэх юм бол одоо энэ ээ дээ энэ тэр уул уурхайн бүтээгдэхүүний үнүүдийнхээ тооцоо энэ тэрийг бас давхар нэг хянаад ороод ирээрэй гэж бас хүсэх байна аа. Баярлалаа.

Х.Булгантуяа: ХХААХҮ-ийн сайд Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Гишүүн ээ уучлаарай энд Узбекистаны дээд хэмжээний айлчлалын төлөөлөгчид ирчхээд бид нар уулзалт хийгээд байна. Таны асуултыг би сайн бүтэн сонсож чадсангүй. Гэхдээ сонссон хэмжээндээ хариулаадахъя. Залруулахыг бодоорой. Тийм. ХАА-н салбарын өсөлт өнгөрсөн 2024 онд уналттай гарсан. 20 гаруй хувийн уналт. Энэ маань юутай холбоотой вэ гэвэл 2023, 2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч 9.2 сая толгой мал хорогдсон нь ХАА-н үйлдвэрлэлийг бууралттай гарахад гол нөлөөлсөн. Энэ жилийн байдлаар бол 20 сая төл авчхаад байна. Авсан төл 99.8 хувь бойжиж байна. Тэгэхээр МАА-н салбарт гарсан уналт энэ ондоо нөхөгдөөд их өсөлт их сайтай гарахаар ийм байна.

УИХ-ын баталсан голлох хөтөлбөрүүд манай үндсэн гол 4 гол хөтөлбөр байгаа. Цагаан алт хөтөлбөр. 1 дүгээрт Цагаан алт хөтөлбөр маань арьс шир, ноос ноолуурынхаа боловсруулалтын түвшнийг 2 дахин нэмэгдүүлэх томоохон зорилт тавьсан. Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд хүнсний үйлдвэрлэлээ чадавхжуулах, өргөтгөх гэсэн чиглэлийн ажлууд явж байгаа. Атрын 4 дүгээр аяны хүрээнд газар тариалангийн салбарыг МАА-н салбартай төгс хослох эрчимжсэн аж ахуйнуудыг олон арваар бий болгох, ингээд зорилт болсон 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо бүрэн үйлдвэрлэх зорилтын хүрээнд энэ хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа.

Хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна. Яг та аж ахуйн нэрийн ААН-үүдийг нэрлэ гэсэн үү? Жишээлбэл одоо ноолуур, ноос, арьс шир гээд цагаан алт хөтөлбөрийн тухайд. Монгол улсад өөрөө 27 арьс ширний үйлдвэр байгаа. 26 нь төвийн бүсэд үйл ажиллагаа явуулж байна. Нэг үйлдвэр Өвөрхангай аймагт явуулж байгаа. Энэ үйлдвэрүүд эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлүүдээ авсан. Ноолуурын ноосны боловсруулах 270 үйлдвэр, цех байгаа. 260 нь төвийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа. Ямар нэгэн шинэ үйлдвэр, ААН-д энэ зээл очоогүй. Уламжлалт үйлдвэрлэл явуулж байгаа өөрийн боловсон хүчин технологитой үйлдвэр явуулж байгаа ААН-үүдэд үйлдвэрлэлээ өргөтгөх шаардлагатай хөрөнгө оруулалтын болон эргэлтийн зээлүүд олгогдсон. Ингээд үйлдвэрлэх хүчин чадлаараа зээлүүдээ авсан, зээлүүд арилжааны 10 банкаар дамжаад арилжааны банкнууд эрсдэлийг нь тооцоод, зээл олголт хэвийн үргэлжилж байгаа. Энэ жилийн нэг том онцлог бол бид нар Монгол Улс ноолуураа сүүлийн 30 жилд анх удаа үндэсний үйлдвэрүүд нь дотооддоо 100 хувь авч боловсруулалтын түвшнээ нэг шат ахиулах буюу бүх ноолуурыг самнадаг болсон. Угаагаад түүхий ноолуур гаргадаг байсан бол одоо самнадаг болсон. Энэ үйл явдлын одоо үр дүнд 700 тэрбум төгрөгийн нэмүү өртөг дотоодын үйлдвэрт цалин, татвар, орлого болж Монгол Улсад нэмүү өртөг болж үлдэж байгаа.

Цаашид бид нар самнасан ноолуураа ээрэх буюу утас хийх утас боловсруулах түвшингээ, чадавхаа сайжруулах чиглэлээр дараа дараа жилд онцгойлон анхаарч явна аа. Ноосон дээр гэхэд одоо хивсний 2 үйлдвэр маань тоног төхөөрөмжүүдээ нэлээн сайн шинэчилж, тоног төхөөрөмж суурилуулах ажлууд явагдаж байгаа. Арьс ширэн дээр Дархан нэхий булигаар үйлдвэрүүд бол хэд хэдэн шинэ технологийн шинэ бүтээгдэхүүний одоо шугамууд хаягдлыг багасгах чиглэлийн шугамуудыг өргөтгөсөн. Ер нь их үр дүн их сайтай. Хүнсний хувьсгалын тухайд гэхэд 51 хүнсний үйлдвэр шинээр ашиглалтад орж, 400 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн сав баглаа боодлоо сольж, бүтээгдэхүүний нэрэлт тоо төрөл нэмэгдсэн байх жишээтэй.

Атрын 4 дүгээр аяны хүрээнд бол энэ эрчимжсэн энэ гахай, тахиа, шувуу, сүүний аж ахуйнууд, тэжээлийн шинэ таримлын одоо аж ахуйнууд, эрчимжсэн МАА өсвөр мал бордох аж ахуйнууд, 4 улирлын хүлэмжийн аж...

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Жаргалан гишүүний асуултад хариулъя аа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт энэ 14 мега төсөл мөн нийслэл дээр хэрэгжих төслүүдийг тусгасан байсан. Ингээд Эдийн засгийн хөгжлийн яамнаас бол энэ мега төслүүд дээр 14 шалгуур үзүүлэлтээр 4 бүлэгт хуваарилаад эрэмбэлж байгаа төслүүдийг. Макро эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, санхүүжилтийн эх үүсвэрийн нөлөөллийн үнэлгээ төслийн бэлэн байдлын үнэлгээ, нийгмийн нөлөөллийн үнэлгээ гээд. Ингээд зарим төслүүдийг болбол одоо энэ уул уурхайн бүтээгдэхүүний үнээс хамааруулаад болбол бид нар зайлшгүй хойшлуулах шаардлага бол үүснэ. Үүнтэй холбогдуулаад нийслэл дээр хэрэгжүүлэх гэж байсан тэр туннелтэй холбоотой төсөл, мөн тэр туннелээс мэдээж одоо холбоотойгоор Засгийн газрын шинэ ордонг барьж байгуулах энэ төслийн санхүүжилтийг болбол одоо бүрэн зогсоохоор одоо бол бид ажиллаж байгаа. Тэгээд төсвийн тодотголын үеэр бас оруулж ирнэ ээ.

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүн Болдын Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Одоогоор ААН-ийн орлого албан татварын тухай хуулиар 29 төрлийн хөнгөлөлт, 16 төрлийн чөлөөлөлт хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Энэ хүрээнд өнгөрсөн жилийн 2024 онд гүйцэтгэлүүд гараад олгогдсон байдаг. Өөрөөр хэлбэл 2024 онд олгогдож байгаа энэ хөнгөлөлт чөлөөлөлтүүд маань 2023 оны тайлангаараа гэсэн үг.

Саяын таны асуусан тэр нийгмийн хариуцлагын хүрээнд нэг хувийн татварын борлуулалтын орлогын нэг хувь хүртэлх татварын хөнгөлөлт болбол 2024 оны тайлан гэдэг маань 2025 онд одоо буцаан олгогдоно оо гэсэн үг юм байгаа юм. Тэгэхээр 2024 оны гүйцэтгэл дээр бол байхгүй. Саяын тэр Засгийн газрын шинэ байрны хувьд болбол 5 сарын 31-нээр хэмнэлтэд орсон байгаа. Хэмнэлтийн тухай Төрийн хэмнэлтийн тухай хуулиар. Өөрөөр хэлбэл зураг төсөв нь бэлэн болж амжаагүй учраас одоо барилгын бүтэн худалдан авах ажиллагааны гэрээ бол хийгдээгүй ээ гэсэн үг. Тэр манай Татварын ерөнхий газраас улсууд тэр ААН-үүдийн асуугаад байна.

Х.Булгантуяа: Татварын ерөнхий газраас 4 номерын микрофон дээрээс хариулъя.

Р.Мягмаржав: Жаргалан гишүүний асуултад тодруулъя, хариулт өгье. ААНОАТ-ын тухай хуулийн дагуу жилийн эцсийн тайлангаар үүссэн ноогдлуудын талаарх хөнгөлөлт чөлөөлөлтийн талаарх мэдээллийг өгье. Нийтдээ 9532 татвар төлөгчийн 946 тэрбум төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлүүлсэн. Энэний үүнийх нь хамгийн дийлэнхийг нь буюу 4882 татвар төлөгч 88.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн. Энэ хөнгөлөлтийнхөө дүн нь болбол 300 саяас 1.5 тэрбум хүртэлх борлуулалтын орлоготой компаниудын төлсөн татварынх нь 90 хувийг нь бол хөнгөлж байгаа дүн байгаад байгаа. Дийлэнх нь нэлээдгүй хувийг нь эзэлж байгаа нь.

2 дугаарт нь Улаанбаатар хотоос тухайн үйл ажиллагаа явуулж байгаа байршлаасаа хамаараад алслагдсан буюу 500-т, түүнээс дээш мянгаас дээш километр зайд үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад 50, 90 хувийн хөнгөлөлт байгаад байгаа. Энэ хөнгөлөлтийг нийтдээ нэг 369 татвар төлөгчийн төлөгч 34.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг ингээд эдэлсэн байна аа. Яг гол хөнгөлөлтүүд нь.

Чөлөөлөлтүүдийн хувьд...

Х.Булгантуяа: 4 номерын микрофон нэмж өгье.

Р.Мягмаржав: Сая тодруулсан спортын хөнгөлөлт чөлөөлөлт болбол өөрөө 2024 оны 8 сарын 30-ны өдөр ААН-ийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, нийгмийн хариуцлагын хүрээнд хөрөнгө оруулалт, хандив тусламж үзүүлсэн юм бол 1 хувийн хөнгөлөлтийг бол эдлүүлж байгаа. Энэ маань өөрөө жилийн эцсийн тайлан буюу 2024 оны жилийн эцсийн тайлан нь 2025 оны 2 сарын 10-нд ирсэн буюу энэ ондоо болбол тайлангаараа бол хөнгөлөлт чөлөөлөлт нь эдлэгдээд явахаар байгаад байгаа юм. Тэгэхлээр 2024 оны гүйцэтгэлээр бол байхгүй ээ гэсэн үг.

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Төсвийн үр ашгийг дүгнэдэг үзүүлэлтүүдээс нэг хэд хэдэн зүйлийг бас асууя. Ер нь энэ төсвийн хөрөнгө оруулалт тендерээс дагаад одоо хэчнээн ер нь ажлын, байнгын ажлын байр болон түр ажлын байрууд ер нь бий болсон бэ? Энэний баримжаа тоо гэж гаргаж дүгнэж үзэж байна уу нэг.

2 дугаарт энэ хэмнэлтийн хууль гээд одоо төсвийн байгууллагуудаар харж байхад тэртээ тэргүй зайлшгүй нэг байгууллагад гарах ёстой энэ зардлуудыг өөр байдлаар гаргадаг нэг ийм хэвшил бий болчихсон байгаад байгаа юм. Тэгэхээр энэ нь өөрөө эргээд улс орон даяараа нөгөө аудитын дүгнэлтээр одоо буруу зөрүү өөрсдөө хэт одоо нөгөө хуурай хууль гаргаснаас болоод ийм асуудал гараад байдаг. Тэгээд энийгээ одоо манай ихэнх төсөв захирагч нар сууж байгаа байх. Байгууллага дээр байдаг нэг ийм арга хэмжээнүүдийг гаргаж болохгүй гэхихсэн нийтэд нь. Энэ тал дээр одоо ямар нэгэн зөрчил байна уу? Аудитын газраас асуумаар байна.

Төрийн албан хаагчдын одоо сая нэг 14 мянган хүн цомхотгоно оо гээд одоо сая ярьсан. Тэгээд 6 мянга, 7 мянга орчим нь одоо яг сул орон тоо байгаад байна гэж байна. Тэгээд энэ 7 мянга орчим одоо сул орон тоогоос өнгөрсөн онд гэхэд хэчнээн нь ер нь зайлшгүй авах шаардлагатай орон тоонууд байгаа вэ гэдгийг би асуумаар байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас хэчнээн төгрөг гарсан бэ? Өнгөрсөн оны 2024 оноос хойш одоо янз янзын наашаа цаашаа хөдөлсөн хүмүүс зөндөө байгаа байх. Энд одоо хэчнээн төгрөг гарсан бэ гэдгийг бас асуумаар байна.

ЭМД-ын сан одоо хүрэлцэхгүй, эмнэлгүүдийн санхүүжилт хүрэхгүй байгаад байдаг. Цаашдаа одоо энэ ЭМД-ын санг оны эцэс гэхэд бодитоор өглөг мөн одоо ер нь бол цаашдаа прогнозоор ЭМД-ын сангийн хэрэгцээ шаардлагууд улам цаашаа өснө. Энийг одоо ямар эх үүсвэрээр цаашдаа ер нь хийх бодол байна вэ гэдгийг асуумаар байна аа.

Ипотекийн зээлд хэчнээн хүн хамрагдав, хэчнээн хүмүүс шинээр хамрагдав дээрээс нь метр квадратаар нь авч үзвэл нэг хэчнээн хүн байна вэ гэдэг ийм тоо баримжаа тоо байна уу? Энэ юуны дүгнэлтэд гарсан байна. Манай Засгийн газрын байгууллагуудын банкн дахь хадгаламжийн мөнгөн үлдэгдэл 2 их наяд болж 9, 10 орчим хувиар өссөн байна. Тэгээд энийг ер нь банкнуудад хэдэн хувийн хүүгээр байршуулдаг юм? Харилцах дансны үлдэгдэл гэж явж байна уу? Яг хугацаагүй хадгаламж гэж явж байна уу? Энд одоо баримжаа тоо байна уу? Ийм асуултуудыг асуугаадахъя.

Х.Булгантуяа: Эхлээд Эрүүл мэндийн сайд Чинбүрэн сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя аа. Ер нь ЭМД-ын гүйцэтгэл үр дүнд тулгуурласан энэ гүйцэтгэлийн тогтолцоо бол өөрөө халдварт өвчинд санхүүжилт өгсөөр байгаад ковидын дараагаас нэлээн их одоо санхүүгийн хямралд орсон. Үүнийгээ гүйцэж чадахгүй, тэгээд гүйцэтгэл нь өөрөө нөхөж чадахгүй байсаар байгаад ер нь нэг 320-360-аад тэрбумын ерөнхий цох дуталт үүсээд үүнийгээ одоо 2024 оны гүйцэтгэл нь дутуу байхад 2025 онд гүйцэтгэлээ төсөвлөхдөө бас л яг тэр дутуугаараа л төсөвлөж байгаа явдал нь энэ нөгөө гүйцэтгэлээ гүйцэхгүй байгаа нэг том доголдол байгаад байгаа. Мэдээж одоо бас энэ банкнууд нь тавиад алдчихсан авлага нь бол ер нь нэг 80-аад тэрийг сайн ухах юм бол одоо 89 гаруй тэрбум төгрөгийн авлагатай байгаа. Чингис хаан банк, Капитал банк гэх мэтчилэнгээр. Энэ бүгдийг бас авахад энэ дутагдлаа бас нөхөх боломж бас байна.

Мөн НДШ-тэй холбоотойгоор, НДШ-ээс бас одоо тохиролцсон дүнгээрээ нэг 80 гаруй тэрбум төгрөг. Ингээд нэгэнт одоо хүрэхгүй байгаа бол бид одоо үнэнээ хэлэх хэрэгтэй гэж би бодож байна аа.

Одоо 2024 оны гүйцэтгэл дээр бол их дутсаан их дутсан. Тэгээд өрөө 2025 он руу шилжүүлээд, 2025 онд дамнуулсан ийм өр үүссэн. Түүнийгээ одоо 2025 оны гүйцэтгэлээсээ төлсөн явдлууд бол энд нэлээн тийм ноцтой асуудлууд харагдаж байна аа. Тэгээд одоо энийг цаашдаа сайжруулахын тулд одоо энэ Засгийн газрын дөнгөж сая Засгийн газрын бүтцийн тухай хууль хэлэлцэхээр бид одоо энэ төслийг боллоо. Тэгээд энэнтэй холбоотой ер нь ЭМД сан өөрөө корпоратив байдлаараа биеэ даасан үйл ажиллагаа явуулдаг. ЭМЯ-ны харьяанд бус байх ийм саналыг би бас одоо Засгийн газарт оруулахаар бэлдэж байна аа.

Ер нь цаашдаа эрүүл тогтолцоо л бүрдүүлэхгүй бол энэ санхүүгийн гачигдал дутагдал. Тэгээд буцаад энэ нь эрүүл мэндийн тусламж үзүүлж байгаа байгууллагуудын үр болоод, тэр нь цаашаа нөгөө эм ханган нийлүүлдэг байгууллагуудын авлага болоод ингээд гурвалжин дөрвөлжин ерөөсөө байдал үүсээд сүүлдээ хамгийн төгсгөл дээр нь өвчтөн эмнэлэг 2 хоорондоо бие биеэсээ мөнгө нэхэх мөнгөгүй бол хэвтэж чадахгүй болох гээд бид нарын одоо маш том зорилт тавьсан том дэвшлээсээ ухрах ийм байдал үүсэхэд нөлөөлөөд байгаа юмаа.

Х.Булгантуяа: За ипотекийн орон сууцтай холбоотойгоор БХБ-ын сайд, БХБЯ-ны ТНБД микрофон дээрээс хариулъя. БХБ-ын сайд хаачив? Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын сайд, ТНБД. Эдний яамнаас тэгээд хүн байхгүй юм уу? Мөнгө үрээгүй юм уу? 2024 онд БХБЯ. За Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ноднингийн төсөв дээрээс Гэр бүл, нийгэм хамгааллын яаман дээрээ энэ айл өрх энэ ипотекой холбоотой бодлого шилжиж очсон байгаа. Би статистик хэлчихье ээ. Бид нарт өөрсдийнхөө статистик. 2024 онд нийтдээ 12150 өрхөд 6 хувийн бодлогын зорилтот ипотекийн зээл банкнуудаар дамжиж очсон байна аа 12150 өрх. Төрийн сангийн гарсан дээр юунуудыг хариулчих даа. Хадгаламж банкнууд дээр байгаа хадгаламжийн хүү. Ер нь банкнууд сүүлийн 5 жил банкнууд дээр шинэ хадгаламж нэг ч тохиолдолд нээгээгүй байгаа. Энэ зүгээр гүйлгээний төрийн сангаас гарч явсан төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагч нар дээрээ очоод зарлагадаж байгаа ийм хөрөнгийн үлдэгдлүүд байх шиг байна. Төрийн сангаас хариулаадхаарай.

Х.Булгантуяа: 3 номерын микрофон дээрээс хариулъя.

Б.Цогбадрах: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя аа. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах. 2024 оны жилийн эцсийн байдлаар дотоодын 16 банканд бол банк санхүүгийн байгууллагад 14.2 их наяд төгрөгийн хөрөнгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна. Тэгээд банкнуудаар бол задгай мэдээллүүд нь байгаа. ТӨК-иуд болон төслүүдийн дансны үлдэгдэл. Тэрнээс биш төсвийн байгууллагуудын харилцах данснууд бол төрийн сангаар дамжин гүйлгээ хийгддэг байгаа. Арилжааны банканд бол данс байхгүй ээ.

Х.Булгантуяа: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Тийм сая эхний асуулт яах вэ ерөнхий том дүр зургаар нь харахад энэ бид нар жилдээ олсон мөнгөө төсөв болгон зарцуулаад ямар үр дүнд хүрээд байгаа юм бэ гэдэг хэдэн юм чухал байна шүү дээ. Хэчнээн ажлын байр бий болсон юм, эдийн засгийн ямар одоо салбаруудаа дэмжсэн юм гэдэг гэх мэтчилэн. Тэгээд энэ тал дээр бол яах вэ? Би анх энэ төсвийн тодотгол хийж байхад л асууж байсан. Тэгээд ер нь бол бид нар цаашдаа ийм дүгнэлт хийж байж. Төсвийн үр дүнгийн үзүүлэлт гэдэг ийм нэг зүйлийг одоо хэдэн тоо маш тодорхой хэдэн үр дүнгийн тоонуудыг л одоо авмаар байгаа юм.

Саяын энэ банкнуудын юун дээр хэлэхэд энэ Тогтвортой байдлын зөвлөлийн хийсэн эс дээр тавьсан дүгнэлт байна л даа. Засгийн газрын байгууллагуудын нийтдээ дансанд 2 их наядын хадгаламж байна гэж байна шүү дээ. Бид нар чинь одоо ахмадуудынхаа зээлийг одоо бараг одоо 50 хувиар нь бууруулаад хаяад байдаг. Гэтэл Засгийн газрын байгууллагуудынх нь хадгаламжид нь 2 их наяд төгрөг байгаад байдаг. Энийг хүүтэй өгдөг юм уу, хүүгүй өгдөг юм уу?

Х.Булгантуяа: Төрийн сан нэг сайн тодорхой хариулаадах даа. Хадгаламж биш байх аа харилцах данс дээр байгаа юм шиг байна гээд гэж та хэд хэлээд байх шиг байх юм. Яг ТӨК дээр нь хэд байгаа юм гээд. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс эс үгүй бол хариулах уу? Тайлан дээр нь дурдсан байгаа юм чинь. Аудит, аудитын тайлан дээрээс. 3 номерын ажлын хэсгийн микрофон. Микрофон нь асчихсан байна.

Б.Цогбадрах: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя аа. Ерөнхийдөө энэ бол дандаа харилцах дансны үлдэгдлүүд байгаа. Нийтдээ Засгийн газрын нэгдсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бол 2.5 их наяд төгрөгөөр өсөхөд бол төрийн

сангийн үлдэгдэл 947.3 тэрбум төгрөгөөр өссөн. Төсөл одоо сангуудын үлдэгдэл бол 2.7 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдсэн. Төрийн болон орон нутгийн өмчит оролцоотой хуулийн этгээдийн дансны үлдэгдэл бол 1.2 их наяд төгрөгөөр, төсөвт байгууллагынх бол 5.8 тэрбум төгрөгөөр буурсан. Ийм мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа. Хүү төлөхгүй зүгээр нийгмийн даатгалын сангийн үлдэгдэл дээр бол нийгмийн даатгал болон ЭМД-ын сангийн үлдэгдлүүд бол арилжааны банканд бол байгаа.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм төрийн сангийнх нь олигтой хариул л даа. Тэр чинь төсвийн шууд захирагч болон төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарлагын данс нь байхгүй юу. Одоо банкнууд дээр байршчихсан байгаа түр данснууд өөрөөр хэлбэл нэг сар, 2 сарын хугацаанд ингээд шууд зарлагдаад дуусдаг. Ингээд дараагийн санхүүжилтүүд нь орж ирээд ингээд одоо цалин хөлс бусад одоо үйл ажиллагааны тогтмол санхүүжилтүүдээ хий. Тэндээсээ хийгээд явдаг ийм данснууд аа гэсэн үг. Төслүүд болон аж ахуйн төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн ийм данснууд гэсэн үг. Тэрнээс биш яг Төрийн сангийн нэгдсэн данс болбол яг одоо Төв банк ингээд Сангийн яам 2-ын хооронд данс тооцоогоо нийлээд явж байдаг ийм зүйлүүд. Урт хугацааны тийм одоо хадгаламж юм уу, хүү тооцуулах эх үүсвэр болбол ЭМД-ын сан болон нийгмийн даатгалын сан дээр л байдаг. Холбогдох сайд нар нь энэ талаар мэдээлэл өгвөл сайн байна.

Х.Булгантуяа: Эрдэнэбат гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэбат: Энэ дүгнэлтийн хэсэгт тодорхой тавьчихсан байна л даа 8, 9 дээр. Арилжааны банканд хадгаламж хэлбэртэй байршиж байгаа энэхүү 2 их наяд төгрөг бий болсон үндэс шалтгааныг тодруулах шаардлагатай бөгөөд гээд. Тэгээд би энийг л асуугаад байгаа юм. Энэ чинь бүр арилжааны банканд дахь хадгаламж хэлбэрээр 2 их наяд төгрөг байгаад байгаа юм байна шүү дээ. 2024 оны жилийн эцэст 2 их наяд тэрбум төгрөг болж өмнөх оноос 1.8 одоо их наяд төгрөг буюу 9.7 дахин өссөн байна аа гээд. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланд өгсөн дүгнэлтийн 8, 9 хоёр дээр байгаа зүйлийг тодорхой асуугаад байна л даа. Тэгэхээр эсвэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн өөрсдөө тайлбарлах юм уу.

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс танилцуулах уу. Энэ бүр төрийн сангаас хэд хэдэн удаа асуулаа. Нэг л юу яаж чадахгүй байх шиг байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланд байгаа юм чинь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 3 номерын микрофон дээрээс хариулъя.

А.Энхбат: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. Бид нар Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан аудитлагдсан тайланг бол үзээд Засгийн газрын байгууллагуудын банкны хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2024 оны эцэст 2 их наяд төгрөг болсон. Өмнөх оноос бол 1.8 тэрбум төгрөгөөр буюу 9.7 дахин өссөн байна гэж дүгнэлтэд тус гарч ирсэн байгаа. Энэ дүн нь бол улсын төсвийн 2024 оны зарлагын гүйцэтгэлтэй бол харьцуулаад үзэхэд бол 6.5 хувьтай тэнцэж байна аа гэсэн ийм дүгнэлт хийсэн байгаа.

Х.Булгантуяа: Далайн Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Ажлын хэсгийнхний энэ үдшийн мэндийг хүргэе ээ. Тэгэхээр өнгөрсөн 7 хоногт яг энэ 2024 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж эхлэхтэй холбоотойгоор Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хуралдсан. Энэ төсөв гэдэг маань өөрөө өргөн сэдэв учраас яг өнгөрсөн төсвийг баталж байх үед хамгийн их шуугианыг дагуулж байсан. Яг энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ гэдэг дээр төсвийн ерөнхийлөн захирагчдыг бүгдэнгий нь дуудаж мэдээлэл авсан байгаа. Тэгээд яг энэ Боловсролын яамтай холбоотой асуудлыг би энэ удаад онцолж асууя гэж бодож байгаа. Яагаад гэхээр маш их хэмжээний тоо байгаад байгаа учраас цаг хангалтгүй байгаад байгаа учраас. Яг одоо яг энэ мөчид яг энэ ЭЕШ-тай холбоотой мөн энэ салбарын чанартай холбоотой, үйл ажиллагаатай холбоотой маш их хэмжээний гомдол саналууд ирж байгаа. Хувь гишүүн дээр. Гэтэл яг энэ өнгөрсөн 2024 онд яг энэ боловсролын салбар маань яг энэ төсвийн хамгийн их нэмэгдлийг боловсролын салбар дээр ирсэн. За яг энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ гэдэгт ордог зардлыг би эхлээд танд хэлээд өгчихье.

Засгийн газрын ашигласан үйлчилгээ, багаж тоног төхөөрөмж, томилолтоор явах шаардлагатай үеийн хоол, ажлын нөхцөл байдлын хэрэгсэл, үндэсний мөнгөн тэмдэгтийн үйлдвэрлэл, гишүүнчлэлийн татвар, захиалгын төлбөр, ажлын байрны дэмжлэг, хангамж, үйлчилгээ, нэг удаа ашиглах зэвсэг, худалдан авч дахин борлуулахаар байлгаж байгаа барааны өртөг, ажлын байран дээр хэрэглэгддэг хувцас, гутал, судалгаа, хөгжүүлэлтэд ашиглагдсан бараа, үйлчилгээ, санхүүгийн үйлчилгээний төлбөр, анхан, анхны түргэн тусламжийн хэрэгсэл, эрүүл мэндийн үзлэг, бусад эрүүл мэндийн шалгалт, үйл ажиллагааны түрээс, нийгмийн тэтгэмжээр үзүүлсэн эсвэл байгалийн гамшиг гэх мэт онцгой нөхцөлийн улмаас өрх гэрүүдэд хүргүүлсэн бараа тайлант хугацаанд худалдан авахад төлсөн бүх мөнгөний бэлэн мөнгөний төлбөр гэсэн зардлуудыг яг энэ бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээ гэж тусгадаг байгаад байгаа юм.

Боловсролын яаман дээр одоо энэ дээр Боловсролын сайдын багцад болбол 2023 онд 44 тэрбум төгрөг байсан болбол 2024 онд 139 тэрбум төгрөг болоод нэмэгдсэн 2 дахин. Би 139 мянган төгрөг яриагүй шүү. 139 тэрбум төгрөг болоод нэмэгдсэн. Тэгээд энэ дээр анхаарах зүйлүүд байгаа юм. Та ахиад анхаараарай. Би энэ багш нарын цалинтай холбоотой ч байдаг юм уу, сургуулиудын урсгал зардалтай холбоотой тэр зардлыг яриагүй байгаа юм. Яг энэ бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээ тэр дундаа хамгийн анхаарал татаж байгаа нь энэ эрдэм шинжилгээ, судалгааны зардал гэж байгаа юм яаман дээр. Яам эрдэм шинжилгээний ажил хийдэг, яам судалгааны зардал хийдэг. 2023 онд 0 байсан зар...

Х.Булгантуяа: Батбаяр гишүүний микрофоныг нэг минутаар сунгая.

Д.Батбаяр: Тэгээд 2023 онд 0 зардал гарч байснаа 2024 онд 3 тэрбум төгрөгөөр нэмэгдчихсэн. Юугаа судлаад байдаг юм мэдэхгүй, ямар ажил хийгдээд байгаа юм ерөөсөө ойлгомжгүй. Тэгээд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хурал дээр танайхаас нэг хүн ирж хариулсан. Манай яамны ажилчид чөлөөт цагаараа эрдэм шинжилгээний ажил хийдэг юмаа, тэрний төлбөр тооцоо байдаг юмаа гэж хариулж байгаа юм. Энэ яг ямар учиртай зардал вэ? Танай тэр төлөөллийн хурал дээр ирж хариулсан тэр хариулт чинь үнэн зөв мөн үү? Ийм асуулт байгаад байна.

Х.Булгантуяа: Боловсролын сайд Наранбаяр хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ бусдаар гүйцэтгүүлэх энэ үйлчилгээний зардлыг бол та сая уншлаа. Ер нь ихэнх юмнууд нь тэр ер нь бол хувьсах зардал дотроо дотуур байрных гээд явдаг. Түүний зэрэгцээ ер нь бусдаар гүйцэтгүүлэх энэ ажил үйлчилгээгээрээ бид бас энэ сургуулийн үйлчилгээ цэвэрлэгээ, харуул хамгаалалт гэсэн ийм зүйлүүдийг төрийн албанд хүнийг авч ажиллуулах биш хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх энэ ажлыг эхлүүлээд ингээд явж байгаа. Үүнтэй холбоотойгоор бас зардал мөнгө зарцуулагдсан гэсэн ийм одоо юу байдаг мэдээ байдаг.

Тэр яг юуны тухайд бол судалгаанд бол Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр хавсралтын 2.2.7 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчийн зарим их сургуулиудын 25 онд хэрэгжүүлэх бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцүүлэн, орон нутгийн их, дээд сургуулиудын судалгаа, эрдэм шинжилгээ, дэвшилтэт технологи дамжуулалт болон инновацын үйл ажиллагааг дэмжих, эрэлттэй мэргэжилтэн бэлтгэх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, боловсролыг дэмжих жилийг угтсан зарим судалгаанд бол тус тус дэмжлэг үзүүлэх ийм зардал орсон байдаг юм байна аа. Энэ бол зүгээр нэмэгдсэн зардал бол биш бичилт нь өөрчлөгдсөн ийм зардал аа гэж ойлгож байгаа. Та бүхэн мэдэж байгаа.

Ер нь энэ бүсчилсэн хөгжлийн хүрээнд ийм эрдэм шинжилгээ, сургалт судалгааны ийм цогцолборуудыг байгуулах ийм ийм хөтөлбөр, төлөвлөгөөнүүд явдаг. Энэ дээр ТЭЗҮ-г нь боловсруулах гэх мэт ийм ажлууд бас явдаг аа. Энэ бас Дээд боловсролын тухай хуульд туссан байдаг юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Батбаяр гишүүн тодруулъя.

Д.Батбаяр: Тэгэхээр яах вэ хуулийн заалтыг болбол шууд ингээд уншчихаж байгаа байх. Бодвол тэгээд шууд цаанаас нь хэлээд өгчхөж байгаа байх л даа. Тэгээд яг одоо бид нар гүйцэтгэл ярьж байгаа учраас 3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл ямар ямар эрдэм шинжилгээний ажлууд хийсэн юм бэ гэдэг л зүйл асуугаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь татвар төлөгчдийн мөнгө байгаад байгаа. Хамгийн их төсөвтэй чинь Боловсролын яам байгаад байгаа юм. Хамгийн их асуудал дагуулаад байгаа нь Боловсролын яам байгаад байгаа юм. Яг бодит байдал дээрээ үр нөлөө ямар ч байхгүй. Тэгээд энэ дээр та хариулж чадахаар болбол хариулчхаарай. Хариулж чадахгүй бол одоо яах вэ.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Энэ 3 тэрбум төгрөгийн задаргааны тухайд бол би танд бичгээр өгье. ШУТИС, АШУҮИС-ийн харьяа ийм цогцолборууд барих ийм ажлууд дээр бол орсон байна. Зүгээр Боловсролын яам чинь та ингээд боловсролын салбар чинь нийт 247 мянган төрийн албан хаагчийн 111 мянга нь энэ салбар дээр багш, тэгээд л их дээд сургуулийн багш, судлаач мөн одоо үйлчилгээний албанд нь ажиллаж байгаа ийм олон хүмүүс байгаа. Тэгэхээр энэ чинь 1 сая гаран хүүхэд суралцаж, сая гаран одоо оюутан залуучууд суралцаж байгаа ийм салбар учраас өөрөө том нүсэр дээр нь нэмээд энэ салбар дээр бас хэл ам нэлээн байдгийг бол хүлээн зөвшөөрнө өө. Та таны хэлж байгааг бол хүлээн зөвшөөрнө. Бид бас энэ салбараа илүү ойлгомжтой ил тод, илүү одоо иргэндээ ойр, илүү одоо эцэг эхийн болоод оюутнуудын сэтгэл ханамжийг багш нарынхаа сэтгэл ханамжийг

дээшлүүлэхийн төлөө л хамтдаа зүтгэж байгаа. Үүний төлөө бол боловсролыг дэмжих жил гээд...

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Надад хэд хэдэн асуулт байна. 1 дүгээрт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 196 ААН-үүдэд аудит хийжээ. 88 нь ашигтай, үлдсэн нь одоо 108 нь алдагдалтай юм байна гэж ойлгож байна. 88 ААН-ийн ерөөсөө 6 нь л ашгийн 96 хувийг бүрдүүлж байгаа, 82 нь үндсэндээ үлдсэн 4 хувийг бүрдүүлж байна аа гэсэн үг. Төрийн өмчит одоо компаниудын засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр бодитой ажил хийнэ ээ гэж зорилтоо дэвшүүлсэн өнгөрсөн хугацаанд Засгийн газар маань. Энэ чиглэлээр одоо үр дүнд хүрсэнгүй ээ гэдэг аудитын дүгнэлт гарсан байна л даа.

Тэгэхээр би Хэрэг эрхлэх газраас энэ асуудал бас эхлэх ёстой юм болов уу гэж хараад байгаа юм. Өнөөдөр Эрдэнэс Монгол Нэгдэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа гэтэл санхүүгийн тайлангийн аудитын үр дүнгээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, ЭХЯ, мөн энэ барилга орон сууцжуулалтын яам руу очиж энэ сайд нарын багцад үр дүн нь нэгтгэгдээд байдаг. Энэ засаглалын энэ одоо оновчгүй тогтолцоогоо хэзээ яаж өөрчлөх юм бэ? Энэ ТӨК-ийн засаглал хэзээ яаж өөрчлөгдөж орж ирэх юм бэ 1 дүгээрт.

2 дугаарт Монгол Улсын Засгийн газар гадаад зээл тусламж багагүй авсан. 24.4 их наяд. Зээлийн эрх үүсгээд ашиглаж чадаагүй эх үүсвэр 13.3 их наяд. Хүүгийн төлбөрт 39.4 тэрбум төгрөгийг төлчихсөн. Хэзээ бид нар төлүүлж сурах вэ? Хэзээ чадах хэмжээгээрээ зээлээ авч энэ төлөвлөлтөө оновчтой болгох юм бэ? Ингээд үргүй зардлаар мөнгө үрээд байх уу хүүнд нь.

3 дугаарт Засгийн газрын хөрөнгө нэлээн нэмэгдэж байна. Үүнтэй зэрэгцээд орон нутгуудад хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын үр өгөөж учир дутагдалтай байна. Хөдөө сумдуудад энд тэндгүй ашиглалтад ороогүй баахан балгас барилга объектуудтай боллоо. Хэдэн жилээр ажлаа хийгээгүй алга болчихдог. Хэн хийж байгаагаа марттал алга болдог. 10 жил болчихсон газар чиг л байна. Араас нь хөөцөлддөг хүн амьтан байдаггүй. Энэ хөрөнгө оруулалтын ажлуудыг ер нь яаж дуусгах юм бэ. Засгийн газар энэ дээр ямар бодлого барих юм бэ? Удаасны шагнал болгоод урамшуулж байгаа юм шиг бид нар төсвийн тодотгол, дээр нь энэ төсөвт өртгийг нь тодотгоод магадлал хийгээд мөнгийг нь нэмж өгөөд байдаг. Энэ урамшууллын энэ тогтолцоогоо хэзээ арилгах юм бэ?

Сүүлийн асуулт аудитын дүгнэлтээр өнгөрсөн оны аудитын дүгнэлтээр хэрэгжүүлэх зөвлөмжийн хэрэгжилт 57.6 хувьтай. Одоо тэгээд аудит дүгнэлт гаргаад хэрэгжүүлэхгүй, гүйцэтгэл нь хангалтгүй орж ирээд байдаг ямар хариуцлагын асуудал яригддаг юм. Үнэхээр эсвэл Үндэсний аудитын газар хэрэгжих боломжгүй шаардлагыг өгөөд байдаг юм уу эсвэл Засгийн газар хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авдаггүй юм уу. Тодорхой хариулт өгөөч?

Х.Булгантуяа: Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дарга Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: ТӨК-иудын үр ашгийг нэмэгдүүлэх Үүрийнтуяа гишүүн асууж байна аа. Тэгээд ер нь одоо бас ТӨК-иуд дээр байнга ярьж байгаа олон нийтийн ойлголт, манай Их Хурлын гишүүдийн ойлголт ер нь бол нэгдсэн. Үр өгөөжгүй, хулгай хийдэг, сонгуульд ажилласан хүмүүсээ томилдог, цүнх баригчдаа томилдог гээд одоо олон шүүмжлэл явдаг. Үүнтэй холбоотой бас тодорхой асуудлууд бас улс орныг хамарсан хэмжээнд хүртэл одоо нүүрсний хулгайгаас авхуулаад сонсголууд хийгдэж хариуцлага хүлээж, асуудлууд бол цэгцэрч байгаа. Гэхдээ бас тийм хангалттай үр дүн гараад одоо тултлаа сайн болчихсон зүйл одоо байхгүй байгаа. Энэ дээр одоо бас Засгийн газар ажлын хэсэг байгуулаад тодорхой бас нэгж байгуулаад судалгаанууд хийж байгаа. Судалгаануудынхаа үр дүнд одоо цаашдаа бас илүү одоо ТӨК-иуд үр өгөөжтэй, давхардал, хийдэлгүй, илүү бүтээмжтэй, тэгээд дээрээс нь одоо ашигтай ажилладаг болох тал дээр бас тодорхой ажлууд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа.

Одоо өнөөдөр бас зарим нь юу гэдэг юм тооны цөөлөх гэдгээсээ илүү тийм үү чанарын өөрчлөлт, хэлбэрийн өөрчлөлтөөс илүү агуулгын өөрчлөлт хийх ёстой байгаад байгаа юм агуулгын. АЗЗА компаниуд гэж байдаг. Одоо 21 аймагт өвөлд нь замын халтиргаа гулгаа цэвэрлэдэг, зунд нь зам нөхдөг хагархай цоорхойг нь. Иргэдийг аюул осолгүй одоо зам дээгүүр зорчих үүрэгтэй. Энэ 21 компанийг нэгтгээд АЗЗА нэгтгэл гээд нэг компани болгосон. Уул нь одоо ингээд 21 компанийг нэг болгоод цөөлсөн юм шиг боловч үр дүн гаруй үр өгөөжтэй байж чадав уу гэхээр үр өгөөж байхгүй, улам хүнд сурталтай, улам нөгөө зам засах ажил нь хүндрэлтэй бэрхшээлтэй, дээрээс нь зардал нь нэмэгдсэн. АЗЗА нэгтгэлийг санхүүжүүлдэг. Уул нь замаа засаж байх, цасаа цэвэрлэж байх тэр мөнгөө том толгой компанийнхаа одоо санхүүжүүлэх цалин болгох байдлаар зарцуулдаг иймэрхүү л өөрчлөлтүүд биднүүс цаашдаа хийх шаардлагагүй гэж харж байгаа.

Төрийн өмчит хувьцаа 108 компани байгаа, 108 компаниас 70 компанийг болгож өөрчлөлт, бүтцийн өөрчлөлт хийх одоо ийм саналыг бол ТӨБЗГ судалгаа хийсэн юм байна лээ. Энийг бас дахиж нэлээн одоо нарийвчилж судалж байж тооны биш чанарын өөрчлөлт, хэлбэрийн биш одоо агуулгын өөрчлөлт хийх тал дээр бас анхаарч ажиллана аа. Та бас хэлж байна. Тэр магадлал хийгээд үнэ өсгөдөг. Ийм мэргэшсэн одоо тендерт ороод шүүхдээд гацаачихдаг тэгээд хоорондоо тохирч байгаад мөнгө авч байгаад барилга барьдаггүй цүнхний компаниуд байдаг. Ажил авчхаад ажлаа хийдэггүй тэгээд янз янзын шалтаг тоочоод, үнээ өсгөөд, магадлал хийлгээд тэр хоорондоо одоо юу гэдэг юм магадлал хийдэг одоо Барилгын хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв зэрэг байгууллагууддаа шан харамж өгдөг ч байж магадгүй. Одоо янз янзын ашиг сонирхол гаргадаг ч байж магадгүй. Ингээд магадлалын үнээр ингээд үнэ нь хэд дахин өсчихсөн ийм бас асуудлууд байдаг аа. Энэ дээр одоо бас манай аудит бас нэлээн томоохон бас арга хэмжээ авах байх, бидэнд бас танилцуулах байх.

Үндэсний аудитын газар шүдгүй арслан гэж одоо яригддаг байсан. Үндэсний аудитын одоо хуульд бас бид нар аудитын болон үндсэн хуулийн байгууллага болгосон. Энэ хүрээндээ бас шүдтэй арслан болгох илүү одоо хууль аудитын дүгнэлт зөвлөмж амьдрал дээр бодитой хэрэгждэг байх бас бололцоо боломжийг бүрдүүлж өгсөн. Өнөөдөр аудитын дүгнэлтээр зөрчилтэй хязгаарлагдмал гарсан бол одоо албан тушаалтнууд дээр хариуцлага тооцдог болох хууль үйлчилж байгаа. Цаашлаад бас эрүүгийн хариуцлага хүлээх ийм боломжтой болсон байгаа. Холбогдох албан тушаалтнууд дээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх. Аудитын

байгууллага ч гэсэн бас гарсан зөрчлүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлээд цаашид улам гүнзгийрээд хариуцлага тооцох ийм эрх нь нээлттэй болсон. Тийм болохоор урьд өмнөхөө бодох юм бол одоо аудитын байгууллага илүү одоо бас хүчтэй, илүү хуулийг хэрэгжүүлж ажиллах ийм...

Х.Булгантуяа: Эдийн засаг, хөгжлийн сайд Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ удаагийн энэ төсвийн хэмнэлт хийх гээд байгаа болбол энэ төрийн болон орон нутгийн өмчит компанитай бас шууд хамааралтай биш. Жишээ нь орон тоон дээр цомхотгол хийх, нөгөө олон хяналтын менежер, бүтээмжийн менежерүүдийг чөлөөлөх асуудлууд бол энэ тусдаа асуудал гэдгийг ойлгох ёстой. Тэгээд Их Хурал төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулийн хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Ингээд энэ хуулийн дагуу Монгол Улсын Засгийн газраас төрийн өмчит болон орон нутгийн өмчийн компанид баримтлах үндсэн чиглэлийг оруулж ирэх ёстой юм хуулиараа. Үүний дагуу хоёрхон статустай болно. Нэг нь ТӨК нөгөөх нь паблик институшн буюу нийтийн үйлчилгээний байгууллага. Хувийн хэвшил хийх бололцоогүй төр заавал хийх шаардлагатай зарим үйлчилгээг салбарын сайд нарын төсвийн багц дээр нь тавиад төсвөөс цалинжуулдгийг нь паблик институшн гэж нэрлээд бусад байгууллагууд бол бүгдээрээ ашгийн төлөө ажиллах. Үүний дагуу л одоо компаниуд татан буугдана, нэгтгэн нийлүүлнэ, өөрчлөн зохион байгуулна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье өө. Тэр төсөвт өртөг нэмэгддэг бол бүр ийм хонгил үүсчхээд байгаа юмаа. Тэгэхээр янз янзаар үнэтэй болоод тэмцээд л байгаа юм. Нэг заалтаа л бид нар маш сайн барьдаг болчихмоор байгаа юм. Юу вэ гэхээр төсөв батлахдаа аливаа одоо төсвийн хөрөнгө оруулалтуудыг тавихдаа сүүлийн 2 жил дотор магадлан хийгдсэн ийм төсөвтэй хөрөнгө оруулалтыг л тавина гэж байгаа юм. Гэтэл энэнээс дээш хуучин ялангуяа одоо ковидоос хойш энэ хугацаанд одоо 2-оос дээш өмнөх жил хийгдсэн ийм магадлантай төсөвт өртөгтэй бүх төсөл, хөрөнгө оруулалтууд төсөв нь нэмэгдсэн. Бүүр аймшигтай нэмэгдсэн зүйлүүд ч байгаа. Бүүр 2, 3 дахин. Энийг одоо тэр магадлан хийдэг эрх бүхий 3 байгууллагаас хөгжлийн төвөөс ирснийг одоо бид нар аргаа бараад аудит руу явуулдаг. Энийг нэг дахиад нэг хянаад өгөөч ээ гээд.

Энэ дээр бас манай аудитынхан нэг дүгнэлт ер нь бодлого хэлчхээрэй. Цаашдаа ер нь энийг одоо ер нь яах ёстой юм бэ?

Х.Булгантуяа: Үүрийнтуяа гишүүн нэмж тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Хэдүүлээ тодорхой л ярья. Учрал сайд аа би одоо явагдаж байгаа төсвийн хэмнэлтийн талаар асуугаагүй. Хэлэлцэж байгаа асуудлын хүрээнд ТӨК-иудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй холбоотой асууж байгаа. Би тодорхой асуусан л даа. Эрдэнэс Монгол Нэгдэл тухайлах юм болбол зөрчил үүсгээд байна аа засаглалын хувьд. Хэрэг эрхлэх газар таны хэрэг эрхлэх газрын дарга байх үед энэ Хэрэг эрхлэх газрын харьяанд л одоо явж байсан. Өнөөдөр аудитын асуудлууд нь сайд нар дээр очоод байдаг, энийг яах юм. Энэ чигээрээ явах юм уу.

2 дугаарт одоо энэ яах ёстой юм бэ гээд суугаад байж бас болохгүй байна л даа Жавхлан сайд аа. Энд төсөвт өртгийн өсөлт дээр Засгийн газар тодорхой бодлого гаргамаар байна. Яагаад энийг гаргаж болохгүй байгаа юм. Болохгүй бол ажлын хэсэг гаргая л даа. Ажлын хэсэг гаргаад бүх газар газруудаар нь яваад энэ ажлын гүйцэтгэлийг нь үзье л дээ. Энэний ар дээр ажиллуулъя л даа. Их Хурал хяналтаа тавья тэгвэл. Аудитын дүгнэлтийн хэрэгжилтийн талаар хариултаа өгөөч.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Үүрийнтуяа гишүүн ээ, 2024 онд 2025 оны төсөв барьж байхдаа төсөв батлах үед тогтоол гараад ингээд 2025 онд энэ төсвийн нэмэгдлүүдийг эргүүлээд Их Хуралд тайлагнана аа гэсэн байгаа. За хугацаанд нь бид Их Хуралд одоо хүргүүлсэн байгаа. Төсөвт өртгийн нэмэгдлүүдийг аудитаар оруулаад аудитлуулаад тэрэн дээр аудитаас бол ихэнх нь л ер нь бараг зөрчилгүй байна гэж гарсан байна лээ дээ. Энийг би Их Хурал руу хүргүүлчихсэн байгаа. Энэ дээр нэг шийдвэр чиглэл өгчих юм бол тэрний дагуу 2026 оны төсөв дээр тусгах эсэхээ шийднэ. Бидний зүгээс бол аль болох тусгамааргүй байгаа юм. Тийм учраас энийг бас Их Хурал дээрээс шийдвэр гаргах ийм шат үлдчихээд байгаа шүү. Тэрийг нэг шийдвэр гаргаад өгөөрэй.

Х.Булгантуяа: Үүрийнтуяа гишүүн нэмж тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Энэ магадлалтай холбоотой асуудал дээр би 2 зүйл яриад байгаа юм л даа Жавхлан сайд аа. 1 дүгээрт төсөвт өртгийн өсөлтийн асуудал, 2 дугаарт одоо энэ эзэнгүй хаягдчихаад байгаа эзэн холбогдогч нь тодорхойгүй болоод бараг хэн хийж байгаагаа мартчихсан энэ олон балгас болсон барилгуудаа яах юм бэ. Тэнд чинь баахан мөнгө орчихоод ингээд байгаад байна шүү дээ. Баригддаг ч үгүй, дуусдаг ч үгүй. Нэг төсөв нэг жилийн төсөв батлах, нэг жилийн гүйцэтгэл хэлэлцэх явцад энэ асуудлаар бас багагүй ярьж байна аа бид. Би ч бас энэ дээр тодорхой саналуудыг гаргаж явж байгаа. УИХ-ын тогтоол гарсан. Аудит энэний мөрөөр бас тодорхой ажлууд хийгээд тайлагнах байх. Холбогдох байнгын хороодоор ороод үр дүн нь гарах байх гэж бодож байна. Тэр үед саналаа хэлээд явна. Энэ хэрэгжихгүй байгаа ажлууд дээр Засгийн газар ямар ажил хийж байгаа юм бэ? Энэний араас ер нь яаж явж байгаа юм?

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ төлөвлөх, төсөвлөх, хянах, мониторинг хийх механизм ер нь бол ажиллахад энэ салбар дундын уялдаа бүрэн хангагдаагүй байсан. Тийм ч учраас энэ урт хугацааны болон дунд хугацааны бодлогыг бүхэлд нь өөрөө үнэлдэг мониторинг хийдэг ийм шинэ одоо Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний механизм энэ удаа ажиллаж эхэлнэ ээ гэж ойлгож байгаа. Яагаад гэхээр өнгөрсөн хугацаанд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар ТӨК-иудыг нэг хянадаг. Дээрээс нь Эрдэнэс Монгол нэгдлийн дэргэд аудит ажилладаг. Компанийнхаа хуулиар. Дээрээс нь төрийн аудит өөрөө ордог. Тэгээд ингээд яг үнэндээ болбол Эрдэнэс Монголын дэргэдэх аудит болбол шинэ механизм бүрдүүлээд энэ дээр чинь бараг 40 компани дээр хязгаарлалттай дүгнэлт гарсан юм шүү дээ. Тэгэхээр энэ аудитуудын дүгнэлтүүд зөрөөд байгаа. Тийм учраас одоо болбол бид нар нэгдсэн дүгнэлтээ танилцуулаад шууд одоо зохих арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй. Тэгээд Үүрийнтуяа гишүүний санал бол зөв өө.

Х.Булгантуяа: Тийм зөвлөмжийн биелэлт хэрэгжихгүй байгаа тухай Учрал сайд нэмж хариулъя. Учрал сайдын микрофоныг.

Н.Учрал: Төлөвлөснийхөө араас явдаггүй, тэгээд төлөвлөснийгөө өөрөө хянадаггүй. Тэгээд зөвлөмж өгөөд зүгээр орхичихдог ийм л үзэгдлүүд давтагдсаар байсан. Тэгээд ерөөсөө 1 ийм тал бүрээс нэгтгэсэн төлөвлөгөөгөө аваачиж Их Хурлаар жилийн төлөвлөгөөгөө баталчихдаг. Тэгээд хянан шалгах нь өөрөө ажил сайжруулахад чиглэдэггүй, зүгээр л нэг ийм хянадаг, шалгадаг тэгээд заавал нэг алдаа гаргахын төлөө зорьдог. Тийм учраас Эрдэнэс Монгол дээр нэг тэр нэгдэл дээр аудит болбол өөрөө нөгөө олон улсын стандарт нэвтрүүлсэн юм. Тийм учраас энэ зөвлөмжүүд болбол ажлыг сайжруулахад чиглэж байгаа ажлыг сайжруулахад. Тэгэхээр энэ зөвлөмжүүдийг хэрэгжүүлж байна уу буюу компани заавал ашигтай ажиллахаас илүүтэйгээр тэр компани өмнө жилийн алдагдлаа бууруулсан байхыг үнэлдэг энэ механизм руу л бид нар явах ёстой.

Тийм учраас цаашдаа бол энэ хөгжлийн яаман дээрээ бол энэ үнэлгээгээ аваад энэ жилийн төлөвлөгөөгөө хянаад та бүхэнд тайлагнадаг ийм байдал руу бол хэвшинэ ээ гэдгийг хэлье ээ.

Х.Булгантуяа: Үүрийнтуяа гишүүний бас яриад байгаа нэг чухал асуудал нь энэ манай Батлан хамгаалах энэ Барилга, хот байгуулалтын сайд бас энэ барилгын тухай хууль, дээрээс нь нэмээд энэ жишиг гэрээ байдаг. Тэрүүнийг нэг шинэчлэх асуудал бол өөрийн эрхгүй бас яригдах юм байна лээ Үүрийнтуяа гишүүн. Тэгэхгүй бол үнэнийг хэлэхэд тэр гэрээгээр бол ингээд хууль шүүхийн байгууллага дээр очоод Засгийн газар одоо төсвийн ерөнхийлөн захирагч нар бол бараг ялахааргүй тийм жишиг гэрээтэй юм байна лээ шүү дээ. Тэгэхээр тэрүүн дээр нь бас та бүхэн маань анхаараарай. УИХ-ын гишүүн Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Их Хурлын гишүүд төсвийн захирагч нарын энэ оройны амар амгаланг айлтгая. 2024 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байна аа. 2024 он бол нэлээн тийм тааламжтай бас жоохон бялуурсан л он жилүүд байсан л даа. Орлогоо ч ахиу төлөвлөж байсан. зардлаа ч ахиухан гаргаж байсан. Тэгэхдээ төлөвлөсөн хэмжээндээ яаж бүрдсэн юм гэдэг тухай, яаж зарцуулсан юм гэдэг тухай хэрхэн хууль тогтоомжоо барьсан юм бэ гэдэг тухай л асуудал байгаа. Орлого ахиутай байх чинь л татварын орлогуудаа тоодоггүй юм хаячхаад байдаг байхгүй юу. Энэ татварын нэр төрлүүдийн орлогын нэр төрлүүдийн хангалт ер нь яаж явсан юм? Татварын орлогын бүрдэл хангах талаар ер нь юу зохион байгуулав аа. Манай аудит энэ дээр ер нь ямархуу байдлаар дүгнэж хандав гэдэг асуудал байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн асуудал дээр үрэлгэн зардлын тухай л их ярьцгаагаад байгаа бид хэд. Төсөвлөгдсөн зардал ямархуу хэмжээний гүйцэтгэлтэй гарчхав, хэмнэгдээд үлдчихээд байгаа зардлууд гэж ямар зүйл ангиуд дээрээ гарав, 7 мянган төрийн албан хаагчийн сул орон тооны тухай ярьцгаагаад эхэллээ. Тэр үнэхээрийн одоо 2024 оны төсвийн гүйцэтгэлээр гарч ирж байгаа юм уу, үгүй юм уу. Энэ дээр би холбогдох байгууллагууд нь аудитынхныг нэг тодорхой хариулт өгөөч гэж нэг хэлмээр байна. 3 дахь тодруулчихмаар зүйл үгүй ээ энэ аливаа асуудал 2 талтай.

Нэг хэдэн баялаг бүтээх ч гэдэг юм уу, барилга угсралтын ажил гүйцэтгэдэг компаниудад буруу өгөх гээд тэнд шуналын тулмууд байгаа тухай яриад хэрэггүй.

Монгол төр хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийлгэнэ гээд тов тодорхой зураг төсөвтэй ажлаа арваад жил жижиглэн хуваах замаар төсөвт мөнгийг нь суулгачхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь тэр компаниуд чинь зайлуул дампуурахгүй яадаг юм. Тэр 10 жилийн хугацаанд үнэ өртөг өсөхгүй хаачдаг юм. Аргаа бараад төсөв дотроо биднүүс хуулийн зохицуулалт хийсэн юм. Нэг удаад төсөвт нь магадлал хийдэг байх тухай 3 жилд багтааж санхүүжүүлж дуусдаг байх тухай асуудлыг зохицуулж өгсөн юмаа. Энүүнд одоо хамрагдаж чадаагүй 600 орчим тэрбум төгрөгийн асуудал хүлээгдэж байгаа гэж би ойлгоод байгаа. Сангийн сайд аа. Тэрийг ер нь одоо ямархуу байдлаар та хэд судалж дүгнэж байна вэ?

Саяын энэ ковид гэж нэг айхтар нөхцөл байдал хамаг юм үймүүлээд, үнэ өртөг өсгөөд энэнээс улбаалж энэ төсөвт өртөг нэмэгддэг магадалдаг юм чинь айхтар болчихлоо л доо. Уг нь бол салбарын сайд Сангийн сайдтайгаа хоёулаа сууж байгаад тухайн салбар дээр үнийн өсөлт хэдэн хувьтай гарсан юм. Яг тэрүүнийг зураг төсөв дээр нэмж тооцох уу, үгүй юу...

Х.Булгантуяа: За эхлээд Үндэсний аудитын газраас хариулах уу? 4 номерын ажлын хэсгийн микрофон дээрээс хариулъя. За 4 номерын микрофоныг өгье.

Ц.Наранчимэг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна аа. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд бид орлого одоо талыг дүгнэж, тодорхой дүгнэлтүүд, дүгнэлтийг бол өгсөн байгаа. Энэ дүгнэлтэд бид нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн орлогын орлогыг бол Уул уурхайн салбарын гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын орлого нэгдсэн төсвийн нийт орлогын 35.3 хувиар бүрдүүлж байгаа. Нүүрсний биет хэмжээ 80.3 сая тоннд хүрч, нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 75.3 хувийг тус салбарт татсан хөрөнгө оруулалт эзэлж байгаа.

Түүнчлэн дээрх салбарын экспортлох нүүрсний зах зээлийн үнэ тэнцвэржүүлсэн үнээс бага буурах хандлагатай байгаа нь дараагийн жилүүдийн төсвийн орлого тасалдах, уул уурхайн салбарыг дагасан худалдаа үйлчилгээний салбарын өсөлт хумигдах эрсдэлтэй байна аа гэсэн дүгнэлтийг өгөөд тэгээд Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдад одоо зөвлөмжийг бол хүргүүлсэн байгаа. Төсвийн зарлагын тухайд бол 2024 оны төсвийн нийт зарлага бол 33.5 их наяд төгрөгийг зарахаас 30.5 их наядыг зарж 3 их наяд төгрөгийн дутуу санхүүжилтийн хэмнэлттэй 91.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байгаа. Эдгээрийн хамгийн их одоо гүйцэтгэл дутуу зарлага бол хөрөнгийн зардал буюу 2.4 их наяд төгрөгийн хэмнэлт байгаа. Дутуу санхүүжилт олгосон.

Х.Булгантуяа: Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Тэгээд тэр хөрөнгө оруулалтын ажил дээр нэг бодитойхон хандахгүй бол олон компаниуд үүдээ барих гээд байгаа юмаа. Энүүнийг одоо хэдүүлээ яаж зохицуулах юм гэдэг асуудал байна. Цаашид тэр барилгын салбар дээр гэдэг юм уу, эрчим хүчний салбар дээр гэдэг юм уу, замын салбар дээр тухайн жилд инфляц хэдэн хувьтай явчхав гэдэг юмаа гаргаж ирээд тэрүүгээрээ төсвөө нэмэгдүүлэх эсэх асуудлаа ярьдаг болохгүй бол одоо жилийн жилд онцгой өсөлттэй явсан үеүдтэй нийцүүлээд магадлал хийгээд байдаг юм гэж байхгүй ээ. Энүүнийг одоо би зөв бодох ёстой болов уу гэсэн нэг ийм бодол байгаад байх юм.

Дараагийн нэг зүйл манай энэ аудитын байгууллагатай би бас хэд хэдэн жил л яриад болж өгөхгүй л байгаад байгаа юм. Зөрчлийн тухай нэг айхтар тоо хэлээд мөнгөн дүн хэлчихдэг. Тэр дотроос яг стандартын алдаа буюу хууль тогтоомж зөрчсөн дээр нь бид төлбөрийн акт тавьдаг.

Х.Булгантуяа: Сангийн сайд хариулах уу. Төсвийн хөрөнгө оруулалтын.

Б.Жавхлан: Төсвийн хөрөнгө оруулалт бол сүүлийн жилүүдэд энэ ковидоос хойш болбол нэгж төслүүдийн энэ үнийн өсөлт бол арай хэтэрсэн. Бид тэр мэргэжлийн байгууллагаар нь ирсэн үнийн өсөлтүүдийг нь бид бол тэрийг чинь хянах эрхгүй, өөрчлөх эрх байхгүй. Тэрийг нь тэгээд би ямар ч байсан тэгээд л энэ институц одоо аудит руу л явуулдаг. Аудитаас хүрээд ирснийг нь одоо төсөвтөө багтаах гээд тэр нь багтдаггүй ийм л цикл рүү орчхоод байгаа юм. За сүүлийнхийг бол мөн л одоо энэ чинь аудитаар юунаас ковидоос хойш шүү дээ. 2023, 2024 оных нь мөн л бас нэлээдгүй нэмэгдэл үүсчихсэн байж байгаа. За энийг аудитуулаад одоо ийм юм болчихлоо, одоо энэ 2026 оны төсөв дээр ер нь яах юм бэ. Одоо энэ бол багтахгүй бид нар энийг төсөвт суулгах ямар ч боломжгүй гэдгийгээ хэлээд ингээд Их Хуралд тогтоолоор өгсөн үүргийн дагуу хугацаанд нь...

Х.Булгантуяа: Энэ бол одоо Сангийн сайдын хэлдгээр тогтоолоор байгаа. Үндэсний аудитын газрын яг эрхлэх чиг үүргийн хүрээнд Төрийн аудитын хуульд бол энэ бол танайд бол байхгүй шүү дээ. Орж ирэх гэж байгаа төсөвт орж ирэх гэж байгаа барилгын үнийн өртгийн нэмэгдлийг Үндэсний аудитын газар хянаж төсөвт оруулна аа гэсэн тийм чиг үүрэг бол байхгүй яг үнэнийг хэлэхэд бол. Тэгэхээр одоо тэгээд дээрээс нь нэмээд энэ барилгын нарийн мэргэжлийн хүмүүс, Барилгын хөгжлийн төвийнхөн өөрснөө нэг бодлын аудит хийж шалгаж оруулж ирсэн юмыг ахиад дээрээс нь Үндэсний аудитын газрынхан дахиж нэмж тэрүүн дээр хянана гэдэг бол хэцүү л байх. Сангийн сайдын хэлдгээр бараг тэр чигээрээ л орж байх шиг байна лээ тийм. Аудитын зөрчил төлбөрийн акттай холбоотойгоор Үндэсний аудитын газраас 4 номерын микрофоныг өгье. Ажлын хэсгийн.

Ц.Наранчимэг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг. Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын ерөнхий аудитор төлбөрийн акт тогтоох, албан шаардлага өгөх, зөвлөмж өгөх журмыг бол баталж, бид энэ журмын дагуу аудитаа хийж гүйцэтгэж, аудитын зөрчлийн шийдлээ гаргадаг. За бид нар санхүүгийн тайлангийн аудитад бол нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой алдааг тайлангийн үед залруулдаг. Энэ залруулсан асуудлаа бол тайланг нь зөв болгоод алдаа хэлбэрээр яг таны сая ярьснаар тайлангаа бол ноднин жилээс өгсүүлээд алдаа нь тусдаа, зөрчил нь тусдаа ийм асуудлаар тайлагнаж байгаа. Хууль тогтоомжийг зөрчсөн асуудлыг бол бид зөрчилдөө авч үзэж байгаа. Хууль тогтоомжийг одоо зөрчөөд тодорхой улсын төсөвт төвлөрүүлэх ёстой асуудлыг бол төлбөрийн акт тогтоож байгаа. Хойшид давтан гаргахгүй байх зөрчлийн асуудал дээр бол албан шаардлага өгч байгаа.

Х.Булгантуяа: Нэмэлт микрофон өгье 4 номер.

Ц.Наранчимэг: Өмнө нь Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй болбол зөрчил гэж үзэж албан шаардлага өгч байгаа ийм шийдлийг гаргаж байгаа. Тэгээд залруулагдаагүй алдаа буюу зөрчлийн дүнгээр санхүүгийн тайлангийн аудитаар 4 дүгнэлтийнхээ аль нэг дүгнэлтийг өгөөд

ингээд явж байгаа стандартын дагуу байгаа. Алдаа зөрчил хоёроо тусад нь тайлагнаж байгаа.

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүн Жудагийн Баярмаа.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ оройн мэндийг хүргэе. Энэ төсвийн гүйцэтгэл чинь маш чухал. Бид нарын хэлэлцэх ёстой ийм баримт бичиг асуудал байгаад байгаа. Сая зөндөө л асууж байна. Тэгээд энэ одоо дөнгөж сая ярилаа л даа тиймээ. Өмнөх оны аудитын зөвлөмжийн биелэлт 54 хувьтай гээд. Гэтэл өөрснөө бол 76 гээд дүгнэчихсэн байсан юм байна. Тэгэхээр энэ 54 хувьтай байна гэдэг чинь төдий чинээ энэ зөвлөмжүүд чинь ерөөсөө ажиллахгүй байгаа учраас энэ чинь дахиад нуль зөрчил байна шүү дээ. Нуль бүүр бүхэлдээ бүүр алинаас нь эхэлж яаж асуухаа ч ойлгохгүй хэмжээнд ингээд байна л даа. Тэгээд Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хэрэгжилт гэхэд 30 хувьтай л гэж байна. 31 хувь нь тусгагдсан мөртөө хэрэгжээгүй л гэж байна гээд ингээд ерөөсөө. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн санхүүжилтийн 37.3 хувь нь одоо яагаагүй олгогдоогүй, санхүүжүүлэгдээгүй л гэнэ.

Тэгээд 2024 онд дуусгахаар төлөвлөсөн арга хэмжээний 31 хувь нь огт хэрэгжээгүй л гэнэ. Тэгээд ингээд бүхэлдээ огт хэрэгжээгүй дутуу хөтүү л нэг ийм юм байна. Тэгээд асуултууд гэх юм бол энд жишээлбэл ийм нэг одоо аудитын илрүүлэлт байна л даа. Нэг ёсондоо нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бууруулж нэгтгэсэн гээд байгаа юм. Тэр ухаан нь мөнгөн хөрөнгө нь 100 тэрбум байж байснаа одоо харагдаад байгаа юм уу, мэдэхгүй хэдэн төгрөг юм би асуумаар байгаа юм. Тэгснээ яагаад хэдийг нь тайландаа багасгаж хэд болгож ингэж нэгтгэсэн юм бэ? Ямар зорилготойгоор яах гэж байгаа тэр одоо тэр мөнгийг зөрүүг нь энэ тоог хэлж өгөөч ээ.

Дахиад энд бас нэг юу байна л даа. Одоо нөгөө бид нарын ноднингоо ярьсан зураг төсөвгүй, магадлал хийлгээгүй гээд. Энэ чинь одоо бүүр 712 төсөл арга хэмжээнээс 485-ыг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 52.8 хувь буюу 256 төсөл арга хэмжээ нь магадлалд ороогүй баталгаажсан зураг төсвийн шаардлагыг хангаагүй гээд энэ чинь одоо бүүр 52 хувь гэдэг чинь бүүр 256 төсөл арга хэмжээ гэдэг чинь бүүр аймаар том дүн байна шүү дээ. Тэгэхээр эндээс чинь л нөгөө төсвийн тэр зарцуулалтын буюу зардлын хэтрэлт энэ тэр чинь яваад эсвэл л дутуу биччихээд нэмж аваад нөгөө авлига хээл хахууль яваад байдаг гээд ноднинжингоо бид нар ярьсан. Гэтэл энэ болбол бүүр арай дэндүү бүүр 50 хувь нь магадлалд ороогүй явж байна гэдэг бол энэ маш том дүн гэж ингэж харж байгаа юмаа.

Тэгээд энэ бас нэг эндээс нэг ийм асуулт явж байгаа юм. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 726 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээний үлдэгдлээс тайлант онд ингээд 102 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээний гүйцэтгэгч нь шалгараагүй байхад санхүүжилтийг нь олгосон.

Х.Булгантуяа: Баярмаа гишүүнд нэг минут нэмж өгье.

Ж.Баярмаа: Энэ бол одоо маш ноцтой л зүйл харагдах юм. Гүйцэтгэгч нь огт шалгараагүй байхад санхүүжилтийг нь байршуулчихсан гээд. Тэгээд бага дүн биш шүү 102.5 тэрбум. Энэ бас ямар учиртай яагаад ийм одоо хууль зөрчсөн үйлдлүүдийг ингээд бараг жил болгон хийгээд байдаг юм бол оо. Тэгээд нөгөө

зөвлөсөн зөвлөмжийг нь хэрэгжүүлэхгүй 50 хувьтай гэхээр чинь одоо арга ч үгүй юм болов уу л гэж бодож байна. Тэгээд бид нар асар их татвар төлөгчдийн мөнгийг ийм замбараагүйгээр үрж ийм хяналтгүйгээр зарцуулсаар байх юм бол энэ Монгол Улс чинь ер нь яаж хөгжих юм бэ? Энэ төсвийг чинь одоо зүгээр жил болгон л батлаад, жил болгон тодотгоод л, жил болгон гүйцэтгэлийг нь хянаж байдаг байсан байлгүй дээ. Тэгээд яагаад энэ зөрчил дутагдлууд нь арилдаггүй юм?

За хамгийн сүүлийн асуулт. Энэ ер нь энэ зөрчил гаргасан алдаатай бөгөөд бусад тэр нөгөө хязгаарлалттай аудитын дүгнэлт авсан этгээдүүдэд хариуцлага тооцсон тэр статистик дүн байдаг юм уу? Гэмт хэрэгт холбогдсончууд нь хэд нь яг хэрэг хүлээгээд эсвэл ингээд хуулийн...

Х.Булгантуяа: Сангийн сайд Жавхлан түрүүлээд хариулах уу. Тэгээд дараа нь Аудитын газар хариулахад бэлдэж байгаарай.

Б.Жавхлан: Би асуугаад байна шүү дээ. Аудит хариулсны дараа. Тэр улсын төсвийн хөрөнгө оруулалтын тэр нөгөө гүйцэтгэл дутуу гарснуудыг Сангийн яамнаас статистикийг нь хариулчих. Дэлгэржаргал дарга хариулчих.

Х.Булгантуяа: Харин тийм. Эхлээд тэр гүйцэтгэлтэй холбоотой, барьцаа хөрөнгөтэй холбоотой баахан асуудлууд байна.

Б.Жавхлан: Тэгээд бусдыг нь аудит хариулсны дараа.

Х.Булгантуяа: Тийм тэгээд акт зөрчилтэй холбоотой аудитынхаа хариулахад бэлдэж байгаарай. 4 номерын микрофон ажлын хэсэг.

Ж.Дэлгэржаргал: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд бол 3.8 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдсан. Нийтдээ 1319 төсөл байгаа, түүний 712 нь бол 2024 онд шинээр эхэлсэн. Энэ шинээр эхэлсэн төслүүдийн 270 төсөл нь УИХ-ын хэлэлцүүлгийн явцад Засгийн газрын өргөн барьсан төсөл дээр нэмэгдсэн буюу аудитын дүгнэлтэд орсон нэг маягаар төлөвлөсөн төслүүд энэ 270 төсөл дотор байгаа. За хэрэгжилтийн явцад бид нар төсвийн хуулийг хэрэгжүүлэх хугацаа нь яг санхүүжилт болон гүйцэтгэлийг хянахдаа яг зураг төсөв батлагдаж тухайн өртөгтөө багтсан гэрээний дагуу санхүүжилтүүдийг хянаад ингээд олгоод явж байгаа. Барьцаа хөрөнгийн дансны хувьд бол төсвийн тухай хууль дээр байгаа 43.2-ын дагуу он дамжуулан хэрэгжүүлэх нь хэрэгжүүлэх заалтыг бол зохицуулсан байдаг. Энэ хуулийн дагуу тухайн жилд гүйцэтгэл төслүүдийг удаашрахаас одоо урьдчилан сэргийлж бид нар Засгийн газрын 349 дүгээр тогтоолоор...

Х.Булгантуяа: 4 номерын микрофоныг нэмж өгье.

Ж.Дэлгэржаргал: Засгийн газрын тогтоол гаргаад захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулаад, энэ оны 8 сарын 30-ны дотор чөлөөлөхөөр ингээд зохицуулалтыг тусгаж байгаа. За барьцаа хөрөнгийн дансны хувьд бол яг валютын сангийн дүгнэлтээр энэ бол нөгөө санхүүжилтийн гүйцэтгэлийг сайжруулах арга хэрэгсэл гэж үздэг байгаа. Хэрвээ бид нар барьцаа хөрөнгийн дансанд авч гүйцэтгэлийг хангахгүй бол энэ төслүүд маань хэрэгжилт нь 2 жилээр ухраад үүнээс үүдэлтэй нэмэлт санхүүжилтүүд үүсэх ийм эрсдэлтэй байдаг. Тэгэхээр энд бол

нийтдээ өнгөрсөн онд 692 тэрбум төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулснаар хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 80 хувьтай гарсан байгаа.

Х.Булгантуяа: Төрийн сангийнхан. 3 номерын микрофон дээрээс нэмээд хариулчихъя. Аудитынхан дараа нь 4 номер дээр бэлдэж байгаарай.

Б.Цогбадрах: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Төрийн сангийн дарга Цогбадрах байна аа. Ер нь бол Төсвийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан чиг үүргийн хүрээнд бол төрийн сангийн зүгээс бол мөнгөн хөрөнгийг нэгдсэн удирдлагаар хангах, мөнгөн хөрөнгийн менежментийг хэрэгжүүлэх үр ашигтай удирдан чиглүүлэх тийм бодлого барин ажилладаг. Мөнгөн хөрөнгө бууруулсан тухайд бол одоо дэлхийн улс орнууд мөнгөн хөрөнгийг нь зайлшгүй байлгах үлдэгдлийг бодлогоор хэрэгжүүлдэг. Түүний хүрээнд бол үлдэгдэл дээрээ бид нар бол төв төрийн сангийн зүгээс бол мөнгөн хөрөнгийн тодорхой хувийг бид нар зээлийн төлбөр болон бусад одоо санхүүжилтэд ашиглан дахин зээл авч, зээлийн хүүгийн зардал гаргахгүйгээр ингэж ашиглан 2024 оны жилийн эцэст бол тийм өглөг үүссэн байгаа. Тэр өглөгийг бид нар улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг стандартын дагуу Засгийн газрын нэгтгэсэн тайландаа бид нар...

Х.Булгантуяа: Нэмж хариулъя. Жоохон чанга яриарай. Микрофон дээр.

Б.Цогбадрах: 2024 оны төрийн сангийн тайланд бол бид нар өглөг үүссэн тайлагнасан. Ер нь бол Засгийн газрын нэгтгэсэн тайланд олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бид нар тэр өглөгийг бол тохируулах бичилт хийж тайлагнасан.

Х.Булгантуяа: Аудит нэмж хариулъя. Яг ямар зөрчил байгаа юм. Дээрээс нь зөрчилтэй холбоотой ямар арга хэмжээ авсан юм, хэчнээн хүнд хариуцлага тооцсон юм, хэдэн төгрөг буцаж төвлөрүүлсэн юм гэж байх шиг байна тиймээ Баярмаа гишүүн. Микрофон асчихсан байгаа шүү.

Ц.Наранчимэг: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Төв төрийн санд байгаа хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэлд орсон 5 их наяд төгрөгийн улсын төсвийн зарлагын эх үүсвэрийг төрийн санд байршуулж, одоо мөнгөн хөрөнгийг зөв зохистой удирдаж байгаа нь бол яг төрийн сангийн өнөөгийн мөрдөгдөж байгаа журам дүрмийн дагуу бол зөв байгаад байгаа юм. Энэ нь Төсвийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан. Энэ дээр энэ төрийн сангийн нэгтгэсэн тайлан 47 төсвийн ерөнхийлөн захирагчийн 266 байгууллагын одоо мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бол бууруулж, цэвэрлэх бичилт хийж тайлагнасан энэ асуудлынхаа бичилтийг одоо хэрхэн яаж шийдвэрлэх талаар өмнөх бид нар зөвлөмж өгсөн. Тэгээд зөвлөмжийг өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй учраас энэ онд бол албан шаардлага өгсөн байгаа.

Бид нар төрийн аудитын байгууллагын түрүүн Монгол Улсын ерөнхий аудитор үгэндээ хэлсэн. Төрийн аудитын байгууллагаас өгч байгаа...

Х.Булгантуяа: 4 номер нэмж минут өгье.

Ц.Наранчимэг: Зөвлөмж албан шаардлагын хэрэгжилтэд энэ жилийн тайландаа бид нар бас дүн шинжилгээ хийж өгсөн. Магадгүй одоо бид нарын өгч байгаа зөвлөмжийг бас ойлгомжгүй юм уу, хэрэгжүүлэх боломжгүй байж магадгүй гэж өөрсдөдөө бас эрсдэл тооцож ингэж энэ жилийнхээ одоо 2 тайланг үзсэн байгаа.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зөвлөмж бол 66.5 хувьтай байгаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан бол 56.3 хувийн зөвлөмжийн хэрэгжилттэй байгаа. 2019-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг аваад үзэх юм бол 2021 онд төрийн аудитынхаа байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хамгийн өндөр, 2023 онд хамгийн бага хувийн хэрэгжилттэй байгаад байгаа.

Тэгээд зөвлөмж хэрэгжүүлэхгүйгээс болж одоо энэ гараад байгаа алдаа зөрчлүүд бас нэлээдгүй ихсээд байгаа. Төрийн аудитын тухай хууль нь төрийн аудитын байгууллагын тайланг хүлээж аваад 30 хоногийн...

Х.Булгантуяа: Жудагийн Баярмаа гишүүн нэмж тодруулъя.

Ж.Баярмаа: Хариултыг нь сайн ойлгосонгүй. Энэ төсвийн ерөнхийлөн захирагчдын ямар хэдэн төгрөгийн гэдэг юм уу мөнгөн хөрөнгийг хэд болгож багасгаж тайлагнаад байгаа юм бэ гэдгийг маш тодорхой мэдмээр байх юм. Энэ бол надад их ноцтой санагдах юм. Ямар зорилгоор, яагаад ингээд багасгаад талыг нь ч юм уу, хэдэн хувийг нь яах гэж ингээд үлдээгээд байгаа ч юм уу мэдэхгүй. Би гайхаад ойлгохгүй учраас л асуугаад байгаа юм л даа.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон.

Ц.Наранчимэг: Энэ болбол үлдээгээд юм уу, багасгаад байгаа асуудал биш. Энэ яг нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудлууд байгаа. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргахад төсвийн ерөнхийлөн захирагчдын хооронд одоо зарцуулж байгаа бүртгэлтэй холбоотой асуудлыг зөв тайлагнахын тулд одоо нэгдсэн тайлан дээр устгах бичилтүүдийг хийж тайлагнаад явдаг ийм асуудал байгаа юм. Манай энэ бичсэн асуудал болбол төрийн сангийн байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зөв зохистой удирдаж, тэрэн дээр байгаа мөнгөнүүдийг одоо удирдан зарцуулж байгаа асуудал нь болбол зөв асуудал байна аа. Гэхдээ энийгээ олон улсын нягтлан бодох бүртгэл талаасаа сайжруулах энэ өглөгүүдийг одоо төсвийн ерөнхийлөн захирагч дээр нь өглөг авлагын асуудал гаргах уу, нэгдсэн тайлан дээр өглөг авлагын асуудал гаргах уу гэдгээ яг нягтлан бодох бүртгэлийнх нь хувьд энийг нөгөө алдаа нь залруулагдаагүй алдаа байгаа учраас энэ асуудлыг энэ тайландаа оруулж бичээд байгаа юм. Түрүүн таны асуусан нэг асуудал дээр энэ жилийн энэ тайлангаар 26...

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд.

Л.Соронзонболд: Оройн мэнд дэвшүүлье ээ. Энэ Монгол банкны 2024 оны тайлангаар Засгийн газрын мөнгөн хөрөнгө 6.8 их наяд төгрөг байгаа юм. Харин одоо Засгийн газрын нэгдсэн санхүүгийн тайланг харахаар зүгээр яах вэ ойролцоо тооцоолохоор 8.5 их наяд төгрөг төрийн сан болон төсөл сангийн хөрөнгөөр байршиж байна аа. Ингээд харахаар зөрүү 1.7 их наяд төгрөг бол гарч ирээд байгаа юм. Энэ одоо ямар учиртай хаана байршиж байгаа вэ? Төрийн сангийн хөрөнгө

зөвхөн Монгол банкн дээр байршиж байгаа юу? Өөр арилжааны банканд байршдаг уу? Төсөл сангийн хөрөнгө Төрийн сан дээр байршдаг юм уу, эсвэл бас тусдаа арилжааны банкн дээр байршдаг уу гэдэг ийм асуулт байна.

2 дугаар асуулт болохоор бол энэ Засгийн газрын өрийн хэмжээнд ордоггүй ТӨҮГ болон орон нутгийн өмчийн үйлдвэрийн газруудын нийт өр төлбөр 22 их наяд болжээ. Үүн дотроо богино хугацаат өр төлбөр буюу одоо нэг жилийн дотор төлөгдөх гэж байгаа өр төлбөр 8 их наяд төгрөг байна аа. Энэ болохоор бол ер нь цаашдаа энэ төрийн өмчийн компаниуд хэрвээ сайн орлоготой ажиллаж чадахгүй бол энэ өрийн төлбөрөө төлөхөд хүндрэл учирч болохоор харагдаж байна аа. Тэгэхээр энэ дээр одоо ер нь манай одоо Засгийн газар ер нь ямар бодлого барьж ажиллах гэж байгаа юм бэ гэдэг.

3 дугаар асуудал болохоор бол энэ зарим улсын төсөвт үйлдвэрийн газар болон төрийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд Засгийн газраас баталсан цалингийн ангилал шатлалыг мөрдөхгүйгээр ингээд цалин орон тоогоо батлаад байна аа. Энэ нь болохоор бол нийт зардалд их хувь эзэлжээ гэсэн байна. За энэ дээр Засгийн газар ер нь ямар арга хэмжээ авах гэж байгаа юм бэ?

4 дүгээр асуулт болохоор бол энэ улсын хэмжээнд зураг төсөв боловсруулах энэ төсөл боловсруулахад нь маш их хэмжээний төсвийн мөнгө зарцуулсан байна аа. Үүнийг одоо улсын хэмжээнд хөрөнгө болгож бүртгэсэн үү. Хэдэн төгрөгийн асуудал байдаг юм болоо гэж. Хугацаа нь удсан ямар ч ашиглах боломжгүй болсон одоо хэдий хэмжээний ийм хэдэн төгрөгийн зураг төсөв одоо ингээд улсын хэмжээнд бүртгэлтэй байдаг вэ гэдэг нэг ийм асуулт байна.

Дараагийн асуудал болохоор бол Үндэсний аудитын газраас энэ Засгийн газрын гадаад зээл ашиглалтын 239.4 тэрбум төгрөг бол эдийн засаг болоод нийгмийг ямар ч үр өгөөжгүй, үр өгөөж багатай салбарт зарцуулсан байна аа гэсэн. Энэ одоо ямар салбарт зарцуулсан хөрөнгө байсан юм бэ гээд нэг асуулт байгаад байгаа.

Дараагийн асуулт бас Үндэсний аудитын газраас төсөв дээр авах боломжгүй боловсон хүчнийг төсөвт тусгуулж, цалингийн сангаа нэмэгдүүлээд, урамшуулал одоо ажиллаж байгаа ажиллагсдынхаа цалинг нэмэгдүүлэхэд зарцуулдаг байдал өөрчлөгдсөн үү гэдэг нэг ийм асуултыг бол Үндэсний аудитын газраас асууя аа. Сүүлийн 2 асуултыг нь Үндэсний Аудитын газраас.

Х.Булгантуяа: За эхлээд Сангийн сайд Болдын Жавхлан хариулах уу?

Б.Жавхлан: Газраас хариулсан нь зөв байх аа.

Х.Булгантуяа: Үндэсний аудитын газар хариулах уу? За Үндэсний аудитын газар эхлээд хариулъя. 4 номерын микрофон дээрээс. Соронзонболд гишүүн маш олон асуулт асуулаа шүү дээ. Та бүхэн бичиж авсан байх. Сангийн сайд хэн хэн хаанаас хариулах юм? За алив юу яагаадахаач.

Б.Жавхлан: Тэр төрийн сантай холбоотой асуултыг Ганбат дарга эсвэл Цогбадрах дарга 2 хариулна. Төрийн өмчийн компаниудын өр авлагатай холбоотой

тэр менежменттэй холбоотой асуултыг ТӨБЗГ-ын дарга хариулах ёстой. Хариуцсан хариуцсан ажлаа хийгээд яваарай.

Х.Булгантуяа: Одоо ингээд бүүр асуултад хариулах хүнгүй болчих юм байна л даа. За 3 номерын микрофоноос төрийн сан эхлээд хариулчих, дараа нь ТӨБЗГ 4 номерын микрофон дээрээс хариулахад бэлдэж байгаарай. Дараа нь Аудитын газар хариулахад бэлдэж байгаарай.

Б.Цогбадрах: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Цогбадрах байна аа. За Засгийн газрын нэгтгэсэн тайлан бол мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 14.5 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй гарснаас Монгол банканд байгаа төрийн сангийн үлдэгдэл бол 4.3 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл. Тийм мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бол.

Х.Булгантуяа: Чанга ярь чанга.

Б.Цогбадрах: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2.5 их наяд төгрөгөөр өсөхөд төрийн сангийн үлдэгдэл бол 947.3 тэрбум төгрөгөөр, төсөл сангийн үлдэгдэл 2.7 их наяд төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчид оролцоотой хуулийн этгээдийн үлдэгдэл 1.3 их наяд төгрөгөөр тус тус өссөн нь бол мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн. Төрийн сангийн үлдэгдлээс Монгол банканд бол 4.3 их наяд төгрөг оны эцэст гарсан. Өөр болон нөгөө Засгийн газрын нэгтгэсэн тайланд бол төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд болон төсөл сангууд бас энэ дээр нэмэгдэж орж байгаа. Тэд нар нь бол арилжааны банканд дээр байгаа.

Х.Булгантуяа: ТЭЗҮ-тэй холбоотой 4 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Ер нь 2020 оноос эхлээд бид нар яг Барилга, хот байгуулалтын сайд дараа нь Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад дараа онуудад хийх хөрөнгө оруулалтын ажлуудын энэ ТЭЗҮ зураг төсвийн багцыг батлагдсан. 2020 оноос хойш өнөөдрийг хүртэл нийтдээ 493 тэрбумыг ТЭЗҮ зураг төсвийн санхүүжилт нь батлагдсан. Сангийн яаман дээр яг энэ ТЭЗҮ зураг төсвөөр ямархуу энэ ТЭЗҮ зураг төсвийн яг нийт барилга байгууламж хөрөнгө оруулалтын өртгүүд нь бол л яг 9.9 их наяд байгаа.

Эдгээрээс хууль дээр тусгагдаад батлагдаад явж байгаа нь бол 2 их наядын ажлуудыг бид нар буцаагаад хөрөнгө оруулалтын ажлуудад тавиад явж байгаа. За яг энэ 2020 оноос хойш багцууд дээр батлагдсан ТЭЗҮ, зураг төсвийн үр дүн, хэрэгжилтийн судалгааг бол нэгдсэн байдлаар танд гаргаад 2026 оны төсөвтэй уялдуулж оруулж ирэхээр ингээд хийгдээд явж байгаа.

Х.Булгантуяа: Үндэсний аудитын газраас хариулъя. Хэрэг эрхлэхийн дарга энэ ТӨБЗГ-аас хүн баймаар байна. За 4 номерын микрофоныг өгье.

Ц.Наранчимэг: Гишүүний асуултад бас хариулъя. Засгийн газрын гадаад зээлийн ашиглалтын 239.4 тэрбум төгрөгийн 9.9 хувийг эдийн засгийн үр өгөөж багатай салбарт ашигласан байна аа гэж аудитын байгууллагаас үзсэн байгаа. Үүний 2.3 нэгж хувийг бол нийгмийн халамж, 3.4 хувь нэгжийг онцгой байдлын

салбарт, 3.5 хувийг засаглалын салбарт, 0.8 хувийг БОАЖ-ын салбарт ашигласан байгаа.

Аудитын байгууллагаас юу гэж харсан бэ гэхээр энэ одоо өрийн менежментийн үр ашгийг сайжруулахын тулд энэ зээлийг дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, ХАА зэрэг ирээдүйд татварын орлого болон өсөлтийн суурь болох нийгмийн болон эдийн засгийн үр өгөөжтэй салбарууддаа зарцуулсан болбол одоо бүтээмж өндөртэй байх байсан байна аа гэж ингэж дүгнэсэн байгаа.

Х.Булгантуяа: Соронзонболд гишүүн нэмж тодруулъя.

Л.Соронзонболд: Яах вэ би нөгөө төрийн сангаас асуугаад байгаа нь Монгол банкны би 2024 оны тайланг уншихаар Засгийн газрын хөрөнгө гээд 6.8 их наяд төгрөгийг өөрсдийнхөө Монгол банкныхаа баланс дээр 6.8 их наяд төгрөг тавьчихсан байгаа байхгүй юу. Тэгээд Засгийн газрын нэгдсэн санхүүгийн тайлангийн болохоор бол яг одоо Төрийн сангийн Монгол банканд байршуулж байгаа хөрөнгө нь ойролцоогоор тийм байх гээд. Төсөл сангийн мөнгө нь гээд бодохоор 8.5 их наяд төгрөг гарч ирээд ингээд зөрүү 1.7 их наядыг тодруулж асуугаад байгаа юмаа.

Тэгээд Төрийн сан мөнгөө Монгол банкнаас өөр газар байршуулдаг юм уу гээд асууж байгаа юм. Сая ингээд Цогбадрах даргын уншихыг сонсохоор 4.3 их наяд төгрөг гэхээр чинь бараг 2.5 их наядын зөрүү гарч ирээд байна шүү дээ бүүр дахиад. Тэгэхээр ингээд жоохон ойлгомжгүй хариулаад энийгээ тодруулъя аа гэж бодож байна. Тэгээд тэр Үндэсний аудитын газар болохоор энэ Засгийн газрын нэгдсэн санхүүгийн тайланг гаргахдаа энэ ТӨҮГ болон Орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн сан, төсөвт байгууллага, тэгээд төсөл сан гэдэг энэ байгууллагын ангиллаараа задлаад энэ санхүүгийн тайлангуудыг нь дэлгэрэнгүй гаргачихвал асуулт асуухад их амар болох юм байна. Тэгэхээр энийг анхаараарай гэж хэлмээр байна.

Х.Булгантуяа: 3 номерын микрофон дээрээс Төрийн сан нэмж хариулах уу. Монгол банкны тайлан энэ төсвийн гүйцэтгэлийн тайлан хоёр 2.5 орчим их наяд байна. Тиймээ Соронзонболд гишүүн. Зөрүүтэй байгаад байна аа. Тэр мөнгө хаана байна вэ гэж байна.

Б.Цогбадрах: Засгийн газрын нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бол 14.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гэж тайлагнагдсанаас төрийн өмчит үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5.4 тэрбум их наяд төгрөг.

Х.Булгантуяа: Жоохон чанга ярья.

Б.Цогбадрах: Төрийн сангийн үлдэгдэл 4.3 их наяд төгрөг, төсөвт байгууллагын үлдэгдэл 2 их наяд төгрөг, төсөл сангуудын үлдэгдэл 7.8 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна аа ангиллаар.

Х.Булгантуяа: Тэгээд тэр нь Монгол банкныхаа дүнтэй нийцэж байгаа юм уу?

Б.Цогбадрах: Би яг Монгол банкны үлдэгдлийг бол мэдэхгүй байна.

Х.Булгантуяа: 6 аравны хэд гэлээ Соронзонболд гишүүн. 6.8 их наяд гэж гарсан байна Монгол банкны болохоор тайлан дээр. Та бүгдийн хэлээд байгаа чинь 4 аравны хэд байгаад байна шүү дээ. За тэндээс төрийн сан нэмж хариулъя. Ажлын хэсгээс. 3 номерын микрофон.

Н.Мөнхсүх: Соронзонболд гишүүний асуултад хариулъя аа. Сангийн яамны Төрийн сангийн газрын хэлтсийн дарга Мөнхсүх байна аа. Манай Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд бол нийтдээ 16 банкны 14.2 их наяд төгрөг одоо тайлагнагдсан байгаа. Энэний 6.3 их наяд нь болбол бид нар Монгол банканд байршиж байгаагаар тайлагнасан. Түрүүн манай Цогбадрах даргын хэлсэн одоо үлдэгдлүүд болбол нөгөө байгууллагынхаа төрлөөр авч үзэхээр ингэж гараад байгаа. Яг банк банкаар нь болбол биш манай одоо Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан өөрөө ямар төрлөөр гарч байгаа вэ гэхээр төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, төрийн сан, төсөвт байгууллага, төсөл сангууд гэсэн ийм төрлөөр гарч байгаа. Ингээд 14.5 тэрбум төгрөг. Орон нутгийн болон төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн газруудад 5.3 их наяд төгрөг, төрийн сан дээр болбол 4.3 их наяд нь тайлагнагдаж байгаа. Төсөвт байгууллага дээр бол 2 тэрбум төгрөг нь...

Х.Булгантуяа: 3 номер нэмж хариулъя.

Н.Мөнхсүх: Төсөвт байгууллага дээр бол 2 их наяд, төсөл сангууд дээр 7.8 их наяд төгрөг тайлагнагдаж байгаа. Тэгээд орон нутгийн төрийн болон орон нутгийн өмчийн компаниуд бөгөөд төсөл сангуудын юунууд бол харилцах дансны үлдэгдлүүд болбол арилжааны банканд дээр бас байршдаг байгаа. Энэ нөгөө төсөл сангууд гэдэгт ордогт нь болбол мөн нөгөө юу нийгмийн даатгал, ЭМД-ын сангууд бас төсөл сан гэдэг ангилал дээр орж байгаа учраас нөгөө зарим нь бол арилжааны банканд байршиж байгаа.

Х.Булгантуяа: Соронзонболд гишүүн нэмж тодруулъя.

Л.Соронзонболд: Тэгвэл энэ төрийн сангийн хөрөнгө маань дангаараа Монгол банканд дээр байршдаг гэж ойлголоо зөв үү гэдэг 1 дүгээр асуулт байна. 2 дугаарт бол энэ төсөл сангийн хөрөнгө бас яг бүртгэлийн хувьд бол төрийн сан дээрээ байдаггүй юм байна тийм ээ тодорхой хувь нь гэж ойлгож болох уу. Би бол уул нь яах вэ нийгмийн даатгал, ЭМД-ын сан эд нарыг хасаад түрүүн асуугаад байгаа шүү дээ. Нөгөө Үндэсний баялгийн сангийн хөрөнгө чинь Монгол банканд дээр байгаа юм байна гэж ойлгоод тэгээд л асуусан юм түрүүн.

Х.Булгантуяа: Нэмж хариулах уу Төрийн сангийнхан. Саяын Соронзонболд гишүүний нэмж тодруулсан нь. Саяны ойлголт ер нь бол зөв байна аа гэж хэлсэн тиймээ Төрийн сангийнхан. Саяны Соронзонболд гишүүний нэмж тодруулсан, нэмж асуусан бол яг ийм учиртай юм байна аа.

УИХ-ын гишүүн Доржзовдын Энхтуяа гишүүн.

Д.Энхтуяа: Та бүхэндээ энэ үдшийн мэнд хүргэе. Ер нь болбол манай Монгол Улс маань энэ чөлөөт зах зээлийн эдийн засагт ороод бас 30 нас нэлээд давчихлаа. Харамсалтай нь өнөөдөр одоо угжнаасаа гараагүй байгааг саяын энэ Үндэсний аудитын газрын тайлангаас бас харж болохоор байна аа. Тэгэхээр сая аудитын

газрын тайланд дурдаж байна. 2024 онд Засгийн газрын өр ойролцоогоор 3 их наядаар нэмэгдсэн байна аа. Тэгэхээр энэ нь болбол 2023 онд 30.8 их наяд байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 33.4 их наяд төгрөг болсон байна аа. Энэ нь бол нэг ойролцоогоор нэг жилдээ нэг 10 хувиар нэмэгдсэн байна аа гэсэн ийм мөнгөн дүн харагдаж байна. Ер нь бол энэ манай улсын эдийн засаг болбол сэхээний тасагт хэвтэж байгаа. Ингэхдээ болбол гадаадын өр зээл гэсэн ийм л одоо ангилалд байна аа гэж ингэж одоо эдийн засагчид дүгнээд байна аа. Тэгээд энэ дээр энэ Засгийн газрын өр дээр би бас нэг ганц 2 тодруулах асуулт байна аа.

Энэ Засгийн газрын өрийн орон нутгийн өр гэдэг хэсэг дээр 2.5 их наяд төгрөгийн одоо өр зээл байна. Энэ өрийг болбол Улаанбаатар хотын одоо бүтээн байгуулалтад зарцуулахаар одоо төсөвт тусгачихсан байгаа. Би болбол Улаанбаатар хотын төсвийг бол батлалцаж байсан хүний хувьд болбол Монгол Улсын хүн амын 50 хувь амьдарч байгаа Улаанбаатар хотод болбол бүтээн байгуулалт явагдах ёстой. Хот болбол өнгө зүсээ сайжруулах ёстой, дэд бүтцээ сайжруулах ёстой, бүтээн байгуулалтын ажлуудыг бол хийх ёстой гэдэг дээр болбол дэмжиж ирсэн, цаашдаа ч дэмжих болно.

Энэ дээр болбол энэ 2.5 их наяд дээр зам засвар дээр болбол 200 тэрбум, Сэлбэ дэд төв дээр 1.7 их наяд, Бөөрөлжүүтийн одоо энэ Бөөрөлжүүт дээр 300 тэрбум батарей хураагуур 298 тэрбум гэсэн ийм мөнгөн дүн харагдаад байна аа. Энэ дээр хотын захиргаанаас хүн ирсэн бол 1 дүгээр асуулт энэ Сэлбэ дэд төвийн энэ бүтээн байгуулалтын асуудал дээр энэ хаваржингаа л ерөнхийдөө энэ Засгийн газрын ордны гадаа иргэд жагслаа. ААН-үүдэд болбол энэ Монгол улсуудын одоо татвар төлөгчдийн мөнгийг Монгол Улсад нь үлдээ, энэ бүтээн байгуулалтын ажилд одоо дотоодын компаниудыг оруул аа гэсэн ийм шаардлагыг тавьсан. Энэ шаардлагыг бол хотын захиргаа хүлээж авсан болов уу гэсэн 1 дүгээр асуулт байна.

2-т нь Эрчим хүчний сайдаас асууя. Батарей хураагуур дээр 298 тэрбум төгрөг төсөвлөсөн байна аа. Энийг хаана ямар юманд зарцуулчлав? Хэдэн мегаваттын одоо ийм батарей хураагууртай бүтээн байгуулалт хаана хийчихсэн бэ? Энэ дээр та хариулт өгөхгүй юү?

Х.Булгантуяа: Хотоос хэн хариулах вэ? Лхагвадоржийн Эрдэнэбадрах НЗДТГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга. 3 номерын микрофоноос хариулъя. Дараа нь Эрчим хүчний сайд хариулъя. Хот бүгдээрэнг нь хариулах юм уу? За тэгвэл хот бүгдээрэнг нь хариулах нь байна шүү. Саяын асуултуудыг хураагууртай хамтад нь.

Л.Эрдэнэбадрах: Гишүүний асуултад хариулъя. НЗДТГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Эрдэнэбадрах байна. Сэлбэ дэд төвийн багцыг бол бид нар 4 багц болгон хуваасан байсан. Өнгөрсөн эхний 2 багц бол тендер нь гэрээ байгуулагдчихсан байгаа. 3 болон 4 дүгээр багцыг бол бид нар дахин хуваасан байгаа гэсэн үг. Тэгэхээр 3 дугаар багц маань бол 609 тэрбум төгрөг байсныг нь дотор нь 3 багц болгож хуваасан байгаа. Тэгэхээр бэлтгэл ажлыг хангаад одоо тендерийг нь бол зарлахаар явж байгаа гэсэн үг. 4 дүгээр багцыг мөн адил 486 тэрбум төгрөгийг бол 2 багц болгон хуваасан байгаа. Тэгэхээр энэ ингэж хувааснаар бол дотоодын ААН-үүд бол энэнд хамрагдах боломжтой гэсэн үг.

Батарей хураагуурын төслийн хувьд энэ жил өнгөрсөн жил бол бид нар бондын санхүүжилтийн эх үүсвэрээр Засгийн газрын 264 дүгээр тогтоолын дагуу бол бид нар 298 тэрбум төгрөг гаргаад бүрэн санхүүжүүлээд, төсөл маань бол ашиглалтад орчихсон явж байгаа гэсэн үг. 50 мегаваттын төсөл.

Х.Булгантуяа: Хаана ямархуу хүчин чадалтай вэ гээд байх шиг байна.

Л.Эрдэнэбадрах: 50 мегаваттын хүчин чадалтай Багануур батарей хураагуурын станцыг бол бид нар ашиглалтад оруулсан байгаа.

Х.Булгантуяа: Энхтуяа гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтуяа: Тэгэхээр энэ батарей хураагуур дээр 298 тэрбум төгрөг төсөвлөөд одоо болбол ерөнхийдөө бүх бүтээн байгуулалт нь хийгдсэн гэж ойлголоо. Тэгээд Багануурын 50 мвгт гэж байна. Тэгэхээр 1 мегаваттын энэ үнэ ханш нь хэдээр тооцож байгаа юм бэ? Энэ бол нэлээн өндөр дүнтэй бараг ингээд бодоход болбол 4, 5 тэрбум төгрөг ингэж эхний юугаар багцаалсан дүнгээр бодогдож байна л даа. Тэгэхээр энэ хэр зэрэг одоо бодитой ийм мөнгөн дүнтэй бүтээн байгуулалт болсон бэ?

Х.Булгантуяа: Эрдэнэбадрах дарга нэмж хариулъя.

Л.Эрдэнэбадрах: 298 тэрбум төгрөгийн гэвэл 5 жилийн хугацаатайгаар бол бид нар гаргасан байгаа. Улаанбаатар Энержи гэдэг компани байгуулсан. Жилд бол бид нар батарей хураагуурын орлогоор бол 23 тэрбум төгрөгийн орлого олно гэж тооцоолсон байгаа. Одоогоор бол эрчим хүчээ нийлүүлээд бол төвийн шугамд нийлүүлээд бол орлогоо олоод явж байгаа.

Х.Булгантуяа: Нийслэлээс Засаг дарга энэ Онцгой комиссын үүрэг даалгавартай гээд оролцож чадахгүй байлаа гээд энэ Засаг даргын орлогч нараас чинь оролцож болохгүй байсан юм уу? Газрын дарга ганцхан газрын даргаа явуулчихсан байх юм.

УИХ-ын гишүүн Баатаржавын Мөнхсоёл.

Б.Мөнхсоёл: За бүгдэнгийнх нь оройн амрыг айлтгая. Тэгэхээр гишүүд зөндөө асууж байна. Энэ одоо яг хаанаас нь яаж хэлмээр юм бэ гээд. Бид нар төсвийн одоо өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон ирэх оныхоо төсвийн тухай хууль гээд энэ болгон дээр хараад яриад байгаа зүйлүүд ерөнхийдөө давтамжтай байна гэж харж байна. Тэгээд аль аль талдаа сайд нар засгаа тэгээд УИХ-ын гишүүд энэ одоо албан хаагчдыг нэг тийм үр дүнгүй ийм залхаасан маягтай давтамжтай асуултууд жил болгон яваад, гадаа бас иргэд олон нийт бид нарт итгэх итгэл улам бүүр муудаад хэцүү байна. Тэгээд татвар одоо жишээлбэл татварын багц хууль орж ирье. Эсвэл одоо НДШ-ийн сан гээд энэ болгоныг ярих гэхээр, бууруулах гэхээр энд одоо төсвийн орлого буурахгүй сангийн мөнгө хэцүүднэ гэдэг. Гэтэл нөгөө талдаа энэ төсвийн орлого зарцуулалтын тайланг харахаар төсвийн гүйцэтгэл юу 2024 оны жишээлбэл төсвийн гүйцэтгэл харахаар үнэхээрийн бас харамсмаар зүйлүүд байна аа. Тэгэхээр одоо бүгдээрээ яах ёстой вэ? Ингээд жил болгон бие биеийгээ хуураад нэг юмыг яана. Нэг зүйлээ дахин дахин одоо тоог нь өөрчлөөд яриад байх юм уу яах юм нөгөө. Аягүй хэцүү юмаа.

Одоо энэ Сангийн яамны хүнийг харсан чинь бүүр өөртөө итгэлгүй бараг битгий сонсоосой гэсэн шиг микрофоноо дээшээ ч яаж чадахгүй арайхийж хариулж байна шүү дээ. Ямар хэцүү юм бэ. Та нарын ч буруу биш улс төрчид бас нөлөө үзүүлээд байгааг ойлгоод байна. За жишээлбэл Санхүүгийн үндэсний аудитын газар ч хэлчихлээ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч хэлчихлээ. Энэ хар аа төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайлан бол сая хэвлэгдэж ирлээ. 18 зүйл, 17 дугаар дээр жишээлбэл энэ юу гэсэн үг вэ. Засгийн газрын болон төсвийн захирагчид санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангаар нийт 15.7 их наяд төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Энэ нь өөрөөр хэлэх юм бол улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын 49.9 гаруй хувьтай тэнцэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр чинь энэ чинь маш харамсалтай байна аа. Энд хэлчхээд байна шүү дээ. Заавал гишүүд биднээс илүү ухаан шаардлагагүй байна. Энд хэлчихсэн энэ тайлангуудад. Засгийн газрын байгууллагуудын хувьд буюу нийт төсвийн захирагчид төсөв санхүүгийн сахилга батыг сахимаар байна, хууль тогтоомжийг мөрддөг баймаар байна, хариуцлага хяналтыг сайжруулмаар байна гээд байгаа юм. Чангатгамаар байна гээд байна, чангатгамаар байна. За энэ 17 өмнө нь бас Баярмаа гишүүн дурдаж асуугаад байх шиг байна. 12 байхгүй юу. Түрүүн ингээд янз бүр ингээд наагуур цаагуур оруулаад ингээд хүнийг улам ойлгомжгүй байдалд оруулаад хариулаад байх юм. Энэ 12 дээр хэлж байна шүү дээ. Жилийн эцсийн санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлээ тайлагнадаггүй, зөрүүтэй тайлагнасан, тайланд нэгтгүүлдэггүй минут дуусвал тодотгох нэг минутаа сунгаад авчихъя Булгантуяа дарга аа.

Х.Булгантуяа: Мөнхсоёл гишүүний минутыг нэмж өгье.

Б.Мөнхсоёл: Тэгээд тайлагнасан тайланд нэгтгүүлдэггүй, төсвийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлдэггүй, зориулалтын бус зүйлд үр ашиггүй зарцуулсан, ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү дутуу тооцож олгодог, сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшил олгодог, татвар суутгаагүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтгүй энэ тэр гээд бүүр бүх боломжит хувилбар бүхий алдаа зөрчлүүдийг дурдаад, бодлогын дүгнэлтийн зөвлөмжийг дор бүр нь өгчихсөн байна. Тэр 18 алдаа зөрчил болгондоо. Дандаа хэлдэг юм. Нөгөө Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль зэрэг хууль тогтоомжуудад энэ талын харилцааг шинээр авч үзэж шинэчлэн тусгах шаардлагатай байна.

Төсвийн сахилга батыг сайжруулж, төсвийн хөрөнгийг үр ашигтай ашиглах төсвийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгамаар байна гэж байгаа байхгүй юу. Тэгээд 1 минутаа нэмээд авчихна. Тэгээд ер нь болбол бүх энэ жил жилийн дараа төсвийн үр дүн, гүйцэтгэл, тайланг хэл...

Х.Булгантуяа: Мөнхсоёл гишүүн хариулт авч байгаад шаардлага хангахгүй байна аа гэж үзвэл 2 дахь удаагаа нэг минут авч болно. Саяын энэ дүгнэлтийг харсан чинь их сэтгэлээр унамаар байна, яаж сайжруулах вэ Сангийн сайд аа гэнэ ээ тийм. төрийн сангийн аудит хариулах уу? Тэгээд энэ зөвлөмжүүд нь ерөөсөө амьдрал дээр буухгүй байгаад байна аа. Ажил хэрэг болохгүй байна аа жилээс жилд л ийм зөвлөмжүүд өгөөд байна аа. Гүйцэтгэл их муу байна аа, үүнийг яаж сайжруулах вэ? Ингээд одоо нөгөө олон янзын акт зөвлөмжүүд өгөөд байдаг тэрүүний хэрэгжилт их муу байна. Тэгээд энэ эс үгүй бол Аудитын тухай хууль чинь

болохгүй байгаад байна уу, юу нь яаж сайжруулах вэ л гэдэг гол асуултыг асууж байна тийм Мөнхсоёл гишүүн. 4 номер.

Ц.Наранчимэг: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Бид нар нийт зардалд аудитаар илэрсэн алдаа зөрчлийн илрүүлэлтийг 2020-2024 он хүртэл бас харьцуулалтын судалгаа хийж дүгнэлт хийсэн. 2028 онд бол нийт урсгал зарлагын 18.9 хувийг эзэлж байсан бол 2024 онд 34.5 хувийг эзэлж байгаа. Тэгэхээр эндээс бас ямар дүгнэлтийг хийж байгаа вэ гэхээр саяын Мөнхсоёл гишүүний хэлсэн тоо бол төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад хийсэн алдаа, зөрчил 2-ыг нийлүүлсэн одоо дүн байгаа. Түрүүн хэлсэн алдааг бол нягтлан бодох бүртгэлийн алдааг бол бид санхүүгийн тайланг баталгаажуулахдаа залруулаад явж байгаа. Тэгэхээр эндээс ямар дүгнэлт хийж байна вэ гэхээр энэ гараад байгаа анхан шатын бүртгэлтэй 6200 гаруй төсөв захирагчийн нийт зөрчил нэгтгэж энд дүн нь орж ирж байгаа.

Тэгэхээр шат шатны төсөв захирагч нар одоо Засгийн газар гэхээсээ илүү шат шатны төсөв захирагч нар өөрсдөө Төсвийн тухай хуулиар хүлээсэн үүрэгтэй байгаа. Тэнд ажиллаж байгаа санхүүгийн ажилтнуудыг нөгөө сонгуулийн жилийн дараа байгууллагын удирдлага солигдохоор санхүүгийн ажилтнууд солигдоод байгаа нь анхан шатны баримтын бүрдэл дутуу ч гэдэг юм уу манай тайлан бол дараа жилд нь хийгддэг тайлан учраас өмнөх хийсэн санхүүгийнхээ ажлуудыг аудит очихоор зөв тайлбарлаж чадахгүй, баримт нь дутуу, хаанаас энэ одоо зөрчлүүд гараад байгаа учраас энэ тал дээр бас төрийн аудитын байгууллага анхаараасай гэж бодож байгаа.

Дараагийн асуудал нь бол манай хуульд хязгаарлалттай санал дүгнэлт авахад хариуцлага тооцдог байсан энэ хуулийн санкц бол байхгүй болсон. Сөрөг дүгнэлт авбал хариуцлага тооцно, татгалзсан дүгнэлт авбал ажлаас халах албан шаардлага өгдөг ийм хуулийн одоо зохицуулалттай болсон байгаа юм. Тэгэхээр энэ аудитын байгууллагаас өгч байгаа зөвлөмжийг энэ албан шаардлагыг төсөв захирагч 1 дүгээр гарын үсэг зурж байгаа хүмүүс өөрсдийнхөө хариуцлага гэж үзэхгүйгээр зөвхөн санхүүгийн ажилтны одоо гаргаад байгаа алдаа мэт ойлгоод, гаргаж байгаа тушаал шийдвэрүүд нь бас буруу гараад, төрийн болон орон нутгийн өмчөөр ажил үйлчилгээ худалдаж авах хуулийг зөрчсөн шийдвэр гаргаж байгаа энэ асуудал дээр болбол төсөв захирагч нар илүү хариуцлагатай хандах ёстой гэсэн аудитын байгууллага бол ийм дүгнэлт хийж байгаа.

Х.Булгантуяа: Мөнхсоёл гишүүн нэмж нэг минут.

Б.Мөнхсоёл: Үндэсний Аудитын газрын хүн маань маш боломжийн зөөлөн ойлгомжтой, нэг хаа газар юу унахааргүй аятайхан хариулах гээд хичээгээд байна шүү дээ. Сангийн сайдыг бас ойлгоод байна аа. Бүх сайд нар буюу төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв бариад гүйнэ, батлуулах гэж гүйнэ. Монгол жижиг танилын нүүр халуун хэцүү. Энд харин бид бүгдээрээ биеийгээ таниад бас амаргүй хариуцлага хүлээнэ. Тэгэхдээ гадаа хүмүүс амьдрал хэцүү байгаад байна, яаж бүгдээрээ төсвийн сахилга батыг сахидаг болох вэ боломжит хэмжээгээр 100 хувь биш юмаа гэхэд гэдгийг л тодорхой асуумаар байгаа юм. Үүний тулд хариуцлагын механизм чухал.

2 дугаарт энэ гаргаж байгаа тайлан болгон дээрээ гүйцэтгэлийн үр дүнгээ чанар тоо хэмжээний хувьд зарцуулсан төсөвтэй нь уяж тайлагнадаг болмоор байгаа байхгүй юу. Гэх мэт хүн ингээд харангуут ойлгомжтой үнэхээрийн тэр сайдын багц сайн зарцуулагдсан, үр дүнтэй нөгөөдөх нь үгүй байна гэдгийг харьцуулахуйц баймаар байна. Ядаж нөгөөд нь үлгэрлүүлье, харьцуулъя, барьцуулъя, өрсөлдүүлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Сая Мөнхсоёл гишүүн санал хэлэх шиг боллоо. Мөнхсоёл гишүүний бас гишүүн болоод ажиллаж байгаа манай ажлын хэсэг дээр энэ гүйцэтгэлийн ер нь бол энэ тайланг жилд ганцхан удаа ингээд хэлэлцээд өнгөрдөг биш ер нь хагас жилээр хэлэлцэх нь зүйтэй юм байна аа гэж олон улсын байгууллагууд бол зөвлөмж өгсөн байна лээ.

Тэгэхээр УИХ-ын чуулганаар ганцхан нэг удаа ингээд хэлэлцээд өнгөрдөг биш хэрвээ хагас жилд нь бид нар хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хэрэгжилтийн байдал, ингээд дээрээс нь нэмээд зөрчлүүдийн хэрэгжилтийг одоо араас нь хяналт тавьж байгаа байдал, аудитынх нь бас тайлангаа оруулж ирээд УИХ-аар холбогдох Байнгын хороодуудаар хэлэлцээд явбал энэ хэрэгжилт бол илүү үр дүнтэй болох байх аа гэж бас харж байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар одоо манай ажлын хэсэг ер нь хууль нь бол бичигдчихсэн байж байгаа. Тэгээд үүн дээр бол бид нар бас хагас жил тутамд УИХ холбогдох Байнгын хороод хэрэгжилтийг авч хэлэлцдэг байаа. Төсвийн хэрэгжилтийг гэж бас оруулж байгаа. Ингэснээр бас илүү их сайжрах болов уу гэж харж байна. УИХ-ын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн. Бадамсүрэн гишүүн байхгүй байна. УИХ-ын гишүүн Мандхай.

М.Мандхай: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. За хөгжлийн бодлого төлөвлөлтөд нийцээгүй энэ хөрөнгө оруулалтыг төсөвт тусгадаг асуудал бол бараг хэвийн үзэгдэл болсон юм байна аа гэж харагдаж байна. Жишээлбэл төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсвийн төсөлд нь нийцүүлэн өөрчилдөг байдал бол одоо давтагдсаар байна. Уг нь бол бид нар төсвийн хүрээний мэдэгдэлд одоо уялдуулж тухайн жилийнхээ төсвийг төлөвлөдөг баймаар байтал эсрэгээрээ явж ирсэн байна. Энийг нэг тодорхой жишээгээр бас хэлье гэж бодож байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд бол 2010 оноос хойш нийт 18 удаа, сая 2025 оны энэ УИХ-д өргөн мэдүүлсэн шинэчлэлийн төслөөр хамруулах юм бол 19 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж ирсэн байна аа.

Энэ нь өөрөө энэ суурь, одоо энэ хуулийн суурь тогтвортой байдал алдагдсан, эрх зүйн орчин тогтворгүй байдлыг бол үүсгэж байгааг харуулж байна. Тэгээд энэ дээр нэг би жишээ хэлмээр байгаа юм. 2024 оны төсвийн тодотголоор төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан 342.6 тэрбум төгрөгийн зардал нь Хөшигийн хөндийн туннелийн байгууламж, Өөдөө тэмүүлэх Монгол to Mongolia, Ган татлагат гүүрэн байгууламж, Шинэ тойрог зам, Улаанбаатар хотын шинэ их тойруу хурдны зам төсөл, Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төсөл Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор зэрэг төслийн зөвхөн урьдчилсан ТЭЗҮ, зураг төсөв, одоо зөвлөх үйлчилгээ зэрэгт санхүүжилтүүд бол зарцуулагдахаар тооцсон байгаа юм. Гэхдээ энэний ихэнх шинэ төслийн эхлэх дуусах хугацаа нь тодорхойгүйгээс гадна эдгээр төсөл Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсыг 2024 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд огт тусгагдаагүй байгаад байгаа.

Энэ нь өөрөө юу гэж хэлж байна гэхлээр төсвийн хүрээний мэдэгдэл жилийн төсвийн төлөвлөлт хөрөнгө оруулалтын урт хугацааны бодлогод бол тодорхой бус байдал үүсгэж байна аа. Улсын одоо энэ санхүүгийн сахилга бат зах зээл дэх одоо энэ итгэлцэл бас сулрах ийм эрсдэл үүсгэж байгааг бол харуулж байна. Тэгээд энэ Сангийн яам нь бас яагаад энэ одоо Үндэсний аудитын газраас өгсөн жил бүрийн зөвлөмж шаардлагуудыг ийм хангалтгүй гүйцэтгэж байгааг бол одоо бас цаашид анхаарах хэрэгтэй. Тэгээд би ийм хэдэн асуулт асуумаар байна аа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулах болсон гол шалтгаан үндэслэл нь юу юм бэ? Тухайн нэмэлт, өөрчлөлтүүдийн аль нь бодлогын, аль нь техникийн шинжтэй талаар бас ангилж үнэлэлт дүгнэлт хийсэн үү? Төсвийн хүрээний мэдэгдэл нь тухайн жилийн батлагдсан төсөвтэй тогтмол нийцэхгүй уялдахгүй байгаа зөрчлийн гол шалтгаан нь яг юу юм бэ? Үүнийг засах механизмууд механизмыг хэрэгжүүлж байгаа юу? 4 дүгээрт хууль тогтоомжийн байнгын өөрчлөлтөөс үүдсэн төсвийн одоо төлөлтийг тодорхойгүй байдал нь хөрөнгө оруулалтын үр ашиг хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бий болгож байна гэж харж байна аа.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Мэдээж төсөв бол энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэйгээ яг нийцэж явдаг. Тийм учраас Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хуулийг Монгол Улсын Ерөнхий сайд Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд өргөн мэдүүлэхээр Үндэсний хороотой буюу яамгүй одоо сайд нарыг цомхотгох, тэгээд цаашлаад тэр Үндэсний хороо, зөвлөл, комисс шаардлагатай хэмнэлтүүдийг хийх ийм санаачилга гаргаад оруулаад ирэхэд Төсвийн тогтвортой байдлын хуулиараа байдаг нөгөө 4 тусгай шаардлагын нэг шаардлагыг нь давж чадахгүй буюу хуулийн хийдэл үүсээд байсан. Энэ юу вэ гэхээр мэдээж төсвийн сахилга батыг бий болгоход төсвийн хариуцлагатай байдлыг бий болгоход энэ төсвийн тогтвортой байдлын хууль бол маш том одоо хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Тийм ч учраас цаашдаа бол энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийг өөрчлөөд байх нь өөрөө ер нь зохимжгүй. Гэхдээ сая энэ тохиолдолд бол Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хуулиар нөгөө 3 сайдаа чөлөөлөөд түүний дэргэд байсан Ажлын алба тэр орон тоо, урсгал зардлыг нь хэмнэе гэтэл Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хуулиа дагуулаад нөгөө төсвөө барья гэхээр 3 сарын хугацаанд Төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас хойш 3 сарын хугацаанд төсөв төсвийн тодотголыг өргөн барихыг Төсвийн тогтвортой байдлын хуулиар хориглочихсон.

Хэрвээ тэр Төсвийн тогтвортой байдлын хуульд магадгүй тухайн жилийн ч гэдэг юм уу тодотгочихсон байсан бол тэр төсвийг өргөн бариад ингээд тодотголоо бариад Их Хурлаар батлуулах нь болно. Гэтэл яг энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагын заалтыг уншихаар юу гэж ойлгож байгаа вэ гэхээр төсвийн хүрээ батлагдчихсан бол 3 сарын хугацаанд тодотгол барьж болохгүй ээ гээд ингээд зохицуулчихсан. Тэгэхээр 5 сарын 31-нд бид Их Хурлаар энэ төсвийн хүрээний мэдэгдлийг баталсан шүү дээ. Тэгэхээр 8 сарын 31 хүртэл Ерөнхий сайд нөгөө бүтэц дээрээ өөрчлөлт хийх ийм ямар ч бололцоогүй ингээд зүгээр царцаагаад байгаад бай гэдэг ийм байдал руу яваад байдаг. Гэтэл нөгөө нөгөө ул уурхайн бүтээгдэхүүний үнэ нь ингээд өдөр тутам унаад байдаг. Тийм учраас

болбол зайлшгүй одоо тодотгол хийгээд тодорхой хэмнэлт гаргаад явахаас өөр гарцгүй.

Мэдээж цаашдаа болбол хөгжлийн бодлого төлөвлөж байгаа гэдэг утгаараа экспортыг нэмэгдүүлэх, тэгээд ч дээрээс нь сая Мандхай гишүүний хэлж байгаа энэ мега төслүүдийг болбол зайлшгүй эрэмбэлэх шаардлагатай болж байгаа. Бид өнгөрсөн жил болбол нөгөө төсөв оруулж ирэхэд бол цаг нөхцөл байдал бол их өөр байсан шүү дээ. Одоо болохоор энэ эдийн засгийн томоохон сорилтууд энэ олон улсын худалдааны дайн, энэ тарифын нөхцөл байдал болбол зайлшгүй бид нар энэ төслүүдээ эрэмбэлэх шаардлага үүсэж байгаа юм.

Тийм учраас 14 шалгуур үзүүлэлтээ дээр нь энэ хөтөлбөрт багтсан төслүүдээ эрэмбэлээд бүүр зогсох гэхээсээ илүүтэйгээр одоо эхлүүлчихсэн байгаа нэг 4 төсөл байгаа. Дээрээс нь одоо санхүүжилт огт шийдэгдээгүй. Гэхдээ одоо төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж болох боломжтой дахиад нэг 5 төсөл хүлээгдээд байдаг. Дахиад үлдсэн 5 төсөл дээр нь бид нар бас одоо 14 шалгуур үзүүлэлтээр үнэлээд эхлэхээр болбол шууд одоо хөрөнгө оруулалт шаардлагатай ийм төслүүд байгаад байна.

Тэгэхээр ер нь бол эдгээр төслүүдээс зайлшгүй нэг 10 төслийг болбол хойшлуулах шаардлага бол зүй ёсоор тавигдаж байгаа юм. Зүгээр 5 төслийн хувьд болбол жишээ нь төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтойгоор ажлын даалгаврыг нь боловсруулаад, хөрөнгө оруулалт татах одоо нэг шинэ арга замууд хайгаад ингээд явж болно. Зүгээр нийслэл дээр хэрэгжүүлэх төслүүд дээр хүртэл одоо бас нэг ийм хойшлуулах, шаардлагатай юмнуудыг нь зогсоох ийм л бодлого барина. Энэ ч утгаараа одоо төсвийн хүрээний мэдэгдлийг бид нар төсвийн тодотголтой хамт өргөн мэдүүлнэ ээ гэсэн үг.

Тэгэхээр төсвийн хүрээ ч бай, төсөв болбол яв цав нийцэж байх ёстой. Энэ утгаараа бол хэрвээ Их Хурлын гишүүд энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хуулийг дагасан Төсвийн тогтвортой байдлын хуулийг баталбал түүний дараа одоо төсвийн хүрээ, төсвийн тодотгол хоёроо зэрэг барина.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя. Тэгээд тодруулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын хууль маань өөрөө бол ер нь дандаа макро тоонуудыг хуульчилсан байдаг, макро тохироонуудыг. Тийм учраас та 2010 оноос хойш ярьж байна. Би бол 2020 оноос хойшхыг нь л сайн мэдэж байна. Тэгэхээр тэнд яг ковидын үеийн гол яг макро тохиргоонууд хийсэн байгаа. Хамгийн том тохиргоо болбол энэ алдагдал дээр байгаа. Ер нь нэг 5 жилийн одоо алдагдлыг 2018 онд орсон өөрчлөлтөөр хуульчилсан байдаг. Жил бүрийн алдагдал ингээд буураад явна аа гээд. Ингээд ковидын үед бол яах аргагүй энэ бол 2 жилээр бол хойшилсон байдаг. Харин хойшилсон хэдий ч 2025, 2022, 2023 онуудад бид алдагдалтай гаргана гээд байсан төсөв маань хуульчлагдсан боловч бид ашигтай гарсан байгаа. Ашигтай гараад тэнцлүүд маань ингээд сайжраад ирсэн. Тэгэхээр тэнд тийм одоо техникийн шинжтэй тохироо гэж бол ер нь бараг байхгүй дандаа ийм макро тохиргоонууд байгаа.

Харин сүүлийн жилүүдэд ноднин одоо жишээ нь тэнцвэржүүлсэн тэнцэл...

Х.Булгантуяа: Жавхлан сайдын микрофоныг нэмж өгье.

Б.Жавхлан: Суурь тэнцэл гэдэг мөн одоо ийм макро тохиргоо орж ирсэн байгаа. Тэр нь юу вэ гэхээр гишүүд хэлээд байна, нэлээдгүй бас сайн мэддэг болсон байгаа. Одоо зээлийн ашиглалт хүлээгдэж байгаа 12 их наяд, өөрөөр хэлбэл ирэх 5 жилийн дотор бид нар энэ 12 их наядыг төсөв дотор алдагдал болгож багтааж чадахгүй, ямар ч боломж байхгүй. Ингээд одоо алдагдалгүй төсөв гэдэг ийм дүрэм батлагдчихсан байгаа учраас. Тэгэхээр энэ дээр одоо цаашдаа мөн тохиргоо хийх ийм шаардлагууд гарч ирнэ ээ. Ноднингийн суурь тэнцэл бол бас үүнтэй холбоотой ийм макро тохиргоонууд юм байгаа юм.

Түрүүн та тэр аудитын дүгнэлтийг Сангийн яамтай холбоод хэлчих шиг боллоо. Тэр ташаа мэдээ юм шиг байна. 2020 онд онд намайг ажил авч байхад 66 хувийн ийм дүгнэлт авч байсан бол энэ жил өнгөрсөн жил 88 хувь, жил бүр сайжраад ирж байгаа. Миний ард одоо энэ нэг 4 мянга, бараг 5 мянган одоо Сангийн яамны харьяа байгууллагууд төрийн албан хаагч нар байна. Эдгээр бүх одоо багаараа ажилласны сайн үр дүн нь ингэж гарч ирж байгаа гэсэн үг. Энийг одоо би хэлээд яах вэ. Аудитын газраас аудитаас бас манай яамтай холбоотой дүгнэлтийг нэг хэлээд өгвөл сайн байна.

Х.Булгантуяа: Мандхай гишүүн нэмж тодруулъя.

М.Мандхай: Яах вэ аудитын газраас өгсөн зөвлөмжийг хангалтгүй гүйцэтгэж байгаа гэдгийг бас өөрсдийнх нь тайлан дээр биччихсэн байгаа учраас Аудитын газар өөрөө тэр тайлбараа хэлнэ биз. Энэ ер нь бол энэ тогтвортой байдлын одоо энэ хууль ерөөсөө тогтворгүй явж ирж байгаа дээр л хэлээд байгаа юм л даа. Бид нар одоо Тогтвортой байдлын тухай хууль ингээд боловсруулчихсан өөрөө энэ хэрэгжихгүй яваад байгааг л анхаараач ээ гэж хэлмээр байгаа юм. 14 шалгуур үзүүлэлт нь ихэвчлэн нийгэм эдийн засгийн үр нөлөө, үр өгөөж гэхээсээ илүүтэйгээр төслийн одоо энэ бэлэн байдалд суурилсан үзүүлэлтүүд байгааг бас анхаармаар байгаа юм.

Цаашид Үндэсний аудитын газраас гүйцэтгэлд бус одоо энэ өнгөрсөн хойно нь алдаа оноог нь дүгнэдэг байдлыг болиод илүү энэ төсөв төлөвлөгдөөд одоо дууссан үед нь төсөв батлагдахаас өмнө энэ аудит орж алдаа зөрчлийг нь илрүүлж зөвлөмж өгч болдоггүй юм уу? Тэгэх юм бол ядаж гишүүд ч гэсэн өмнө нь гаргаж байгаа энэ төлөвлөгөө дээр чинь харьцуулалт хийж...

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулах уу?

Б.Жавхлан: Тийм тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт орох дүрэмд өөрчлөлт орох, төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах 2 бол бас жоохон арай өөр шүү. Төсвийн хүрээний мэдэгдэл бол одоо энэ уул уурхайн эдийн засагтай улсад болбол ер нь жил, ялангуяа сүүлийн жилүүдэд энэ ковидын үетэй геополитикийн үетэй гадаад нөхцөл байдал ийм тодорхойгүй байгаа үед болбол төсвийн хүрээн дээр бол одоо гарцаагүй өөрчлөлтүүд орох шаардлагууд маш их гарч ирж байна аа. Одоо ч гэсэн одоо удахгүй баригдах төсвийн тодотголоор ч энэ төсвийн хүрээ одоо өөрчлөгдөж таарна. Ноднин яг өдийд 2025 оны төсвийг төлөвлөж байх үед бол орчин нөхцөл байдал бол шал өөр байсан. Төсөөлөл бол бүгд одоо өөдрөг ийм эерэг байсан. 9 сарын 1-нд өргөн барихад ч эерэг байсан.

Ингээд 11 сараас хойш болбол ингээд төсөөллүүд бол муудаж эхэлсэн байгаа. Ингээд одоо 5 сарын дунд үеэс 5 сарын одоо 14-ний. Тухайлбал одоо тэр өдрөөс хойш нөхцөл байдал бол огцом муудсан байгаа. Энэнтэй холбоотойгоор одоо орлогод нөлөөлөх сөрөг дарамт бол маш ихээр...

Х.Булгантуяа: Дахиад нэг минут тодруулах уу. Мандхай гишүүн нэмж тодруулъя.

М.Мандхай: Тэгэхээр би бол ингэж ойлголоо Жавхлан сайд аа. Төсвийн хүрээний мэдэгдэл гээд бид нар одоо үндсэндээ энэ төсвийн хүрээний мэдэгдэл бол байх шаардлага байгаа юм уу. Цаг үе өөрчлөгдөж байгаа учраас жил болгон одоо төлөвлөгөөгөө өөрчлөөд, төсвөө батлаад явдаг байх ёстой юм уу. Яг аягүй сонин хариулт л өгчихлөө л дөө. Энэ чинь хөрөнгө оруулалтын, аливаа хөрөнгө оруулалт чинь өөрийн гэсэн хөрөнгийн өгөөжтэй, ирээдүйн одоо энэ үнэ цэнээ тооцож чаддаг. Жишээ нь хаана ч компани ч гэсэн яг л ийм байдлаар л одоо төлөвлөгөөгөө гаргаад түүнийхээ дагуу хэрэгжүүлээд явж байгаа шүү дээ. Тэгэхээр одоо улсын төсөв тэгвэл бид нар энэ төсвийн хүрээний мэдэгдэл гээд хэлэлцээд байх шаардлага бас байгаа ч юм уу гэдэг одоо бас бодол төрж байна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Мандухай гишүүний асуултад хариулъя. Төсвийн хүрээ бол макро төлөвлөлт. Эдийн засгийн хөгжлийн яаман дээрээс гардаг ийм тоонууд. Төсөв бол энүүнийхээ хүрээнд бид төсвөө төлөвлөлтөө хийгээд явдаг. За яах вэ би ингээд яам, яамаар нь одоо хийдэг ажлуудаа ярьж байгаа юм. Тэрнээс биш энэ бол Засгийн газрын л бодлого эцэстээ бол энэ нэг л шийдвэр, нэг л төлөвлөлт, нэг л хөгжлийг дэмжиж явдаг ийм л зүйл юм байгаа юм. Тэгэхээр макро төлөвлөлтгүйгээр бид нар төсөв төлөвлөнө гэсэн ойлголт байж болохгүй. Тэгэхээр макро төлөвлөлт маань бол яах вэ одоо яг ийм хөгжиж байгаа орны хувьд ялангуяа ийм эдийн засаг нь өөрөө бол уур уурхайгаас хэт савлагаатай ийм хамааралтай, бидний энэ нөлөөлж чадахгүй. Бидний одоо урьдчилж төсөөлөх төлөвлөх боломжгүй гадаад орчин нөхцөл байдлаас хэт их хамааралтай ийм эдийн засгийн хувьд болбол одоо яах аргагүй бид өөрчлөлтүүдтэй тулж байгаа.

Ер нь бол яах вэ өмнөх 4 жилд бид одоо шинэ сэргэлтийн бодлого энэ одоо 4 жилийн эхэн дээр бид төлөвлөгөөгөө батлахдаа 14 мега төсөл гээд л ингэж байна. За энэ бүх одоо макро зорилтууд маань одоо...

Х.Булгантуяа: Эдийн засаг, хөгжлийн сайд Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Төсвийн хүрээний мэдэгдэл болбол энэ хөгжлийн жилийн төлөвлөгөөний санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах ийм бол агуулга зорилттой юм байна лээ. Тэгээд ер нь Эдийн засгийн хөгжлийн яам байгуулагдсаны зорилго бол энэ макро эдийн засгийнхаа чиг хандлагыг энэ хувийн хэвшлийнхэндээ ч гэсэн яг ойлгуулах чиг хандлагыг нь тодорхойлоход болбол чиглэдэг. Тийм учраас бид бол төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулснаараа цаашдаа ямар чиг хандлагатай байх вэ? Дээрээс нь энэ уур уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай улсад тухайн цаг үед хэрхэн одоо эдийн засагт ямар өөрчлөлт өгөх вэ гэдэг дээр тэр төсөв орлогынхоо дээд хэмжээг ч гэсэн тавьдаг. Дээрээс нь одоо тэр гол бүтээгдэхүүнийхээ үнийг ч гэсэн одоо хэдээр яаж тооцох вэ гэдгийг нь тавьж өгөөд

түүнд нь тохирсон төсвийг хийгээд энэ нь өөрөө жилийн төлөвлөгөөнд нь нийцдэг. Ингэсний үр дүнд болбол эргээд ийм үнэлдэг ийм тогтолцоо руу явдаг. Тийм учраас төсвийн хүрээний мэдэгдэл бол төсөвтэйгөө заавал одоо зэрэг орж ирж байж ингэж одоо хоорондоо нийцэж байх ёстой тийм.

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүн Бадамдоржийн Пунсалмаа.

Б.Пунсалмаа: Баярлалаа. 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай тогтоолын төслийг хэлэлцэж байна. 2024 он болбол бүхэлдээ их онцлог жил байсан л даа. Ковидын дараах жил байсан, сонгуулийн жил, мөн зуд турхан нүүрлэсэн ийм жил байсан. Үүнийгээ дагаад энэ ХАА-н салбар болбол бууралттай, боловсруулах үйлдвэр бас нэлээн хасах үзүүлэлттэй гарсан байна. Улсын төсөвт татварууд болбол нэлээн багасаж орж ирсэн байна. Нэмэгдсэн өртгийн албан татвар болбол 300-гаад тэрбум төгрөгөөр буурч орж ирж, НДШ бас мөн 300-гаад тэрбум төгрөгөөр буурч орж ирсэн байна. Гэтэл нэг татвар болбол ганцаараа өсөж өсөлттэй гарч ирсэн. Энэ бол онцгой албан татвар. Энэ онцгой албан татвар төлдөг ямар бүтээгдэхүүн орж ирсэн бэ гэсэн чинь автомашин. 122 мянган автомашин орж ирсэн байгаад байгаа юм.

Ерөөсөө жилийн дунджаар нэг 70, 80 мянган, 60-аад мянган автомашин орж ирдэг бол тухайн жил 120 мянган 122700 зуугаад автомашин орж ирсэн. Ер нь эдийн засгийн ямар бодлого хэрэгжүүлэхлээр ингэж гэнэт огцом машин импорт нь нэмэгдээд, машин ингээд маш олноороо ихээрээ орж ирэх ийм шалтгаан болдог юм болов оо. Энэ дээр одоо асуулт тавьж байна. 2 дугаарт нь болбол төсвийн зардал 3 их наяд төгрөгөөр болбол дутуу зарцуулагдсан байгаад байгаа юм. Урсгал зардлаас мэдээж тодорхой хэмжээнд бас зарцуулагдаагүй үлдсэн байна. Хөрөнгийн зардлаас 2.4 их наяд. Энэ 2.4 их наяд төгрөгөөр ер нь ямар ямар бүтээн байгуулалтууд тухайн жилдээ хийгдэхгүй үлдчихэв. Дараа жилийн энэ шилжих энэ хөрөнгө оруулалтын зардал эдгээр нь шилжиж орж ирсэн үү, эсвэл тухайн жилдээ ингээд хийгдэхгүй ээ гээд ингээд хаагдаад үлдсэн 2.4 их наяд төгрөг өө энэ төслүүдийн задаргааг авъя аа гэж бодож байна.

3 дугаарт нь ер нь 2024 оны төсвийг ингээд хэлэлцсэн, сонссон болоод ингээд батлаад өнгөрөх гээд байх шиг байна. Ер нь Засгийн газрын зүгээс ер нь 2024 оны төсөв, төлөвлөлт, гүйцэтгэл талаасаа ер нь бидэнд бас ямар санал дүгнэлт ер нь гаргаж ер нь дараа дараа жилийн төсөв тайлангууддаа анхаарч явах ийм дүгнэлтийг гаргасан байгаа вэ гэдэг ийм 3 асуултыг асууя аа.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос ажлын хэсэг хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр 3.8 их наяд батлагдсанаас бид нар 3.1-ийг бол гаргаад 80.3-ын гүйцэтгэлтэй гаргасан. 760 тэрбум бол улсын төсөвт буцаан төвлөрсөн. Үүнийг 3 ангилж үзэх юм бол тендерийн болон гүйцэтгэлийн хэмнэлт 58 тэрбум. 90 төсөл арга хэмжээ ял өмнөх одоо асуулт дээр хэлж байсан. Нийтдээ 712 төслийн 270 нь УИХ дээр батлагдсаны 90 төсөл нь гэрээ хийж амжаагүйгээс 358 тэрбум улсын төсөвтөө буцаагаад төвлөрсөн. Үлдсэн нь бол тухайн жилдээ гүйцэтгэлээ бүрэн хангаж чадаагүй байгаа. Тэгэхээр энэ тооцооллоос бол одоо бид нар хэмнэлт гэрээ байгуулаагүй дүнгүүд бол орж ирэх магадлал нь бол тун бага. 2026 оны төсвийн төсөл дээр гүйцэтгэл гараагүй үлдэгдэл

400-гаад, 300-гаад тэрбум төгрөг шилжих байдлаар орж ирэх ийм тооцоололтой байгаа.

Энийг бол яг 2026 оны төсвийн төсөл боловсруулахдаа бид нар яг энэ төслүүд хэрэгжих үү, үгүй юу тиймээ бүх байдлаар нь хянаж үзээд төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээд төсвийн төсөлдөө тусгана аа.

Х.Булгантуяа: Пунсалмаа гишүүн нэмж тодруулъя.

Б.Пунсалмаа: Нөгөө онцгой албан татвартай холбогдоод бас асуулт асуусан тиймээ.

Х.Булгантуяа: Тийм. Гэв гэнэт яагаад автомашины импорт 120 мянга орчим машин импорт болов оо, ямар бодлогын үр нөлөө байв аа гэж байна. Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ер нь манай эдийн засгийн өсөлттэй жилүүд дээр хэрэглээ их нэмэгддэг. Ялангуяа одоо тансаг хэрэглээ дээр манайх ер нь нэлээн нэмэгддэг байгаа. Гэхдээ яах вэ уул уурхай манай эдийн засагтай орны хувьд онцлог бас ийм эдийн засгийн өсөлттэй. Ялангуяа уул уурхайн өсөлттэй жилүүд дээр энэ уул уурхайн машины тоног төхөөрөмжүүд ч бас нэлээн нэмэгддэг байгаа. Тэр тоонууд орсон дүн шүү. Тэр суудлын автомашиныг тусад нь бас гаргаж ярих хэрэгтэй байх. Та тэрийг асуусан уу яасан. Тэгээд өнгөрсөн жилийн өнгөрсөн одоо 2024 онд ч биш 2023 онд ч гэсэндээ мөн одоо автомашины хэрэглээ огцом нэмэгдсэн байгаа. Огцом нэмэгдсэн 2024 онд ч мөн адил.

Сая ингээд 2025 оны 2 дугаар улиралд авсан арга хэмжээ СЗХ, мөн Төв банкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд харин энэ автомашины импорт огцом буурсан байгаа. 4, 5 саруудад. Цаашдаа ч гэсэн энэ төв банк энэ бодлогоо СЗХ ч гэсэн энэ бодлогоо ер нь бариад мөнгөний бодлогын одоо чангарах хатуурах ийм төлөв дотроо болбол үргэлжилнэ ээ гэж ингэж бодож байгаа. Тэр нөгөө...

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулна гэсэн үү, үгүй юү? УИХ-ын гишүүн Цэндийн Сандаг-Очир.

Ц.Сандаг-Очир: Бүхэл бүтэн жилийн төсвийн аудитын дүгнэлтийг ярихаар дөрөвхөн минут бас багадаа юмаа. Тэгээд нөгөө хүрээний бузрыг яривал далай далай гэдэг шиг санхүүгийн гүйцэтгэл тайлагналыг ярихаар үнэхээр л далай далай байна шүү. Үнэхээр хариуцлагагүй зөрчил, дутагдал, алдаанууд жил болгон давтагдаж гарсаар байна аа. Би энэ аудитын дүгнэлт зөвлөмжөөс 3, 4-хөн асуулт асууя Сангийн сайдаас. Засгийн газрын тогтоолоор 2019-2024 онд хэрэгжээгүй төсөл арга хэмжээний нийтдээ 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчдын барьцаа хөрөнгийн дансанд байршуулаад ингээд жил дамжуулан зарцуулж байгаа нь төсөвт өртөг нэмэгдүүлэх, төсвийн сахилга батыг алдагдуулах нөхцөл болж байна аа гэж аудит дүгнэчихжээ. Энийг та юу гэж үзэж байгаа вэ? Энэ цаашдаа байхаар байна уу? Бодлого хэрэгжихээр байгаа юу? Энэ 1.7 их наяд. Би бодох нь ээ бол одоо хувийн хэвшлийнхэн дээр гүйцэтгэгч нар дээр очих ёстой мөнгө байх гэж бодож байна. Гэтэл өнөөдрийг хүртэл очоогүй байна аа. Энэ ямар учиртай юм бэ гэж.

Хоёрт, Монгол Улсын Засгийн газар гадаад улс орон хөгжлийн түншүүдийн эх үүсвэрээс нийтдээ 24 их наяд төгрөгийн зээл тусламж авах гэрээ байгуулснаас 13 их наяд төгрөгийн зээлийн эрхийг ашиглаагүйгээс 39.4 тэрбум төгрөгийн хүүг төлчхөөд явж байгаа юм. Үгүй ээ тэгээд 13 их наядын зээлийн гэрээ хийчхээд яагаад ашиглахгүй байгаа юм. Тэгээд яагаад энд хүү төлөөд яваад байгаа юм. Энэний хариуцлагыг хэн хүлээх юм. Энэ дээр хоёрт хариулж өгөөч ээ.

Улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 9 их наяд алдаа зөрчил. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 48 хувиар буюу 2.9 их наядаар нэмэгдчихсэн, өсчихсөн. Үгүй ээ энэ байгууллагууд дээр чинь ер нь энэ дотоод аудит энэ төсвийн ерөнхий захирагч төрийн байгууллагууд дээр чинь энэ дотоод аудит миний мэдэхээр 14, 15 жил болж байна. Энэ дотоод аудит ер нь ажиллаж байгаа юм уу, үгүй юу? Энэ олон улсуудыг цалинжуулж ажиллаж байгаа хэрэгцээ шаардлага байна уу, үгүй юу? Энэ зөрчил дутагдал цаашдаа гарсаар байх юм уу? Алдаа зөрчил дутагдлууд их наядаар яригддаг болж. Актууд тэрбум төгрөгөөр яригддаг болж. Энэ байх ёстой асуудал уу гэдгийг 3-д хариулж өгөөч.

Дараа нь эрх бүхий байгууллагуудаас төрийн болон төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн бие даасан байдалд нөлөөлөхүйц хууль эрх зүйн орчинтой уялдаагүй шийдвэрийг гаргаж, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй, нийгмийн шинж чанартай төсөл арга хэмжээнүүдийг санхүүжүүлж байна аа. Энэ нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөгдөж үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна гэж байгаа юм. Энэ...

Х.Булгантуяа: Эхлээд Болдын Жавхлан сайд хариулах уу?

Б.Жавхлан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. За байз энэ аудитынхан маань энэ тайлан дээр бас нэг тайлбар ойлголтын зөрүүг нь гаргаж өгөөрэй. Энэ барьцаа хөрөнгийн дансанд байгаа 1.7 их наяд гэдэг чинь 2 мянга энэ чинь бараг 2019 оноос хойших энэ чинь 6 жилийн нийлүүлсэн дүнг яриад байна шүү. Тэрнээс биш 2024 оных биш шүү. Энэ чинь нэг жилдээ нэг 200-гаад, 300-гаад тэрбум төгрөгийн их үлдэгдэлтэй үед нь одоо барьцаа хөрөнгийн дансанд авдаг байгаа. Тэгэхээр энэ барьцаа хөрөнгийн дансанд авдаг практик бол энэ олон улсын практик ялангуяа ОУВС-гаас өгдөг зөвлөмжид бас энэ орсон байдаг зүйл шүү. Хэрвээ энийг нь бид нар хадгалж авч үлдэхгүй болбол хойтон жил нь 2026 он, одоо жишээ нь энэ жилийн 2024 оныхыг 2025 онд бид нар барьцаа дансанд авч үлдэхгүй бол 2026 оны төсөв дээр яг тэр хэмжээгээрээ дарамт ирнэ. 2027 онд ирнэ, 2028 онд ирнэ.

Тийм учраас нэгэнт мөнгөн хөрөнгөөрөө бид нар ингээд хуульчилчихсан учраас тэрийг нь аль болох зарцуулаад дуусгах хэрэгтэй. Энэ бол яг үр нөлөө нь таны яриад байгаа тэр төсөвт өртөг нэмэгдэхийнх чинь яг эсрэг нь байхгүй юу. Хэрвээ энийг дундын дансанд нь авч үлдэхгүй шууд хэрвээ хэмнэлт гээд тооцчих юм бол яах вэ төсөв сайн гарна гэхдээ тухайн төсөл дээрээ болбол ингээд мөнгө нь яваад өгчихөөр төсөл нь өөрөө удаашрах, жил нь уртсах одоо энэ нөлөөгөөрөө нөгөө төсөвт өртөг нь нэмэгдээд явах ийм эрсдэл сууриуд нь бий болдог юм байгаа юм.

Тэгэхээр энэ одоо дундын дансанд авах, барьцаа хөрөнгийн дансанд авах энэ болбол байдаг практик аа цаашдаа болбол яах вэ сахилга бат талдаа болбол

сайд нар дээр нэлээн цохилт болж очдог хэрвээ шууд хураачих юм болбол. Тухайн төсөл дээрээ тухайн ААН хувийн хэвшил дээрээ болбол энэ бас их сайн дэмжлэг болж очдог юм байгаа юм. Тэгэхээр энийг бол юу юугүй болбол 100 хувь бол зогсоох боломжгүй ээ. Энийг цаашаага бас тодорхой хэмжээнд үргэлжлээд бид нар бариад бариад д явахгүй бол болохгүй ээ.

24 их наяд, 24 их наядаас 13 их наяд нь ашиглагдаагүй биш шүү. Энэ ерөөсөө 13 их наяд нь өөрөө ашиглагдаагүй л ийм дүн байгаа. Тэгэхээр энэ маань өөрөө хэд хэдэн шалтгаантай байна. Сүүлийн жилүүдэд манай төслийн дүнгүүд санхүүжилтийн энэ одоо хэмжээ маань бол огцом нэмэгдэж ирж байна аа. Одоо хамгийн сүүлд л гэхэд бид одоо стратегийн одоо 14 мега төсөлд орсон энэ нефть боловсруулах үйлдвэр байна. Энэ дангаараа 5.6 их наяд төгрөг.

Өөрөөр хэлбэл 90 оноос хойш авсан бид нарын хамгийн том зээл. Энэ зээл бол бүүр 2019 онд эхэлчихсэн. ...Та бол маш сайн мэдэж байгаа байх түүхийг нь. 2017, 2018 онд яригдаад ингээд эхэлчихсэн төсөл. Энэ одоо ковидын үед мөн гацаад ингээд төсөвт өртөг нь нэмэгдээд 5.6 их наяд болчихлоо. Одоо больё больё бид нар төсвийн дүрэм нь маань ийм гадаадын зээл тусламжийг төсөвтөө багтааж чаддаггүй юм, алдагдал тооцоод байдаг юм больё гэлтэй нь биш. Энийг одоо бид үргэлжлүүлж авахаас өөр арга байхгүй, яаралтай дуусгахаас өөр арга байхгүй. Энэ бол одоо энэ дүнд огцом нөлөөлж байгаа гэсэн үг. Одоо энэ 13 их наядынх чинь 5.6 буюу бараг тал нь нэг төслийнх.

Эрдэнэбүрэнгийн төсөл мөн орж ирнэ. Энэ 2 нийлэхээрээ бараг талаасаа илүү дүнтэй болчихож байгаа байхгүй юу. Тэгэхээр цаашдаа бид нар одоо энэ бол урсгал зардал биш мөртөө алдагдалд тооцогддог. Өөрөө эх үүсвэртэй, эх үүсвэртэй зардал мөртөө алдагдалд тооцогддог энэ 13 их наядыг одоо ойрын 5 жилийн хугацаанд бид нар төсөвтөө багтаах ёстой. Гэтэл төсөвтөө бид нар одоо байгаа дүрмээрээ бол багтаах ямар ч боломжгүй. Нөгөө 40 гаруй гишүүдийн санаачлаад яваад байгаа хууль маань бас энэнтэй холбоотой ийм л зүйл юм байгаа юм.

Тэгэхээр ер нь том улс гүрнүүд ялангуяа бидний Азийн бар гэж боддог одоо энэ улсууд бол яг ийм зовлонтой. Тэгээд 90-ээд оны үед, 80-аад оны сүүлээр 2000 онд болбол тулж байсан байдаг юм даа. Бүгд өөр өөрийн гэсэн онцлог энэ дүрмүүдээ өөрчлөлт оруулаад, энэ гадаадын зээл тусламж гээд эх үүсвэртэй зардлуудаа бол төсвийнхөө алдагдалд тооцохгүйгээр харин эргээд төлөхдөө төсвөөс төлөхгүй төсөл нь өөрөө өөрийгөө аваад явах ийм зарчим шаардлагуудыг тавиад ингээд одоо тэгэхдээ нөгөө Засгийн газрынхаа нөгөө гадаад зээлийнхээ хязгаартаа бол багтаагаад харин алдагдлаасаа бол гадуур тооцоолоод төсөв дээр алдагдал авчрахгүйгээр төсөл нь өөрөө өөрийгөө төлдөг гэдгийг л би байн байн хэлээд байгаа шүү. Ийм маягаар ингээд явдаг...

Х.Булгантуяа: Энэ асуудлаар бас манай ажлын хэсэг дээр бас ярьж байсан. Эх үүсвэртэйгээс эдийн засгийн хувьд өөрөө өгөөжтэй тиймээ, өөрөө энүүнийгээ буцаад эргэн төлөлтөөрөө Жавхлан сайд нэмж хариулья.

Б.Жавхлан: Тийм, хоёр л юм хэлээд байна л даа. Нэг нь хоёуланг нь л хэлээд байгаа юм. 1 дүгээрт гадаад зээлийн эх үүсвэрүүд маань өөрөө эх үүсвэртэй гэсэн үг. Татварын орлогоос одоо санхүүжиж байгаа ямар нэг урсгал зардал биш. 2 дугаарт төсөл өөрөө өөрийгөө аваад явах үр өгөөжтэй байх ёстой. Өөрийнхөө одоо

төсөвт ямар нэг эрсдэл учруулахгүйгээр төлөөд явах учиртай. Ийм байвал одоо бид цаашдаа арай өөр дүрмээр явбал зохиж байгаа юм аа.

Нийгмийн шинж чанартай ямар зээлүүдийг тэгж үзсэн юм. Аудитаас энийгээ дүгнэлтээ хийвэл их зүгээр. Ер нь бид нар 3, 3 жилээр энэ өрийнхөө стратегийг Их Хурлаар батлуулж аваад ингээд явдаг байгаа. Сүүлийн 6 жилийн хугацаанд энэ стратегия бид нар маш сайн барьсан учраас одоо зээлжих зэрэглэл маань ингээд сайжраад явж байгаа. Нийгмийн шинжтэй зээлүүд гэдгийг нэлээн хуучин зээлүүдийг хэлээд байх шиг байна. Сүүлийн үед нэмэгдэж байгаа зээлүүд дээр болбол ийм зээл ерөөсөө огт байхгүй. Дандаа одоо яг прожект файнансинг буюу яг төслийн үр өгөөжтэй төсөл өөрөө өөрийгөө төлөөд явах ийм зээлүүдийг л Их Хурал дээр бидэнд зөвшөөрч энд одоо соёрхон баталж байгаа.

Х.Булгантуяа: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Ганцхан минутдаа. Дотоод аудитын эрх зүйн орчныг бүрдээгүй байна аа гэж байна. Энэ дотоод аудит ажиллаад байгаа, ажиллаад байгаа. Ажиллаад байхад энэ одоо алдаа зөрчил, дутагдал их наядаар хэмжигдээд яагаад гараад байгаа юм бэ? Акт төлбөрүүд яагаад тэрбумаар гараад байгаа юм бэ? Энийг одоо та юу гэж үзэж байна аа? Аудит саяын ярьсан энэ эрх бүхий байгууллагуудаас гаргасан шийдвэр нь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын бие даасан байдалд нөлөөлөхүйц үндсэн үйл ажиллагаатай холбоогүй, нийгмийн шинж чанартай төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж байна аа гэсэн дүгнэлт хийсэн байна. Энийгээ та бүхэн тайлбарлаж өгөөч. Энэ ямар компаниуд дээр, хэний гаргасан шийдвэрээр үндсэн үйл ажиллагаатай холбоогүй асуудлуудыг санхүүжүүлсэн арга хэмжээ явагдаад байгаа юм. Тэгвэл тэр компанийн удирдлага бол хариуцлага хүлээх ёстой, үйл ажиллагаанаас үндсэн үйл ажиллагаанаас төрийн хэмнэлтийн хууль ч хэрэгжиж байгаа.

Үндсэн үйл ажиллагаатай холбоогүй зардлыг яагаад гаргаад байдаг юм. Энийгээ ямар байгууллага дээр ийм алдаа зөрчил дутагдал байс...

Х.Булгантуяа: Аудит хариулъя. Ажлын хэсгийн микрофон дээрээс.

Ц.Наранчимэг: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. За Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн болон төрийн өмчийн оролцоотой ААН байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэж тэдгээрийн үр дүн, үр ашгийг бас бид нар тодорхой хэмжээгээр дүгнэдэг байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар дүгнэлтдээ энэ одоо томоохон компаниудын үндсэн үйл ажиллагаагаа явуулахад одоо хамааралгүй шийдвэрүүдийг одоо удирдах байгууллага буюу Засгийн газраас гаргаад байгаа дээр энийгээ одоо яг үндсэн үйл ажиллагаанд нь хамааруулсан ийм нөлөөлөх нөлөөлөхүйц бус шийдвэрийг одоо нөлөөлөхүйц шийдвэрийг гаргаад байгаа нь эдгээрийн ашигт ажиллагаанд бол нөлөөлөөд байна аа гэж үзсэн байгаа. Энэ дээр дэлгэрэнгүй тогтоолтой нь тайлбар байгаа. Тэрийг танд үзүүлье.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Дотоод аудитын үйл ажиллагаа энэ төсвийн ерөнхийлөн захирагч бүр дээр янз янз байгаа. Аудитын ерөнхий газраас гаргасан энэ дүгнэлт,

төсвийн ерөнхийлөн захирагч сайд нар болгон дээр тус бүрдээ ийм дүгнэлтүүд гарч байгаа. Энэ бол одоо Засгийн газрын үйл ажиллагаа, сангийн одоо яамдуудын үйл ажиллагаанд маш нэмэртэй ийм дүгнэлтүүд гарч байдаг. Энийг одоо сайд нар өөрийнхөө дэргэд байдаг аудитынхаараа энэ ажлуудыг цааш нь үргэлжлүүлээд, доошоогоо одоо нэгжүүд дээрээ ингээд ажиллаад явах учиртай.

Ер нь яах вэ яам болгон дээр л өөр өөр байгаад байгаа. Ер нь дүгнэлтүүд нь жил ирэх тусам сайжирч байгаа яамдууд ч байна, сайжрахгүй байгаа яамдууд ч байна. Тэгэхээр одоо манай сайд нар төсвийн ерөнхийлөн захирагч нар одоо тус бүрдээ энийгээ одоо маш сайн дүгнэлтээ хийгээд, өөрсдийнхөө дэргэд байдаг аудитаа маш сайн одоо ашиглах учиртай. Ер нь бол одоо манай Аудитын ерөнхий газрын дүгнэлтүүд дээр...

Х.Булгантуяа: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Эцэст нь би нэг санал хэлэх гэсэн юм аа. Энэ Төсвийн байнгын хорооныхон байхгүй байх юм. Энэ гүйцэтгэлээр ингээд зүгээр нэг ингээд сонсоод өнгөрчихмөөргүй байгаа юм. Болж өгвөл би бол хяналтын сонсгол хиймээр байна. Зарим төрийн өмчийн компаниуд дээр сөрөг дүгнэлт гаргасан компаниуд байна. 21 аймгаас нэг компани дээр сөрөг дүгнэлт гаргасан аймаг байна. Төсвийн байгууллагууд дээр асар олон одоо зөрчилтэй дүгнэлт гаргасан төсвийн байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нар байна. Тэгээд ямар хариуцлага тооцсон юм бэ, ямар арга хэмжээ авч байгаа юм бэ? Ирэх жил магадгүй 2026 оны төсвийн гүйцэтгэл аудитын тайлан ярихад яг л энэ зөрчил дутагдал ахиад гарсан хэвээрээ л байна.

Тийм учраас энэ санхүүгийн зөрчил дутагдлыг энэ чинь хуруу хумсаа хугалан байж татвар төлөгчдийн олсон мөнгийг ингэж ийм байдлаар зарцуулна гэдэг бол үнэхээр байж боломгүй асуудал шүү. Тийм учраас энэ дээр бол одоо бас үнэхээр анхаар...

Х.Булгантуяа: Сандаг-Очир гишүүн санал хэллээ. УИХ-ын гишүүн Лутаагийн Энхнасан.

Л.Энхнасан: Гишүүдийн оройн мэндийг дэвшүүлье. Өнөөдөр ингээд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланг болбол ярилцаж байна. Жилээс жилд бас энэ нэг яригддаг асуудал нь энэ аудитын тайлангаар илэрсэн энэ зөрчлүүд болох Чингис Хаан Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршсан энэ 256.9 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгийн эрсдэлийг бол үүссэн байна аа энд анхаарна уу гэж байнга анхааруулдаг. Энэ дээр холбогдох Засгийн газар болон Сангийн яам ямар ажил хийсэн бэ? 2 дугаарт бол энэ төрийн хэмнэлтийн хуулийн дагуу энэ 13.1.1 дэх заалт дээр энэ жилээс энэ заалт бол хэрэгжиж эхэлсэн. Тэгээд тухайн жилийн энэ төсөвт тавигдсан энэ төсөл хөтөлбөрүүд 5 сарын 31-ээс болбол өмнө нь гэрээ хийгдээгүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй ингээд шууд хэмнэлтэд орсон байна аа. Энийг ингээд хараад үзэхэд 130 төслийн 535 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээний хэмнэлт тооцогдож, тухайлбал Эрүүл мэндийн сайдын багцаас 70 тэрбум төгрөг, Боловсролын сайдын багцаас 33.7 тэрбум гээд нийтдээ 535 тэрбум төгрөг төсвийн хэмнэлтэд оржээ. Тэгээд энэ эрүүл мэндийн салбарынхан одоо энд санаа зовж байгаа юм уу, үгүй юм уу мэдэхгүй.

Одоо ингээд бие биедээ буруугаа өгөөд ингээд сошиалаар яриад байдаг. Тэгэхэд энэ 60 тэрбумаар чинь болбол Ховд, Орхон аймгийн нэдсэн эмнэлгийн MRI, Амгалан амаржих газар болон эрүүл хүүхэд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2 компьютер томограф, хавдрын энэ эрт илрүүлгийн зураг, хөхний зураг авагч, хавдар илрүүлэх аппарат, хэвлийн хөндийн мэс заслын энэ 10-аад тоног төхөөрөмж авахаар төлөвлөсөн байсан байна. Тэгэхлээр сайдаас би асуух гэж байна. Энэ одоо 2025 оны төсвийн тодотгол одоо ингээд тодотгол ороход энэ 60 тэрбумыг буцаж суулгах боломжтой юу? Энэ дээр бас Чинбүрэн сайд бас анхаарч ажиллана гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Энхнасан гишүүн тэгэхдээ энэ оны төсвөөс асуугаад байх шиг байна. Тийм төсвийн тодотголын.

Л.Энхнасан: Энэ оны төсөвт байсан.

Х.Булгантуяа: Төсвийн тодотгол дээр ярих ёстой л доо. Одоо бол 2024 оны төсвийн гүйцэтгэл ярьж байгаа. Тэгэхээр 2024 оны төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуулт асуугаад төсвийн тодотгол өргөн баригдахаар төсвийн тодотголтой холбоотой асуух нь зүйтэй байх тийм. Тэгвэл Жавхлан сайд хариулчих уу?

Б.Жавхлан: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Эхлээд тэр 2 банкан дээр байгаа бол асуудлуудыг энэ ЭМД-ын сан, нийгмийн даатгалын сантай холбоотой ийм чөлөөт үлдэгдлүүд байгаа. Холбогдох сайд нар нь хариулчихвал их сайн байна. Бид нарын хувьд бол 2020 оноос хойш энэ дээр маш сайн хяналт тавьж ажиллаж байгаа. 2020 оноос хойш болбол нэмж нэг төгрөгийн ч хадгаламж эрсдэлд ороогүй байгаа. Энэ дандаа өмнө нь аваачаад хадгалуулчихсан ийм одоо эрсдэлд орчихсон эх үүсвэрүүд байгаад байгаа юм. Хэчнээн төгрөг яаж барагдуулсан талаар сайд яг хариуцаж байгаа сайд нар хариулбал, хариулах ёстой.

2025 оны 5 сарын 31-ний байдлаар төрийн хэмнэлтийн хуулиар нийтдээ 535 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтууд хэмнэгдсэн байгаа. Эргэж нэг төгрөгийн ч хөрөнгө оруулалт одоо тодотголоор тавигдахгүй. Эрүүл мэндийн яаман дээр одоо энэ хураах одоо хэмнэгдсэн энэ 60 гаруй тэрбум төгрөг бол маш харамсалтай байна. Өнгөрсөн жил нэлээн юм болж байгаад л ингээд л тавигдсан. Энэ чинь байшин барилга биш байгаа байхгүй юу. Тоног төхөөрөмжийн л одоо худалдан авалтууд байгаа. Тэгээд энийг ингээд 6 сарын хугацаанд одоо худалдаж авч чадаагүй гэхээр одоо үнэхээр харамсалтай байна. Дээрээс тавигдахгүй.

Х.Булгантуяа: Чинбүрэн сайд нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Бид 2020 оны 8 сарын ээлжит бус чуулганаар ЭМД болон Эрүүл мэндийн хуульд нэмэлт, өөрчлөлт энэ тэр оруулахдаа бол гол гаргасан санаа бол ЭМД-ын чөлөөт үлдэгдэл мөнгийг ямар нэгэн одоо банканд барьцаалж тавихгүй байхаар суулгаж өгсөн. Тэгээд энэнээс хойш бол ямар нэгэн барьцаанд тавьж мөнгө алдсан зүйл байхгүй. Харин одоо 2 компаниас 2 банк Чингис Хаан болон Капитал банкнаас одоо авах ёстой энэ авлагууд бол одоо тийм хурдацтай сайн явахгүй байгаа мэдээллийг авсан. Тухайлах юм бол одоо барьцаанд байгаа үл хөдлөх хөрөнгүүдийг нь одоо зарах борлуулах, мөн одоо өр барагдуулах процесс бол өөрөө асар удаан тэгээд даатгалын сан өөрөө хүрэхгүй байхад одоо ямар нэгэн мөнгө орж

ирж байгаа тийм сайн мэдээ ерөөсөө харагдаагүй ээ. Ер нь бол ойролцоогоор одоо нэг 80-аад тэрбум төгрөг авах эрхтэй байгаа.

Х.Булгантуяа: Нийгмийн даатгалын дарга Батжаргал дарга нэмж хариулах уу? Хэдээс хэдэн оны хооронд хэдэн төгрөг байршуулаад, хэдэн оноос хойш одоо ийм нөхцөл байдал үүсчихсэн юм бэ нийгмийн даатгалын сан дээр гэдгийг нэг сайн нарийн сайн тайлбарлаадхаач 3 номерын микрофон дээр, НДЕГ-ын дарга Батжаргал,

Б.Батжаргал: Энхнасан гишүүний асуултад хариулъя аа. За нийтдээ Капитал банкн дээр 104.2 тэрбум төгрөг 2016 он хүртэл хугацаанд нийтдээ 16 удаагийн гэрээгээр байршсан байгаа. Тэгээд энэ мөнгөнөөс 38.8 тэрбум төгрөгийг төлүүлээд одоогийн байдлаар 65.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Чингис хаан банкны хувьд 103.6 тэрбум төгрөгийн авлагатай байсан. Үүнээс 14.2 тэрбум төгрөг төлүүлээд одоо 89.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийтдээ энэ 2 банкнаас авах авлагын дүн бол 154.8 тэрбум төгрөг байгаа. Тэрний мөнгө одоо хөрөнгийн араас бол энэ 53 тэрбум төгрөг бол 2016 оноос хойш төлүүлсэн мөнгөн дүн байгаа гэдгийн бас нийлбэр дүн байгаа. Энэ нуугдмал хөрөнгө илрүүлэх ажлуудыг бол прокурорын газар тэгээд Авлигатай тэмцэх газар, ШШГЕГ-тай хамтарч ажиллаж байна аа одоогийн байдлаар жоохон удаашралтай байгаа юм бол үнэн баярлалаа.

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүн Отгоны Саранчулуун.

О.Саранчулуун: Гишүүддээ оройн мэнд. Надад нэг тодруулах зүйл байна л даа. Энэ төсвийн 36 дугаар хуудас дээр нийгмийн бүлэгт чиглэсэн гэдэг дотор 30 төсвийн ерөнхийлөгч нь ерөнхийлөн захирагчийн 2417 байгууллагын, 7830 албан хаагчийн 150.3 тэрбум төгрөгийн цалин урамшуулал гэсэн ийм зардал байгаа. Энийг болохлоор юу гэж оруулчихсан байна вэ гэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлогын хүрээнд гэсэн байгаа байхгүй юу. Энэ хүрээнд ингээд нийтдээ 6 ажлыг дурдсан эхнийх нь энэ байгаа. 150 тэрбум төгрөг. Тэгэхээр би энийг тодруулмаар байгаа байхгүй юу. Энэ 7830 албан хаагчдад 150 тэрбум төгрөгийн цалин урамшуулал гэдэг зүйл яагаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэсэн бодлогын ангилалд зардал болоод явчхав аа. Энэ дээр тайлбар авъя 1 дүгээр асуудал нь.

2 дугаар асуудал нь болохлоор хөгжлийн бэрхшээлтэй хүний гадаадад суралцах эрхийг хуулиар баталгаажуулсан боловч боловсролын зээлийн сангийн санхүүжилтийн дутагдлаас шалтгаалан хэрэгжих боломжгүй байгаад байгаа. Бид нар энийг өнгөрсөн удаа нэлээн ярьсан. Энэ хуулийн заалтыг биелүүлэхгүй байна гэсэн үг. Аудитын байгууллага нь ийм төрлийн санхүүгийн шалтгаантай хууль зөрчлийг хэрхэн дүгнэж хариуцлагыг нь тооцдог юм бэ гэдгийг тайлбар сонсмоор байна. Маш олон хуулийн заалтаар гадаадад сургана гээд заачихсан байгаа.

3 дугаарх нь төсвийн төсөв тавьдаггүй, тэгэхдээ ингээд маш олон хуулиуд байдаг эсвэл төсөв байхгүй гээд байдаг. 1 дүгээр асуудал нь бол хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль байгаа. 2 дахь нь бол Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль байгаа. Энэ хуулиуд дээр төсөв ерөөсөө ч одоо өнгөрсөн тайлан дээр ч харагдахгүй байгаа. Тэгэхээр энэ хуулиудыг одоо ингээд биелүүлэхгүй байж байж төсвийн биелүүлэхгүй юм бол ер нь ямар

зорилготой ингээд байлгаад байдаг юм бэ. Төсөв тавихгүй юм бол гэдэг дээр тайлбар авмаар байна. Би тэгээд дараа нь тодруулъя.

Х.Булгантуяа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулъя. Мөнхзул дарга 3 номерын микрофон дээрээс хариулъя.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр гэсэн төсвийн 7 кодоор эхэлсэн энэ төсвийн хөтөлбөр хэрэгждэг. Энэ төсвийн хөтөлбөрийн хүрээнд 26 тэрбум төгрөг төсөвлөж гүйцэтгэлээрээ 20 тэрбум төгрөг зарцуулагдсан байна аа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахаас гадна хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмж олгох зохицуулалтууд тусгадаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд одоо олгох тэтгэвэр тэтгэмжүүд бол яг энэ нөхцөл шаардлага хангасан иргэдэд бол, болзол шаардлага хангасан иргэдэд бол хэвийн олгогдоод явдаг аа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гол тавьж байгаа асуудал маань одоо хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлээч ээ, санхүүгийн дэмжлэгийн олгож байгаа мөнгөн дүнг нэмэгдүүлээч, мөн түүнчлэн санхүүгийн дэмжлэгийнхээ 50 хувийг эргэн олгодог. Үүнийг одоо санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөлтгүй болооч ээ. Яагаад вэ гэвэл эхний 3 жилийн хугацаанд ашиг орлого олоход хүндрэлтэй байдаг аа гэсэн ийм асуудлууд тавьдаг.

2025 оны төсвийн тухайд бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар багц нэлээн томоохон төслүүд бол батлагдсан. 2025 онд бол хэрэгжилт нэлээд өндөр гарахаар бас ийм төлөвлөгөөтэй байгаа. Яг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбарт Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарт ажиллагчдын тоо бол 512 орон тоо л байгаа. Энд болбол Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалтын хөгжлийн төв буюу эмнэлгийн орон тоо, сэргээн засал сургалт үндэсний төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын агентлаг гэх мэт хөгжлийн бэрхшээлийн чиглэлээрх нийт улсын хэмжээний орон тоо 512 л байгаа. 6 аймагт байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний одоо хөгжлийн төвүүдийн албан хаагчдын орон тоог оролцуулаад.

Тэгэхээр энэ албан хаагчдад зориулсан төсөв бол манай салбарын сайдын багцад тусгагдаад, олгогдоод явдаг ийм зүйл байгаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний дэмжих дэд зөвлөлүүд яамдуудад ажиллаж байгаа. Яам болгон энэ зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулсан төсөв тавьдаг. Гэхдээ энэ төсөв бол хангалтгүй байдаг асуудлаар байнга одоо хүсэлт шаардлага ирдэг ээ. Дэд бүтцийн асуудал бол маш хүндрэлтэй байгаа орчны хүртээмжийн асуудал. Тэгэхээр цаашдаа болбол энэ орчны хүртээмжийг сайжруулах, стандартыг нь хэрэгжүүлэх байгаа боловч амьдралд хэрэгжихгүй байгаа. Энэ дээр одоо стандартын хэрэгжилтэд шаардлагатай төсөвт хөрөнгүүд тавигдах шаардлага бий.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулъя. Тэгээд Саранчулуун гишүүн тодруулчихъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ боловсролын зээлийн сантай холбоотой тэгээд дээр нь нэмээд Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих хуулийн энэ чинь 15.6 дээр Хүний эрхийн тухай хууль дээр. Энэ асуудлыг бас хөндөж байна гэж

ойлгож байна. Тэгэхээр энэ асуудлыг бол ярихаас өөр аргагүй болчхоод байгаа юмаа. Ер нь бол 2024 онд бол 929 суралцагчид бол 2 тэрбум төгрөгийг дотоодод сурахад нь Боловсролын зээлийн сангаас одоо зардлыг нь олгосон. Гадаадад бол 2 иргэнд олгосон байдаг. Энэ нь 400-гаад сая төгрөг болсон. Энэ 2 иргэнд. Энэ байдлаараа ингээд явах юм бол энэ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15.6 дээр бол ерөөсөө л хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүдийн өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг Боловсролын зээлийн сан хариуцна гээд ямар нэгэн тийм нөхцөл тавилгүйгээр шууд хуулийн заалттай. Тэгээд энэ хуулиудыг нь харахаар нэг 5 хууль, 1 УИХ-ын тогтоол дээр иймэрхүү заалтууд байгаа юм.

Яг энийг нь хэрэгжүүлээд явъя гэхээр Боловсролын зээлийн сангийн өөрийнх нь 2024 оных нь нийт төсөв нь ердөө 158.4 тэрбум төгрөг. Улсын төсвөөс бол 124.3 тэрбум...

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Үүнээс бол одоо 2025 он гэхэд бид бас 33 тэрбумыг эргэн төлөлтөөс нь олох ёстой ийм нөхцөл байдалтай байгаа. Энэ жилийн тухайд ингээд харж байхад бол олон хүсэлт ирж байна аа. Тэгээд ер нь нийтдээ одоо 2025 оны эхний 6 сар гэхэд дотоодод суралцагчид бол 583 хүн хүсэлтээ өгчихсөн байна суралцъя гээд. Тэгээд гадаадад бол 17 хүн болчихсон байна. Тэгэхээр гадаадад суралцаж байгаа хүн нь бол дотоодод суралцаж байгаа хүнээс бараг мянга дахин илүү зардал гардаг. Тэгэхээр ийм нөхцөл байдалд бид одоо яаж тэгш хүртээмжтэй энэ тэгээд энэ одоо дэмжлэгийг олгох вэ гэдэг бол өөрөө нэлээн тийм хурц асуудал болоод байгаа. Ийм учраас одоо тантай бас ярилцаж энэ хуулийн заалтуудыг хэрхэн амьдралд хэрэгжүүлэх вэ? Амьдралд илүү яаж ойртуулах вэ, яаж тэгш хүртээмжтэй болгох вэ гэдгийг ярилцахгүй бол болохгүй байгаа. Хүсэлтээ өгсөн хүн болгоны хүсэлтийг хүлээж аваад хэрэгжүүлэхийг бид зорьдог. Ноднин бол тэрийг бол хийж чадсан. Гэтэл энэ жил бол ийм олон хүн болсон. Тэгэхээр энэ дээр бас нэлээн хэцүү нөхцөл байдал үүсээд байгааг хэлэхээс өөр арга алга. Баярлалаа.

Х.Булгантуяа: Саранчулуун гишүүн нэмж тодруулъя.

О.Саранчулуун: Гэр бүлийн яамны тайлбарыг сонслоо. Би зүгээр тодруулаад байгаа юм. 30 төрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2417 байгууллагын, 7830 албан хаагчийн 150.3 тэрбум төгрөгийн цалин урамшуулал яахаараа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих бодлогын зардал руу орчихдог юм бэ л гэж би асуугаад байгаа юм. Зорилтот бүлгийн хүртээмж, үйлчилгээний чанарыг сайжруулахад шууд чиглэсэн энэ ангилалтай гарчиг энэ ерөнхий цалинтай хольж тооцох нь өөрөө бодлогын хариуцлага мөн юм уу? Энэ дээр тайлбар авмаар байна.

Дараагийнх нь болохоор нийт боловсролын зээлийн сангаас гадаадад сурч байгаа суралцагчдаас хэдэн хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийх болчхоод байгаа юм. Хувийг нь пропорцыг нь тодруулчихъя гэж бодож байна.

Х.Булгантуяа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

Л.Мөнхзул: Энэ 150 тэрбумтай холбогдолтой төсөв бол манай сайдын багцад тусгагдахгүй. Гэхдээ энэ Үндэсний аудитын газраас илүү тодруулах байх.

Энэ 150 ба хөгжлийн бэрхшээлтэй хүнийг заавал ажиллуулах хуультай. Тодорхой квотыг хангана. Тэгэхээр төрийн байгууллагуудад ажиллаж байгаа нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгогдсон цалингийн сан байж магадгүй байх гэж бодож байна аа. Тэгээд энэ дээр болбол төрийн, цалингийн төрийн албан хаагчдын цалингийн систем тат систем Сангийн яамны мэдэлд байдаг. Тэгэхээр энэ нэгтгэл дүн гарч ирэх байх аа. Манайд болбол зөвхөн өөрийн албан хаагчтай холбогдолтой цалингийн сангийн нэгтгэл харагддаг аа. Ихэнх яамдууд бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах тэр чиг үүргээ бол хэрэгжүүлдэг. Харин дунд болон анхан шатанд бол хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах квотоо бас хангахгүй байгаа төрийн байгууллагууд дээр зөрчил илэрдэг.

Сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс суралцах эрх боловсролын талаар тавьж байгаа нэг асуудал бол гадаадад боловсрол эзэмшихэд боловсролын...

Х.Булгантуяа: Аудитынхан энэ дээр нэмж тайлбар өгье. Мөнхзул дарга аа наадах чинь нөгөө Жавхлан сайд дэмжээд 2024 оны төсвийн тодотголоос байна уу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлсан зарлагын ангилал гаргаад төсвийн ерөнхийлөн захирагч болгон дээр бараг тавьдаг болсон шүү дээ. Тэрүүнтэй холбоотой зардал юм биш үү? Төрийн сан тайлбар өгөх үү? За төрийн сан 3 номерын ажлын хэсгийн микрофон дээрээс. Тэгээд шаардлагатай бол нэмээд аудитынхан тайлбар өгөөрэй.

Б.Цогбадрах: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах. Бид нар энэ тайландаа бол нийтдээ 2024 оны Засгийн газрын нэгтгэсэн тайлангийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлогын хүрээнд зарцуулсан зарцуулалтыг тайландаа тусгасан. Нийтдээ улсын хэмжээнд буюу 30 төсвийн ерөнхийлөн захирагч 2417 төсвийн байгууллагад ажиллаж буй 7830 албан хаагчдад нийт улсын хэмжээнд 2024 онд цалин урамшуулалд нь 150.3 тэрбум төгрөгийн төгрөгийг зарцуулсан байна. Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн 36693 иргэнд 142.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Мөн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, том хүн асарч байгаа 32230 иргэнд улсын хэмжээнд 2024 онд нийт 94.5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Х.Булгантуяа: Саранчулуун гишүүн нэмж асууя.

О.Саранчулуун: Би саяынхыг чинь уншаад тэгээд асуугаад байгаа байхгүй юу даа. 150 тэрбум төгрөгийн цалин урамшуулалтай 7830 албан хаагч авсан юм байна. Энийгээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлогыг дэмжих төсөл гээд төсөв гээд яваад байна шүү дээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлогын хүрээнд гэхихсэн байгаа байхгүй юу. Тэгвэл энэ төсвийн ерөнхийлөн захирагч нь тэгээд энэ 7830 хүн өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөө ажиллаад ингээд тусдаа цалин аваад байгаа юм уу, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнх нь цалин юм уу? Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнх нь цалин юм бол яагаад ажил хийсэн цалин буюу энэ засаглалын энэ чинь одоо цалин урамшууллын зардал шүү дээ. Ердийн төрийн албанд ажиллаж байгаа ердийн тогтмол цалин урамшууллын зардал гэдэг ангилалдаа орохгүй юм уу?

Х.Булгантуяа: 3 номерын микрофон дээрээс хариулъя. Энэ чинь одоо хөгжлийн бэрхшээлтэй хүн төрийн албанд ажиллалаа гээд энэ бол хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэсэн зардал гэж болохгүй шүү дээ. ХЗДХ-ийн сайдын багц дээр жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэсэн зардал гэх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүн тэр салбар дээр ирээд үйлчилгээ авахад чиглэсэн зардал л байх ёстой болохоос биш энэ чинь хөдөлмөрийн хөлсийг хөгжлийн бэрхшээлтэй хүнээр гэж ялгаварлан гадуурхаж уг нь та бүхэн маань арай тайлагнамааргүй юм. 3 номер хариулъя.

Н.Мөнхсүх: Энэ нөгөө нэг 30 төсвийн ерөнхийлөн захирагчийн 2417 төсвийн байгууллагад 7830 одоо хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байгаад олгосон цалин гэдгийг харуулсан. Зүгээр ер нь болбол яах вэ бид нар нөгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ямар хэмжээний зардал гаргаж байна вэ гэдгийг харуулах гэж зорьсон. Яагаад гэхээр манай нөгөө нэг стандартын дагуу бид нар тайлагнахаар болбол яг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ямар хэмжээний мөнгө зарцуулж байна вэ гэдэг нь харагддаггүй учраас цалингаасаа салгаж харуулсан. Тэрнээс энэ бол цалин хөдөлмөрийн хөлсний зардалдаа суугаад явж байгаа зардал шүү.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Саранчулуун гишүүн ээ. Одоо та бид 2-ын одоо яриад байгаа юм чинь яг л энэ шүү дээ. Бид нар хөдөлмөрийн хуулиар тодорхой хэмжээнд одоо ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах ёстой. Тэгээд ажлын байраар хангахын тулд энэ чинь төсөвт нь суусан байх ёстой шүү дээ. Тийм учраас өөрөөр хэлбэл бүр баталгаажуулж байгаа байхгүй юу. Тэр одоо хөдөлмөрийн ажлын байраар хангана гэдгийг төсөвт нь суулгаад төсвийнхөө жил бүр яг тодорхой энэ хэсгийг ийм хувь хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангахад чи энийгээ зарцуулах ёстой шүү гээд ингээд хуульчилчихаар чинь бүүр амар болж байгаа, бүүр баталгаажиж байгаа биз дээ Саранчулуун гишүүн ээ, бид 2 одоо таны таныг би зөв ойлгосон байх гэж бодож байгаа. За одоод цаашдаа 2026 оны төсөв дээр ч гэсэн бас ингэж оруулна гэж бодож байгаа. Та нэг одоо хэлээдхээч зөв үү, буруу юу.

Х.Булгантуяа: Саранчулуун гишүүн нэмж тодруулъя.

О.Саранчулуун: Зардлын ангилал оруулах гэж байгаа оролдлогыг нь бол ойлгож байна аа, маш таатай байна аа. За ер нь бол зорилтот бүлэгт чиглэсэн зардал буюу тэдний оролцоог нэмэхтэй холбоотой гэдэг зардал дотор энэ ард нь байгаа бусад зардлууд бол халамжийн төрөл халамжийн үйлчилгээнүүд хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэмж, байнгын асаргаа гээд эд нар байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авч байгаа гэдэг нь ажилтай холбоотой тохиргоо хийгдсэн байх зардлууд. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд буюу мэдээлэл нь хүртээмжтэй байгаа холбоотой зардлууд одоо жишээлбэл веб сайтаа хүртээмжтэй болгодог юм уу тиймээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан ажлын байрны тохиргооны зардлууд байгууллагын орц гарцаа хүртээмжтэй болгосон эсэх зардал, мэдээллийн хүртээмжийн зардлууд.

Хөгжлийн бэрхшээлтэй ажлын биш ээ ажлын байрны хүртээмжтэй зардал гэх мэтээр зардлуудаа ялгаж оруулбал бүүр илүү тодорхой болох юм шүү ерөнхийдөө манайханд. Тэрнээс биш энэ хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орлоо гээд зөвхөн

тэр хүмүүстээ зориулж ажиллахгүй байгаа байх гэж би бодож байна. Энэ чинь төрийн ажил шүү дээ. Ажлаа хийж байгаа хүний зардлыг одоо би жишээлбэл одоо энэ дотор явж байгаа болж таарч байна уу? Бүгд...

Х.Булгантуяа: Саранчулуун гишүүний хэлж байгаа зөв шүү. Үгүй ээ хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагч хөгжлийн бэрхшээлтэй хүнд заавал үйлчилнэ гэсэн юм байхгүй шүү дээ. Энэ бол жишээлбэл ХЗДХ-ийн сайд дээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилнэ ээ гэх юм бол жишээлбэл дохионы хэлмэрч хүн цагдаа дээр цагдаагийн байгууллагад ажиллах ёстой. Шүүх хурал дээр дохионы хэлмэрч хүн байх ёстой. Төрийн бүх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй болгохтой холбоотой зардлыг хэлж байгаа болохоос биш хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн албанд ажиллуулсныхаа төлөө зүгээр энэ чинь тэр хүн цалингаа л авах ёстой шүү дээ. Хөдөлмөрийн хуулийн дагуу. Төрийн албаны хуулийн дагуу тийм биз дээ. Дахиж тодруулах дэг байхгүй. Саранчулуун гишүүн 2 удаа тодруулга авчихсан учраас.

Тэгэхээр үүнтэй холбоотой хэлээд байна л даа. УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд үдшийн мэнд хүргэе ээ. 2024 он болбол онцгой жил байсан. Сонгуулийн жил байсан. Тэгээд эрх баригчид сонгуульд ялахын тулд ёстой дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэсэн гэдгийг энэ ерөнхий аудит солигдоод нэг дүлий цэрэг гэдэг шиг бичээд ороод ирсэн байна. Танд баярлалаа. Энэ аудитын эхэнд болбол 9 их наяд 292 тэрбум 100 сая гээд биччихсэн байсан. Сүүлд аудитынхаа дүгнэлтийн сүүл рүү болбол бүүр наадах чинь 15 их наяд 719 тэрбум 500 сая төгрөгийн алдаа дутагдал зөрчил гарч ирж байгаа юм. Тэгээд би одоо энэ Хэрэг эрхлэхийн шинэ дарга Бямбацогт сайдаас асууя. Яг зарчмын асуулт.

Хэрэг эрхлэх газрын дарга аа. Энэ төрийн албан одоо энэ юу гэх юм Төсвийн ерөнхийлөгч нь ерөнхийлөн захирагч нар болон ТӨК-иудад аудит гэж байгууллага байна уу? 1 дүгээрт. Тэгээд 2 дугаарт одоо энэ тайлан дээрээс тоонууд асууя. Тэгэхдээ хурал даргалагч аа энэ сайд нар чинь байхгүй байгааг бас анхаараад өгөөрэй. Батлагдсан төсвийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан нийт 33.8 тэрбум төгрөг. Энд болохоор гадаад харилцааны сайд 8 тэрбум, ХАА-н сайд 6.4 тэрбум, Уул уурхайн сайд 6 тэрбум, Шадар сайд 2.8 тэрбум, Боловсролын сайд 2.8 тэрбум, Зам, тээврийн сайд 2.8 тэрбум. Нийтдээ 33.8 их наяд. Тендерийн хуулийг зөрчсөн нийтдээ 161.6 тэрбум төгрөг энэчээнээс Сангийн сайд 73.6 тэрбум, Шадар сайд 33.8 тэрбум, Боловсролын сайд 31 тэрбум, энэ Гэр бүл, нийгмийн хамгааллын сайд 16 тэрбум, Цахим сайд 2.6 тэрбум гэх мэт ингээд 160 тэрбум.

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн гэж байгаа юм. Нийт 9.5 тэрбум. Сангийн сайд 2 тэрбум Сангийн сайд, Зам тээврийн сайд 1.9 тэрбум, Боловсролын сайд 1.6 тэрбум гэх мэт эд нар дээр сайд болгоноор нь хариулт авбал уг нь зүгээр байгаа юм.

Тэгээд намайг нэг нийслэлийнхэнд үг хэлчихсэн чинь томроод бай, попроод бай, бараг л бацаан минь гээд байсан. Би яг Төсвийн байнгын хорооны хурал дээр асуулт асууж хариулт авах үедээ үг хэлсэн. Сүүлд нь би чинь томроод бай, попроод бай гэдэг нэр зүүсэн. Бас л нийслэлийн дарга. Энэчээ биччихсэн байгаа баримтыг

нь ярьж байна шүү. Нийслэл 2024 онд 2 их наяд 86 тэрбумын төсөв батлуулж авсан. 12 тэрбум 700 сая нь энэчээ ямар нэгэн алдаа дутагдалтай гээд биччихсэн. Батлагдсан төсвийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан 6.6 тэрбум. Үүнээс нийслэлийнх нь 3.2, анхан шатны баримтын бүрдэл дутуу хүчин төгөлдөр бус баримтаар Нийслэл дээр 1.9 тэрбум, тэгээд тендерийн хууль зөрччихсөн 7.6 тэрбум Хэрэг эрхлэхийн дарга хариулах уу? Энийг хэн хариулах вэ?

Тэгээд ард талд нь бас нэг, хоёр, гуравхан асуулт. Дахиад Хэрэг эрхлэхийн дарга хариулах юм уу? Нийтдээ бид нар нэг...

Х.Булгантуяа: Цогтбаатар гишүүнд нэг минут нэмж өгье.

Да.Цогтбаатар: Нийтдээ 6916 төсвийн ерөнхийлөгч нь Ерөнхийлөн захирагчийн 122 тэрбум төгрөгийн асуудлыг энэчээ ярьж байгаа юм шиг байгаа юм. Тэгээд энэчээнээс гарч ирэхээрээ өмнөх оноосоо 7.5 их наяд төгрөгөөр нэмэгдсэн алдаа буюу 93 хувиар өссөн алдааны талаар л ярьж байгаа юм. Энэ нөгөө одоо энэ дээр цаашдаа ямар арга хэмжээ авах вэ? Хэрэг эрхлэхийн даргаа эсвэл аудитын даргаа. Тэгээд энэ Зам тээврийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд 2 Бодь гэдэг компанитай, 2021 онд 130 тэрбум төгрөгийн гэрээ байгуулаад одоо болтол яах ийх нь тодорхойгүй асуудал шийдэгдээгүй байна аа. Тэгээд аудитад хамрагдсан 21 сангаас 8 сан нь хязгаарлалттай гэсэн дүгнэлт гарсан байна. Энэ дээр ямар тайлбар байна аа Сангийн сайд аа? За энэ асуултуудад хариулт авъя.

Х.Булгантуяа: Эхлээд Сангийн сайд, Хэрэг эрхлэхийн дарга хариулах уу? За Бямбацогт сайд хариулъя. Тэгээд Сангийн сайд.

С.Бямбацогт: Яамд болон ТӨК-иуд дээр аудит байна уу гэж асууж байна аа тэгээд аудит байгаа. Төрийн захиргааны төв байгууллага болох яамдууд дээр болбол Дотоод хяналт хяналт шинжилгээ үнэлгээ аудитын газар гэж одоо бас бүх яамдууд дээр яг хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй ийм байгууллага өөрийн яамны болон яамны харьяа байгууллага агентлагуудын одоо үйл ажиллагаа бүх үйл ажиллагаа нь зөвхөн санхүү биш бүх бодлогын болон одоо зохицуулалтын хэрэгжүүлж байгаа зохион байгуулж байгаа бүх үйл ажиллагаан дээр хяналт тавьж үнэлгээ хийдэг.

Үүний дагуу бас хариуцлага тооцох үедээ хариуцлага тооцох бололцоотой. ТӨК-иуд дээр ТУЗ-ийн дэргэд аудитын хороо ажиллаж байгаа бас. Өөрөөр хэлэх юм бол гүйцэтгэх захирлаа хянана. Гүйцэтгэх захирал болон доошоо одоо явуулж байгаа бүх үйл ажиллагааг ТУЗ-ийн дэргэд. Гүйцэтгэх захирлын дэргэд бас одоо дотоод хяналтын нэгж ажиллаж байгаа. Ийм байдлаар үндсэндээ бол яг анхан шатнаасаа авхуулаад нэгжүүд хянаж байна. Дээрээс нь одоо ингээд гүйцэт төсөв дээр аудитын байгууллага, гүйцэтгэлийн болон нийцлийн тэгээд санхүүгийн аудит одоо 3 төрлийн аудит жил болгон хийдэг.

Мөн одоо Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар дээр бодлогын бичиг баримтын хэрэгжилтийн, дээрээс нь үйл ажиллагааны хяналтуудыг хийдэг. Ийм байдлаар энэ хяналтууд бол нэлээн одоо хангалттай байгаа. Ганцхан одоо гарч байгаа үр дүн бас байна уу, байхгүй юу гэж та асууж байгаа. Ер нь болбол хуучин бол маш задгай замбараагүй байсан, өдрөөс өдөрт одоо жилээс жилд бол ер нь сайжраад байгаа. Аудитынхан бас хариулах байх гэж найдаж байна. Одоо гарч

байгаа тэр саяын таны уншиж байгаа зөрчлүүд энэ мэдээж гэмт хэргийн шинжтэй болбол хууль хяналтын байгууллага руу шилжүүлдэг. Гэмт хэргийн шинжтэй биш ерөнхийдөө одоо юу гэдэг юм баримт бичиг нь дутуу, гар хөлийн үсэг нь дутуу гарцаа байхгүй зарцуулчихсан мөртөө одоо үйл ажиллагаа зардал нь гарчихсан мөртөө асуудлууд байдаг. Тэрэн дээр бол аудит бол маш сайн. Одоо хянаж дүгнэлт гаргадаг дүгнэлт гаргадаг. Өөрөөр хэлэх юм бол одоо гэмт хэргийн шинжтэй биш одоо зөрчлийн шинжтэй тиймэрхүү одоо асуудлууд байна шүү. Иймэрхүү асуудлуудаа дахиж битгий гаргаарай гэдгээр одоо юу гэдэг юм зөрчилтэй, хязгаарлагдмал гэсэн дүгнэлтүүд өгч байгаа. Энийг бас тайлбарлаад бас аудитынх нь бас нэмээд өгчхөөрэй.

Мэдээж одоо хууль зөрчсөн гэмт хэргийн шинжтэй байх юм болбол хууль хяналтын байгууллагад шилжүүлдэг. Ийм байдлаар л үндсэндээ төрийн захиргааны төв байгууллага болох одоо яамдууд, ТӨК-иуд дээр болбол хяналтууд тавиад явж байгаа. Ер нь жилээс жилд одоо өдрөөс өдөрт хяналт бол сайжирч байгаа. Дээрээс нь одоо ард иргэдийн хяналт бас хангалттай байдаг. Хэвлэл, мэдээллийн хяналт байдаг Энийг та бас мэдэж байгаа байх. Тэгэхээр одоо хяналтууд бол хамгийн гол нь одоо еще илүү шилэн, еще илүү нээлттэй ил тод ажиллах шаардлага. Энэ зарчмыг бид нар барьж байгаа. Энэ хүрээнд бас Засгийн газрын ХЭГ-ын дэргэд бас энэ тодорхой бас нэг судалгаа хийх нэгж байгуулагдсан. Судалгааны төсөл хэрэгжиж байгаа энэ хүрээндээ улам одоо ТӨК-иудын үйл ажиллагааг сайжруулах ийм одоо бас ажлууд цаашдаа бас хийж хэрэгжинэ ээ гэдгээ бас танд хэлье ээ.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя аа. Аудитынхан маань бас анзаарч байгаа байх аа. Энэ асуулт болбол бас яг тэр зарчмын асуулт шүү. Энийг цаашдаа одоо бас ямар, яаж дүгнэж явах юм нэг талдаа гаргачихсан нь зөв байх. Тэр Сангийн сайд дээр гэхихсэн байгаа тэр тендерийн хууль гэж байгаа юм чинь Сангийн яаман дээр Сангийн сайд зохион байгуулдаг нэг ч тендер арга хэмжээ байхгүй. Энэ бол гадаадын зээл тусламжтай холбоотой дандаа төслүүд дээр хийгдэж байгаа ийм худалдан авах ажиллагаанууд гэсэн үг.

Гадаад зээлийг авахдаа энэ танхимд УИХ дээр соёрхон баталдаг. Тэрийг соёрхон батлахдаа тэр нь гэрээн дотор чинь цаад талынхаа хөгжлийн түнш Азийн хөгжлийн банк, дэлхийн банк, олон улсын юу ингээд Европын сэргээн босголт хөгжлийн банк ч гэдэг юм уу цаад талынхаа дүрмээр худалдан авалт нь явна аа гээд ингээд заачихсан байдаг. Тэрийг одоо Монголын тендерийн хуулиар явах ёстой гээд аудитынхан маань дүгнэлт гаргачхаад байгаа юм. Тэгээд энэ одоо гадаадын зээл тусламж чинь нөгөө бөөндөө том багцаараа Сангийн сайдын багц дээр байдаг болохлоор Сангийн сайд дээр гэдгийг та гаргачхаад байх шиг байгаа юм. Тэрнээс биш энэ чинь төсөл болгон нь өөрөө тус тусдаа...

Х.Булгантуяа: Одоо тэгээд сайд болгон тэгээд хариулах юм уу. Жавхлан сайд нэмээд хариулчихъя.

Б.Жавхлан: Өөр нэг юм дутуу тэр сангуудтай холбоотой яасан байна. Тэрийг сангуудыг бол харин сайд нар тус тусдаа өөрсдөө хариулах нь зөв байх аа. Тийм дандаа сайд нар. Тэрийг одоо би хариулна гэж юу байх вэ.

Х.Булгантуяа: Дамдинням сайд. Тэгээд сайд нар ихэнх нь байхгүй байна аа.

Г.Дамдинням: Цогтбаатар гишүүн асуугаасай гэж бодож байсан асуулт асуугаад байна. Би өөрт чинь их баярлаж байна. Яагаад вэ гэвэл энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр гарч байгаа энэ аудитын дүгнэлтийг бол манай төрийн нарийнаар ажиллаж байсан Улсын ерөнхий аудитор Магнайсүрэн дарга бол мэдэхийн дээдээр мэдэж байгаа тиймээ. Яаманд юу ч байхгүй, яг ялгаагүй Сангийн сайдтай ижилхэн. Энэ төрийн өмчийн Эрдэнэс Монгол тэгээд л Монросцветмет, Шивээ-овоо, Илчис Ойл энэ бүх компаниуд дээр байдаг байхгүй юу. Энэ төрийн өмчийн энэ уул уурхайн компаниуд бол Уул уурхай яаманд огт хамаагүй шүү дээ. Санхүүгийн хувьд бол бүр. Тэгээд гүйцэтгэх удирдлагыг нь томилдоггүй, оролцдоггүй. Тэгсэн мөртөөсөө ял нь ирээд бичигдчихээд байдаг юм аа. Энийг одоо нэг бас нээрээ тоглоомгүй энэ Сангийн сайд сая хэлж байна. Энийг нэг шийдээд өгмөөр байгаа юм. Нэг болбол одоо ямбыг нь эдлүүлээд энэ компаниудаа манай яаманд өг. Тэгээд бид нар одоо ялаа үүрээд явъя. Үгүй бол энийгээ нэгмөсөн...

Х.Булгантуяа: Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Тэр сангуудтай холбоотой манай сайд нар хариулчхаарай. За Сангийн сайд дээр байгаа Ирээдүй өв сан, Тогтворжуулалтын сан, Засгийн газрын нөөц сан гээд 3 сан байдаг Цогтбаатар гишүүн ээ. Тэгэхээр энэ 3 сан дээр болбол хязгаарлалттай дүгнэлт гараагүй хэвийн гэж гарсан байгаа. Тэгэхээр тэр юун дээр гадаад зээл тусламжийн тендертэй холбоотой асуулт тэр аудитынхан маань ер нь цаашдаа ер нь яах юм нэг хэлээд өгөөч. Ингээд тендерийн хуулиараа Монголын хуулиар явах юм уу, цаад тал нь зээлээ өгөхдөө тийм нөхцөл тавиад энд соёрхон батлаад цаад талынхаа тэр зээлийн эх үүсвэр өгч байгаа талынхаа дүрмээр худалдан авалт нь явна шүү гээд ингээд 30, 40 жил ингээд яваад ирчихсэн энэ дүрмээ хэдүүлээ цаашаа яах вэ. Энэ дээр нэг хариулж өгөөч ээ.

Х.Булгантуяа: Одоо тэгээд аудит хариулах юм уу? Та хэд чинь одоо бие биеэсээ асуугаад суугаад байх. Уг нь УИХ-ын гишүүд УИХ-ын гишүүд та нараас болон аудитаас асуух ёстой байсан чинь Засгийн газар нь аудитаас асуугаад байх юм. Мэдэхгүй одоо тэрнийгээ та нар хоорондоо ярьж байгаад хэрвээ тэр хуульдаа өөрчлөлт оруулах ёстой бол хуульдаа өөрчлөлт оруулаад өргөн барьсан нь дээр байлгүй дээ тиймээ Цогтбаатар гишүүн ээ. За тэгье. Цогтбаатар гишүүн. Үгүй ээ та чинь нэг тодруулчихсан байгаа биз дээ. тодруулаагүй билүү? За нэг тодруулаад хангалтгүй байна гэх юм бол нэмж нэг минут тодруулна. Шууд нэг минут гэдэг дэг байхгүй. Шууд нэг минут гэдэг дэг байхгүй тийм. Дэгээ л сахихгүй бол болохгүй шүү дээ хоёулаа. За Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Бямбацогт сайд хэлж байна аа. Бүх сайд нарт дотоод аудит байгаа. Гүйцэтгэх удирдлагын дэргэд аудитын нэгж байгаа, ТУЗ бүгдээрээ аудиттай гэж байна. Тэгээд яагаад эд нар ажил хийхгүй өнөөдрийг болтол ингээд асуудлууд чинь 122 их наяд төгрөгийн асуудал чинь одоо 15 их наяд нь зөрчил дутагдалтай гэж орж ирээд байгаа юм бэ. Энэ хүмүүсээ цаашид нь ажлыг нь хийлгээд чадаж байгааг нь ажлыг нь хийлгээд, чадахгүй байгаа одоо энэчээ бол жишээлэхэд сая нэг дарга хэлээд зогсож байна шүү дээ. Ажил удаашралтай байгаа. Үнэнээ хэлье ээ гээд. УИХ дээр удаашралтай байгаа гэж хэлэхийн тулд энэчээ дарга байх шаардлага байхгүй шүү дээ. Эд нарыг чинь одоо халахыг нь халаад, солихыг нь

солиод, ажил хийж чадаж байгааг нь ажлыг нь хийлгээд явахгүй л бол Монгол Улсад энэ удаашралтай байгаа дарга нар чинь гай болоод байна шүү дээ.

Тэгээд одоо энэ сайд нар нь бас хариуцлага хүлээхгүй ээ энэ бусад компаниуд нь хариуцдаг гээд байх юм. Тийм учраас та нарыг сайд бол гэж ингэж томилоод байгаа юм биш үү. Та нар доошоо хариуцлага тооцох ёстой юм биш үү. Тэгээд бид нар хэнээс нь хариуцлага нэхэх юм. Тэгээд энэ асуудлуудаа цаашид анхаараад тэгээд одоо энэ...

Х.Булгантуяа: Уг нь хариулт өгөөд тэгээд одоо шаардлагагүй хангахгүй байна аа гэвэл нэг минут нэмж асуух ёстой байхгүй юу. Дэгээрээ. За Магнайсүрэн даргаар хариулаад 4 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Аудитын нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд бид нар нэлээн олон тооны зөвлөмжүүд, Монгол УИХ-д толилуулах одоо асуудлууд, Ерөнхий сайд Засгийн газрын гишүүдэд толилуулах зөвлөмжүүдийг өгсөн байж байгаа. За ингээд бид нар ямар дүгнэлтэд хүрсэн бэ гэхээр зэрэг зарим асуудлууд бол олон жил дамнаад ингээд давтагдаад байна аа. Ерөөсөө жил болгоны аудитын тайлангаар энэ илрүүлэлтүүд гараад байгаа учраас энэ жил бид нар УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн боломжийг ашиглаад Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Төсвийн байнгын хороо дээр яриад энэ УИХ-ын тогтоолын төсөл бас нэг гаргаж нэг тийш нь шийдэхгүй болбол энэ зөрчлүүд бол...

Х.Булгантуяа: 4 номерын микрофоныг нэмж өгье.

С.Магнайсүрэн: Зөрчлүүд ингээд давтагдаад байгаа учраас энэ дээр бид нар нэг тийш нь шийдээд УИХ-ын одоо хяналтын бүтцийн байгууллагууд Байнгын хороодын ажлын албатайгаа хамтраад энэ дээр хүч хавсраад тодорхой шийдлүүд гаргаж, хяналт, хариуцлагыг одоо ингэж хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй юм байна аа гэсэн ийм саналыг оруулж ирээд түрүүн одоо аудитын дүгнэлтэд тусгагдсан байгаа. Тэр Засгийн газар юу гаднын зээл тусламжтай холбоотой Сангийн сайдын хэлж байгаа дээр болбол манай зөвлөмж дээр Засгийн газраар болон УИХ-аар гэрээ хэлэлцээрийг соёрхон батлахдаа энэ одоо шатанд нь энэ бодлогын түвшинд энийг бол онцгойлон анхаарахгүй болбол яг тэр баталчихсан гэрээ хэлэлцээр дотор болбол гаднынхан одоо гаднын тухайн санхүүжүүлэгч орноос гүйцэтгэгч нь орж ирнэ. Тийм тийм одоо хөрөнгө юм нь тэдний одоо тоног төхөөрөмж байна аа гээд ингээд хийчихээр нэгэнт батлагдсан зээл тусламжийг бол тэгж одоо хэрэгжүүлэхээс өөр гарцгүй болчихоод байгаа нь бас их одоо сөргөөр нөлөөлж...

Х.Булгантуяа: Цогтбаатар гишүүн нэмж тодруулна тиймээ. Тодруулъя.

Да.Цогтбаатар: АН-ыг сая МАН эрх баригч нам одоо засагт ороод ажил хийгээд болохгүй алдаа дутагдал илрүүлээд байна гээд сая хөөгөөд гаргачихсан л даа. Тэгэхээр энэ эрх баригч нам одоо өөрөө яг ажлаа хийгээд, сайд нар нь тэр холбогдох доор удирдаж байгаа нэгж одоо тэр ТӨК-иуд дээрээ учрыг нь олоод алдаа дутагдалгүйгээр ирэх жил тэр аудитын дүгнэлт оруулж ирээрэй. Тэгээд энэ зөвхөн сайд дарга нар биш ээ, энэчээ төсвийн ерөнхийлөн захирагч нар гээд нэг баахан улсууд сууж байгаа. Тэд нар дээр нь ямар асуудалд тооцож, хариуцлага тооцож хуулийн байгууллагад шилжүүлсэн юм. Энэ аудит, Хэрэг эрхлэх газраас.

Бас бичгээр мэдэгдээд ир ээ. Тэгээд энэ 2024 оноос эхлээд энэ хариуцлага тооцдог хуулийн байгууллагад шилжүүлдэг ажлыг бас эхлүүлмээр байна гэж уриалж байна.

Х.Булгантуяа: За үг хэллээ тиймээ Цогтбаатар гишүүн. Яах вэ одоо хуулийн байгууллагад шилжүүлдэг бол одоо ч гэсэн байгаа, одоо ч гэсэн байгаа. Түрүүн Үндэсний аудитын газраас энэ тухай бас мэдээлэл хийсэн. Зарим холбогдох албан тушаалтнууд, хуулийн байгууллагад шилжүүлсэн. Авлигатай тэмцэх газар болон гээд. Энэ тухай бол мэдээлэл өгсөн тийм. Яах вэ Цогтбаатар гишүүн аль ч цаг үед Аудитын газраас төсвийн олон захирагч нар энүүн дээр угаасаа алдаа оноотой ажиллаж байгаа зүйлүүд бол байгаа. Энийг сайжруулах нь бол чухал болохоос биш. Одоо энүүн дээр хэдүүлээ ийм улс төр хийх бол утгагүй байх аа. Тэгээд 2024 оны талд нь танай сайд нар ч гэсэн ажиллаж байсан цаг үе шүү дээ. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Цогтбаатар гишүүний асуултад бас хариулъя. Яагаад гэвэл энэ боловсролын салбарт 1807 байгууллагад ийм аудитын дүгнэлт гаргаад үүнээс 68 нь бол хязгаарлалттай гэж ийм дүгнэлт авсан. Тэгээд том дүнтэйг нь яагаад ийм юу гараад ирэв ээ, зөрчил гараад ирэв ээ гэдгийг тайлбарлая аа. Тэгэхээр салбарын хэмжээнд бол хугацаандаа ашиглалтад орж чадаагүй нийтдээ 68 барилгын төсөл арга хэмжээ байж байгаа. За үүний шалтгаан нь бол анхнаасаа нөгөө зураг төсөвгүй байхад нь батлаад ингээд явчихсан. Тэрнээсээ болоод удсан. 2 дугаарт нь бол явцдаа үнэ нь нэмэгдээд тэр нь магадлангаараа ороод хугацаа авсан. 2 дугаарт үнэ нь одоо зарим тохиолдолд бол 2 дахин, 3 дахин нэмэгдсэн тохиолдол ч бий.

Мөн одоо нийслэл болон аймгийн Засаг дарга нарт эрхийг нь шилжүүлээд өгчихсөн. Тэгээд тэндээсээ тэр одоо юм нь сайн яваагүй төсөв бэлэн биш эд нар гэдэг шалтгаанаар байна. Шалгарсан компаниудтай холбоотой ийм...

Х.Булгантуяа: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн байхгүй байна. Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Гишүүдэд Засгийн газрын гишүүддээ ажлын хэсэгт оройн мэнд хүргэе ээ. Жавхаа сайд сая нөгөө эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн 70-аад тэрбум төгрөг гээд байна шүү дээ. Энд маш чухал юм байгаа юм. Зарим одоо багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, энэ дээр бас анхаарч үзээрэй гэдгээ хэлье. Эрүүл мэндийн сайд, ерөнхий аудитор оос асуух асуулт байна. Энэ эрүүл мэндийн салбарын өр зээл гээд хэтэрлээ одоо.

Жилийн эцсээр ЭМД-ын эрсдэлийн сангийн 54 тэрбум чөлөөт төлбөр нь 60 хэдэн тэрбум дээр нь одоо Сангийн яам, Засгийн газраас бас 350 хэдэн тэрбумыг шийдэж өгвөл би одоо ингээд өр зээлгүй болгоно гэж сайд ярьж байсан. Гэтэл одоо өр зээл нь хэтэрчихсэн. Жишээлбэл одоо энэ 1 дүгээр эмнэлэг, 2 дугаар эмнэлэг, 3 дугаар эмнэлэг, ХСҮТ ХӨСҮТ, ЭХЭМҮТ гэмтэл согогийн энэ 7 тийм том эмнэлэг одоо хэчнээн өр зээлтэй байна. Жишээлбэл халдвартын эмнэлэг бол түрүүн бид нар очсон 23 тэрбумын өртэй гэж байна. Энэ аудитынхныг шалгаад үзсэн үү энэ гол нь юундаа байна. Тэр ЭМД-ын одоо шалгуур үзүүлэлттэй холбоотой байна уу. Эмнэлгүүд яах аргагүй тэр эм хэрэгслээ зарцуулчихдаг. Гэтэл одоо даатгалын үнэлгээгээр нөгөөдхөө хасаад хаячихдаг. Энэ хэнд нь буруу байна гэж ойлгож байна. Саяын эмнэлгүүдийн яг өр зээл нөгөө талаар 21 аймгийн одоо нэгдсэн эмнэлгүүд байна. Энэний өр зээл яг хэчнээн өр зээлтэй байна тэрийг нэг хэлж өгөөч.

Дараа нь энэ 2024 онд одоо төсөв нь тавигдсан 2025 онд дамжиж байгаа эмнэлгүүд байж байна. Жишээлбэл сая би түрүүн Сангийн яамныханд бас хэлсэн Баян-Өлгийн нэгдсэн эмнэлэг одоо 2025 он гараад хүлээлгэж өгөх ёстой одоог хүртэл яагаагүй 3 тэрбум хэдэн зуун сая төгрөгийн юутай гэж байна. Цалингийн зөрүү гэнэ үү тийм нэг юм яриад байгаа. Энийг одоо ингээд тавих юм уу. Тавихгүй бол тэгээд 2026 он хүртэл энэ эмнэлэг чинь бас ингээд сунжраад явах нь ээ. Яагаад гэвэл энэ алслагдсан аймгуудад одоо хүнд өвчтөн, харвалттай, зүрхний шигдээстэй улсууд машинаар зөөгөөд байна. Хэрвээ эмнэлэг нь ашиглалтад орчхоод хотоос эмч нар очоод тэнд хийх бүрэн боломжтой болчхоод байгаа юм. Энэ дээр одоо ямар бодлого барьж байна энэ талаар асууя. Дараа тодруулъя.

Х.Булгантуяа: Чинбүрэн сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Бейсен гишүүн тийм ээ одоо эрүүл мэндийн салбарын өр бол одоо хэтэрсэн. Сая 2024 оны гүйцэтгэлийн араас бол бараг 360-аад тэрбум төгрөгийн өртэй гараад, 2025 оны санхүүжилтийнхээ дүнгээсээ өмнөх өрөө нөхөөд нэг ёсондоо урд хормойгоо хойд хормойгоо нөхөөд л явж байна. Одоо энэнээс гарах гаргалга маш хэцүү байна. Дэлхий даяараа геополитикийн хямралтай, эдийн засгийн хямрал болчихсон. Төсвийн тодотгол хийх гээд сууж байгаа 3.3 их наяд төгрөг төсвөөсөө хэмнэх гээд бид тодотгол хийх гэж байна. Юу нэмэх манатай байдалтай, хүнд байдалтай байж байна.

Тийм учраас би салбараараа бас одоо үнэнээ ярьж энэ нөхцөл байдлаасаа салбараа элгээр нь хэвтүүлчихгүй байх гаргах гаргалгаа стратеги төлөвлөгөөгөө боловсруулж байна аа. Энийгээ ч гэсэн бид одоо ард иргэддээ үнэнээ хэлэх ёстой, үнэнээ хэлээд эрүүл мэндийн салбар нь өөрөө өр ширэндээ баригдаад, тэгээд одоо элгээрээ хэвтэж болохгүй ээ. Тийм учраас одоо хамтын төлбөрийн асуудлыг бид ярих хэрэгтэй болж байна. Дээрээс нь төлбөртэй тусламж үйлчилгээг инфляцтай уялдуулаад 20-25 хувь нэмэхгүй бол болохгүй болж байна.

Дээрээс нь сая одоо ярьж байгаа тэр банк санхүүд алдчихсан байгаа бараг нийлээд нэмэх юм бол 30, 75 тэрбумаа нэмэх юм бол 110 гаруй тэрбум төгрөг байна. Энийгээ яаж хурдан авах юм, энийг яаж одоо буцааж даатгалын сангийн юу өрөө нөхөх юм гэдэг олон олон асуултууд бид нарын одоо том энэ Засгийн газрын бас одоо сорилт болж байна аа. Тэгээд энэ болгоны цаана гарахын тулд одоо бид зөв тогтолцоо зөв стратеги гарахаас өөр одоо аргагүй болсон. Тэгээд энийгээ одоо үнэнээ хэлнэ ээ. Энэ төлөвлөгөө боловсруулаад та бүхэндээ танилцуулна аа.

Х.Булгантуяа: Аудитаас за аудитаас энэ эмнэлгүүдэд очиж аудит хийсэн үү, өр шир маш ихтэй байна аа гэдэг асуулт тавьсан тиймээ. 4 номерын микрофон.

Ц.Наранчимэг: Бейсен гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна аа. Бүх төрийн аудитын байгууллага бол төсвийн шууд захирагчаас төсвийн ерөнхийлөн захирагч хүртэл бүх шатны төсөвт захирагчдын санхүүгийн тайланд аудит хийж одоо дүгнэлт гаргаж байгаа. За эрсдэл багатай байгууллагуудад бол хэсэгчилсэн буюу түүврийн аудитыг хийж гүйцэтгэж байгаа. Эм, эмийн сан, эмнэлгийн тусламж үйлчилгээний өглөг өмнөх оноос 98.5 тэрбумаар өсөөд энэ оны саяын баталгаажуулсан тайлангаар бол 316.8 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байгаа. Өглөгийн үлдэгдлийн 228.6 тэрбум төгрөг буюу 72.2 хувийг улсын эмнэлэг 64.8 тэрбум төгрөг буюу 20.4 хувийг хувийн хэвшлийн

эмнэлэг, 9.7 тэрбум төгрөг буюу 3.1 хувийг ӨЭМТ, 8.2 тэрбум төгрөг буюу 2.6 хувийг эмийн сан, 5...

Х.Булгантуяа: 4 номерын микрофоныг нэмж өгье.

Ц.Наранчимэг: 5.5 тэрбум төгрөг буюу 1.7 хувийг рашаан сувилалд өгөх одоо ерийн үлдэгдэл эзэлж байгаа. Тэгэхээр бид нар энэ санхүүгийн тайлангийн аудитаараа ЭМД-ын сангийн тогтолцоог сайжруулах бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх ийм зөвлөмжийг болбол өгсөн байгаа.

Х.Булгантуяа: Бейсен гишүүн нэмж тодруулъя.

Б.Бейсен: Та нар энэ саяын 7 эмнэлэг байна шүү дээ үндсэн тэгээд хөдөөгийн 21 аймгийн эмнэлэг эд нарын өр зээлийг тодорхой хэлмээр юм. Энэтэй холбоотой ерөөсөө өвчтөнүүд гаднаас эм авчирч байна, эмчлүүлж чадахгүй байна. Нөгөө талаар нэг асуух юм нөгөө өнгөрсөн жил бид нар гадаадад эмчлүүлэгчдээ 10 тэрбум төгрөг хуваарилсан. Тэрэнд аудит хийж үзсэн үү?

Ер нь эмнэлгүүдийн энэ өр зээлийг нуух шаардлагагүй. Энэ чинь одоо орон тооны хэтрэлттэй холбоотой байна уу, аль эсвэл одоо хүчлэн цаг үетэй холбоотой эмнэлгүүд өөрсдөө мэдээд хаячихсан, бүтэц орон тоог шинэчлэхгүй бол ерөөсөө энэ цаашаа явахгүй байна. Энэ өр зээлийг нь одоо нуухгүйгээр ил болгомоор байх юм. Энэ талаар асууя.

Х.Булгантуяа: Чинбүрэн сайд нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр одоо энэ нөхцөл байдлаасаа нуухгүй ээ. Бид бодитой ярина аа. Одоо зүгээр л ердийн эмнэлэг дээр очоод л хагалгаа хийлгэснийхээ дараа шархаа болгоход л өөрснөө би энд шарика барьж очиж байна шүү дээ энэ чинь одоо нууц биш байна аа. Үнэн, бодит байдал ийм байгаа. Зарим эмнэлэг дээр бол санхүүжилт байхгүй учраас та төлбөрөө төл гээд л бүтэн төлбөрийг нь аваад л хэвтэж байна шүү дээ. Бид үндсэн том зорилго тавьж байсан. Эрүүл мэндээсээ болоод санхүүгийн хямралд орохгүй байх том зорилгоосоо одоо ухралт болчихсон. Энэ одоо нуух юм байхгүй.

Тийм учраас энэ бүх тогтолцоондоо нэг ЭМД-ын сан өөрөө биеэ даасан корпоратив шинж чанартай үйл ажиллагаа явуулахгүй л бол болохгүй байдаг юмаа гэдгийг л харууллаа. 2-т олон нийтийг хамарсан халдварт өвчнийг бид ЭМД-ын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэх нь өөрөө ямар хор уршигтай юм бэ гэдгийг бас давхар нотоллоо. Сая та түрүүн асуусан. ХӨСҮТ дээр нэг 20 гаруй тэрбум төгрөгийн өр байгаа гэсэн. Үнэн шүү дээ. Энэ чинь л улаан бурхантай холбоотой л гарсан зардал...

Х.Булгантуяа: Бейсен гишүүн нэмж тодруулъя.

Б.Бейсен: Тэр халдвартын өр зээл гэхээр халдварт өвчин гарвал тэгээд санхүүжээд халдварт өвчин гаргахгүй бол тэгээд юм авч чадахгүй нь байна шүү дээ. Тэгэхээр энийг төрд авах асуудлыг бас Чинбүрэн сайд энэ асуудал болбол тавихгүй бол үнэхээр болохгүй асуудал юм байна. Нөгөө талаар энэ эмнэлгүүдийн бүтэц орон тооны стандартыг батлахгүй бол энэ ерөөсөө илүү ажилчдын цалинд явж

байна уу, НДШ-д явж байна уу гэдэг энэ. Сангийн яам, ЭМЯ, ХНХХ-ын яам хамтарч байж энэ бүтэц стандартыг нь батлаад нөгөө талаар төсвийг нь тодорхой болгож өгөхгүй бол энэ үргүй зарцуулж байгаа асуудал байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Чинбүрэн сайд нэмж хариулья.

Ж.Чинбүрэн: Тэгээд бас одоо бид 2017 онд батлагдсан Эмнэлгийн тусламжийн тухай хуулиа хэрэгжүүлж, эмнэлгийн хагас бие даасан тогтолцоог бүрдүүлээд тэгээд ТУЗ нь хасах баланст өр ширтэй гаргадаг захирлыг ажлын дүгнээд халдаг л байх хэрэгтэй. Бидэнд одоо сайн менежерүүд бас хэрэгтэй байна аа. Гүйцэтгэлийг сайн тодорхойлж чаддаг, ард иргэддээ тусламж үйлчилгээг сайн хүртээж чаддаг, дээрээс нь эмнэлгээ өрөнд оруулдаггүй байх энэ тогтолцоог бид хянадаг ийм систем бидэнд дутагдаж байгаа нь бол тод харагдаж байна аа.

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Энэ хуралдаан даргалж байхад өөрөө бол асуулт асууж байж болдоггүй юм байна, кнопоо дарахаар ордоггүй юм байна. Тэгээд би нэг хэдэн асуултуудыг асууя гэж бодсон юм.

Засгийн газраас Дотоод аудитын тухай хуулийг хэзээ оруулж ирэх вэ? За манай төсвийн ерөнхийлөн захирагч болгон ТӨК болгон дотоод аудитын газартай, бараг 10 хүнтэй албан хаагчтай байх. Энэ ингээд хууль эрх зүйн орчин нь тодорхойгүй. Одоо миний мэдэхээр Сангийн яаман дээр бараг л 7, 8 жилийн өмнө л ийм хуулийг боловсруулчихсан байсан. Энэ эрх зүйн орчин нь сайн болохгүй болохоор түрүүн бас хэд хэдэн гишүүд бас асууж байсан. Энэ зөрчлүүдээ дотооддоо илрүүлээд явж байсан бол өдийд ингээд нэг 50 хэдхэн хувийн хэрэгжилттэй гээд ингээд бас төсөв өнөөдөр УИХ-д орж ирэхгүй байсан байх аа. За энүүнийгээ яах вэ? Одоо ингээд энэ том нөгөө мега төслүүд маань төр хувийн хэвшлийн түншлэлээр уг нь бол хэрэгжих ёстой. Учрал сайд түрүүн энд байж байсан хаачив?

Тэгээд энэ төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль чинь ер нь хэрэгжихээр хууль байгаа юм уу? Үүгээр ер нь явж байгаа нэг ч төсөл хөтөлбөр байхгүй байна аа. Засгийн газар өөрөө энэ хуулиа оруулж ирээд л батлуулсан. Одоо энэ хууль нь хэрэгжихийн аргагүй хууль батлуулчихлаа гээд ингээд яриад яваад байх юм. Тэгвэл энэ хуулиа яаралтай та бүхэн маань өөрчлөөч ээ. Нэгэнт л алдагдалгүй төсөв батлахаар бид нар ярьж байгаа энэ цаг үед төсвөөс бүгдийг хийж чадахгүй гэдэг Жавхлан сайдын хэлж байгаа бол бас үнэн.

УИХ-аас гарсан Ажлын хэсгийн зүгээс бид нар ажлаа тун удахгүй энэ хуулийг бас өргөн барих гэж байна төсөвт. УИХ-ын гишүүд мэдэж байгаа. Одоо төсвийг төсвийн төслийг өргөн барихад Ерөнхий сайд өөрөө танилцуулгаа хийгээд УИХ-ын чуулганд бүх Засгийн газрын сайд нар, төсвийн ерөнхийлөн захирагч нар энд суугаад асуултад хариулдаг. Төсвийн гүйцэтгэлийг ярих болохоор нэг ерөнхий нөхцөл байдал ийм байгаа юм.

Тэгэхээр яг адилхан Ерөнхий сайд өөрөө орж ирээд төсвийн гүйцэтгэлийнхээ танилцуулгыг хийдэг, Засгийн газрын сайд нар асуултад хариулдаг, дээрээс нь нэмээд Төсвийн хүрээний мэдэгдэл сая бид 2026 оны төсвийн хүрээ 2027, 2028 оны төсвийн төсөөллийг баталчихсан. Тэгсэн мөртөө төсвийн гүйцэтгэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг үүний араас баталдаг. Уг нь бол төсвийн гүйцэтгэлийг түрүүлж хэлэлцэж батлаад үүний араас дараа жилийнх нь төсвийн хүрээний мэдэгдлийг

баталж байвал бид өмнөх оныхоо төсөвтөө дүн шинжилгээ хийж байж дараа жилийнхээ төсвийн хүрээг батлах нь зарчмын хувьд уг нь бол илүү зөв юм.

Тэгээд иймд одоо зарчмын өөрчлөлтүүдийг оруулж бид бас УИХ-д ажлын хэсгийн зүгээс бас өргөн барих гэж байгаа. Нэг асуултыг асуух гэсэн юм. Учрал сайд, бас Цахим хөгжил, харилцаа холбооны сайдуудтай хийсэн нэг том ажил бол энэ аудитынхан маань бас Засгийн газраас хэрэгжүүлсэн нэг том нэг мөрийн хөтөлбөр, том ажлыг бас нэг эхлүүлдэг шүү дээ тухайн жилд. Түүний үр дүнг тусгайлан аудитын тайланд оруулж тайлагнаж байвал их зөв байна аа.

2023 онд Учрал сайд нэг эхлүүлсэн ажил бол шилэн ажиллагаа. Shilen.gov.mn гэдэг дээр бараг бүх сангуудын, бүх төсвийн ерөнхий захирагч нарын үйл ажиллагааг шилэн болгосон. Миний одоо би жишээлбэл сайд байхдаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн, Хүүхдийн төлөө сан, Нийгмийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааг шилэн болгосон. Тэгээд энүүнийг бол бараг бүх төсвийн ерөнхийлөн захирагч нар хийсэн. Энэ бол тухайн үед сайн боллоо гэж ил тод болгосон нь сайн боллоо гэсэн. Ил тод болгоод үр дүн хэрхэн одоо сайжирсан бэ. Ил тод болгоод дээрээс нь нэмээд буцаж эргэн төлөх одоо төвлөрүүлэх үйл ажиллагаа сайжирсан уу гэдэг нэг ийм асуулт байна. Энийг одоо хэн хариулах вэ? Учрал сайд хариулъя. За тэгье.

Н.Учрал: За тэр шилэн ажиллагааны хүрээнд нэг 850 мянган юнит мэдээлэл тэр Shilen.gov.mn дээр нэгдсэн. Тэгээд тэр 850 мянган юнит мэдээллийг нөгөө их өгөгдөл болгож хувиргах ажлуудыг болбол хийсэн. Ингээд их өгөгдөл болгож хувиргах ажил дээрээс нь одоо энэ Гааль татварын, санхүүгийн мэдээлэл технологийн төв, төрийн үйлчилгээг явуулж байгаа энэ нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглаж хэрэглэж байгаа энэ И Монгол гээд ингээд ер нь бол энэ мэдээллүүдийг нэгтгэж байгаа байгууллагуудыг нийт мэдээлэл их өгөгдөл болоод эхлэхээр шийдвэр гаргалт нь их өгөгдлийг ашиглах бололцоо болбол бүрдэж байгаа. Энэ ч утгаараа болбол бид нөгөө цаашдаа нөгөө хиймэл оюун дээр шийдвэр гаргая аа гээд зорьж байгаа бол эхлээд өгөгдөл нэгтгэж, одоо боловсруулж чадахгүйгээр их өгөгдөл дээр шийдвэр гаргана гэж байхгүй. Хиймэл оюуныг ашиглана гэж байхгүй.

Тийм учраас энэ их өгөгдлүүдээ бид нар боловсруулах чиглэл рүү одоо зорих ёстой. Эхний үр дүн болбол сая Хэрэг эрхлэхийн сайд байхдаа энэ И кабинет 2 нойлийг болбол хэрэгжүүлсэн. Ингээд одоо Засгийн газрын бүх гишүүдийн яг өөрсдийнх нь ордог тэр программ дээр нь шууд одоо энэ бүх мэдээллүүд харагдаж байгаа. Жишээ нь энэ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ 21 аймгийн 330 сум тус бүрээр аль боомтоор одоо нүүрс яг хэдээр зарагдаж байгаа юм, яг экспортын үнэ нь хэд байгаа юм, гаалиар одоо ямар ямар бараа бүтээгдэхүүн орж ирж байгаа гэдгийг яг рийл таймаар хараад байгаа юм. Ингээд үүний үр дүнд болбол жишээ нь Эдийн засгийн хөгжлийн тэр сайдын хувиар ч гэсэн энэ макро эдийн засаг талаасаа тэр бүтээгдэхүүний үнэ гаргахад бол маш ойлгомжтой болчихсон байхгүй юу. Яг одоо хэд байгаа вэ гэдгийг хараад л ингээд тавих ийм бололцоотой болсон болбол сайн дэвшил. Тэгээд цаашаа хийх ёстой.

Түрүүн нөгөө аудит дээр бас та асуусан. За компанийн хуулиар болбол өөрөө ТУЗ-ийн дэргэд аудит ажилладаг ийм л хуультай. Тэгээд ингээд тэр аудит нь өөрөө компанийнхаа ТУЗ-ийн дэргэд хөндлөнгөөс ажиллаад ингээд одоо үнэлэлт

дүгнэлтээ өгөөд явдаг. Цаашдаа энэ олон хяналт шалгалтын давхардлыг арилгах зорилгоор болбол бид нарын эхний хийж байгаа алхам бол энэ Ерөнхий сайдын оруулж ирж байгаа Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хууль.

Цаашдаа одоо нөгөө Байнгын хороон дээр 3 сайд орж ирчхээд хэн нь бодлогын баримт бичгийнхээ үнэлгээг хийх вэ гэдгээ мэдэхгүй бие бие рүүгээ харж суудаг байдлыг бол зогсоож байгаа. Нэг ёсондоо бол хяналт тавих буюу хяналт чинь өөрөө бодлогын баримт бичгээс гадна 5 жилийн одоо үндсэн чиглэл, жилийн төлөвлөгөө бүгдийг нь өөрөө төлөвлөсөн болбол түүнийгээ үнэлээд дээрээс нь төлөвлөгөөнд тусаж байгаа ажлууд дээрээ хүртэл тэр аудитын зөвлөмжийг нь аваад энийг тусах нь, тусахгүй гэдэг чиг үүргээ тэр хөгжлийн бодлогыг хариуцаж байгаа сайд нь өөрөө хариуцах энэ зөв жишиг рүү явж байна.

Засгийн газраас гарч байгаа тогтоол шийдвэрээ болбол хэрэг эрхлэх өөрөө хянаад явах энэ бодлого руугаа явж байгаа учраас яг одоо өөрийн чинь хэлдгээр тэр аудитыг болбол цогц утгаар нь яг хэн ямар үүрэг хариуцлага оногдуулах вэ, хэнд ямар үүрэг хариуцлага байх вэ гэдгийг бол нэгдсэн нэг хуулиар болбол хийх нь зөв юм байна аа гэж үзэж байгаа.

Мөн Эдийн засаг, хөгжлийн яамнаас бол одоо өнгөрсөн хугацаанд хууль дээр бол ажиллаж байсан юм байна лээ. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль. Засгийн газрын зүгээс бол энэ хуулийг бол өргөн мэдүүлнэ. Шат дамжлагуудыг бол багасгана. Урьдчилсан үнэлгээ хийгдэх ажил дээр маш их цаг алддаг. Ингээд жилд нэг 20-25 төсөл бичигдээд л тэгээд яг урагшилж байгаа зүйл бас төдийлөн байхгүй. Тэгээд төр хувийн хэвшлийн түншлэл болбол шат дамжлагыг багасгана. Цар хүрээг нь илүү өргөтгөөд тавигдах шаардлагуудыг цөөлөөд илүү хялбар болгох. Одоо бол төр хувийн хэвшлийн түншлэлийг дэд бүтцийн төсөл бараг 8 сар болж байгаа шүү дээ. Энийг л багасгах ёстой.

Х.Булгантуяа: Нэмээд бас нэг зүйл хэлэхэд манай Чинбүрэн сайд бас зовлонг нь одоо бас хамгийн сайн мэдэж байгаа, Аубакир сайд бас сайн мэдэж байгаа. Энэ Засгийн газрын зүгээс бас энэ Активын удирдлагын тухай хуулийг яаралтай өргөн бариач ээ.

Одоо манай Чинбүрэн сайдаар нэг баахан үл хөдлөх хөрөнгө авсан байгаа байх тиймээ. Нөгөө эрх хүлээн авагчаас. НДЕГ дээр бас тийм юм байгаа. Гахайны ферм, сүүний ферм, амралтын газар энэ тэр гээд бараг 100-гаад тэрбум төгрөгийн янз янзын үл хөдлөх хөрөнгийг одоо иргэдийн тэтгэвэр бодох ёстой манай НДЕГ-ын ажилчид тэрүүнийг яаж түрээслэх вэ, яаж зарах вэ гээд ингээд толгой нь өвдөөд сууж байгаа юм. Энэ бол энэ хүмүүсийн ажил ерөөсөө биш байхгүй юу. Яаж гахайны фермийг ажиллуулах вэ гээд ингээд бодоод сууж байна гэдэг бол энэ хүмүүсийн ажил ерөөсөө биш.

Хэрвээ Активын удирдлагын хуультай болчих юм бол Эдийн засгийн хөгжлийн сайд Учрал сайд аа. Энүүнийг Засгийн газраас яаралтай өргөн барих юм бол энэ хүндэрчихсэн байгаа активуудаа яаралтай зарж борлуулах энэ ажлуудыг хиймээр байна аа. Энэ бол эрүүл мэндийн сайдын ажил биш ээ. Энэ бол Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын ажил ерөөсөө биш ээ. Тэгэхээр энэ бас одоо энэ акт тавигдаад байгаа нэг үндэслэл болоод байгаа юм Үндэсний аудитын газраас.

Тэгэхээр энэ олон актууд тавигдаад байгаа асуудлуудыг дахин дахин ийм акт тавиулахгүйн тулд энэ эрх зүйн орчноо Засгийн газар өөрснөө бий болгохоос ажиллаач ээ гэж бас хүсэж байна аа.

Ингээд өнөөдөр дарааллын дагуу асуулт асууж, гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон бусад байнгын хороодод шилжүүллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ